



БhДVhe ӨB

*Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх*

БИДНИЙ ӨВ

*Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх*

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв
Солт Лейк Сити, Юта

Хуудас 50: Иосеф Смит Либертийн Шоронд, Грег Олсен.

© Greg Olsen

Хуудас 68: *Парли Гудамжны Төгсгөл Хэсэг*, Глен Хопкинсон.

© Glen Hopkinson

© 1996 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 11/96.

Орчуулгын зөвшөөрөл: 4/97.


Our Heritage: A Brief History of

The Church of Jesus Christ of Latter-day Saints-ын орчуулга

Mongolian

Агуулга

Оршил	v
Бүлэг 1: Анхны Үзэгдэл	1
Бүлэг 2: Сүмийн Суурийг Үндэслэн Байгуулсан нь	7
Бүлэг 3: Огайогийн Көртландад Хаант Улсыг Байгуулсан нь	23
Бүлэг 4: Миссурид Сионыг Үндэслэсэн нь	43
Бүлэг 5: Навуу дахь Золиослол ба Адислалууд	63
Бүлэг 6: Алхам Тутам дахь Итгэл	81
Бүлэг 7: Үндэстнүүдэд Тугийг Үндэслэсэн нь	95
Бүлэг 8: Зовлон Зүдгүүр ба Сорилтын Үе	109
Бүлэг 9: Сүмийг Өргөжүүлсэн нь	123
Бүлэг 10: Дэлхий Даяарх Сүм	141
Бүлэг 11: Өнөө үеийн Сүм	155
Төгсгөл	169
Төгсгөл дэх тэмдэглэл	



Энэ эрин үеийн бошиглогч бүр Аврагч, Есүс Христийн бурханлиг үүрэг зорилгын тухай гэрчилсэн юм.

Оршил

Энэ номын гол захиас бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн эхлэлээсээ хойш тунхаглаж байгаа тэрхүү захиас юм. Энэ эрин үеийн анхны бошиглогч Иосеф Смит заахдаа:

“Манай шашны тулгуур зарчмууд бол Есүс Христийн тухай, Тэрбээр хөнөөгдөж, оршуулагдан мөн гурав дахь өдөр босч ирсэн болон тэнгэрт дээшлэн одсон тухай Төлөөлөгчид хийгээд Бошиглогчдын гэрчлэл юм; тийнхүү манай шашинд хамаатай бусад бүх зүйл нь зөвхөн үүнд хавсралтууд болдог”¹ гэжээ.

Иосеф Смитийг залгамжилсан бошиглогч бүр Аврагчийн бурханлиг үүрэг зорилгын тухай хувийн гэрчлэлээ нэмсээр иржээ. Тэргүүн зөвлөл батлахдаа:


“Бүх дэлхийд Есүс Христийн тухай гэрчлэхээр дуудагдаж, томилогдсон хүмүүсийн хувьд бид, Тэрбээр бараг хоёр мянган жилийн өмнө Улаан Өндөгний Баярын өглөө амилсан бөгөөд өнөөдөр Тэрбээр амьдардгийг гэрчилж байна. Тэрбээр алдар суут болгогдсон, мах хийгээд яснаас бүтсэн үхэшгүй биетэй юм. Тэр бол Аврагч, дэлхийн Гэрэл хийгээд Амьдрал мөн.”²

Итгэлтэй сая сая Гэгээнтнүүд бас Есүс Христийн бурханлиг мөн чанарын тухай гэрчлэлтэй байдаг билээ. Энэхүү мэдлэг нь тийнхүү газар дээрх Бурханы хаант улс, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг байгуулахад зайлшгүй шаардлагатай золиослолуудыг хийх хүсэл эрмэлзлийг төрүүлсэн юм. Сүмийг үндэслэн байгуулсан түүх нь итгэлийн, ариуслын хийгээд баяр баясгалангийн түүх юм. Энэ бол өнөөгийн дэлхийд Бурханы үнэнүүдийг заасан амьд бошиглогчдын түүх юм. Энэ


бол Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг эрэлхийлж, улмаар үүнийг олсноороо Аврагчийн шавь нар болсны төлөөсийг төлөхөд бэлэн байсан, нийгэм эдийн засгийн өөр өөр нөхцөл байдал бүхий эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн түүх юм. Эдгээр тууштай Гэгээнтнүүд зовлон бэрхшээлүүдийг үл харгалзан урагш давшиж, тэр ч байтугай бүр хамгийн хэцүү бэрхцэгт ч гэсэн Бурханы нинжин сэтгэлийн тухай хийгээд түүний хайрын баяр баясгалангийн тухай гэрчилсээр байсан билээ. Тэд итгэлийн, эр зоригийн, дуулгавартай байдал болон золиослолын өвийг үлдээсэн юм.

Итгэлийн өв өнөөдөр үргэлжилсээр байна. Дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтнүүд бол шинэ бэрхшээл болон боломжуудаар дүүрэн цаг үед итгэл болоод эр зоригоор амьдарч байгаа, өөрсдийнхөө улс орон дахь өнөө үеийн анхдагч нар юм. Бичигдэж хараахан амжаагүй байгаа түүхийн хуудсууд бий. Бидний хүн бүрт тэдэнд Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч үүнийг хуваалцахын баяр баясгаланг ойлгоход нь туслах ирээдүй үеийнхэнд өв үлдээх боломж бий.

Бид өөрсдийнхөө өмнөх үеийнхний итгэлийн талаар илүү ихийг мэдэх тусам Аврагчийн тухай гэрчлэхэд тэдэнтэй гар нийлсэн тэрхүү хүмүүсийг илүү сайн ойлгож, мөн түүний хаант улсыг байгуулахад тусалж чадна. Бид Их Эзэн Есүс Христийн итгэлтэй шавь нарын хувьд илүү зөв шударгаар амьдрахад шийдвэр төгс байж чадна.



Америкийн Нэгдсэн Улс 1847 онд, Энэхүү газрын зураг нь Сүмийн эхэн үеийн түүхэнд чухал ач холбогдолтой байсан аяны байршил болон замын чиглэлийг харуулдаг.



Судруудыг уншсан нь залуу Иосеф Смитийг аль сүм үнэн болох тухай Их Эзэнээс асуухад хөтөлжээ.

АНХНЫ ҮЗЭГДЭЛ

Сэргээлтийн Хэрэгцээ Шаардлага

Есүсийн Төлөөлөгчид хөнөөгдсөний дараа санваарын хүч болон сайн мэдээний үнэнүүдээс олон нь дэлхийгээс авагдаж, их Урвалт хэмээн нэрлэгддэг сүнсний харанхуйн урт удаан үе эхэлсэн юм. Бошиглогч Амос энэхүү урвалтыг зөнчөөр угтан харж, “талхаар өлсөх, усаар цангах бус, харин Эзэний үгсийг сонсохын төлөө өлсгөлөн уг нутагт” байх цаг ирэх болно гэдгийг мэдэгдсэн билээ (Амос 8:11). Урвалтын урт удаан зуунуудын туршид олон шударга эрэгтэй, эмэгтэй хүмүүс сайн мэдээний үнэний бүрэн байдлыг эрж хайж байсан хэдий ч үүнийг олох боломжгүй байв. Олон итгэл бишрэлийн лам хуврагууд өөр өөр захиасуудыг номлож, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг өөрсөдтэйгөө нэгдэхийг уриалж байлаа. Хэдийгээр тэдний ихэнх нь өөрсдийнхөө санаа бодолд үнэнч байсан ч гэсэн хэнд нь ч үнэний бүрэн байдал буюу Бурханы эрх мэдэл байсангүй.

Гэсэн хэдий ч Их Эзэн Эзэн өөрийнх нь сайн мэдээ хийгээд санваарын хүч нэг өдөр дэлхий дээр сэргээгдэж, тэгээд дахин хэзээ ч авагдахгүй байх болно гэдгийг өөрийн нигүүлсэлд амласан юм. Арван есдүгээр зуун эхлэхэд түүний амлалт хэрэгжих эхлэл тавигдаж, урвалтын урт удаан шөнө төгсөх үедээ орж байлаа.

Залуу Иосеф Смитийн Эр Зориг

1800-гаад оны эхээр Иосеф Смит, Люси Мак Смитийн гэр бүл Америкийн Нэгдсэн Улсын Нью Хампширын Лебанонд амьдарч байв. Тэд бол хүнд хүчир хөдөлмөрөөрөө ядуу

тарчиг амьдралаа залгуулдаг, нэрд гараагүй, даруу хүмүүс байлаа. Тэдний тав дахь хүүхэд Бага Иосеф, Шинэ Английн бүсэд 3000 гаруй хүний амийг авч одсон гэдэсний гоц халдварт хижиг өвчнийг тэсэн гарсан үедээ долоон настай байжээ. Түүний бие сайжрахад зүүн хөлнийх нь чөмгөнд гоц халдвар бий болж, бараг л тэсвэрлэхийн аргагүй өвдөлт гурван долоо хоног гаруй үргэлжилсэн ажээ.

Тэндхийн мэс заслын эмч хөлийг нь тайрах хэрэгтэй гэсэн боловч, Иосефийн ээж өөрийнхөөрөө зүтгэж, өөр эмч рүү хүн явуулжээ. Ойролцоох Дартмаутын Коллежийн эмч Натан Смит чөмөгний ясны нэг хэсгийг авч хаяхын тулд харьцангуй шинэ бөгөөд үлэмж их өвтгөдөг нэг аргыг ашиглан түүний хөлийг эдгээхийг оролдоод үзье гэж хэлжээ. Эмч хөвгүүнийг уях уяа авчирсан боловч, Иосеф татгалзан уяагүйгээр мэс заслыг тэсч гарч чадна гэж хэлсэн аж. Түүнд байсан цорын ганц өвчин намдаагч хатуу архинаас тэр бас татгалзаж, мэс заслын үед зөвхөн аав нь л түүний гараас барьж байхыг хүссэн ажээ.

Иосеф агуу эр зоригоор мэс заслыг тэсэн гарч, улс орондоо хамгийн их мэдлэгтэй эмч нарын нэг Доктор Смит, Иосефийн хөлийг эдгээж чадсан ажээ. Хөл нь эдгэрч, өвчингүйгээр явж чаддаг болох хүртлээ Иосеф удаан хугацаагаар зовж шаналан байлаа. Иосефийн мэс заслын дараа Смитийн гэр бүл Вермонтгийн Норвич уруу шилжиж, тэнд тэд гурван жил дараалан ургац алдаж, тэгээд Нью-Йоркийн Палмира руу шилжжээ.

Анхны Үзэгдэл

Иосеф Смит залуу байхдаа гэр бүлдээ газар цэвэрлэх, чулуу зөөх болон бусад үй олон ажил үүрэг гүйцэтгэхэд тусалдаг байв. Иосеф хөвгүүн аливаа юмсын талаар ул суурьтай боддог, тэрчлэн өөрийн мөнх бус бодгалийг халамжлах талаар олонтаа боддог байсан гэж түүний ээж Люси хэлсэн байдаг. Тэрээр Палмирагийн бүсэд номлож

байсан бүх сүмүүдээс аль нь зөв бол гэдэг талаар онцгойлон санаа тавьдаг байлаа. Тэр өөрийн үгээр тайлбарлахдаа:

“Энэхүү их үймээний үед миний оюун буурь суурьтай бясалгал хийгээд үлэмж хүндрэлд учраад байв; хэдийгээр миний бодол санаа гүн гүнзгий хийгээд хурц байсан хэдий ч, хэдийгээр би тэдний зарим цуглаануудад гол төлөв тохиолдлоор оролцдог байсан хэдий ч, би эдгээр бүх бүлгүүдээс өөрийгөө хол хөндий байлгадаг байв. Цаг хугацаа өнгөрөх тусам миний оюун Методист урсгалд ямар нэг байдлаар татагдаж, бас тэдэнтэй нэгдэх хүсэл ямар нэг хэмжээгээр надад бий болов; гэвч шашны янз бүрийн бүлгүүдийн дундах будлиан хийгээд сөргөлдөөн тийм их байсан нь, хүмүүс болон юмстай төдийлөн танилцаж амжаагүй над шиг залуу хүний хувьд, хэнийх нь зөв, мөн хэнийх нь буруу байсан тухайд ямар нэг тодорхой дүгнэлт хийх боломжгүй байв. . . .

“Шүтлэгтнүүдийн эдгээр бүлгүүдийн тэмцлээр бий болсон туйлын хүнд байдал дор хөдөлмөрлөн байхдаа би нэг өдөр Иаковын захидлын нэгдүгээр бүлэг, тавдугаар шүлэг дэх: *Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүйгээр өгөгч Бурханаас гуйг, тэгээд түүнд өгөгдөх болно* гэснийг уншив.

“Судрын ямар ч хэсэг энэ удаад надад тохиолдсоноос илүү хүчтэйгээр хүмүүний зүрх сэтгэлд ирж байсан нь хэзээ ч үгүй бөлгөө. Энэ нь зүрх сэтгэлийн минь бодол болгонд агуу хүчтэйгээр нэвтрэн орох мэт санагдаж билээ. Хэрэв хэн нэгэн хүнд Бурханаас мэргэн ухаан хэрэгтэй байгаа бол, тэр нь би юм гэдгийг мэдсэнээр би энэ талаар дахин дахин тунгаан бодов; учир нь би яахаа мэдэхгүй байлаа, мөн хэрэв тэр үед өөртөө байснаас илүү мэргэн ухааныг би олж авч чадаагүй бол, би хэзээ ч үүнийг мэдэхгүй байсан биз ээ; учир нь өөр өөр урсгалуудын шашны багш нар судрын яг адил хэсгүүдийг өөр өөрөөр ойлгодог байсан нь Библид хандан асуудлыг шийдэхэд итгэлтэй байх явдлыг үгүй болгодог байв.

“Нэг бол би харанхуй хийгээд төөрөгдөлд үлдэх ёстой эсвэл би, Иаковын чиглүүлснээр, Бурханаас асуух ёстой гэдэг дүгнэлтэд яваандаа хүрэв” (Иосеф Смитийн–Түүх 1:8, 11–13).

1820 оны хаврын нэгэн сайхан өглөө Иосеф Смит гэрийнхээ ойролцоох ойн цоорхойд ганцаархнаа өвдөг сөгдөн зүрх сэтгэлийнхээ хүслүүдийг Бурханд уудалж эхлэн удирдамж хүсчээ. Тэгэхэд тохиолдсон зүйлийг тэрээр дүрслэхдээ:

“Тэр даруй намайг бүхэлд нь эзэмдсэн ямар нэг хүчинд би баригдан, бас би ярьж чадахгүй болтлоо хэл минь гацаж, ийм нэгэн гайхалтай нөлөөлөлд автав. Миний эргэн тойронд түнэр харанхуй болж, гэнэтийн устгалын хувь тавилан надад ирсэн мэтээр надад түр зуур санагдаж билээ” (Иосеф Смитийн Түүх 1:15).

Иосеф агуу ажил хийх ёстой байсныг бүх зөв шударгын дайсан мэдэж байсан болохоор түүнийг устгахыг завдсан хэдий ч, Иосеф бүх хүчээ шавхан Бурханыг дуудаж тэгээд тэр даруй чөлөөлөгджээ:

“Энэхүү агуу түгшүүрийн яг тэр мөчид өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харав.

“Намайг хүлсэн тэрхүү дайснаас миний бие чөлөөлөгдөөд удаагүй байхад энэ нь хүрэлцэн ирсэн. Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар сууг юугаар ч дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх рүүгээ зааж хэлэв—*Энэ бол миний Хайртай Хүү. Түүнийг сонс!*” (Иосеф Смитийн—Түүх 1:16–17).

Иосеф биеэ эзэмдэнгүүтээ шашны бүлгүүдийн аль нь зөв болохыг мөн тэрээр алинд нь нэгдэх ёстойг Их Эзэнээс асуув. “Тэд бүгдээрээ буруу байсан учир тэр тэдний алинд нь ч” тэр нэгдэх ёсгүй, мөн “тэдний бүх итгэл үнэмшил түүний мэлмийд жигшүүрт явдал” гэж Их Эзэн хариулжээ. Тэд “бурханлиг байдлын дүртэй” боловч, “түүний хүчийг” үгүйсгэдэг хэмээн Тэр хэлэв (Иосеф Смитийн—Түүх 1:19). Тэрээр бас илүү олон зүйлийн тухай Иосефт ярьжээ.

Үзэгдэл өндөрлөсний дараа Иосеф тэнгэр өөд харсан хэвээр гэдрэгээ харан хэвтэж байгаага мэдэв. Тэрээр хүч чадал нь алгуурхан сэргэж, тэгээд гэр рүүгээ буцав.

1820 оны тэр өглөө нар мандахад Иосеф Смит үүр цайсныг арайхийн ухаарч, газар дэлхий дээр ахин нэгэн бошиглогч алхах болсон ажээ. Баруун Нью-Йоркод амьдардаг, нэрд гараагүй хөвгүүн тэрээр гайхамшигт ажил хийгээд сайн мэдээний болон Есүс Христийн Сүмийг сэргээхийн гайхамшигийг дэлхий дээр гүйцэтгэхээр Бурханаар сонгогдсон байлаа. Тэрбээр тэнгэрлэг хоёр хүнийг харж, эдүгээ Бурхан Эцэг болон түүний Хүү, Есүс Христийн жинхэнэ мөн чанарыг гэрчлэх хосгүй боломжтой болсон байлаа. Тэр өглөө бол илүү хурц гэрэлтэй өдрийн жинхэнэ үүр цайлт байлаа—тэрбээр гэрэл ойн цоорхойг дүүргэж, Бурхан Эцэг, Есүс Христ хоёр 14 настай хөвгүүнийг өөрсдийн бошиглогч болгохоор дуудсан юм.



*Кумора гүвээн дээр Иосеф Смит алтан ялтсуудыг тэнгэр элч
Моронайгаас хүлээн авч, орчуулгын ажлыг эхлэхийг түүнд
хэлж байгаа нь.*

Сүмийн Суурийг Үндэслэн Байгуулсан нь

Мормоны Ном Гарч Ирсэн нь

Тэнгэр элч Моронайн Ай.лчлалууд

Анхны Үзэгдэл хүлээн авснаас хойш гурван жилийн дараа 1823 оны Есдүгээр сарын 21-ний орой Иосеф Смит өөрийн идэр залуу насны мунхаглалуудад өршөөл эрэн Их Эзэнд хандан залбирч, цаашдын чиглүүлэлийг хүсчээ. Их Эзэн түүнд заавар өгөхийн тулд тэнгэрлэг элчийг илгээж хариулсан юм. Иосеф бичихдээ:

“Тэрээр намайг нэрээр минь дуудаад мөн надад хандан, тэр бол Бурханы дэргэдээс илгээгдсэн элч гэдгийг, мөн түүний нэр Моронай гэдгийг; Бурханд надад зориулсан хийх нэг ажил бий гэдгийг; мөн миний нэр бүх үндэстэн, ястан болон хэлтнүүдийн дунд сайнаар бас муугаар дурсагдаж, өөрөөр хэлвэл бүх хүмүүний дунд сайн болон муу аль алинаар нь яригдах болно гэдгийг хэлэв.

“Тэрээр алтан ялтсууд дээр бичигдсэн, энэ эх газрын эртний оршин суугчдийн тухай, мөн тэд хаанаас үүсэж бий болсон эх сурвалжийн шастирыг агуулсан нэгэн ном хадгалагдсаныг хэлэв. Түүнчлэн Аврагчаар эртний оршин суугчдад хүргэгдсэн үүрдийн Сайн мэдээний бүрэн байдал үүнд агуулагдсан гэдгийг тэр хэлэв” (Иосеф Смитийн—Түүх 1:33–34).

Моронай бол эртний энэхүү цэдэгт зориулан бичсэн сүүлчийн бошиглогч байсан бөгөөд Их Эзэнээр чиглүүлэгдсэний дагуу тэрээр үүнийг Кумора толгойд булж нуусан ажээ. Тэр бас эрт дээр үед бошиглогчид ашигладаг байсан бөгөөд уг

цэдгийг орчуулахад Иосефийн ашиглах Урим ба Туммимыг нуусан ажээ.

Тэнгэр элч Иосефийг ойролцоох гүвээ рүү очиход нь чиглүүлж, хожмын өдрүүд дэх Их Эзэний ажлын тухай олон чухал зүйлийг түүнд ярьсан ажээ. Тэрээр Иосефийг ялтсуудыг олж авах үед хэрэв Их Эзэн түүнд зарлиглахгүй бол тэдгээрийг ямар ч хүнд үзүүлэх ёсгүйг түүнд хэлжээ. Моронай тэр шөнөдөө хоёр удаа мөн маргааш нь дахин нэг удаа Иосеф дээр эргэж ирсэн ажээ. Ирэх болгондоо тэрээр өөрийн чухал захиасыг давтаж, нэмэлт мэдээлэл өгч байв.

Тэнгэр элч ирж уулзсаны дараагийн өдөр нь Иосеф зааварчлагдсаны дагуу Кумора гүвээ рүү очлоо. Тэрээр энэ тохиолдлын тухай өгүүлэхдээ:

“Энэ гүвээний баруун талд, оройгоос нь холгүй, томоохон чулууны дор, чулуун хайрцганд хадгалагдсан ялтсууд байлаа. Энэ чулуу нь төв рүүгээ дээш товойсон зузаан, харин захаараа нимгэвтэр учир төв хэсэг нь газраас дээш харагдахаар, эргэн тойрных нь захын бүх хэсэг нь шороонд булагдсан байлаа.

“Шороог нь зайлуулаад би хөшүүрэг олж авч, түүнийг чулууны ирмэг доогуур ивж мөн бага зэрэг хүчлээд үүнийг дээш өргөв. Би дотогш харж, мөн элчийн дурьдсан уг ялтсуудыг, басхүү Урим ба Туммим мөн цээжний хуягийг үнэхээр харав” (Иосеф Смитийн–Түүх 1:51–52).

Тэнгэр элч Моронай ирж, энэ үеэс хойш яг нэг жилийн дараа энэ гүвээн дээр түүнтэй ирж уулзан, цаашид ялтсуудыг хүлээн авах цаг иртэл жилд нэг удаа яг энэ цагтаа энд ирж байхыг Иосефт хэлжээ. Моронай ирэх болгондоо Их Эзэн юу хийх гэж байгаа болон түүний хаант улс хэрхэн зохион байгуулагдах гэж байсан тухай цаашдын заавруудыг өгдөг байлаа (Иосеф Смитийн—Түүх 1:27–54-ийг үз).

Орчуулгын Ажил

Дөрвөн жилийн бэлтгэлийн дараа 1827 оны Есдүгээр сарын 22-нд, Моронай алтан ялтсуудыг Бошиглогч Иосеф Смитэд өгч, түүнд орчуулгын ажлыг бариад . . . гэж хэлэв. Тэр жилийн

эхээр Иосефийн гэрлэсэн Эмма Хейл тэр үйл явдлын үеэр түүнийг дагалдан явж, нөхрийгөө ялтсуудыг авч эргэн иртэл Кумора гүвээний бэлд хүлээж байлаа. Тэрээр Бошиглогчид чухал туслалцаа үзүүлж, богинохон хугацааны турш Мормоны Номыг бичсэн бичээчүүдийн нэг нь болж байв.

Орон нутгийн бүлэг танхайрагчид алтан ялтсуудыг хулгайлах гэсэн удаа дараагийн, улаан цайм оролдлогын улмаас Иосеф, Эмма хоёр Нью-Йоркийн Манчестер дахь гэр орноо орхин явахаас аргагүйд хүрэв. Тэд Манчестераас зүүн өмнө зүгт 120 миль орчимд Пеннсилвангийн Хармонид, Эммагийн эцэг Исаак Хейлийн гэрт толгой хоргодох болов. Тэнд Иосеф ялтсуудыг орчуулж эхэлжээ. Түүний найз, амжилттай ажилчин асан фермийн аж ахуй эрхлэгч Мартин Харрис түүний бичээч болж түүнтэй нэгдэв.

Өөрсдийнхөө хийж байгаа ажлын чухлыг гэрийнхэндээ нотлон харуулахын тулд орчуулагдсан 116 хуудсыг гэр лүүгээ авч явж болох уу гэж Мартин Иосефоос хүсчээ. Иосеф Их Эзэнээс зөвшөөрөл хүссэн боловч Их Эзэний хариу ирсэнгүй. Мартин Иосефоос дахин асууж өгөхийг гуйсанд Иосеф дахиад хоёр удаа дурамжхан хүсч, эцэст нь зөвшөөрөл авчээ. Гар бичмэлийг зөвхөн тодорхой хэдэн хүнд үзүүлэхээр Мартин гэрээ хийсэн боловч, тэрээр амлалтаа зөрчин гар бичмэлийн хуудсууд хулгайлагджээ. Ийнхүү алга болсон нь Иосефийг тайтгаршгүй гуниглалд хүргэв. Учир нь тэрээр Их Эзэнд үйлчлэх түүний бүх хүч чармайлт үгүй боллоо гэж бодсон ажээ. “Би яах билээ? Би нүгэл үйлдлээ—Бурханы хилэгнэлийг өдөөсөн хүн бол би. Би эхний удаад Их Эзэнээс хүлээж авсан хариугаар л дуусгавар болгох ёстой байсан шүү дээ”¹ хэмээн тэрээр үйлж байлаа.

Иосефийг чин сэтгэлээсээ наманчилж, алтан ялтсууд болон Урим ба Туммимыг түр хугацаагаар авагдсаны дараа Их Эзэн түүнийг өршөөж, тэрээр дахин орчуулж эхэлсэн ажээ. Их Эзэн түүнд шашны бус түүхийг агуулсан, алга болсон материалыг дахин орчуулахгүй байхыг зааварлав. Иосеф үүний оронд, Христийн тухай илүү агуу бошиглолууд болон бусад ариун би-

чээсүүдийг агуулсан бөгөөд нэгэн адил цаг хугацааг хамарсан, бошиглогч Нифайн бэлтгэсэн бусад ялтсуудыг орчуулахаар болжээ. Их Эзэн 116 хуудсыг алдагдахыг урьдчилан харсан бөгөөд энэ нь Нифайд хоёр дахь түүхийг бэлтгэхэд нь бурханлигаар нөлөөлсөн ажээ. (1 Нифай 9; С ба Г 10:38–45-ыг үз; мөн энэ үед хүлээн авагдсан С ба Г 3, 10-ыг үз.)

Энэ үед Иосеф Их Эзэнээр Бошиглогчийн гэр лүү чиглүүлэгдсэн сургуулийн залуу багш Оливер Каудерийн туслалцаагаар адислагдсан байлаа. Оливер 1829 оны Дөрөвдүгээр сарын 7-нд бичиж эхлэв. Яг нүдээ олсон тэр цаг үеийн тухай тэрээр хэлэхдээ: “Тэнгэрийн нөлөөллөөр дуудан өгүүлэх дуу хоолойн дор сууж, энэхүү ач буяны хамгийн дээд баяр талархалд сэргэсэн эдгээр өдрүүд хэзээ ч мартагдах аргагүй юм!” гэжээ (Иосеф Смитийн—Түүх 1:71, зүүвэр тайлбар).

“Тэр ном үнэн. . . . Би үүнийг Бошиглогчийн уруулаар хэлэгдсэний дагуу өөрөө бичсэн. Энэ ном үүрдийн сайн мэдээг агуулдаг, мөн бүх үндэстэн, хэлтэн болон хүмүүст номлох үүрдийн сайн мэдээтэйгээр ирэх тэнгэр элчийг тэрээр харсан тухай Иоханы илчлэлтүүдийн биелэлтэд ирсэн билээ. Энэ ном авралын зарчмуудыг агуулдаг. Мөн хэрэв та үүний гэрлээр алхалж, үүний захиасуудад дуулгавартай байх юм бол Бурханы үүрдийн хаант улсад аврагдах болно”² хэмээн Оливер цааш нь тунхаглажээ.

Иосеф, Оливер хоёр ажлынхаа дунд үеэр цэдгийн орчуулгад өөрсдийгөө зориулсан нь тэднийг хоол хүнс буюу мөнгөгүй хоцроход хүргэснийг мэдэв; тэр ч байтугай тэдэнд шаардлагатай бичгийн материалууд дутагдаж байв. Бошиглогчийн нэг найз, ажил олгогч асан, Ахмад Жозеф Найт тэдний гачигдал зовлонг мэдээд тэдэнд тусламж үзүүлэхээр шийдсэн ажээ. Тэрхүү яг цагаа олсон түүний тусламжийн мөн чанарыг тэрээр дүрслэн:

“Би нэг торх хар амар загас, бас шугамтай бичгийн цаас нэлээдийг худалдаж авав. . . . Би ес юм уу арван бушель (1 бушель= 36.3 л) үр тариа, бас тав буюу зургаан бушель төмс худалдаж авав.” Тэгээд тэрээр Хармонид хоёр хүнтэй уулзаж, “Иосеф, Оливер хоёр хүнс ханган нийлүүлэх ажил

эрхэлдэг газар эрж олохоор явсан боловч, тийм газар олж чадаагүй ажээ. Тэд гэртээ эргэж ирээд намайг хүнс нийлэх болсныг мэдээд баяртай байв, учир нь тэдний хүнс дууссан байлаа. . . . Тэгээд тэд ажиллахаар явсан бөгөөд орчуулга дуустал хүрэлцэхүйц хоол хүнстэй болсон байлаа”³ хэмээн дурссан байдаг.

Энэхүү зөв шударга хүний талаар: “Тэднээс нэг нь үлдлээ гэхэд, тэр хүн нь Израил дахь итгэлтэй энэ хүн байна хэмээн Сионы хөвгүүд түүний тухай хэлэх болно; тиймээс түүний нэр хэзээ ч мартагдахгүй байх болно”⁴ гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэнд гайхах юун.

Хавчлага ширүүссэний улмаас Иосеф, Оливер хоёр Хармонийг орхиж, 1829 оны Зургадугаар сард орчуулгын ажлыг Нью-Йоркийн Фейттед Петр Витмерийн ферм дээр дуусгасан юм. Ийм бэрхшээлтэй нөхцөл байдлын үед энэ ажлыг дуусгана гэдэг үнэхээр өнөө үеийн гайхамшиг юм. Албан ёсны боловсрол нимгэн Иосеф Смит үнэндээ хоёр сар гаруйхан хугацаагаар ажиллаж, орчуулгыг хэлж бичүүлэн нэн цөөхөн засвар оруулсан ажээ. Өнөөдөр уг ном үндсэндээ түүний орчуулсан тэр байдлаараа үлдэж, дэлхий даяарх сая сая хүмүүсийн хувьд гэрчлэлийнх нь эх сурвалж болсоор байна. Иосеф Смит хожмын өдрүүдийн Гэгээнтнүүдийн адислалын төлөө эртний бошиглогчдын үгсийг гаргаж авчрахад Их Эзэний мутар дахь хүчирхэг зэмсэг болж байлаа.

Мормоны Номын Гэрчүүд

Оливер Каудери, Давид Витмер, Мартин Харрис нар бол алтан ялтсуудыг тэдэнд үзүүлэхээр зөвшөөрөгдөх гурван онцгой гэрч байх болно гэдгийг Бошиглогч Иосеф Смитийг Фейттед байх үед Их Эзэн илчилжээ. (2 Нифай 27:12; Ифэр 5:2-4; С ба Г 17-г үз). Тэд Иосефийн хамт энэхүү эртний цэдгийн гарал үүсэл хийгээд үнэнийг гэрчлэх боломжтой болсон билээ.

“Бид ойролцоох ой руу хүрч очоод тайрдсан дээр сууж, хэсэгхэн хугацаанд ярилцав. Тэгээд бид өвдөг сөгдөн залбир-

сан. Иосеф залбирав. Тэгээд бид босч, тайрдсан дээр суугаад ярилцаж байтал гэнэт бидний дээрээс нэг гэрэл доош бууж ирэн тэр орчинд багахаан газарт биднийг хүрээлэв; тэгтэл нэг тэнгэр элч бидний өмнө зогсож байв” гэж Давид Витмер тайлбарласан байдаг. Энэ тэнгэр элч бол Моронай байсан юм. “Тэр цагаан хувцастай байсан, мөн ярьж, намайг нэрээр минь дуудан ‘Түүний зарлигуудыг сахидаг хүн адислагддаг болой’ гэж хэлсэн хэмээн Давид хэлжээ. Бидний өмнө ширээ тавьж, түүн дээр ялтсуудыг тавьсан байлаа. Мормоны Ном үүнээс орчуулагдсан Нифайчуудын Цэдгүүд, гуулин ялтсууд, Зүг Чиг Заагч Бөмбөрцөг, Лэбэний илд болон бусад ялтсуудын хамт байв.”⁵ Эрчүүд эдгээр зүйлүүдийг үзэж байх зуураа: “Эдгээр ялтсууд Бурханы хүчээр илчлэгдсэн юм, мөн эдгээр нь Бурханы хүчээр орчуулагдсан. Та нарын харсан эдгээрийн орчуулга зөв юм, тиймээс эдүгээ өөрсдийн харсан, мөн сонсон зүйлүүдээ гэрчлэхийг би та нарт зарлиглаж байна”⁶ гэж хэлэх дуу хоолойг тэд сонсов.

Энэ үйл явдлын дараа удалгүй Иосеф Смит ялтсуудыг Нью-Йоркийн Манчестер дахь Смитийн гэр бүлийн ойролцоо олны хөлнөөс зайдуухан нэг газарт тэдгээрийг гараараа барьж үзсэн өөр найман гэрчид үзүүлсэн билээ. Энэ хоёр бүлэг гэрчийн гэрчлэлүүд Мормоны Номын эхэнд цэдэглэгдсэн байдаг.

Мормоны Номоор Номлох нь

Орчуулгын ажил дуусахад Бошиглогч Мормоны Номыг хэлүүлэхээр Палмирагийн Эгберт Б.Грандинтай хэлэлцээ хийв. Мартин Харрис 5000 хувь ном хэвлүүлэхэд 3000 америк доллар төлөхөөр баталгаа гаргаж Ноён Грандинтай барьцаат гэрээ байгуулжээ.

Мормоны Номын анхны хувиуд 1830 оны Гуравдугаар сарын 26-нд Э.Б.Грандины Номын Дэлгүүрт олон нийтэд зориулагдан бэлэн болсон ажээ. Шинээр хэвлэгдсэн ботийг ашигласан анхны номлогч нарын дунд Самуел Смит байлаа. 1830 оны Дөрөвдүгээр сард тэрээр Нью-Йоркийн Мендон

хотхоны Томлинсоны Дэн Буудалд очжээ. Тэнд тэр нэг номыг Бригам Янгийн ах Файнас Янг нэртэй нэг залуу хүнд худалдсан байна.

Зургадугаар сард тэр ирсэн замаараа буцаж явжээ, энэ удаад Нью-Йоркийн Блумфиелд дахь Жон П.Грейний гэрт нэг Мормоны Ном орхижээ. Жон нь Бригам Янгийн эгч Рода Янгтай гэрлэсэн. Бригамын аав Жон Янг дараа нь номны сургаар ирж, уг номыг гэртээ аваачин, дуустал уншсан аж. “Энэ бол хамгийн агуу бүтээл бөгөөд Библи ч хүлээхээргүй түүний үзсэн аливаа алдаа мэдгээс хамгийн цэвэр нь байлаа” гэж тэр хэлжээ.

Хэдийгээр Бригам Янг 1830 оны хавраас хойш гэр бүлийн гишүүд хийгээд номлогч нар аль алинаар нь уг номын агуулгатай танилцуулагдсан ч гэсэн, үүнийг бүх талаас нь судалж үзэх цаг түүнд хэрэгтэй байлаа. “Энэ номыг хүлээж авах шийдвэр гаргахаасаа өмнө би уг асуудлыг хоёр жил хичээнгүйлэн нягталж үзэв. Би ном үнэн гэдгийг мэдэж байлаа. Мөн түүнчлэн би нүдээрээ харах, эсвэл хуруугаараа тэмтэрч, эсвэл мэдрэхүйн эрхтнүүдээрээ бүгдээр нь мэдэрч болохыг мэдэж байв. Энэхүү тохиолдол байгаагүй бол би энэ өдөр үүнд итгээд зогсож байж хэзээ ч чадахгүй байх байсан биз ээ. . . . Би өөрийнхөө хувьд бүх зүйлийг нотлох хангалттай цаг хугацааг хүсч байлаа”⁸ хэмээн тэрээр тэмдэглэжээ.

1832 оны Дөрөвдүгээр сарын 14-нд Бригам Янг баптисм хүртжээ. Түүний баптисм болон гишүүний баталгааны дараа тэрээр дурсан санахдаа, “Аврагчийн үгсийн дагуу миний нүглүүд өөршөөгдсөнийг надад гэрчлэх, даруухан, хүүхдийнх лугаа адил сүнсийг би мэдэрсэн”⁹ гэжээ. Хожим нь тэрээр Төлөөлөгч болж, улмаар Сүмийн хоёр дахь Ерөнхийлөгч болсон билээ.

Аароны болон Мелкизедек Санваарууд Сэргээгдсэн нь


Тэнгэр элч Моронай 1823 оны Есдүгээр сард Кумора гүвээн дээр Иосеф Смиттэй анх удаа уулзахдаа, дэлхий дээр санваарын эрх мэдлийг сэргээх чухал зааврууд,

түүний дотор: “[Алтан ялтсууд] хөрвүүлэгдсэн үед *Их Эзэн зарим хүмүүст ариун санваар хүртээх болно*, ингээд тэд энэ сайн мэдээг тунхаглаж, усаар баптисм хүртээж эхлэх болно; мөн үүний дараа гар тавилтаар Ариун Сүнс өгөх хүч тэдэнд байх болно”¹⁰ гэсэн тунхаглалыг өгсөн ажээ.

1829 оны хавар Иосеф тэнгэр элчийн үгсийн зарим бие-лэлтэд оролцов. Оливер Каудери тэр хоёр Мормоны Номыг орчуулж байхдаа нүглүүдийн ангижралын төлөөх баптисмын тухай дурдсаныг олж үзжээ. Тавдугаар сарын 15-нд тэд энэ асуудлаар Их Эзэнээс цаашдын мэдлэгийг залбиралд эрэлхийлжээ. Сасквиеханна голын эрэг дээр өөрсдийн хүсэлтийг өргөж байх үеэр, энэ хоёр дээр нэг тэнгэрлэг элч хүрч ирсэн аж. Тэрээр өөрийгөө Шинэ Гэрээний үеийн Иохан Баптист хэмээн танилцуулав. Тэрээр Иосеф, Оливер хоёрын тэргүүн дээр гараа тавьж, хэлсэн нь, “Миний нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр, тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын төлөө усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгагч Аароны Санваарыг хүртээж байна” (С ба Г 13:1).

Энэхүү томилолтын дараа Иосеф, Оливер хоёр Иохан Баптистын зарлигласны дагуу бие биендээ баптисм хүртээж, мөн бие биенээ Аароны Санваарт томилов. “Аароны энэхүү Санваар бол Ариун Сүнсний бэлгийн төлөөх гар тавилтын хүч биш, харин энэ нь хожим бидэнд хүртээгдэх болно” гэж Иохан тэдэнд хэлжээ. “Цаг нь болохоор бидэнд хүртээгдэх Санваар болох Мелкизедек Санваарын түлхүүрүүдийг атгадаг Петр, Иаков, Иохан нарын удирдлага дор тэрээр ажиллалаа” хэмээн тэрээр бас хэлжээ (Иосеф Смитийн—Түүх 1:70, 72; мөн 1:68–72-ыг үз).

Бошиглогч энэ туршлагын тухай: “Бид баптисм хүртсэний дараа уснаас гарч ирсэн тэр даруйд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ агуу хийгээд алдар суут адислалуудыг мэдрэв. Бибээр Оливер Каудерид баптисм хүртээж мөн Ариун Сүнс түүн дээр ирээд тун удаагүй байхад мөн тэрээр босч, удахгүй тохиохоор ирэх



Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр хүрч ирэн, тэдэнд Мелкизедек Санваар хүртээж байгаа нь.

ёстой олон зүйлийг бошиглов. Мөн дахин бибээр түүгээр баптисм дөнгөж хүртээгдмэгц, бас бошиглолын сүнстэй болж, босоод энэ Сүмийн өсөн мандалт хийгээд Сүмтэй холбоотой бусад олон зүйлийн талаар түүнчлэн хүмүүний үрсийн энэ үеийнхний талаар бошиглов. Бид Ариун Сүнсээр дүүрч, бас авралынхаа төлөө Бурханд баясав” хэмээн өгүүлжээ (JS—Н 1:73).

Хожим нь Петр, Иаков, Иохан нар Иосеф, Оливер хоёр дээр хүрч ирэн Мелкизедек Санваарыг тэдэнд хүртээв. Тэд бас Бурханы хаант улсын түлхүүрүүдийг тэр хоёрт олгожээ (С ба Г 27:12–13; 128:20-ийг үз). Мелкизедек Санваар бол дэлхий дээр хүмүүнд өгөгдсөн хамгийн дээд эрх мэдэл мөн. Энэхүү эрх мэдлээр Бошиглогч Иосеф Смит энэ эрин үед Есүс Христийн Сүмийг зохион байгуулах боломжтой болж, өнөөдөр Сүмд байгаа санваарын янз бүрийн чуулгуудыг үүсгэн байгуулж эхэлсэн юм.

Сүмийг Зохион Байгуулсан нь

1830 оны Дөрөвдүгээр сарын 6 бол энэ эрин үед Есүс Христийн Сүм зохион байгуулагдах тэрхүү өдөр мөн гэдгийг Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн юм (С ба Г 20:1-ийг үз). Итгэгчид хийгээд найз нартаа мэдэгдлүүд явуулахад 56 эрэгтэй, эмэгтэй хүмүүс Нью-Йоркийн Фейеттед Ахмад Петр Витмерийн дүнзэн байшинд цуглав. “Манай орны хуулиудад нийцүүлэн, Бурханы хүсэл зориг хийгээд зарлигуудаар” (С ба Г 20:1) бий болсон байгууллагад туслахын тулд зургаан эрэгтэй хүнийг Бошиглогч сонгов.

“Бидний Тэнгэрлэг Эцэгт хандсан хүндэтгэлийн залбирлаар цуглааныг нээгээд бид үргэлжлүүлэн өмнөх зарлигийн дагуу, ах нар маань биднийг Бурханы Хаант улсын зүйлүүд дэх өөрсдийн багш нар хэмээн хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг, мөн бид цааш үргэлжлүүлэх ёстой, бидний хүлээн авсан, өмнө дурдагдсан зарлигийн дагуу Сүм болж зохион байгуулагдахад тэд сэтгэл ханамжтай байгаа эсэхийг мэдэхийн тулд ах нарыг дуудсан билээ. Эдгээр хэд хэдэн мэдэгд-

лийг тэд санал нэгтгэйгээр дэмжив”¹¹ хэмээн бошиглогч тэмдэглэжээ.

Оролцсон хүмүүсийн дэмжлэгтэйгээр, мөн тэд Их Эзэнээр чиглүүлэгдсэний дагуу Иосеф Оливерийг Сүмийн ахлагчаар томилж, мөн Оливер Бошиглогчийг ахлагчаар томилов. Ариун ёслолыг адисалж, ирсэн гишүүдэд түгээв. Баптисм хүртсэн гишүүд гишүүнээр батлагдаж, тэдэнд Ариун Сүнс өгөв. “Ариун Сүнс бидэн дээр үлэмж ихээр юүлэгдэв—бид бүгдээрээ Их Эзэнийг магтахад зарим нь бошиглож, тэгээд үлэмж ихээр баясав”¹² хэмээн Бошиглогч хэлжээ. Бошиглогчийн үгст, тэдгэрийг Их Эзэнээс өөрөөс нь ирсэн гэж үзэн анхаарал хандуулахад Сүмийг зааварласан илчлэлтийг энэ цуглааны үеэр Иосеф хүлээн авсан юм (С ба Г 21:4–6-г үз).

1830 онд тэр цуглаан дээр байсан элементүүд: нийтийн дэмжлэгийн хуулийг хэрэглэх, дуулах, залбирах, ариун ёслолоос хүртэх, хувийн гэрчлэлээ хуваалцах, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг өгөх, томилолтууд, хувийн илчлэлт болон санваарын ажилтнуудаар дамжсан илчлэлт өнөөдөр Сүмд үргэлжилж байгаа болно.

Бошиглогчийн эцэг, ахмад Иосеф Смит баптисм хүртсэн тэр өдөр болсон сэтгэл хөдлөм үйл явдлыг Иосефийн эх Люси Мак Смит: “Ноён Смитийг уснаас гарч ирэхэд, Иосеф эрэг дээр зогсож байв, тэгээд тэрээр аавынхаа гараас барьж, баярын нулимс цийлэлзүүлэн, ‘Есүс Христийн үнэн Сүмд аав минь баптисм хүртэхийг харах хүртэл амьдарсны минь төлөө Бурханыг минь магт!’ хэмээн уулга алджээ”¹³ гэж тэмдэглэсэн байдаг. Тэрхүү мөчийн тухай Ахмад Жозеф Найт: “[Бошиглогч] Сүнсээр агуу их хэмжээгээр дүүрсэн байлаа. . . . Түүний баяр баясгалан дүүрэн байгаа юм шиг харагдаж байв. Тэрээр өөрийн эхэлсэн, мөн үүнийг үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа тэрхүү агуу ажлыг тэр харсан гэж би оддог”¹⁴ гэж хэлжээ.

Эцэг хүү хоёрын хооронд хайрын хүчирхэг холбоос байлаа. Хожим нь Бошиглогч эцэгтээ өргөх магтаал болгон, “Би аавыгаа бас түүний дурсамжийг хайрладаг; түүнчлэн

түүний эрхэм сайхан үйл хэргийн дурсамж оюун бодолд минь ямагт байдаг, мөн надад хэлдэг түүний эелдэг хийгээд эцгийн үгс зүрх сэтгэлийн минь гүнд бичигдсэн юм”¹⁵ гэж хэлсэн байдаг.

Бошиглогч, түүний эцгийн хоорондох хайрыг Ахмад Иосеф Смит өөрийн эцэг Асаел Смитэд мөн харуулсан байдаг. 1830 оны Наймдугаар сард Ахмад Иосеф Смит, эцэг эх болон ах эгч дүү нартаа өгөхийн тулд Мормоны Номын хувиудыг Нью-Йоркийн Сейнт Лоренс Гүлнлэг рүү зүүн өмнө зүг рүү авч очжээ. Асаел Смит 1830 оны Аравдугаар сард бараг л нас барахынхаа өмнөхөн уг номыг уншиж дуусаад, “эрт үеэс нэрд гарсан яг тэр Бошиглогч түүний гэр бүлд хүрч иржээ”¹⁶ гэж ач хүү Бага Иосеф Смитийгээ хүлээн зөвшөөрчээ. Асаелын өөр гурван хүү—Силас, Жон, Бага Асаел нар эцэст нь Сүмд нэгдсэн ажээ. Түүний шууд гэр бүлийнхэн, түүнчлэн түүний эцгийн гэр бүлээс олон хүн баптисмын усанд умбуулагдсаныг харах онцгой боломж Бошиглогчид тохиосон билээ.

Хожим нь Тэргүүн Зөвлөлийн гишүүн болсон Сидней Ригдон Сүмийн даруухан эхлэлүүдийн тухай түүнчлэн бүр тэр үед зохион байгуулагчдад байсан ирээдүйн талаарх агуу үзэгдлийн тухай: “Нью-Йоркийн Ватерлоогийн ойролцоо 20 фут орчим талбайтай, жижигхэн хуучин дүнзэн байшинд би Христийн бүрэн сүмтэй танилцаж, тэгээд дэлхий бидний захиргаанд байгаа юм шигээр бид Бурханы хаант улсын тухай ярилцаж эхлэв; хэдийгээр бид олон хүмүүс байгаагүй ч гэсэн, . . . агуу итгэлтэйгээр ярьж байв; . . . бид мянга дахин илүү том Бурханы сүмийг; . . . бошиглогчдын гэрчлэлийг бүхэлдээ үл тоомсорлогч, Бурханы хийх гэж байгаа ажлын тухай мэдлэггүй дэлхийг үзэгдлээр харж байлаа”¹⁷ хэмээн өгүүлжээ.

1830 оны Дөрөвдүгээр сарын 6-нд баруун Нью-Йоркд болсон үйл явдал сая сая хүмүүсийн амьдралыг өөрчилсөн юм. Жижигхэн дүнзэн байшин дахь цөөн тооны хөрвөгчдөөс сайн мэдээ дэлхий даяар тархаад байна. Эдүгээ Сүм олон

газар нутагт, анх Фейеттед үүнийг зохион байгуулсан хүмүүсийнх шиг тийм даруухан нөхцөлд ихэнхдээ үндэслэгдэн байгуулагдаад байна. Дэлхий даяарх Гэгээнтнүүд баясаж: “Хоёр буюу гурваараа миний нэрээр цугласан тэнд, . . . болгоогтун, би тэдний дунд байх болно” (С ба Г 6:32) гэсэн Аврагчийн амлалтад тайвшралыг олдог билээ.

“Огайо Уруу Яв”: Хожмын Үеийн Израилын Цугларалт

Колесвилл дахь Хавчлага

Сүм зохион байгуулагдсан яг тэр сард Бошиглогч Иосеф Смит, Нью-Йоркийн Колесвиллд оршин сууж байсан өөрийн найз нар Бага Жозеф Найтын гэр бүлд заахаар номлолд явжээ. Зургадугаар сарын 28-нд Найтын гэр бүлийн ихэнх гишүүд болон найз нар нь баптисмын гэрээ хийхэд бэлтгэгдсэн байлаа.

Колесвиллд сайн мэдээг номлохыг хүчтэй эсэргүүцэж байв, тиймээс ус тогтоон хадгалах зорилгоор ах нарын барьсан даланг нураах замаар танхайрагч бүлэг баптисмуудыг зогсоох гэж оролдов. Гэсэн хэдий ч, даланг удалгүй засварласан байна. Итгэлийн дайснуудын хийсэн зүйлийг Бага Жозеф Найт дүрслэхдээ: “Бид [баптисмаас] гарч явахдаа, бидэн рүү зааж, хонь угаав уу гэж биднээс асууж байсан, хөршүүдийнхээ олонтой нь тааралдлаа. . . . Тэр шөнө манай мухлаг тэргүүдийг хөмөрч хаян, дээр нь мод овоолж, заримыг нь усанд живүүлж, хашааны модыг хаалган дээр овоолон, тэрэг хөллөдөг цулбууруудыг горхинд хаяж, үлэмж их хор хөнөөл учруулсан байв”¹⁸ гэжээ.

Мөн энэ үед эсэргүүцэгчид Бошиглогчийг баривчлуулж, амар амгаланг бусниулах замаар түүний анхаарлыг сарниулах гэж оролдож байв. Гэсэн хэдий ч, түүнийг ямар ч ялгүй болохыг тогтоосон хуульчдыг Ахмад Жозеф Найт хөлсөлжээ.

Сүм хаана чухал амжилт олно, бүх зөв шударгын дайсан тэнд Бурханы хаант улсын өсөлтийг зогсоохын тулд улайрсан оролдлого хийж байлаа. Гэвч бүхнээ зориулсан Бурханы Гэгээнтнүүд асуудлуудыг даван туулж, улам хүчирхэгжин,

Колесвиллын Гэгээнтнүүдийн хийсний нэгэн адил өөрсдийгөө хүчирхэг, нэгдмэл салбарт нэгтгэж байв.

Номлогч нар Индианчууд уруу

1830 оны Ес, Аравдугаар сард дөрвөн залуу эрэгтэй Мормоны Номын хүмүүсийн үр удам—Америкийн Индианчуудад сайн мэдээ болон Мормоны Номын захиасыг хүргэхийн тулд илчлэлтээр дуудагджээ. Эдгээр номлогч нар нь Оливер Каудери, Бага Петр Витмер, Парли П.Пратт, Зиб Петерсен нар байв (С ба Г 28:8; 30:5–6; 32-ыг үз). Тэд маш хэцүү нөхцөлд олон зуун миль газар аялж, Нью-Йоркийн Буффалогийн ойролцоох Катерогусын Индианчууд, Огайогийн Веяндотсынханд мөн эцэст нь Миссури муж улсын баруунтаа амьдарч байсан Делаварегийнханд номлох боломж олджээ. Гэвч тэд зэргэлдээх Огайогийн Көртландын оршин суугчдын хувьд хамгийн их амжилт олж, тэд тэнд 127 хүнийг хөрвүүлжээ. Номлогч нарыг явсны дараа, энд үлдсэн гишүүдийн номлолын үр дүнд Огайодахь Гэгээнтнүүдийн тоо удалгүй хэдэн зууд хүрчээ.

Огайод Цугларах Дуудлага

Тохинуулагч асан, Көртландын бүсээс шинээр хөрвөгдсөн гишүүн Сидней Ригдон, тэрчлэн Эдвард Партриж нэртэй гишүүн бус найз нь Бошиглогчтой уулзаж, Сүмийн заадаг зүйлүүдийн талаар илүү ихийг мэдэхийг ихэд хүсч байв. 1830 оны Арванхоёрдугаар сард тэд Иосеф Смитэд зочлохын тулд Нью-Йоркийн Фейетте уруу 250 миль гаруй газар аялав. Тэд өөрсдөдөө болон Көртландын Гэгээнтнүүдэд Их Эзэний хүсэл зоригийн хамаарлыг эрэлхийлэхийг түүнээс хүсчээ. Их Эзэн хариуд нь Нью-Йоркийн Гэгээнтнүүд “Огайод хамтдаа цуглах” ёстойг илчлэв (С ба Г 37:3). 1831 оны Нэгдүгээр сарын 2-нд Витмерийн фермд болсон Нью-Йорк дахь сүүлчийн болоод Сүмийн гурав дахь чуулган дээр Их Эзэн гишүүдэд өгөх өөрийн удирдамжийг давтан өгүүлжээ:

“Мөн та нар дайсны хүчнээс зугтааж, мөн толбогүй хийгээд буруугүй зөв шударга хүмүүс болж надад цугларч болохын

тулд буюу—Иймийн тул, энэ шалтгааны учир та нар Огайо уруу явах ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна; мөн тэнд би та нарт өөрийн хуулийг өгөх болно; мөн тэнд та нар тэнгэрийн хүчээр хишиг хүртэх болно” (С ба Г 38:31–32). Энэ бол энэ эрин үед Гэгээнтнүүдийг хамтдаа цуглахыг дуудсан анхны дуудлага байв.

Цөөхөн гишүүд өмч хөрөнгөнөөсөө салахгүй байх түүнчлэн Нью-Йоркоос Огайо уруу урт аян хийхгүй байхаар сонгосон бол, Гэгээнтнүүдийн олонх нь Израилыг цуглуулах Хоньчны дуу хоолойг сонссон ажээ. Ньюел Найт бол санваартны удирдлагыг дагаж доорх дуудлагад хариулсан шавь нарын төлөөлөгч юм:

“Чуулганаас гэртээ эргэж ирээд миний бие Колесвилл Салбарын хамт, өгөгдсөн зарлигт дуулгавартай байж, Огайо уруу явах бэлтгэлээ базааж эхлэв. . . . Ингэхээс өөр замгүй байснаас, бид өмч хөрөнгийнхөө хувьд их золиослол хийх үүрэгтэй болсон юм. Бид нэг хамтлаг болж цугтаа аялаж болохын тулд миний ихэнх цаг ах нартай очиж уулзан, ажил хэргээ зохицуулахад нь туслахад зориулагдаж байв.”¹⁹

Ахмад Жозеф Найт бол Огайод Бошиглогчтой нэгдэхийн тулд өмч хөрөнгөө зарж золиослол хийхэд бэлэн байсан хүмүүсийн бас нэг жишээ юм. *Broome Republican* сонинд фермээ зарах тухай өгсөн түүний зарлал сайн мэдээнд тэрээр шийдвэр төгс байсан талаар ихийг өгүүлдэг: “Эдүгээ Жозеф Найтын эзэмшиж байгаа ферм Колесвиллийн Гүүрний дэргэд Колесвилл хотхонд—Сасквиеханна Голын хажууд хил залган оршдог бөгөөд нэг зуун дөчин хоёр акр хэмжээтэй. Энд дурдсан ферм нь Сууцны хоёр байшин, нэг сайн саравч бас Жимсний сайхан цэцэрлэг юм. *Худалдах нөхцөл нь худалдан авагчид нэн тааламжтай байх болно*”²⁰. 1831 оны Дөрөвдүгээр сарын дундуур гэхэд Колесвиллээс 68 гишүүн Огайо уруух замдаа гарсан байлаа.

1831 оны Тавдугаар сарын эхээр Фейетте Салбарын 80 Гэгээнтэн, Манчестер Салбарын 50 гишүүн Их Эзэний зарлигт эн тэнцүү дуулгавартай байж, гэр орноо орхижээ.

Бошиглогчийн ээж Люси Мак Смитээс Фейеттегийн гишүүдийн дүрвэлтийг хариуцахыг хүссэн ажээ. Тэднийг Нью-Йоркийн Буффалод ирэхэд Эрие Нуурын боомт мөсөөр хучигдан битүүрсэн байв, иймээс Фейеттегийн Гэгээнтнүүдийг авч явсан уурын хөлөг онгоц боомтоос хөдлөх боломжгүй байв. Энэхүү хүнд нөхцөлд Люси Мак Смит : “Ах эгч нар аа, хэрэв одоо та нар бүгдээрээ өөрсдийн хүслийг тэнгэрт өргөх юм бол, мөс хагарч, тэгээд Их Эзэн амьдардаг нь баттай адил бид чөлөөтэй болж, энэ нь гүйцэлдэх болно” хэмээн итгэлээ хэрэглэхийг гишүүдэд уриалсан ажээ. Яг энэ мөчид “тэнгэр дуугарах шиг” дуу сонсогдов. Мөс хагарч дундуур нь нарийхан завсар гарсанд хөлөг онгоц түүгээр нэвтрэн гарчээ. Зурвас зам дахин хаагдахад тэд дөнгөж түүгээр нэвтэрч амжсан болохоор тэд задгай усанд гарч аянаа үргэлжлүүлж чадсан ажээ. Ийнхүү гайхамшигтайгаар амжиж гарсны дараа түүний нигүүлслийн төлөө өөрсдийн нэрийн өмнөөс Бурханд талархал өргөх залбирлын цуглаанд хамтлаг цугтаа дуудагджээ.²¹

Тавдугаар сарын дунд үе гэхэд Нью-Йоркийн Сүмийн бүх салбар Эрие Нуураар дамжин Огайогийн Файрпорт Боомт хүртэл аялах боломжтой болж, тэнд тэднийг Гэгээнтэн нөхөд нь тосч аван, хүрэх газар—Көртланд болон Томпсон хотхонд хүргэж өгөв. Хожмын үеийн Израилын агуу цугларалт эхлэв. Эдүгээ Гэгээнтнүүд нэгэн бүлэг болж Их Эзэний сонгогдсон үйлчлэгчдээр заалгуулах, түүний хуулиудад зааварлагдах, түүнчлэн ариун сүмүүдийг барих байр сууринд байлаа.

Огайогийн Көртландад Хаант Улсыг Байгуулсан нь

Бошиглогч Огайод Ирсэн нь

1831 оны хоёрдугаар сарын нэгэн хүйтэн өдөр Бошиглогч Иосеф Смит, тэгэхэд ихэр хүүхэд тээсэн жирэмсэн болоод зургаан сар болж байсан түүний гэргий Эмма нар Нью-Йоркоос Огайогийн Көртланд хүртэл 250 милийн аянаа дуусгаад байлаа. Тэд Гилберт ба Витнейн дэлгүүрт чаргаар хүрч иржээ. Дараах ишлэлд Ньюел К.Витней Бошиглогчтой танилцсан тухай тэмдэглэжээ:

“[Чарган дээрх] хүмүүсийн нэг нь, нас залуу бөгөөд тууштай, шулуун шударга байрын нэг хүн бууж ирээд довжоо өөд харайн гарч, залуу түншийн зогсож байсан дэлгүүрт орж ирэв.

“ ‘Ньюел К.Витней! Та тэр хүн мөн үү!’ гэж тэрээр дуу алдаад, уриалгахнаар гараа дэлгэн, хуучны танил хүнтэй уулзаж буй мэт хэллээ.

“ ‘Та надаас илүү авхаалжтай хүн юм’ гэж түүний хандсан хүн хариулаад, сунгасан гарыг зөнгөөрөө бариад . . . — ‘Та намайг нэрээр хэлсэн байтал, би таныг нэрээр чинь дуудаж чадахгүй л байна шүү.’

“ ‘Би Иосеф, Бошиглогч’ гэж ирсэн хүн хэлээд, инээмсэглэж, ‘Та энд миний төлөө залбирчээ; одоо та надаас юу хийхийг хүсэх бол?’ ”¹ гэв.

Хэсэг хугацааны өмнө Ньюел түүний гэргий Элизабет хоёр удирдамжийн төлөө шаргуу залбирал хийсэн байжээ. Хариуд нь, Ариун Сүнс тэдэн дээр бууж ирэн, тэдний байшинг үүл сүүдэрлэсэн аж. Үүлнээс нэгэн дуу хоолой, “Их Эзэний үгийг хүлээж авахад бэлтгэ, учир нь үг ирж байна!” хэмээн өгүүлсэн



Көртландын Ариун Сүм

ажээ.² Түүнээс хойш удалгүй, Индианчуудад заахаар дуудагдсан номлогч нар Көртландад иржээ, харин одоо Бошиглогч хүрч ирсэн байв.

Ньюелийн ач хүү Оорсон Ф.Витней энэ үйл явдлын талаарх мэдрэмжүүдээ хожим нь өгүүлэхдээ: “Махан бодид өмнө хэзээ ч хараагүй хүнийг, энэхүү гайхамшигт хүн Иосеф Смит ямар хүчээр таньсан юм бол? Яагаад Ньюел К.Витней түүнийг таньсангүй вэ? Энэ бол Иосеф Смит үзмэрч, сонгогдсон үзмэрч байсных; хэрэг дээрээ бол тэрээр өвдөг сөгдсөн Ньюел К.Витней, өөрийг нь Көртландад ирэхийн төлөө залбирч байхыг хэдэн зуун милийн цаанаас харсан хэрэг. Гайхамшигтай—гэвч үнэн юм!”³ гэжээ.

Бошиглогч ирсэн нь Сүмийн олон чухал элемент зохих ёсоороо бий болсон Көртландад Их Эзэний үгийг авчирсан юм. Сүмийн удирдлагын үндсэн зохион байгуулалт илчлэгдэж, номлогч нар гадагш илгээгдэн, анхны ариун сүм баригдаж, бас олон чухал илчлэлт хүлээн авагдсан билээ. Итгэл, эр зориг хийгээд Их Эзэний тослогдсон бошиглогчийг дагахад бэлэн байгаа эсэхээ харуулахын тулд Гэгээнтнүүд хүнд бэрхээр хавчигдаж мөн соригдсон юм.

Сүмийн Үйл Ажиллагааны Хоёр Төв

Мөн энэ үед Гэгээнтнүүд Огайод цуглахаар дуудагдсан байлаа, тэд Сионыг үндэслэн байгуулж болох цагийг хүсэн хүлээж эхлэв. 1831 оны Зургадугаар сард Бошиглогч Иосеф Смит, түүнийг өөрийг нь, Сидней Ригдон болон бусад 28 ахлагчийг шашиндаа элсүүлэх номлолоор Миссури уруу явахад мөн тэнд Сүмийн дараагийн чуулганыг хийхэд чиглүүлсэн илчлэлт хүлээн авчээ (С ба Г 52-ыг үз). Тэр үед Миссури Көртландаас баруун зүгт 1 000 гаруй мильд орших Америкийн Нэгдсэн Улсын баруун хил дээр байлаа. Миссурийн Жэксон Гүнлэгт Гэгээнтнүүд өөрсдийн өвийг хүлээн авч, Сионыг үндэслэн байгуулж болохыг Их Эзэн Иосефт илчилжээ.

1831 оны зуны туршид Гэгээнтнүүдийн нийт бүлэг Нью-Йоркийн Колесвиллээс Жэксон Гүнлэг рүү шилжин ирснээс хойш удалгүй Иосеф, бусад номлогч нар суурин газар байгуулж эхлэв. Бошиглогч болон бусад удирдагчид Көртландад эргэж ирэх үед Сүмийн олон гишүүд Миссурид суурьшсан байв.

1831–1838 оны хооронд хүн ам суурьшсан хоёр төв Сүмд байлаа. Иосеф Смит, Арванхоёрын Зөвлөлийн гишүүд болон Огайогийн Көртландын бүсэд асар олон тооны Гэгээнтнүүд амьдарч байсан бол, санваарын томилогдсон удирдагчдын тэргүүлсэн Сүмийн бусад олон гишүүд Миссурид амьдарч байв. Мөн энэ үед энэ хоёр газрын аль алинд нь чухал үйл явдлууд болж, шаардлага гарсан үед Сүмийн ажилтнууд нэг газраас нөгөө рүү аялж байв. Долоон жилийн хугацаанд Көртландад болсон үйл явдлуудыг эхлээд авч үзэн, дараа нь мөн энэ үед Миссурид болсон үйл явдлуудыг авч үзье.

Огайод Цугларахад Гэгээнтнүүдийн Хийсэн Золиослолууд

Огайод ирсэн Гэгээнтнүүдээс олон нь агуу золиослолууд хийсэн юм. Зарим хүмүүс гэрийнхэндээ ад үзэгдэж; бусад нь найз наргүй болов. Цуглар гэсэн Бошиглогчийн дуудлагад хариулахын тулд хэрхэн золислол хийсэн тухайгаа Бригам Янг дүрслэхдээ:

“Биднийг Көртландад ирэхэд [1833 оны Есдүгээр сард], хэрэв Гэгээнтнүүдтэй хамт хэн нэгэн хүн цугласан бол надаас илүү ядуу нэгэн биш байсан биз—учир юун гэвэл түүнд юу ч байгаагүй юм. . . . Халамжлах ёстой хоёр хүүхэд л надад байв—бүх юм нь тэр. Би бэлэвсэн байлаа. ‘Бригам Ах аа, танд гутал байсан уу?’ Байхгүй ээ; хүнээс гуйж авсан түрийтэй гутлаас өөр хөлд углах юм надад байгаагүй. Гурав, дөрвөн жил өмссөн гар хийцийн хүрэмнээс өөр өвлийн хувцас надад байсангүй. ‘Ямар нэгэн өмд?’ Байхгүй ээ. ‘Та тэгээд яасан бэ? Өмдгүй явсан хэрэг үү?’ Үгүй ээ; Би өөр өмдтэй болтлоо нэг өмд хүнээс гуйж авсан юм. Би аялж, номлон тэгээд өмчийнхөө доллар бүрийг дуусгасан. Би номлож эхлэхдээ ялиггүйхэн үнэ хүрэх өмчтэй байлаа. . . . Авч

явах юм юу ч үгүй болох хүртлээ би аялж, номлосон л доо; гэвч Иосеф: ‘наашаа ир’ гэж хэлэв; тэгээд чадах хамгийн сайн зүйлээ хийж би тийшээ очсон юм.”⁴

Гишүүд тэднийг аль хэдийн баяртай хүлээн авч өөрсдийн хомсхон эд хөрөнгөнөөсөө хуваалцахад бэлэн байсан Көртландад, итгэлтэй бусад олон Гэгээнтнүүд ирсэн юм. Ийм шулуун шударга хүмүүс Сүмийн гайхалтай өсөлт хөгжилтийн суурийг тавьсан юм.

Көртландын Бүсэд Хүлээн Авсан Илчлэлтүүд

Бошиглогч Иосеф Көртландын бүсэд амьдарч байхдаа үлэмж олон илчлэлт хүлээж авснаас 65 нь Сургаал ба Гэрээнд орсон байна. Халамж, тэмдэг эрэлхийлэх, биеэ авч явах ёс суртахуун, хооллох зарчмууд, аравны нэг, санваарын эрх мэдэл, бошиглогчийн үүрэг, алдар суугийн гурван зэрэглэл, номлогчийн ажил, Хоёр Дахь Ирэлт, зориуллагын хууль болон бусад олон сэдэвт холбогдох Их Эзэний хүсэл зоригийг эдгээр илчлэлтүүд заадаг байв.

Библийн Иосеф Смитийн Орчуулга

1830 оны Зургадугаар сард Иосеф Смит Библийн Хаан Жеймсийн (англи хэл дээрх) Хувилбарт сүнсээр нөлөөлөгдсөн засваруудыг хийх бурханлигаар итгэмжлэл хүлээсэн ажлаа эхэлсэн юм. Энэ ажил Библийн Иосеф Смитийн Орчуулга гэж нэрлэгддэг. 1830 оны Зургадугаар сараас 1833 оны Долдугаар сарын хооронд Бошиглогч Библийн энэхүү бичвэрт, түүний дотор библийн хэлийг залруулах, сургаалуудыг тодотгох түүнчлэн түүхийн хийгээд сургаалын материалыг сэргээхэд үй олон өөрчлөлт хийжээ.

Энэ ажлын явцад, ихэвчлэн тэрээр судрын хэсгүүдийг тунгаан бодоход гарч ирсэн асуултуудын хариу болгож олон илчлэлт хүлээн авчээ. Иосеф, Сидней Ригдон хоёр Иохан 5:29-ийг орчуулж байсан 1832 оны Хоёрдугаар сарын 16-нд ийм нэгэн илчлэлт иржээ. Тэд энэ хэсгийг бясалган байтал, “Их Эзэн [тэдний] ойлголтын мэлмийд хүрч мөн энэ нь

нээгдсэн болой, мөн Их Эзэний алдар суу эргэн тойронд гийж байв” (С ба Г 76:19). Эдүгээ Сургаал ба Гэрээний бүлэг 76-д цэдэглэгдсэн, бүх цаг үеийн агуу үзэгдлүүдийн нэгийг тэд хүлээн авсан ажээ. Тэд Эцэг, Хүү хоёрыг харж, Бурханы хүүхдүүдийн тэнгэрлэг хувь тавилангийн талаар мэдэж аван, алдар суугийн гурван хаант улсыг хэн эзэмших тухай мөнхийн үнэнүүдийг хүлээн авчээ.

Илчлэлтүүдийг Нийтэлсэн нь

1831 оны Арваннэгдүгээр сард Огайогийн Хайрамд болсон тусгай чуулган дээр Сүмийн гишүүд Бошиглогчид өгөгдсөн ойролцоогоор 70 илчлэлийг агуулсан Зарлигуудын Номыг нийтлэхээр санал өгсөн байлаа. Энэ чуулганы үеэр Зарлигуудын Номны өмнөх үг хийгээд хавсралт болох ёстой илчлэлтүүдийг Их Эзэн Иосеф Смитэд өгсөн байна. (Хожим нь эдгээр нь Сургаал ба Гэрээний хэсэг 1 ба 133 болжээ.)

Миссурийн Жэксон Гүнлэгт хэвлэх үйлдвэртэй байсан Виллям В.Фелпст уг номыг хэвлэх ажлыг хариуцуулав. (Зарлигуудын Номны талаарх нэмэлт мэдээллийг хуудас 41-ээс үз.) Зарлигуудын Номон дахь илчлэлтүүд нь бусад илчлэлтүүдийн хамт хожим нь 1835 онд Көртландад хэвлэгдсэн Сургаал ба Гэрээ хэмээх нэртэй ботид хэвлэгдсэн байна. Бошиглогч Иосефийн хийсэн бага сага засвартайгаар Мормоны Номын хоёр дахь хэвлэл бас Көртландад хэвлэгджээ.

Сүм зохион байгуулагдсанаас хойш хэдхэн сарын дараа Их Эзэн ариун дууллуудаас сонголт хийж эхлэхийг Бошиглогчийн гэргий Эммад зарлигласнаар Сүм дэх хөгжмийн чухал байр суурьт онцгой анхаарал хандуулжээ (С ба Г 25:11-ийг үз). Түүний эмхтгэсэн дууллын ном Көртландад нийтлэгдсэн нь : “Учир нь зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно” (С ба Г 25:12) гэсэн Их Эзэний амлагдсан адислалыг хүлээж авах замыг Гэгээнтнүүдэд нээсэн юм.

Бошиглогчдын Сургууль

1832 оны Арванхоёрдугаар сар, 1833 оны Нэгдүгээр сард Бошиглогч Иосеф Сургаал ба Гэрээний хэсэг 88 болсон илчлэлтийг хүлээн авчээ. Энэхүү илчлэлт бусад зүйлүүдийн хамт, ах нарыг сайн мэдээний сургаал болон зарчмууд, Сүмийн ажил хэрэг хийгээд бусад асуудлуудад зааварлахын тулд “бошиглогчдын сургууль” байгуулахад чиглүүлжээ.

1833 оны өвлийн турш Бошиглогчдын Сургууль байнга цуглаж, Иосеф Смит, Эмма Смит хоёр аль аль нь ах нарын тамхи татдаг зуршлын тухайд, ялангуяа цуглаанууд дээр тамхины утаан үүл хөшиглөж,ажилдаг тамхины улмаас ариун цэвэр тааруухан байдагт санаа нь зовж байжээ. Энэ асуудлын талаар Иосеф Смит Их Эзэнээс асууж, Мэргэн Ухааны Үг хэмээн нэрлэгддэг илчлэлийг хүлээн авсан юм. Энэ илчлэлт бие хийгээд сүнсэнд анхаарал халамж тавихын төлөө Их Эзэний зарлигуудыг өгч, эдгээр зарлигуудыг дуулгавартай дагасан хүмүүс “мэргэн ухаан хийгээд мэдлэгүүдийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах” (С ба Г 89:19) сүнслэг адислалуудыг хүлээн авах болно хэмээн амлажээ. Мэргэн Ухааны Үг нь бас тэр үед анагаах ухааны буюу шинжлэх ухааны ертөнцөд мэдэгдээгүй байсан эрүүл мэндийн тухай мэдээллийг агуулсан бөгөөд архи, тамхи хэрэглэхгүй байх зөвлөгөө мэт нь ашиг тустай болохоо тэр үеэс хойш нотлон харуулсаар байгаа билээ.

Өргөлийн Хууль

1831 онд Их Эзэн, хэрэв үүнийг зөв шударга байдалд дагах юм бол, Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн үгүүрсэн ядуу амьдралыг адисалж болох өргөлийн хууль буюу сүнслэг болон түр зуурын тогтолцооны талуудыг илчилж эхэлсэн ажээ. Энэ хуулиар бүх өмч хөрөнгөө Сүмийн бишопт өргөл болгон бүртгүүлэхийг Сүмийн гишүүдээс хүсчээ. Дараа нь тэр өв буюу үүрэг даалгаврыг гишүүдэд буцаан баталгаатай болгож байв. Гэр бүлүүд өөрсдийн

хариуцсан үүрэг даалгавруудыг чадахаараа сайн гүйцэтгэж байлаа. Хэрэв жилийн эцэст тэдэнд илүүдэл байх юм бол үүнийг гачигдалтай хүмүүсийг халамжлахын тулд бишопт өгдөг байв. Эдвард Партриж Сүмийн анхны бишопоор үйлчлэхээр Их Эзэнээр дуудагджээ.

Өргөлийн хууль нь гишүүдийг сүнслэг байдлын хувьд бэхжүүлж, шунахайрал, ядуурлыг арилган, эдийн засгийн хувьд харьцангуй тэгш байдлыг бий болгодог зарчмууд хийгээд дадал зуршлуудаас бүрддэг. Зарим Гэгээнтнүүд үүнийг өөрсдийнхөө болон бусдын адислалуудын төлөө амьдралд сайн хэрэгжүүлж байсан боловч, бусад гишүүд аминч үзлээ даван туулж чадахгүй байсны улмаас эцэстээ уг хуулийг Сүмээс татан авахад хүргэжээ. Өнөөдөр Сүмийн санхүүгийн хууль болон үргэлжилж байгаа аравны нэгийн хуулийг (С ба Г 119-ийг үз) Их Эзэн 1838 онд илчилжээ.

Санваарыг Бэхжүүлэх нь

Санваарын Албан Тушаалууд Илчлэгдэв

Сүм гишүүнчлэлийн хувьд өсөхийн хэрээр Бошиглогч санваарын албан тушаалуудын тухай илчлэлтүүдийг үргэлжлүүлэн хүлээн авсаар байв. Их Эзэнээр чиглүүлэгдсэний дагуу тэрээр Тэргүүн Зөвлөлийг зохион байгуулж, өөрийгөө Ерөнхийлөгч, Сидней Ригдон, Фредерик Г.Виллямс нарыг Зөвлөхүүдээ болгов. Тэрээр бас Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Далын Нэгдүгээр Чуулгыг зохион байгуулав. Тэрээр бишопууд болон тэдний зөвлөхүүд, дээд санваартнууд, патриархууд, дээд зөвлөхүүд, далууд хийгээд ахлагчдыг дуудан томилгов. Тэрээр Сүмийн анхны гадсуудыг зохион байгуулжээ.

Шинээр баптисм хүртсэн, туршлагагүй гишүүд үйлчлэх дуудлагуудаар дарагдах нь олонтаа байлаа. Жишээ нь, Ньюел К.Витней 1831 оны Арванхоёрдугаар сард Көртландад Сүмийн хоёр дахь бишоп болж дуудагдахад, Эдвард Партриж Миссури дахь Гэгээнтнүүдийн бишоп болжээ. Их Эзэн түүнийг бүр илчлэлтээр дуудсаныг Бошиглогч түүнд хэлсэн ч гэсэн Ньюел

уг албан тушаалын шаардлагуудыг биелүүлж чадна гэж бодохгүй байлаа. Тиймээс Бошиглогч, “Явж, Эцэгээс өөрөө асуу” гэж түүнд хэлжээ. Ньюел явж, даруухан залбиралд өвдөг дээрээ сөгдөхөд “Чиний хүч чадал надад буй”⁵ хэмээн тэнгэрээс хэлэх дуу хоолойг сонсов.⁵ Тэрээр дуудлагыг хүлээн авч, бишпоор 18 жил үйлчилсэн ажээ.

Сионы Хуаран дахь Удирдагчдын Сургалт

Хүч чармайлт гарган ажилладаг, туршлагажсан, итгэлтэйгээ нотлон харуулсан, ямар ч нөхцөл байдалд Их Эзэн хийгээд бошиглогчдоо үнэнч хэвээр үлддэг санваартны удирдагчдын хэрэгцээ Сүмд нэн их байлаа. Хүнд нөхцөлд дуулгавартай байж, Бошиглогч Иосеф Смитээр биечлэн сургагдах боломжийг Сионы Хуарангийн аян олгожээ.

Шашны итгэл бишрэлийнхээ улмаас ноцтойгоор мөрдөн хавчигдаж байсан Миссури дахь Гэгээнтнүүдэд туслахын тулд Сионы Хуаран зохион байгуулагдсан юм. (Нэмэлт мэдээллийг хуудас 39–45-аас үз.) Көртландаас Миссури руу аянаар очиж, газраа буцааж авахад нь Гэгээнтнүүдэд туслахын тулд Иосеф Смит бүлэг хүмүүсийг зохион байгуулах ёстой гэсэн илчлэлтийг Их Эзэн түүнд 1834 оны Хоёрдугаар сарын 24-нд өгчээ (С ба Г 103-ыг үз). Түүний оршихуй тэдэнтэй хамт явахыг түүнчлэн тэдний “хичээл зүтгэл, итгэлтэй байдал мөн итгэлийн залбирлуудаар дамжин бүх ялалт хийгээд алдар сууд” (С ба Г 103:36) авчрагдах болно хэмээн Их Эзэн амлажээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Далын Чуулгын анхны гишүүдийн ихэнх нь энэ туршлагаар ирээдүйнхээ үүрэг хариуцлагуудад бэлтгэгдсэн байлаа.

Сионы Хуаран 1834 оны Тавдугаар сарын 6-нд Огайогийн Нью Портейжид албан ёсоор зохион байгуулагджээ. Бошиглогч хүмүүсийг аравт, тавьтын хамтлагуудад хувааж, бүлэг бүр өөрийн ахмадыг сонгохоор зааварлаж, эцэстээ хуаран нь 207 эрэгтэй, 11 эмэгтэй, 11 хүүхдээс бүрдэж байв. Хуаран “Израилын эртний жаягийн дагуу”⁶ зохион байгуулдагдсаныг нэг шинэ элсэгч Жозеф Холбрук тэмдэглэжээ. Тэд Миссурийн Клей Гүнлэг

хүртэл 1000 гаруй миль зайг 45 өдөр хамтдаа аялжээ. Тэд хүнд бэрх нөхцөлд аль болох түргэн аялж байв. Хангалттай хүнс олж авах нь маш хэцүү байв. Хүмүүс бүдүүн ширхэгтэй талх, хуршсан цөцгийн тос, эрдэнэ шишийн нухаш, эссэн зөгийн бал, гахайн түүхий мах, муудсан утсан гахайн мах, өтсөн гахайн өвчүү, бяслагийг хомс тарчигхан хэмжээгээр идэх шаардлагатай болох нь олонтаа байлаа. “Би маш их ядран, өлсч, нойрмоглох, зам даган явж байхдаа сайхан устай горхи, аятайхан сүүдэртэй мод, булгийн дэргэд давуун дээр тавьсан сайхан зүсэм талх, бас лонхтой сүү мөрөөддөг байлаа”⁷ гэж хожим нь Төлөөлөгч болсон Жорж Смит байнга өлсдөг байснаа бичжээ.

Хуаран сүнслэг байдал хийгээд зарлигуудыг дуулгавартай дагахад онцгой ач холбогдол өгдөг байв. Ням гарагуудад тэд цуглаан хийж, ариун ёслолоос хүртдэг байв. Хаант улсын сургаалуудыг Бошиглогч олонтаа заадаг байлаа. “Бурхан бидэнтэй хамт байгаа, мөн Түүний тэнгэр элчүүд бидний өмнө явж байгаа, бас бидний бяцхан бүлгийн итгэл гуйвшгүй бөх. Тэнгэр элчүүд бидний хамтрагчид гэдгийг бид мэднэ, учир нь бид тэднийг харсан” гэж тэрээр хэлдэг байв.⁸

Гэсэн хэдий ч, хуарангийн бэрхшээлүүд оролцогчдод нь гарз хохирол учруулж эхлэв. Энэхүү сайжруулагч үйл явц нь дуулгавартай байдлын сүнсгүй, өөрсдийнхөө зовлон бэрхшээлүүдийн төлөө Иосефыг олонтаа буруутгадаг байсан үглэн гомдоллогчдыг илчилсэн ажээ. “Тэд цээрлүүлэгдэхгүй байж болохын тулд өөрсдийгөө Их Эзэний өмнө даруусгаж, эв нэгдэлтэй байхыг”⁹ эсэргүүцэгч сүнстэй хүмүүст Бошиглогч Тавдугаар сарын 17-нд ухуулжээ.

Зургадугаар сарын 18 гэхэд хуаран Миссурийн Клей Гүнлэгт хүрэв. Гэвч Миссурийн захирагч Даниел Данклин гэр орноосоо албадуулан хөөгдсөн Сүмийн гишүүдийн эрхийг сэргээхэд нь Гэгээнтнүүдийн армид туслах тухай амлалтаа биелүүлсэнгүй. Хуаран дахь зарим хүмүүсийн хувьд энэхүү цэргийн зорилго бүтэлгүй болсон нь тэдний итгэлийн эцсийн сорилт байлаа. Санаагаар унаж, уурласан зарим хүмүүс илэрхий эсэргүүцэлд босов. Үүний үр дүнд Их

Эзэн тэдэнд дээр сүйрүүлэгч цээрлүүлэлт илгээж болохыг Бошиглогч тэдэнд сануулжээ. Удалгүй хуаран даяар аюултай халдварт булчин задрах тахал гарав. Энэ өвчин төгсгөл болохоос өмнө хуарангийн гуравны нэг нь, түүний дотор Иосеф Смит өвчилж, үүнээс хойш хуарангийн 14 гишүүн нас барав. Долдугаар сарын 2-нд Иосеф Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгах, түүнчлэн түүний зарлигуудыг сахих гэрээнд орохыг хуаранд дахин сануулж, хэрэв тэд ингэхгүй бол энэ үеэс эхлэн тахал хэвээр үлдэх болно гэж хэлжээ. Гэрээ гар өргөлтөөр хийгдэж, тэгээд тахал зогсов.

Долдугаар сарын эхээр хуарангийн гишүүдийг Бошиглогч хүндэтгэлтэйгээр халав. Аялал нь хэн Их Эзэний талд байсныг тэрчлэн удирдлагын албан тушаалуудад үйлчлэхэд хэн зохистой болохыг илчилсэн ажээ. Хожим нь аяны үр дүнг Бошиглогч тайлбарлахдаа: “Бурхан байлдахыг та нараас хүсээгүй юм. Амьдралаа зориулсан, Абрахамын хийсэн шиг агуу золиослол хийсэн хүмүүсийн бүрэлдэхүүнээс тэднийг Тэрээр авахгүй юм бол, сайн мэдээний хаалгыг дэлхийн үндэстнүүдэд нээхийн тулд Тэрбээр арванхоёр хүнтэйгээр, мөн тэдний мөрөөр дагах далан хүний удирдлага дор өөрийн хаант улсыг байгуулж чадахгүй байлаа”¹⁰ гэжээ.

“Бид өөр ямар ч арга замаар хуримтлуулж чадахгүй байсан тийм туршлагыг хуримтлуулсан юм. Бошиглогчийн нүүрийг харах онцгой боломж бидэнд байсан, мөн түүнтэй хамт мянган миль газар аялах хийгээд Бурханы сүнс түүнтэй хамт ажиллахыг, түүнчлэн түүнд өгсөн Есүс Христийн илчлэлтүүд болон тэдгээр илчлэлтүүдийн биелэлтийг харах онцгой боломж бидэнд байлаа”¹¹ гэж хуарангийн гишүүн, хожим нь Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч болсон Вилфорд Вудрафф хэлжээ.

Хуаранг халснаас хойш таван сарын дараа 1835 оны хоёрдугаар сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Далын Нэгдүгээр Чуулга зохион байгуулагджээ. Энэ хоёр чуулга дахь наян хоёр албан тушаалаас далан есөд нь

Сионы Хуарангийн аянд өөрсдийгөө нотлон харуулсан хүмүүс тавигдав.

Көртландад Иосеф Смит ирээдүйн удирдагчдыг сургахаа үргэлжлүүлж байв. Сүмийн ирээдүйн дөрвөн Ерөнхийлөгч—Бригам Янг, Жон Тейлор, Вилфорд Вудрафф, Лорензо Снөү нар Көртландын жилүүдэд багтисм хүртэж, дараа нь 1901 оныг хүртэл Сүмийг дэс дараалан удирдаж байв. Түүнээс гадна, 1951 он хүртэл сүмийг үргэлжлүүлэн удирдсан дараагийн гурван ерөнхийлөгч—Жозеф Ф.Смит, Хибер Ж.Грант, Жорж Алберт Смит нар бол Көртландын тууштай анхдагчуудын шууд үр удмынхан байлаа.

Номлогчийн Ажил Урагш Ахив

Гэгээнтнүүдийг Көртландад амьдарч байх үед сайн мэдээг гэр орноосоо алс хол заахын тулд, тэдний ихэнх нь үлэмж их хувийн золиослол хийж, олон номлогч дуудагдсан юм. Номлогч нар Америкийн нилээд олон муж улс, Канадын зарим хэсэг, түүнчлэн Атлантыг гатлан Англи уруу илгээгдэж байлаа. Эдгээр номлогч нарын хүч чармайлтаар дамжуулан олон хүмүүс сайн мэдээний үнэний тухай гэрчлэл хүлээн авсан юм. Тэд бол шинэ тулгар Сүмд агуу хүч чадал авчирсан эрэлхэг зоригт гишүүд болжээ.

Көртландад цэдэглэгдсэн нилээд олон илчлэлт нь сайн мэдээг дэлхийд номлох талаар гишүүдэд өгсөн зарлигуудыг багтаадаг. “Та нар миний сайн мэдээг номлож, хоёр хоёроороо, мөн миний нэрээр, бүрэн дуу мэт дуу хоолойгоо өргөн, Бурханы тэнгэр элчүүд лугаа адил миний үгийг тунхаглан миний Сүнсний хүчээр урагш одох ёстой” (С ба Г 42:6) гэж Их Эзэн тунхаглажээ. Дараагийн жил нь Их Эзэн, “Сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө сэрэмжлүүлэх нь хэрэгтэй болой” (С ба Г 88:81) хэмээн зарлиглав.

Огайогийн Анхны Хөрвөгчдийн Номлол

Огайогийн хөрвөгч Зера Пулсифер бол Сэргээлтийн захиасыг урам зоригтойгоор хуваалцсан хүмүүсийн үлгэр жишээ



Америкийн Индианчуудад сайн мэдээг хүргэхээр дуудагдсан энэ дөрвөн номлогч маш хүнд нөхцөлд Сүмийн эхэн үеийн түүхийн туршид итгэлтэй номлогч нарын хийж байсан золиослолуудын үлгэр дуурайл юм.

юм. Тэр 1832 оны Нэгдүгээр сард Сүмд нэгдсэн бөгөөд дараа нь удалгүй “ахлагчийн албан тушаалд томилогдож, номлохоор явж, төрөлх нутагтаа болон алс хол үлэмж амжилт олсон”¹² тухай тэмдэглэгдсэн байдаг. Тэр болон өөр нэг номлогч Элайжа Чени Нью-Йоркийн Ричланд гэдэг жижигхэн хот руу явж, тэд тэнд орон нутгийн сургууль дээр номлож эхэлжээ. Ахлагч Пулсиферээр баптисм хүртээгдсэн анхны хөрвөгчдийн нэг нь Вилфорд Вудрафф гэдэг нэртэй фермийн залуу эзэн байсан нь тэрээр нэг өдөр Сүмийн түүхэн дэх хамгийн амжилттай номлогч нарын нэг, түүнчлэн Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч болсон билээ. Ганцхан сарын хугацаанд тэр хоёр номлогч нилээд олон хүмүүст баптисм хүртээж, Ричландад сүмийн нэг салбар зохион байгуулсан юм.

Хөршүүдээ сэрэмжлүүлэх дуудлагын хариуд нийгэм эдийн засгийн янз бүрийн байдалтай номлогч нар иржээ. Тэднээс олон нь гэрлэсэн байсан бөгөөд гэр бүлийн үүрэг хариуцлага хүлээсэн хүмүүс байв. Тэд ургац хураалтын дундуур, өвлийн хүйтнээр, хувь хүний цэцэглэл хөгжилтийн үедээ түүнчлэн эдийн засгийн бууралтын үеэр явцгаасан ажээ. Нилээд олон

ахлагч номлолын талбарт орж ирэхдээ бараг л ядуу тарчиг амьдралтай байсан юм. Бошиглогч өөрөө 1831–1838 онуудад богино хугацааны 14 номлолд үйлчлэн олон муж улс болон Канадад 15 000 миль газар аялжээ.

Бошиглогчийн үеэл Жорж А.Смит Нэгдсэн Улсын дорнод хэсэгт үйлчлэх дуудлага хүлээн авсан бөгөөд өөрт нь хэрэгтэй байсан хувцас, номнууд түүнд байхгүй буюу тэдгээрийг худалдаж авах юмгүй тийм ядуу байлаа. Тиймээс, Бошиглогч Иосеф Смит, түүний ах Хайрум нар түүнд хэсэг саарал даавуу өгснөөр Элиза Браун хүрэм, хантааз, өмд хийж өгсөн аж. Бригам Янг түүнд хос гутал, аав нь халаасны Библи, Бошиглогч нэг Мормоны Ном өгчээ.

Ахлагч Эраст Снөү, Жон Е. Пейж нар 1836 оны хавар номлолын талбарыг зорих үедээ бас л ядуу зүдүү байлаа. Баруун Пеннсилванид номлолд явах үеийнх нь түүний байдлыг дүрсэлж Ахлагч Снөү бичихдээ, “Би Көртландаас явганаар, Сүмийн хэдэн ном, хос оймс агуулсан ганц жижигхэн чөмдантай, халаасандаа таван центтэй явж билээ, надад байсан дэлхийн бүх баялаг ердөө л энэ байв” гэжээ. Ахлагч Пейж хувцсаар ядуу байсан учир тэр номлох дуудлага хүлээн авч чадахгүй гэж Ахлагч Пейж Бошиглогчид ярьжээ. Тэр ч байтугай түүнд өмсөх хүрэм ч байсангүй. Бошиглогч хариуд нь цуваа тайлж, Ахлагч Пейжид өгчээ. Тэрээр Ахлагч Пейжид номлолдоо яв, Их Эзэн элбэг дэлбэгээр адислах болно гэж хэлжээ.¹³ Зуу зуун хүмүүст сайн мэдээг хуваалцан, тэд нь Сүмтэй нэгдсэн адислалыг Ахлагч Пейж номлолдоо хүртжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Номлол

1835 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд Нэгдсэн Улсын дорнод хэсэг болон Канадад номлолд дуудагдав. Энэ бол Сүмийн түүхэнд уг Чуулгын арванхоёр гишүүн нэгэн зэрэг номлолд гарсан цорын ганцхан тохиолдол юм. Тэднийг буцаж ирэхэд, тэд Бурханы хүчийг мэдэрч өвчтөнүүдийг эдгээн, чөтгөрүүдийг зайлуулж байсан тухай Хибер К.Кимбалл гэрчилжээ.

Англи дахь Номлол

Көртландын үеийн хожуу хэсэгт Сүмийн дотоодод хямрал үүссэн юм. Зарим гишүүд, түүний дотор зарим удирдагчид урвав, учир нь тэд гай зовлон хийгээд мөрдлөг хавчлагыг тэвчиж чадсангүй, учир нь тэд Бошиглогч Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчдад бурууг тохож эхэлжээ. Түүний Сүмийг аврахын тулд ямар нэг шинэ зүйл хийх ёстойг Их Эзэн Иосеф Смитэд илчлэв. Тэрхүү ямар нэг зүйл гэдэг нь хөрвөгчдийг Английн Сүмд очуулах явдал байв. 1837 оны Зургадугаар сарын 4-ний Ням гарагт Бошиглогч Көртландын Ариун Сүмд Хибер К.Кимбалл уруу ойртон очиж, “Хибер Ах аа, ‘Миний үйлчлэгч Хибер Англид очиж, миний Сайн Мэдээг тунхаглаж, тэр үндэстэнд авралын хаалгыг нээг’ гэж Их Эзэний Сүнс надад шивнэлээ” гэж хэлжээ.¹⁴

Хибер К.Кимбалл номлолынхоо төлөө онцгойлон адислагдаж байсан үеэр Ахлагч Оорсон Хайд өрөөнд орж ирэв. Юу болж байгааг тэрээр сонсоод наманчлах бодол Оорсонд төржээ, учир нь тэр бол Бошиглогчид бурууг тохоход оролцсон хүмүүсийн нэг байв. Тэр номлогчоор үйлчлэх саналаа хэлж, тэгээд бас Англи уруу явахаар онцгойлон адислагджээ.

Хибер К.Кимбалл гадаад оронд номлох туйлын их хүсэлтэй байсан болохоор хөлөг онгоц Английн Ливерпулд газардмагц тэрээр хөлөг онгоц зангуугаа хаяхаас өмнө хөлгөөс зогсоол уруу үсрэн бууж, Сэргээлтийн захиастайгаар далайн чанадад хүрч ирсэн анхны хүн гэдгээ тунхагласан ажээ. Долдугаар сарын 23 гэхэд номлогч нар үй олон хүнтэй цугларагсдад номлон, анхны баптисмууд Долдугаар сарын 30-нд төлөвлөгдсөн байлаа. Жорж Д.Ватт Престон дахь Риббл Гол руу хийсэн явган уралдаанд түрүүлж, Британи дахь анхны баптисм хүртэгч болж алдар хүндийг хүлээв.

Найман сарын дотор хэдэн зуун хөрвөгч Сүмд нэгдэж, олон салбар зохион байгуулагдав. Бодгалиудын энэхүү агуу хадалтын талаар Хибер эргэн дурсахдаа, Бошиглогч болон түүний зөвлөхүүд “над дээр гар тавьж тэгээд . . . Түүнд

бодгалиудыг ялан авчрахад намайг Бурхан тэр үндэстний дотор хүчирхэг болгох болно; тэнгэр элчүүд намайг дагалдан, бас намайг өргөж явах болно, би хазгай гишгэхгүй байх болно; би үлэмж ихээр адислагдаж, мянга мянган хүмүүст авралын эх сурвалжийг нотлон харуулах болно” хэмээн хэлж билээ гэжээ.¹⁵

Эхэн үеийн олон номлогч нар хувийн золиослолыг үл харгалзан номлолын дуудлагуудыг дуулгавартайгаар хүлээн авч байсан учраас Британийн мянга мянган хөрвөгчид сэргээгдсэн сайн мэдээний адислалуудыг эдэлж байлаа. Тэд Сионд цугларч, ирээдүйн шийдвэрлэх цаг үеүдэд Сүмийг агуу ихээр хүчирхэгжүүлсэн билээ.

Көртландын Ариун Сүм

Гэгээнтнүүдийн Золиослолууд

1832 оны Арванхоёрдугаар сарын 27-нд Гэгээнтнүүд ариун сүм барих Их Эзэний зарлигийн тухай анх мэджээ (С ба Г 88:119-ийг үз). Ариун сүмийн барилга 1833–1836 оны хооронд Көртланд дахь Сүмийн эн тэргүүнд анхаарах зүйл болов. Шаардлагатай ажилчид мөнгө хоёулангаар нь дутагдаж байсан Гэгээнтнүүдэд энэ нь их хүндрэл бэрхшээл учруулсан юм. Элиза Р.Снөүгийн хэлснээр, “Тэр үед, . . . Гэгээнтнүүд тоогоор цөөхөн байв, бас тэдний олонхи нь нэн ядуу байлаа; мөн Бурхан ярьсан гэдэгт итгэх баттай итгэл байхгүй байхад, мөн түүний нэрэнд байшин баригдах ёстой, үүний зөвхөн хэлбэр нь илчлэгдсэн төдийгүй, бас хэмжээ нь ч тогтоогдсон, тэрхүү Ариун Сүмийг барих оролдлого нь тэр үеийн нөхцөл байдалд бүх нийтээр санаа тавигдан, зарлагдсан нь утга учиргүй мэт байлаа.”¹⁶

Шаардлагатай тусламж, хөрөнгө мөнгөөр Бурхан хангана гэдэг итгэлтэйгээр Бошиглогч Иосеф Смит хийгээд Гэгээнтнүүд шаардлагатай золиослолуудыг хийж эхэлжээ. Ариун сүм барихад хөрөнгө мөнгөөр туслахад Их Эзэний бэлтгэсэн хүмүүсийн нэг бол Жон Таннер байв. Нью-Йоркийн Болтоны саяхны хөрвөгч Жон 1834 оны Арванхоёрдугаар сард “тэрээр тэр даруй

Өрнөд дахь Сүм рүү явах хэрэгтэй бас ингэх ёстой гэдэг сэтгэгдлийг зүүдээр буюу шөнийн үзэгдлээр хүлээн авсан ажээ. . . .

“Тэрээр Көртландад ирснийхээ дараа, тэрээр тэр даруй Сүм рүү явах ёстой гэсэн сэтгэгдэл хүлээн авсан яг тэр үед Бошиглогч Иосеф болон хэсэг ах нар залбирлын цуглаанд уулзацгааж, дээр нь ариун сүм баригдаж байсан фермийн барьцааны мөнгийг төлөхөд тэдэнд туслах нэг ах буюу хэсэг ах нарыг тэдэнд илгээгээч гэж Их Эзэнээс гуйсныг олж мэджээ.

“Түүнийг Көртландад ирсний маргааш нь, . . . хэрэв фермийг худалдаж авах өрийг төлөхгүй бол өмнө дурдсан фермийг зээлдүүлэгч буцаан авах дээрээ тулчихаад байсныг [түүнд] мэдээлсэн ажээ. Ингээд тэрээр бошиглогчид хоёр мянган доллар зээлүүлж, бошиглогч уг мөнгийг хүүгийн хамт эргүүлж төлнө гэж нотолсон зурвасыг түүнээс авчээ.”¹⁷

Көртландын Гэгээнтнүүдийн гаргасан гайхамшигтай хүч чармайлтууд бол золиослол хийгээд цаг, авъяас, хөрөнгө мөнгөө өргөл болгохын үлгэр жишээ юм. Гурван жил тэд тус барилга дээр ажиллажээ. Эрэгтэйчүүд барилга барих ур чадвар, хүч чармайлтаа дайчилж байснаас гадна, эмэгтэйчүүд ажиллаж байсан хүмүүсийг хувцаслахын тулд ээрч, нэхэж сүлжиж байлаа. Хожим нь тэд өрөөнүүдийг тусгаарласан хөшигнүүд хийжээ. Барилга илүү хүнд нөхцөлд баригдаж байлаа, танхайрагч бүлэг ариун сүмийг устгахаар заналхийлж байснаас өдөр нь ажилласан хүмүүс шөнө нь ариун сүмийг хамгаалж хонодог байв. Гэвч Гэгээнтнүүд цаг, нөөцүүдээ үлэмж хэмжээгээр золиосолсны дараа эцэст нь ариун сүм 1836 оны хавар дууссан юм.

Ариун Сүмийг Онцгойлон Адисалсан нь

Ариун Сүмийг дуусгаснаар Көртланд дахь Гэгээнтнүүдийн дээр сүнсний хүчирхэг адислалуудыг, түүний дотор үзэгдлүүд хийгээд тэнгэр элчүүдийн тохинууллыг Их Эзэн юүлсэн билээ. Иосеф Смит энэ үеийг “бидний хувьд тэмдэглэлт баярын үе, баяр баясгалангийн үе”¹⁸ хэмээн нэрлэсэн байдаг. “Бүх хүмүүс

тэнгэрийн мэдрэхүйг урьдчилан мэдэрч байв. . . . Мянган жил эхэлчихэв үү гэж бид бодож байлаа”¹⁹ гэж Даниел Тайлор гэрчилжээ.

Сүнсний юүлэлтийн оргил үе нь ариун сүмийн онцгойлон адислалт байв. 1836 оны Гуравдугаар сарын 27-нд ариун сүм дээр тооцоолсноор 1000 хүн цуглаж, баяр баясгалангийн сүнсэнд байлаа. Онцгойлон адислалтын магтуунуудыг түүний дотор Виллям В.Фелпсийн энэ үйл явдалд зориулан бичсэн “The Spirit of God Like a Fire Is Burning,” (“Бурханы Сүнс Гал Шатах Лугаа Адил”) дууллыг дуулж байлаа. Ариун ёслолыг гүйцэтгэж, Сидней Ригдон, Иосеф Смит болон бусад хүмүүс номлол айлдав.

Түүнд илчлэлтээр өгөгдсөн бөгөөд эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 109 болон цэдэглэгдсэн онцгойлон адислалтын залбирлыг Иосеф Смит уншив. Уг залбиралд тэрээр Их Эзэн Пентекостын өдөр түүнд байсан лугаа адилаар хүмүүсийг адислаач хэмээн түүнээс: “Мөн таны өргөө хуйлрах хүчит салхи лугаа адил таны алдар суугаар дүүргэгдэг” (С ба Г 109:37) хэмээн гуйжээ. Тэр орой Бошиглогч санваартны чуулгуудын гишүүдтэй уулзахад энэхүү залбирал биелэгдсэнийг олон хүн тэмдэглэсэн байдаг .

“Тэрхүү онцгойлон адислалтын ёслолууд давтагдаж болох хэдий ч, тэрхүү дурсгалт өдрийн тэнгэрлэг илэрхийлэлтүүдийг мөнх бус хэл дүрсэлж чадах нь үгүй. Зарим хүмүүст тэнгэр элчүүд үзэгдсэн бол энд ирсэн бүх хүмүүст бурханлиг оршихуйн мэдрэмж төрсөн байлаа, ингээд зүрх сэтгэл бүр илэрхийлэх аргагүй хийгээд бүрэн алдар суугаар дүүрсэн байлаа” гэж Элаижа Р.Снөү бичсэн байдаг.²⁰ Онцгойлон адислалтын залбирлын дараа бүх цугларагсад босч, гараа өргөн хосанна хэмээн хашгирч байв.

Үүнээс хойш нэг долоо хоногийн дараа 1836 оны Дөрөвдүгээр сарын 3-нд хожмын үеийн түүхийн хамгийн чухал зарим үйл явдал тохиосон юм. Тэр өдөр ариун сүмд Аврагч өөрөө Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр хүрч ирэн, “Учрыг болгоогтун, би энэ өргөөг хүлээж авлаа, мөн миний нэр энд байх бол-

но, энэ өргөөнд өөрийн хүмүүст нигүүлсэлд бибээр өөрийгөө үзүүлэх болно” (С ба Г 110:7) гэж хэлжээ. Мосе, Елиас, Елиа нар санваарын нэмэлт түлхүүрүүдийг сэргээхээр хүрч ирсэн зэрэг бусад агуу хийгээд алдар суут үзэгдлүүд дараа нь ирсэн юм. Мосе Израилын цугларалтын түлхүүрүүдийг олгож, Елиас Абрахамын сайн мэдээний эрин үеийг Иосеф, Оливер хоёрт итгэмжлэн даатгаж, Елиа лацдалтын түлхүүрүүдийг сэргээжээ (С ба Г 110:11–16-г үз). Эдгээр бүх нэмэлт түлхүүрүүд цаг хугацааны эцсийн эрин үед Их Эзэний хаант улсын өсөлт хөгжилтөд зайлшгүй чухал байсан юм.

Ариун сүмд гүйцэтгэгдсэн санваарын адислалууд Көртландын үед бүрнээрээ илчлэгдээгүй буюу гүйцэтгэгдээгүй юм. Эдгээр адислалууд хэдэн жилийн дараа Навуугийн Ариун Сүм баригдаж байхад Бошиглогч Иосеф Смитээр дамжин Сүмд илчлэгдсэн билээ.

Көртландаас Дүрвэсэн нь

Ариун сүм барьсан нь олон адислал авчирсан боловч, Көртланд дахь Сүмийн үеийн төгсгөлийг түргэсгэсэн урвалт хийгээд мөрдлөг хавчлагын улмаас итгэлтэй Гэгээнтнүүдэд 1837, 1838 онуудад мөн л асуудлууд тулгарав.

Нэгдсэн Улс санхүүгийн бэрхшээлтэй тулгарч, үр дагавар нь Сүмд туссан юм. Зарим гишүүд бизнесийн үйл ажиллагаанд хяналтгүйгээр оролцон, өр тавьж, эдийн засгийн уналтын харанхуй үеийг, түүний дотор Көртландын Аюулгүй Байдлын Нийгэмлэгийн уналтыг сүнслэг байдлын хувьд даван гарч чадсангүй. Банкны энэ байгууллагыг Көртланд дахь Сүмийн гишүүд үндэслэн байгуулсан бөгөөд үүнтэй холбоотой асуудлуудын талаар Иосеф Смитийг зүй бусаар буруутгаж байв.

Зохион байгуулалттай хавчлага хийгээд танхайрагчдын балмад үйл ажиллагаа орон нутгийн оршин суугчдын зүгээс түүнчлэн Сүмээс хөөгдсөндөө хорссон буюу урвасан гишүүдийн зүгээс ирж байлаа.

Гэгээнтнүүд болон тэдний удирдагчдын эсрэг харгислал шатлан өргөжихийн хэрээр, Көртландад үлдэх нь тэдний хувьд аюултай болж байлаа. Амь нас нь хутганы ирэн дээр байсан Бошиглогч 1838 оны Нэгдүгээр сард Көртландаас Миссурийн Фар Вест уруу зугтав. 1838 оны туршид хамгийн итгэлтэй Гэгээнтнүүдийн ихэнх нь эндээс явахаар албадуулагджээ. Тэд итгэлийн, өргөлийн түүнчлэн Бурханд зориулан барьсан ариун сүм дэх золиослолын сүрлэг хөшөөг ардаа үлдээсэн юм. Тэд бас амьдралынхаа үлгэр жишээнд Их Эзэний тослогдсон удирдагчдыг итгэлтэйгээр дуулгавартай дагах болон Их Эзэний ажилд хувийн золиослол хийх байнгын өвийг ардаа үлдээсэн юм.

Миссурид Сионыг Үндэслэсэн нь

Миссури дахь Эхний Жилүүд

Гэгээнтнүүд Огайогийн Көртландад Бурханы хаант улсыг байгуулахаар тэмцэж байсан мөн тэр үед Сүмийн олон гишүүн Миссурийн Жэксон Гүнлэгт агуу тэмцлүүд хийж байлаа.

Мөн үүний тулд дуудагдсан, Нью-Йоркийн Колесвиллд амьдарч асан Гэгээнтнүүд Көртландад цуглахын тулд гэр орноо орхиход бэлэн байлаа (хуудас 18-ыг үз). 1831 оны Тавдугаар сарын дундуур тэднийг Огайод ирэхэд тэдэнд зориулан гаргасан газар байхгүй болсныг тэд мэдэв. Бошиглогч Иосеф Смит тэдний хүнд бэрх зовлон зүдгүүрийг Их Эзэнд залбиралд мэдүүлжээ. Түүнийг өөрийг нь, Сидней Ригдон болон өөр 28 ахлагчийг шашиндаа элсүүлэх номлолд Миссури уруу явахыг чиглүүлсэн илчлэлтийг тэр даруй хүлээн авчээ, ингээд Колесвиллийн Гэгээнтнүүд бас “Миссурийн нутаг уруу” (С ба Г 54:8) аялахыг Их Эзэн зааварлажээ. Тэд бол Сион хэмээн нэрлэгдэх болсон тэр газарт суурьшсан Гэгээнтнүүдийн анхны бүлэг байлаа.

Колесвилл Салбарын ерөнхийлөгч Ньюел Найт тэр даруй өөрийн хүмүүсийг цуглуулав. “Бид бол хамгийн үнэнээр нь хэлбэл илүү сайн газар нутаг эрэлхийлсэн аянчдын бүлэг байлаа”¹ гэж Эмили Кобөрн өгүүлжээ. Огайогийн Велсвиллд тэд уурын хөлөг онгоцонд сууж, Огайо, Миссисипи болон Миссури мөрнүүдээр дамжин Миссурийн Жэксон Гүнлэг рүү аялжээ. “Тэд бол өрнө зүгт тэдний хэзээч зөөж байгаагүй, хамгийн амар амгалан, чимээ шуугиангүй, хараал зүхлийн муу үгүй, мөрийтэй тоглодоггүй, архи уудаггүй цагаачлагчид байлаа”² гэж уурын онгоцны ахмад хэлжээ.

Бошиглогч болон Сүмийн бусад удирдагчид Колесвиллийн Гэгээнтнүүдийг Жэксон Гүнлэгт байршуулах ажлыг урьдчилан зохицуулахын тулд тэдний өмнө хуурай газраар яаравчлан гарсан ажээ. Бошиглогчийн хэсэг 1831 оны Долдугаар сарын 14-нд Миссурийн Индепенденст хүрч ирэв. Тэр нутгийг үзсэний дараа Бошиглогч бурханлиг удирдамж эрэлхийлэн, “[Их Эзэн] өөрийгөө надад үзүүлж, цугларалтын ажлыг эхлэхээр, түүнчлэн Сион хэмээн нэрлэгдэх ёстой ариун хотыг барихаар тэрбээр өөрийн тогтоосон яг тэр газрыг надад болон бусад хүмүүст тогтоож өгөв”³ гэж хэлжээ.

Миссури бол Гэгээнтнүүдийн цугларалтад Их Эзэнээр төлөвлөгдсөн газарт энэ илчлэлт зориулагдсан бөгөөд “эдүгээ Индепенденс хэмээн нэрлэгддэг уг газар нь төв газар болой, мөн ариун сүмд зориулсан хэсэг газар баруунтаа, шүүхийн байрнаас холгүй буй” (С ба Г 57:3) гэжээ. Тэр хотоос баруун тийш Миссури муж улс болон Индианчуудын нутаг дэвсгэрийг заагладаг шугам хүртэлх зурвас газар бүрийг Гэгээнтнүүд худалдаж авах хэрэгтэй байлаа (С ба Г 57:1–5-ыг үз).

Иосеф Смит, Бишоп Партриж хоёр Индепенденсээс баруун тийн 12 миль орчимд орших Коо Хотхонд Колесвилл Салбарт зориулан газар олж авчээ. Салбарын гишүүдийг ирсний дараа 1831 оны Наймдугаар сарын 2-нд бэлэгдлээр дүүрэн нэг ёслол болжээ. Израилын 12 овгийг төлөөлсөн арванхоёр хүн дөнгөж саяхан огтолсон царсан гуалинг авч ирэн Оливер Каудерийн тавьсан нэг чулуун дээгүүр дамнуулан тавьсан нь, ийн Сионыг үндэслэн байгуулах суурийн бэлэгдэл болсон ажээ. Гэгээнтнүүд энэхүү даруухан эхлэлээс сүм болон сургуулийн байр болгож ашигладаг байсан нэг барилгыг барьсан юм.⁴

Дараагийн өдөр нь нилээд олон ах нар Индепенденсийн шүүхийн байрнаас баруун тийш нэг хагас мильд орших өргөгдсөн цэг дээр цугларав. Бошиглогч Иосеф Смит тэр газарт дотроо төсөөлөн бодсон ариун сүмийн суурийн чулууг тавьж, үүнийг Их Эзэний нэрээр онцгойлон адислав. Сионы

газар нутгийн гол онцлог нь Их Эзэний өргөө болоход байлаа.⁵

Бошиглогч Көртландад эргэн ирж, Жэксон Гүнлэг дахь Гэгээнтнүүд Бишоп Эдвард Партрижаас хэсэг газар хүлээн авч эхлэв. Тэд маш ядуу байсан бөгөөд тэр ч байтугай бүхээг барьж байх үед байгалаас хамгаалах майхан ч тэдэнд байсангүй. Сейнт Люис руу зүүн зүгт 200 милээс хол газар руу хөдөлмөрийн багаж хэрэгсэл олж ирэхээр багуудыг илгээх хүртэл тэдэнд бас нийтэд нь хөдөлмөрийн багаж хэрэгсэл байхгүй байлаа. Гэгээнтнүүд багаж хэрэгсэлтэй болсноос хойш тэд тариалалтад зориулан газраа хагалж эхлэв. Эмили Кобөрн өөрөө гэрч нь болсон зүйлд сэтгэл ихэд хөдлөн өгүүлэхдээ: “Баялаг үржил шимтэй хөрсийг буулга бүхий дөрөв юм уу таван шар эргүүлэхийг харах нь үнэхээр сонин байлаа. Хашаа барих болон бусад тохижуулалтуудыг түргэн амжуулж байв. Бүхээгүүд цаг хугацаатай уралдан гэр бүлүүдэд зориулж бэлтгэн баригдаж, мөнгө болон хөдөлмөр уг ажлыг гүйцэлдүүлэв”⁶ гэжээ.

Хил хязгаарын ая тухгүй байдлыг үл харгалзан Колесвиллын Гэгээнтнүүд хөгжилтэй, баяр хөөртэй байлаа. Тэдэнтэй хамт суурьшсан Парли П.Пратт: “Бидний залбирлууд болон бусад цуглаануудад олон баяртай үе мөчүүд бидэнд тохиолддог байв, түүнчлэн Их Эзэний Сүнс бидэнд дээр юүлэгдэн, бүр бяцхан хүүхдүүд хүртэл, найм, арав буюу арванхоёр настай олон нь үт хэлж, залбиран, бидний цуглаанууд болон бидний гэр бүлийн шүтлэг бишрэлд бошиглож байв. Амар амгалангийн болон эв нэгдлийн сүнс, тэрчлэн хайр хийгээд сайн санаа аглаг буйд дахь энэ бяцхан Сүмд харагддаг байсан нь зүрх сэтгэлд минь үүрдийн дурсамж болон үлдэх болно”⁷ гэжээ.

1832 оны Дөрөвдүгээр сард Бошиглогч, Сидней Ригдон нар хоёр дахь удаагаа айлчлан ирснээр Гэгээнтнүүд адислагдсан ажээ. Энэ хоёр удирдагч Библийн орчуулга дээр өөрсдийн ажиллаж байсан Огайогийн Хайрам дахь Жон Жонсоны ферм дээр болсон нэн гунигт туршлагаас шууд ирсэн байлаа. Сүмийн дайснуудын танхайрагч бүлэг тэр

шөнө Иосеф Смитийг гэрээс нь чирж гаргасан ажээ. Тэд түүнийг багалзуурдан, нүцгэлж, биенд нь давирхай, өд наасан ажээ. Сидней Ригдоныг хөлдүү, овон товон газар руу өсгийнөөс нь чирж гулдрал гаргаж, толгойг нь хүнд бэртээн шархдуулжээ.

Эдүгээ, тэднийг бие бялдрынх нь хувьд зодсон ч гэсэн, тэд найз нартайгаа эсэн мэнд аюулгүй байлаа. Тэрээр “нэг итгэл, мөн нэгэн баптисмаар нэгдэн, мөн нэгэн Их Эзэнээр дэмжигдсэн, түүнийг мэддэг ах, эгч нар нь түүнийг баяртай хүлээн авсан. Ялангуяа Колесвилл салбар эртний Гэгээнтнүүд Паулын хувьд ямар байсан шиг тийм байдлаар баяссан ажээ. Бурханы хүмүүстэй хамт баясах нь сайхан хэрэг”⁸ гэж Иосеф баталсан байдаг

Жэксон Гүнлэг Дэх Мөрдлөг Хавчлага

Бишоп Партриж Их Эзэний зарлигийг дагаж, Огайо болон бусад газраас цагаачлан ирсэн олон Гэгээнтэнд зориулан Жэксон Гүнлэгт хэдэн зуун акр газар худалдаж авчээ. Эдгээр гишүүдэд зориулан удирдагчид эхлээд Индепенденс, Колесвилл, Витмер, Биг Блүү болон Прайри Салбаруудыг бий болгожээ. 1833 оны сүүлээр нийт арван салбар үндэслэн байгуулагдсан байлаа.⁹ 1833 оны Дөрөвдүгээр сард Сүмийн суурийг тавьсны гурван жилийн ойг тэмдэглэхээр Биг Блүү Гол дээр нэгдсэн салбарууд цуглах үед 1000 гаруй Гэгээнтнүүд ирсэн бололтой. Энэхүү цугларалт Сион дахь үүний анхны түүхэн үйл явдлыг дурсан тэмдэглэсэн явдал байсан бөгөөд Гэгээнтнүүд нийтээрээ баяр хөөрийн сүнстэй байлаа. Гэсэн ч, “Гэгээнтнүүдийг баясахад чөтгөр галзуурдаг, бас өөрийн хүүхдүүд болон үйлчлэгчдийг тэр уурлуулдгийг Ньюел бас ажиглажээ.”¹⁰

Дөрөвдүгээр сар дуусахаас өмнө, мөрдлөг хавчлагын сүнс өөрийгөө харуулав. Эхний үе шатанд, удалгүй санал өгөх хуудсанд өөрсдийг нь хэт давамгайлж мэднэ хэмээн айж, өдий олон тооны Хожмын Үеийн Гэгээнтнүүд ирсэнд дургүй байгаагаа нутгийн иргэд Сүмийн гишүүдэд сануулдаг байв.

Гэгээнтнүүд ихэвчлэн умард муж улсуудынх байсан бөгөөд тэд Миссури муж улсад хууль ёсны болсон хар арьст боолчуудыг эзэмшихийн эсрэг ерөнхийдөө байсан билээ. Мормоны Номыг судар гэж үздэг Гэгээнтнүүдийн итгэл, Жэксон Гүнлэг эцсийн бүлэгт тэдний Сион байх тухай тэдний мэдэгдэл, түүнчлэн тэд бошиглогчоор удирдагддаг гэсэн тэдний нотолгоо тайван байдлыг ихээр алдагдуулсан ажээ. Бас тэд Индианчуудтай хэлхээ холбоотой байсан нь нутгийн иргэдийн сэжгийг төрүүлдэг байжээ.

“Мормоны гамшгийг” устгахад бэлэн байгаа хүмүүсийн гарын үсгийг цуглуулахын тулд эсэргүүцэгч хүчин бичгээр, зарим үед нууц бүтцээр дамжуулан тарааж байжээ. Дайсагналын эдгээр мэдрэмжүүд 1833 оны Долдугаар сарын 20-нд 400 орчим хүнтэй танхайрагч бүлэг өөрсдийн хүч чармайлтуудыг зохицуулахын тулд Индепенденс дахь шүүхийн байранд цугласан тэр үед дээд цэгтээ хүрсэн юм. Гэгээнтнүүд Жэксон Гүнлэгийг орхин явах; *Evening and the Morning Star* сонингоо хэвлэн гаргахыг зогсоох; түүнчлэн Жэксон Гүнлэгт нэмж нэг ч Сүмийн гишүүнийг ирүүлэхгүй байх бичгэн шаардлагыг Сүмийн дуудлагын удирдагчдын өмнө тавьсан ажээ. Сүмийн удирдагчид эдгээр хууль бус шаардлагуудыг зөвшөөрөөгүй болохыг танхайрагч бүлэг мэдээд, мөн энэ нь хянан тохиолдуулагч Виллям В.Фелпсийн гэр байсан сонины газрыг тэд дайрчээ. Дайрагчид хэвлэлийн дардсыг хулгайлан, барилгыг нураасан байв.

Зарлигуудын Номыг Устгасан нь

Сонины газарт хэвлэгдэж байсан хамгийн чухал төсөл нь Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан илчлэлтүүдийн анхны түүвэр—Зарлигуудын Ном байлаа. Барилгыг танхайрагч бүлэг дайрах үед тэд уг номны боогоогүй хуудсуудыг гудамжинд гарган хаяжээ. Хожмын үеийн хоёр залуу Гэгээнтэн, Мэри Элизабет Роллинс, түүний эгч Каролин нар үүнийг хараад, номыг аврахыг бодон, амь насаа аюулд дүйн байж, чадах бүхнээ хийсэн ажээ. Мэри Элизабет эргэн дурсахдаа:

“[Танхайрагч бүлэг] нилээд хэдэн том хуудас цаас гаргаж ирээд, ‘Мормоны Зарлигууд энэ байна’ гэж хэлэв. Миний эгч Каролин бид хоёр хашааны буланд тэднийг харан зогсож байлаа; зарлигуудын тухай тэднийг өгүүлэхэд тэдгээрийн заримыг нь олж авъя гэж би шийдлээ. Хэрэв би зарлигуудыг олж авахаар явах юм бол тэр ч бас явна, гэвч тэд ‘биднийг ална шүү дээ’ гэж тэр хэллээ.” Танхайрагчид байшингийн нэг буланд завгүй байх үед хоёр охин гүйж очоод үнэ цэнэтэй хуудсуудыг гараараа дүүргэн авчээ. Танхайрагчид тэднийг хараад охидыг зогс гэж тушаав. Мэри Элизабет өгүүлэхдээ: “Бид чадах чинээгээрээ хурдан гүйлээ. Тэднээс хоёр нь бидний араас гүйв. Хашаанд зай байгааг хараад, бид эрдэнэ шишийн талбайд орж, цаасуудыг газар дээр тавиад, тэдгээрийг өөрсдийн биеэр халхлав. Эрдэнэ шиш тав, зургаан фут өндөр, маш өтгөн байлаа: тэд эргэн тойронд нэлээд нэгжиж, бидэнд маш ойрхон ирсэн ч, биднийг олоогүй” гэжээ.

Танхай балмад этгээдүүдийг явахад охид хуучин дүнзэн морины жүчээ рүү өөрсдийн замаар явлаа. Энд Мэри Элизабетийн өгүүлснээр, “Фелпс эгч болон хүүхдүүд нь үүнийг сойзон дотор аваачин, саравчны нэг талд овоолон дээр нь орнуудаа тавьсан ажээ. Надад юу байгааг тэрээр асуухад би түүнд хэлэв. Тэгээр тэр хуудсуудыг биднээс авсан. . . . Тэд хуудсуудыг жижигхэн номнууд болгон боож, надад нэгийг явуулсныг би ихэд эрхэмлэдэг байлаа.”¹¹

Бишоп Партрижийг Давирхайдаж, Өд Наасан нь

Танхайрагч бүлэг дараагийн удаа Бишоп Эдвард Партриж болон Чарльз Алленыг барьж авчээ. Тэднийг Индепенденс дахь нийтийн талбай дээр аваачин, Мормоны Номноос татгалзаж, тус гүнлэгийг орхин явахыг түүнд тушаасан ажээ. “Тэгээнтнүүд дэлхийн бүх эрин зуунуудад мөрдлөг хавчлагад зовж зүдэрч байсныг; би хэн нэгнийг гомдоох зүйл юу ч хийгээгүйг; хэрэв тэд надтай зүй бус харьцвал, тэд гэмгүй хүнтэй зүй бус харьцсан хэрэг гэдгийг; Христийн төлөө зовоход би бэлэн байна; гэвч

гүнлэгийг орхин явах тухайд бол, би үүнийг зөвшөөрөхгүй” гэж Бишоп Партриж хэлжээ.

Ийнхүү татгалзсанд, эрэгтэйчүүдийн гадуур хувцсыг тайлж, биенд нь давирхай, өд наажээ. “Надтай зүй бус харьцсаныг би ихэд хүлцэнгүй, номхон байдлаар тэсэн гарсан нь намайг чимээгүйхэн шиг тэсэн гарах боломж олгосон цугласан олон мэл гайхав бололтой, олон хүн ихэд хүндэтгэлтэйгээр харж байсан нь зүрх сэтгэлд минь нөлөөлөв, харин өөрийнхөө тухайд гэвэл, би Бурханы Сүнс хийгээд хайраар дүүрч, өөрийгөө мөрдөн хавчигчдыг, эсвээс өөр хэн нэгнийг үзэн ядсан нь үгүй”¹² хэмээн Бишоп Партриж өгүүлсэн байдаг.

Биг Блүүгийн Тулалдаан

Танхайрагч бүлэг Долдугаар сарын 23-нд дахин ирэхэд тэд хүмүүст хор хүргэхгүй байхын тулд өөрсдийгөө барьцаалан өгөхийг санал болгов. Гэвч танхайрагч бүлэг нийт Сүмд хор хохирол учруулна гэж сүрдүүлэн, бүх Хожмын Үеийн Гэгээнтнүүд тус гүнлэгийг орхин явахаар зөвшөөрүүлэхийг ах нарт албаджээ. Танхайрагч бүлгийн үйлдлүүд хууль бус, Нэгдсэн Улсын болон Миссури муж улсын үндсэн хуулиудын эсрэг байсан учраас Сүмийн удирдагчид муж улсын захирагч Даниел Данклинаас тусламж эрэв. Тэрээр тэдэнд иргэний эрхүүдийнх нь талаар зөвлөгөө өгч Гэгээнтнүүдийг хуулийн зөвлөгөө авахад чиглүүлжээ. Александр В.Донифан бусад хуульчдыг Сүмийн гишүүдийг төлөөлүүлэн хөлсөлсөн нь танхайрагч бүлгийг улам ч хилэгнүүлэв.

Эхний үед Хожмын Үеийн Гэгээнтнүүд шууд сөргөлдөөнөөс зайлсхийхийг чармайдаг байв; гэсэн хэдий ч, гишүүдийг зодож, өмч хөрөнгийг нь устгаж байсан нь эцэстээ Биг Блүү Голын ойролцоо болсон тулалдаанд хүргэсэн юм. Танхайрагчдын бүлгийн хоёр гишүүн алагдаж, Гэгээнтнүүд Андрю Барберийг алдсан ажээ. Фило Диббл гэдсэндээ гурван удаа буудуулсан байв. Ньюел Найт түүнийг адислахаар дуудагдаж, гайхамшигт үр дүнд хүрэв. Диббл Ах :

“Ньюел Найт Ах надтай уулзахаар ирээд, миний орны дэргэд суулаа. . . . Түүний гар надад хүрэхээс өмнө миний тэргүүн дээр Сүнс оршин байгааг би мэдэрч билээ, ингээд би эдгэрнэ гэдгээ тэр даруй мэдсэн. . . . Би тэр даруй босч, гурван кварт (0.94 л) буюу арай илүү цус сумаар миний биенд орсон хэсэг даавууны хамт гарав. Тэгээд би өөрөө хувцсаа өмсөж, хаалгаар гарч явав. . . . Тэр цагаас хойш дусал цус ч гарсангүй, мөн түүнээс хойш, цус алдсанаас болж бие бага зэрэг суларсныг эс тооцвол, өчүүхэн төдий өвдөлт буюу шархнаасаа болж тавгүйрхэхийг би хэзээ ч мэдрээгүй билээ”¹³ гэж өгүүлжээ.

Захирагч Данклин хоёр талын зэвсгийг хураахыг Хурандаа Томас Пичерт зуучлан зааварлав. Гэвч Хурандаа Пичер танхайрагчдын бүлгийг дэмжиж, Гэгээнтнүүдийн зэвсгийг хурааж аваад танхайрагч бүлэгт өгсөн ажээ. Хамгаалалтгүй болсон Гэгээнтнүүийг дайрч, гэр орныг нь устгаж байлаа. Хүмүүс ойд толгой хоргодох газар эрэх буюу эсвэл зодуулж хүндээр бэртэж байлаа. Эцэст нь өөрсдийнхөө юмыг авч, Жэксон Гүнлэгээс дүрвэхийг Сүмийн удирдагчид хүмүүст уриалжээ.

Клей Гүнлэгт Толгой Хоргодсон нь

1833 оны сүүлчээр Гэгээнтнүүдийн олонхи нь Клей Гүнлэг рүү Миссури Мөрнийг хойд талаар гатлан тэнд түр зуур толгой хоргодох газар олсныг Парли П.Пратт дүрслэхдээ:

“Гармын хоёр талаар жагссан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдээр эрэг дүүрч эхлэв; ачаа бараа, хөсөг тэрэг, хайрцагтай юмнууд, хоол хүнс гээд гарам байнга завгүй байх болов; дахин шөнө болж, хөвөнгийн модоор элбэг тэр газрыг бидний дээгүүр харанхуйлахад, аяны цуглааны төрх байдалтай болно. Зүг бүрд хэдэн зуун хүмүүс харагдана, бороо цутган ороход зарим нь майханд, зарим нь галынхаа эргэн тойронд задгай агаарт байлаа. Нөхрүүд нь эхнэрээ, эхнэрүүд нь нөхрөө; эцэг эхчүүд нь хүүхдүүдээ, бас хүүхдүүд нь эцэг эхчүүдээ сураглана. Зарим хүмүүс гэр бүлийнхэнтэйгээ хамт, гэрийн эд

хогшилтойгоо, хоол хүнстэй дүрвэх аз тохиосон байхад, бусад нь найз нарынхаа хувь заяаг мэдэхгүй, бүх эд хөрөнгөө алдсан байлаа. Ийм дүр зураг . . . биднийг харалганаар мөрдөн хавчигчид, бас харалган хийгээд харанхуй бүдүүлэг тэр нутгийнхнаас бусад газар дэлхий дээрх хүмүүсийн зүрх сэтгэлийг уяраан хайлуулах байсан биз ээ”¹⁴ гэжээ.

Ийнхүү Жэксон Гүнлэгт Сионыг үндэслэн байгуулж мөн өөрсдийн Бурханд ариун сүм барих боломжийг Гэгээнтнүүдээс түр хугацаагаар хүчээр булаан авчээ. Эдүгээ Сүмийн 1200 орчим гишүүд Клей Гүнлэгт голын дэргэд хахир хатуу өвлийг даван туулахад шаардлагатай байсан тэр зүйлийг хийжээ. Зарим хүмүүс мухлаг тэргэн дээрх хайрцагнуудад, майханд юм уу эсвэл өндөр газрын хажуу бэлд ухсан нүхнүүдэд толгой хоргодож байсан бол бусад нь хаягдсан бүхээгнүүдэд оржээ. Ньюел Найт Индиан урцанд өвөлжсөн ажээ.

Клей Гүнлэгт Гэгээнтнүүдийн барьсан анхны барилгуудын нэг нь шүтэн бишрэхэд зориулсан, сүмийн жижигхэн дүнзэн байшин байлаа. Энд тэд “өөдгүй дайснуудын гараас чөлөөлснийх нь төлөө Бүхнийг Чадагч Бурханд хариу талархал өргөж, ирээдүйн төлөө Түүний хамгаалагч халамжлалыг эрэлхийлэхээ мартсангүй—ингэснээр тэдний зугтан очсон хүмүүсийн зүрх сэтгэлийг Тэрбээр зөөллөж, ингэснээр тэд хүмүүсийн дунд өөрсдийг нь дэмжих ямар нэг зүйлийг олж болох байлаа.”¹⁵

Сионы Хуаранг Мөшгин Хавчсан нь

Жэксон Гүнлэгт газраасаа хөөгдсөн Гэгээнтнүүдэд туслахын тулд Көртландаас Миссури уруу аялах хүмүүсийг цуглуулах зарлигийг Их Эзэн Иосеф Смитэд өгснийг бүлэг 3-т дүрсэлсэн билээ. Сионы Хуаран 1834 оны Зургадугаар сарын сүүлчээр Миссурийн дорнод Клей Гүнлэгт хүрэхэд 300 гаруй хүнтэй Миссуричүүдийн танхайрагч бүлэг—тэднийг устгах зорилгоор өөдөөс нь угтан гарсан аж. Ах нар Бошиглогчийн удирдлагаар Литтл Фишинг, Биг Фишинг голуудын уулзвар дээр хуаранг байрлуулжээ.

Танхайрагч бүлэг их бууны галаар дайрч эхэлсэн боловч Их Эзэн Гэгээнтнүүдийн талд тулалдсан юм. Толгой дээгүүр үүл түргэн хуралдаж эхлэв. “Бороо, дараа нь мөндөр орж эхлэв. . . . Хүчтэй шуурга дэгдэв; салхи, бороо, мөндөр, аянга тэднийг хилэгнэн угтав, тэгээд удалгүй тэдний зүрх үхэж, ‘Жоү Смит болон түүний армийг устгах’ тэдний бүх төлөвлөгөө нурав. . . . Байлдааных нь хэрэгсэл шалба нороход тэд шуурга өнгөртөл мухлаг тэрэгнүүд доогуур, модны хонхор уруу мөлхөн орж, нэгэн болхи модон оромжийг пиг дүүртэл чихсэн байлаа. Шөнөжингөө шуургаар нүдүүлсний дараа ‘бошиглогч болон гэгээнтнүүдийг алахаар тангараг өргөсөн танхайрагчдын хэсэг ниргүүлэн танхайрагчдын үндсэн хэсэгтэй нийлэхийн тулд’ Индепенденс уруу гэдрэг ухрахдаа, Иехова тулалдах үед тэд байхгүй болж мэднэ . . . гэдэгт бүрэн үнэмшсэн байлаа. Өс авах буюу хариу барих нь Өөрийн Гэгээнтнүүдийг тэдний дайснуудаас хамгаалахын тулд тулалдсан Бурханаас урагш гарч ирсэн мэт байлаа”¹⁶ хэмээн нөхцөл байдлыг Бошиглогч дүрсэлжээ.

Танхайрагчдын арми Гэгээнтнүүдтэй сөргөлдөн, Захирагч Данклин тэдэнд туслах амлалтаа биелүүлэхгүй нь тодорхой болсон үед Бошиглогч Их Эзэнээс заавар хүсч залбирав. Тэр үеийн нөхцөл байдал нь Сионы гэтэлгэлийн тулд зөв биш байсныг Их Эзэн түүнд хэлсэн ажээ. Сионыг барихын төлөө хувийнхаа амьдралыг бэлтгэхийн тулд Гэгээнтнүүд маш ихийг хийх шаардлагатай байв. Тэднээс олон нь Их Эзэний шаарддаг зүйлүүдэд: “Энэ нь сэлэстиэл хаант улсын хуулийн зарчмуудаар биш бол, Сион байгуулагдаж чадах нь үгүй; эс тэгвээс бибээр үүнийг өөртөө хүлээн авч чадахгүй. Мөн тэд дуулгавартай байдлыг сурах хүртлээ миний хүмүүс, хэрэв энэ нь шаардагдах аваас, тэдний амсах ёстой тэр зүйлүүдээр зэмлэгдэх ёстой нь шаардлагатай байна” (С ба Г 105:5–6) гэдэгт дуулгавартай байж хараахан сураагүй байлаа.

Сионы Хуаран цэрэг дайны зорилго өвөрлөх ёсгүйг Их Эзэн зааварлаж: “Миний хүмүүсийн зөрчлүүдийн улмаас, миний ахлагчид Сионы гэтэлгэлийг багахан хугацаагаар

хүлээх ёстой нь надад шаардлагатай байна—Тэд өөрсдөө бэлтгэгдэхийн тулд, мөн миний хүмүүс илүү төгсөөр заалгаж болохын тулд буюу” (С ба Г 105:9–10) гэжээ. Сионы Хуарангийн ах нар хүндтэйгээр чөлөөлөгдөж, Бошиглогч Көртландад эргэж ирэв.

Фар Фар Вест Дэх Сүмийн Төв Байгууллагууд

Миссурийн Гэгээнтнүүдийн олонхи нь тэд зөвхөн Жэксон Гүлнэг рүү буцах хүртлээ энд байх болно гэж амласныг нь нутгийн иргэд тэдэнд сануулсан 1836 оныг хүртэл Клей Гүлнэгт үргэлжлэн байжээ. Одоо бол боломжгүй мэт санагдах боловч, тэднийг барьцаалагдсан байдлаар гарч явахыг тэднээс хүсчээ. Хууль зүйн хувьд тэд үүнийг гүйцэтгэх ёсгүй байсан боловч, зөрчил бий болгохоос зайлсхийн, тэд дахин нүүсэн ажээ. Муж улсын хууль тогтоох байгууллага дахь тэдний найз Александр Донифаны хүч чармайлтаар 1836 оны Арванхоёрдугаар сард Рей Гүлнэгээс Колдвелл, Давиесс нэртэй хоёр шинэ гүлнэгийг бий болгожээ. Клей Гүлнэгээс умардад 60 миль орчимд өөрсдийн Фар Вестийн суурин нутаг болох Колдвелл Гүлнэгийн нутгийг үндэслэн бий болгохыг Гэгээнтнүүдэд зөвшөөрөв. Тус гүлнэгийн анхны албан хаагчид нь Хожмын Үеийн Гэгээнтнүүд байсан бөгөөд энэ нь Гэгээнтнүүдийг мөрдөн хавчихыг төгсгөл болгоно хэмээн олон хүн найдаж байв.

Огайогийн Көртландаас хийсэн хүнд бэрх аяны дараа Бошиглогч Иосеф Смит 1838 оны Гуравдугаар сард Миссурийн Фар Вестэд хүрч ирэн, Сүмийн төв байгууллагуудыг тэнд үндэслэн бий болгожээ. Тавдугаар сард тэрээр умардад Давиесс Гүлнэг рүү явж, Гранд Гол уруу очихдоо, тэр бүс Адам-ондай Аманы Хөндийг “Адам өөрийн хүмүүстэй уулзахаар ирэх” тэр газар болохыг бошиглолоор тогтоосон ажээ (С ба Г 116:1).¹⁷ Адам-ондай Аман Давиесс Гүлнэг дахь Гэгээнтнүүдийн анхны суурьшмал нутаг болсон юм. 1838 оны Долдугаар сарын 4-нд Фар Вестэд ариун сүмийн суурийн чулуу онцгойлон адислагдаж, тэд эцсийн эцэст дайснуудаасаа түр амсхийлт оллоо гэж Гэгээнтнүүд бодох болжээ.

Крукед Голын Тулалдаан

Гэвч мөрдлөг хавчлага дахин эхлэв. 1838 оны Наймдугаар сарын 6-нд 100 хүнтэй танхайрагчдын бүлэг Давиесс Гүнлэгийн Галлатинд сонгуулийн санал өгөлт дээр Гэгээнтнүүдийг санал өгүүлсэнгүй. Энэ нь нилээд хэдэн хүн бэртсэн зодоонд хүргэв. Эмх замбараагүй явдал өсөн нэмэгдсэн нь Захирагч Лилбөрн В.Богтс муж улсад энхийг сахиулахын тулд цагдаагийн хүчийг авчрахад нь Колдвелл, Давиесс Гүнлэгүүд дахь танхайрагч бүлэг дэм үзүүлжээ.

Цагдаагийн хүчний офицеруудын нэг ахмад Самуел В.Богарт хэрэг дээрээ танхайрагч бүлэгтэй ойр дотно холбоотой байжээ. Хожмын үеийн гурван хүнийг хулгайлж, тэднийг Рей Гүнлэгийн баруун хойт хэсэг Крукед Гол дээр өөрийн хуаранд барьж байснаар сөргөлдөөнийг эхлэхээр шийдсэн ажээ. Эдгээр хүмүүсийг аврахын тулд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн цагдаагийн сайн дурын хамтлагийг явуулснаар, 1838 оны Аравдугаар сарын 25-нд ширүүн тулалдаан болов. Арванхоёр Төлөөлөгчийн нэг, ахмад Давид В.Паттен хамтлагийг удирдсан бөгөөд тулалдаанд үхлийн шарх олсон хүмүүсийн дунд оржээ. Давидын гэргий Фоеве Анн Паттен, Иосеф Смит, Харум Смит хоёр; түүнчлэн Хибер К.Кимбалл нар нас эцэслэхийнх нь өмнө түүнтэй хамт байхаар Фар Вестээс ирэв.

Давид Паттены талаар Хибер хэлэхдээ: “Өмнө нь түүнд төдий их үнэ цэнэтэй байсан Сайн мэдээний зарчмууд түүнийг талийгаач болох тэр үед түүнд дэмжлэг хийгээд тайвшралыг авчирч, үхлийг үүний ялзрал хийгээд аймшгаас ангижруулсан юм” гэжээ. Өөд болж байгаа тэр хүн, тууштай байдлаасаа урваж урвалтад унасан зарим Гэгээнтнүүдийн тухай орныхоо дэргэд байсан хүмүүст, “Ай тэд миний нөхцөл байдалд байсан болоосой! Учир нь би итгэлээ хадгалснаа мэдэрч байна” гэж тайлбарлан ярьжээ. Дараа нь тэрээр Фоебе Аннад хандан, “Чи өөр юу ч хийлээ гэсэн, Ээ, итгэлээ л бүү үгүйсгээрэй” гэж хэлсэн аж. Тэрээр өөд болохынхоо дөнгөж өмнөхөн, “Эцэг минь, Та сүнсийг минь чөлөөлж,

үүнийг Өөртөө хүлээн авна уу хэмээн би Есүс Христийн нэрээр Танаас гуйж байна” хэмээн залбирчээ. Тэгээд дараа нь тэрээр өөрийнхөө эргэн тойронд байсан хүмүүст хандаж, “Ах нараа, та нар намайг итгэлээрээ өргөж байлаа, гэвч намайг орхиж, намайг явуулаач, би та нараас гуйж байна” хэмээн гуйжээ. “Тэр дагуу бид түүнийг Бурханд даатгаж, тэгээд тэр удсан ч үгүй эцсийнхээ амьсгалыг хурааж, ёолсон ч үгүй Есүсийн дотор нойрссон юм”¹⁸ гэж Кимбалл ах хэлсэн байдаг.

Ахмад Самуел Богартын хамтлаг муж улсын цагдаа гэхээсээ илүүгээр танхайрагч бүлэгтэй адил үйл ажиллагаа явуулж байв. Гэсэн хэдий ч, Крукед Голын Тулалдаанд цагдаа алагдсан нь бусад мэдээллүүдийн хамт түүний “хүйс тэмтрэх шившигт тушаалыг” томьёолоход Захирагч Лилбөрн В.Богтсыг түлхсэн аж. 1838 оны Аравдугаар сарын 27-ны өдрийн тэрхүү тогтоолын нэг хэсэгт, “Мормончуудыг дайсан гэж үзэн, хүйс тэмтрэх буюу хэрэв шаардлагатай гэж үзвэл Муж улсаас хөөн гаргах ёстой, олон нийтийн амар амгалан байдлын хувьд—тэдний бухимдал өгүүлэхийн аргагүй их байна”¹⁹ хэмээн нотолсон байлаа. Захирагчийн тушаалыг биелүүлэхийн тулд цагдаагийн офицер томилогдсон байлаа.

Хауны Тээрэм дээр Олноор нь Хөнөөсөн нь

Хүйс тэмтрэх тушаал гарснаас хойш гурав хоногийн дараа 1838 оны Аравдугаар сарын 30-нд Колдвелл Гүнлэгийн Шоэл Грийк дахь Хауны Тээрэм дээр цөөн тооны Гэгээнтнүүдийн эсрэг 200 орчим хүн гэнэтийн дайралт зохион байгуулжээ. Дайрагчид урван тэрсэлсэн үйл ажиллагаагаар, өөрсдийгөө аврахыг хүссэн хүмүүсийг дархны газар луу орохыг дуудсан аж. Тэгээд барилгын орчны газрыг эзэлж аван, барилга уруу гал нээж, дотор нь байсан бүх хүмүүсийг үхсэн гэж бодсон ажээ. Бусдыг нь зугтаах гэж оролдох үед нь бууджээ. Нийт 17 эрэгтэй хүн, хөвгүүн алагдаж, 15 хүн шархадсан байв.

Ийнхүү олноор нь хөнөөсний дараа Аманда Смит дархны газар луу орж, нөхөр Варрен хүү Сардиус нар нь

үхсэн байхыг олж харжээ. Олноороо алагдасдын дунд хүнд шархадсан боловч амьд байсан өөр нэг хүү, бяцхан Алмаг тэрээр олж тун баяртай байлаа. Түүний дунд чөмөг их бууны сумны дэлбэрэлтээр хажуу тийшээ эргэсэн байлаа. Хүмүүсийн олонхи нь үхсэн буюу шархадсан учир Аманда өвдөг сөгдөн, Их Эзэнээс тусламж гуйжээ:

“Ай, Тэнгэрлэг Эцэг минь, би яах билээ? Би уйлан хайлан байна. Шархадсан миний муу хүүг Та харж байна, бас миний туршлагагүйг мэднэ. Ай Тэнгэрлэг Эцэг минь, хийх зүйлд минь намайг чиглүүлээч!” “Нэг дуу хоолойгоор чиглүүлэгдэн, тэрээр шарх цэвэрлэх үнсний уусмал бэлтгэхээр зааварлагдсан” гэж Аманда ярьжээ. Тэгээд тэр хайлаасны навч, холтсоор чийглэг зөөлөн, зуурмаг бэлтгэж, шархыг түүгээр дүүргэв. Маргааш нь тэр шарх руу нэг лонх бальзам цутгав.

“Алма, миний хүү, . . . Их Эзэн чиний дунд чөмгийг хийсэн гэдэгт чи итгэдэг үү? гэж тэр хүүдээ хэлэв.

“Тийм ээ, ээж ээ.

“За тэгвэл, Их Эзэн чиний дунд чөмгийг хэвэнд нь оруулахад ямар нэг зүйл хийж чадна, тэр тэгж чадна гэдэгт чи итгэж байгаа биз дээ, Алма?

“Их Эзэн үүнийг хийж чадна гэж та бодож байна уу? гэж хүүхэд энгийнээр лавлав.

“Тийм ээ, миний хүү, тэр энэ бүхнийг надад үзэгдлээр харуулсан гэж би хариулав.

“Тэгээд би түүнийг эвтэйхнээр дээш нь харуулж хэвтүүлээд: Одоо ингээд хэвт, хөдөлж болохгүй, тэгээд Их Эзэн чамд өөр нэг дунд чөмөг хийх болно гэж хэлэв.

“Тийнхүү Алма бүрэн эдгэрэх хүртлээ—хөдлөхөө байсан үе болон булууны хонхорт уян хатан мөгөөрс бий болтол таван долоо хоног дээшээ харж хэвтсэн юм.”²⁰

Аманда болон бусад хүмүүс өөрсдийнхөө хайртай хүмүүсийг оршуулах тэрхүү аймшигтай зүйлийг нүдээрээ харсан юм. Бие бялдрын чадвартай хэдхэн хүн, түүний дотор Бригам Янгийн ах Жозеф Янг үлдсэн ажээ. Танхайрагч бүлэг эргэн ирэхээс тэд

айж байсан учир ердийн булш ухах цаг байсангүй. Цогцсуудыг нэг хуурай худагт хийн, нийтээр нь оршуулжээ. Бяцхан Сардиусын цогцсыг авч гарахад Жозеф Янг тусалж, “тэрээр хөвгүүнийг энэхүү аймшигтай булш руу хаяж чадсангүй” гэж хэлжээ. Тэрээр “энэхүү сонирхолтой хөвгүүнтэй” Миссури уруу аялах замд тоглож явсан бөгөөд Жозефын “уг мөн чанар нь зөөлөн сэтгэлтэй байсан” тул үүнийг хийж чадаагүй ажээ. Аманда Сардиусыг хөнжлийн даавуунд ороож, маргааш нь тэр болон өөр нэг хүү Виллям нь цогцсыг худагт хийжээ. Энэхүү аймшигт хэсэгхэн газрыг дараа нь шороо, сүрлээр хучжээ.²¹

Адам-ондай Аманд 20 настай Бенжамин Ф.Жонсон Миссурийн нэгэн этгээд түүнийг буудахаар шийдэж, мөн үүнтэй төстэй хувь заяа түүнд ноогдон амь хэлтрүүлэгдэв. Бенжаминыг баривчилж, задгай түүдэг галын өмнө, туйлын хүйтэн цаг агаарт найман өдөр харуул хамгаалалт гарган цагджээ. Түүнийг гуалин дээр сууж байтал, нэг харгис этгээд гартаа винтов буу барин, түүн рүү хүрч ирэн, “Чи Мормоны шашныг яг одоо хая, үгүй бол би чамайг буудлаа” гэж хэлжээ. Бенжамин шийдэмгий татгалзахад, мөнөөх балмад этгээд түүн рүү буугаа онилон шагайж, гохоо дарав. Буу авалцсангүй. Тэр хүн чангаар хараал тавиад, “бууг 20 жил ашиглахад өмнө нь нэг ч удаа ингэж гацаж байгаагүй” гэж хэлэв. Тэрээр бууны замгийг шалгаад, дахин сумлаж, шагайн, гохыг дарсан боловч буу дахин гацав.

Мөн ийм байдлаар тэр гурав дахь удаагаа оролдсон боловч үр дүн нь нэгэн адил байв. “Буугаа жаахан янзалчих, тэгвэл чи энэ хараал идмэрийг цааш нь харуулж чадна” гэж нэгэн гэрчлэгч түүнд хэлэв. Тэгээд дөрөв дэх удаа, мөн эцсийн удаа, тэр алуурчин бэлтгэж, бүр шинэ сум хийжээ. Гэвч Бенжамин, “Энэ удаад буу дуугарч, нөгөөх өөдгүй этгээдийг цааш нь харуулах нь тэр” гэжээ. “Чи энэ хүнийг алах гэж оролдохгүй байсан нь дээр байсан юм” гэж Миссурийнхний нэг нь хэлэх нь сонсогджээ.²²

Бошиглогч Шоронд Хоригдов

Хауны Тээрэм дээр хүмүүсийг олноор нь хүйс тэмтэрсний дараа Бошиглогч Иосеф Смит болон бусад удирдагчдыг муж улсын цагдаагийн газар шоронд хийв. Цэргийн шүүх хурал болж, Бошиглогч болон түүний нөхдийг зэвсэгт бүлэглэл маргааш өглөө нь Фар Вест дахь хотын талбайд, буудан алах ял оноон буруутгажээ. Гэвч, цагдаагийн Генерал Александр В.Донифан, уг шийдвэрийг “санаатай аллага” хэмээн нэрлэж, тэднийг буудахыг хэрэгжүүлэхээс татгалзав. Хэрэв тэр эдгээр хүмүүсийг цаазлах оролдлогоо үргэлжлүүлэх юм бол “Би таныг дэлхийн шүүх хурлын өмнө хариуцлагад татах болно, үүнд Бурхан надад тусална” гэж тэрээр цагдаагийн газрыг захирч байсан генералд сэрэмжлүүлсэн ажээ.²³

Бошиглогч болон бусад хүмүүсийг эхлээд Индепенденст аваачив, тэгээд дараа нь Клей Гүнлэгийн Ричмонд уруу илгээж тэнд шүүх хурал хүлээлгэн шоронд хорив. Парли П.Пратт бол Бошиглогчтой хамт байсан хүмүүсийн нэг юм. Нэг орой хоригдлуудыг харуулууд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дундах тэдний хүчин, аллага, дээрмийн хэргүүдийн тухай ярьж элэг доог болгон байсныг тэрээр өгүүлжээ. Бошиглогч түүний дэргэд сэрүүн байсныг мэдэж байсан бөгөөд Иосеф гэнэт өндийн босч ирээд, их хүчтэйгээр харуулуудыг зэмлэж хэлсэн нь:

“ЧИМЭЭГҮЙ, чөтгөрийн найз нар та нар. Есүс Христийн нэрээр та нарыг би зэмлэн буруутгаж, чимээгүй байхыг би та нарт зарлиглаж байна; би ийм хэлийг сонсож дахиад нэг минут амьдрахгүй. Ингэж ярихаа зогсоо, ЭНЭ МӨЧИД нэг бол та нар нэг бол би үхнэ!

“Тэр ярихаа зогсов. Тэрээр агуу сүртэйгээр босон зогсож байлаа. Салгалан чичирч, зэвсэг нь доош буусан буюу газарт унасан харуулуудыг тэрээр гинжлүүлсэн, зэвсэггүй; тэнгэр элч мэт амгалан тайван хийгээд эрхэмсгээр ширтэн харахад тэдний өвдөг нь нийлж, буланд шавааралдан, түүний хөл дор атиралдан, түүнээс уучлал гуйж, тэгээд харуулууд солигдтол таг чимээгүй байлаа.”



Либертийн Шоронд хоригдож байхдаа Бошиглогч Иосеф Смит Гэгээнтнүүдийн зовлон зүдгүүрүүдийн учир Их Эзэнд хандан гуйж, тэгээд эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 121, 122, 123-т цэдэглэгдсэн бурханлиг чиглүүлэл хийгээд тайтгарлыг хүлээн авчээ.

“Хаад, хааны шүүхүүд, хаан ширээ хийгээд титмүүдийн талаар; хаант улсуудын хувь заяаг шийдэхээр эзэн хаад цугларсныг төсөөлөхийг би хичээдэг байсан, гэвч Миссурийн нэрд гараагүй нэгэн тосгон дахь газар доорх шоронд шөнө дунд, гинжлүүлэн зогсож байсан ийм эрхэмсэг, сүрлэг нэгнийг одоо л харж байгаа минь энэ билээ”²⁴ гэж тэр үед Парли өгүүлжээ.

Шүүхийн байцаалт дуусахад, Иосеф Смит, Хайрум Смит, Сидней Ригдон, Лайман Вайт, Калев Болдвин, Александр МакРей нарыг Клей Гүнлэгийн Либертийн Шорон уруу явуулж, тэд энд 1838 оны Арванхоёрдугаар сарын 1-нд иржээ. Бошиглогч өөрсдийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо:

“Биднийг өдөр ч шөнө ч, хүчтэй харуул хамгаалалт дор давхар хана хаалгануудтай шоронд байлгаж, бидний ухамсрын эрх чөлөөг хориглож, бидний хоол хомс тарчиг байлаа. . . . Биднийг сүрэл дэвссэн шалан дээр албадан унтуулж байсан бөгөөд хучих дулаан хөнжил бидэнд хүрэлцээгүй байв. . . . Бид гэм буруугүй байсныг, иймээс бид чөлөөлөгдөх ёстой байсныг Шүүгчид үе үе бидэнд санаа зовон ярьдаг байлаа, гэвч тэд хуулийг бидний хувьд хэрэглэж зүрхлэхгүй байв, учир нь танхайрагч бүлгээс айж байжээ.”²⁵

Иллиной уруу Дүрвэсэн нь

Бошиглогчийгоо шоронд хоригдож байсан тэр үед 8000 гаруй Гэгээнтнүүд хүйс тэмтрэн устгахаас зугтаж, Миссурийг гатлан Иллиной уруу зүүн тийш явжээ. Өвлийн хүйтнээр тэд явахаар албадуулагдсан бөгөөд Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янг тэднийг чиглүүлж, боломжтой бүх тусламжийг тэдэнд үзүүлж байсан ч гэсэн, тэд асар их зовлон бэрхшээл амсчээ. Толгой хоргодох газар эрж байсан олон гэр бүлийн нэг нь Жон Наммерын гэр бүл байв. Тэрхүү хүнд хэцүү нөхцөл байдлыг Жон эргэн дурсахдаа:

“Тэр цагийн зовлон бэрхшээл, хахир хатууг би сайн санадаг. . . . Манайх ганц мухлаг тэрэгтэй байв, тэргэнд хөллөх бидний бүх мал гэвэл ганц сохор морь, тэр сохор морь маань бидний бүх эд юмыг Иллиной Муж улс руу зөөх учиртай байв. Бид жижигхэн мухлаг тэргээ хоёр морьтой ахтайгаа морь бүхий нэг хөнгөн мухлаг тэргээр солилцсон, энэ нь хоёуланд маань таатай байлаа. Энэ жижигхэн мухлаг тэргэнд бид хувцас хунар, ор дэр, жаахан эрдэнэ шишийн будаа, бидний цуглуулж авсан бусад бага сагахан хүнсээ тавиад, тэс хөлдүү хүйтэн цагаар явган хөдөлж билээ, тэгээд тэнгэрийн лавринг хучлагаа болгон замын хажууд хооллож, унтаж явлаа. Шөнийн тасхийсэн жавар, нэвт үлээсэн салхи нь, уур хилэнгийнх нь өмнө бидний зугтсан тэрхүү хүн дүрст чөтгөр шулмуудаас хавьгүй өр нимгэн, хэрцгий бус байлаа. . . . Бусад олон гэр бүлийн адил манай гэр бүл бараг

л хөл нүцгэн байв, хөлдөхөөс болон хөлдүү газрын хурц үзүүрээс хөлөө хамгаалж дулаацуулахын тулд тэд хөлөө даавуугаар ороосон байлаа. Энэ нь сайндаа л туйлын ядмагхан хамгаалалт болж байсан бөгөөд бидний хөлнөөс цус олонтаа гоожиж, хөлдүү газар мөр үлддэг байв. Миний ээж, эгч хоёр гэрийнхэн дундаас гуталтай нь байсан хэдий ч тэдний гутал элэгдэж хуучирснаас, биднийг Иллинойн зочломтгой эргүүд хүрэхээс өмнө бараг л хэрэгцээгүй болж билээ.”²⁶

Тус муж улсаас түүний хүмүүс хөөгдөж гарах үеэр Бошиглогч яах ч аргагүйгээр шоронд хүлээн сууж байлаа. Түүний сэтгэл зүрхний шаналал, Сургаал ба Гэрээ, хэсэг 121-д цэдэглэгдсэнчлэн, Их Эзэнд хандсан түүний гуйлтад илэрч байлаа:

“Ай Бурхан минь, та хаана байна вэ? Мөн таны байгаа нууц газрын бүрхэгч тэрхүү асар хаана байна вэ?

“Таны мутар хичнээн удаан хүлцэн тэвчих юм бэ, мөн таны мэлмий, тийм ээ таны цэвэр ариун мэлмий өөрийнхөө хүмүүсийн бас өөрийнхөө үйлчлэгчдийн буруу зүйлүүдийг мөнхийн тэнгэрээс болгоогооч, мөн тэдний гуйлтууд сонорт тань хичнээн удаан нэвтрэх юм бэ?” (С ба Г 121:1-2).

“Хүү минь, бодгальд чинь амар амгалан байг; саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно;

“Мөн тэгээд чи үүнийг дажгүй давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно; чи бүх дайснуудаа ялах болно.

“Найз нар чинь чиний дэргэд зогсох бөлгөө, мөн тэд халуун дотно сэтгэлээр мөн нөхөрсөг гараараа чамайг дахин мэндчилэх болно” (С ба Г 121:7-9) гэсэн эдгээр тайтгаруулагч үгсээр Их Эзэн түүнд хариулжээ.

Их Эзэний үгс 1839 оны Дөрөвдүгээр сард үнэнхүү бие-лэгдсэн юм. Зургаан сар хууль бусаар шоронд хоригдсоны дараа хоригдлуудын хоригдох газрыг эхлээд Миссурийн Давиесс Гүнлэг дахь Галлатинд, дараа нь Бууне Гүнлэгийн Колумбид болгож өөрчилжээ. Гэвч, Цагдаагийн Дарга Виллям Морган “[тэднийг] Бууне Гүнлэгт хэзээ ч аваачих-

гүй” байх заавар хүлээн авсан байжээ. Дээд албан тушаал дахь нэг хүн буюу хэсэг хүмүүс хоригдлуудыг оргуулахаар шийдсэн нь тэднийг ялах нотолгоо байхгүй байхад олон нийтийн мөрдлөгөөс ичиж зовон зайлсхийх зорилготой байж болох юм. Хоёр морь худалдаж авах болон харуулуудаас бултаж гарах боломжийг хоригдлуудад олгожээ. “Бидний газар Иллиной муж улсад болж өөрчлөгдөн, тэгээд найм буюу есөн өдрийн зам туулж, Адамс Гүнлэгийн Квинсид эсэн мэнд хүрч ирэн, ядуу зүдүү хэдий ч, эрүүл мэнд нь сайн байсан гэр бүлийнхэнтэйгээ бид тэнд учрав”²⁷ хэмээн Хайрум Смит хэлжээ. Тэнд тэднийг үнэхээр “халуун сэтгэл, нөхөрсөг гар” мэндчилэн хүлээж авсан юм.

Бошиглогчтой дахин нэгдсэн тухайгаа Вилфорд Вудрафф өгүүлэхдээ: “Иосеф Ахыг гараараа тэврэх онцгой боломж надад дахин тохиов. . . . Тэрбээр агуу баяр хөөртэй бидэнтэй мэндчилэв. . . . [Тэр] илэн далангүй, эв нийцтэй, ердийнх шигээ найзархаг байсан бөгөөд бидний баяр хөөр туйлын их байлаа. Ийм уулзалтаар бий болсон баярт мэдрэмжүүдийг сайн мэдээний төлөө гай зовлон амссан хүнээс бусад хүмүүс ойлгож чадахгүй.”²⁸ Их Эзэн өөрийн Бошиглогч болон Сүмийн бие бүрэлдэхүүнийг гайхамшигтайгаар хамгаалан үлдээсэн юм. Өнөө үеийн Израил шинэ газарт шинэ боломжууд хийгээд тэдний өмнөх гэрээнүүдтэйгээр нэгэнтээ дахин цугларч эхлэв.


Навуу дахь Золиослол ба Адислалууд

Иллиной уруу аян замаа хөөсөн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг Квинси хотхоны өгөөмөр сэтгэлт иргэд халуун дотноор хүлээн авав. Либертийн Шоронд хоригдсоныхоо дараа Бошиглогч Иосеф Смит эргэж ирснээс хойш, Гэгээнтнүүд умард зүгт Миссиппи Мөрнийг өгсөн 35 миль орчим нүүдэллэв. Тэнд тэд уг нутаг дахь том намгийг хатааж голын нэг тохойн хажууд Навуу хотыг барьж эхэлжээ. Хот удалгүй ажил үйлс, арилжаа наймаа өрнөсөн газар болж, Нэгдсэн Улс, Канад, Английн өнцөг булан бүрээс тэнд Гэгээнтнүүд цугларч эхлэв. Дөрвөн жилийн дотор Навуу Иллиной дахь хамгийн том хотуудын нэг болжээ.

Сүмийн гишүүд харьцангуй тайван байдалд, аюулгүй амьдарч, бошиглогч тэдний дунд алхан, тэдэнтэй хамт хөдөлмөрлөж байлаа. Бошиглогчийн дуудсан хэдэн зуун номлогч нар сайн мэдээг тунхаглахаар Навууг орхин одов. Ариун сүм баригдаж, ариун сүмийн хишиг хүлээн авагдаж, анх удаа хэсгүүд зохион байгуулагдан, гадаснууд үндэслэгдэж, Нийгмийн Халамжийн Бүлэг зохион байгуулагдан, Абрахамын ном хэвлэгдэн чухал илчлэлтүүд хүлээн авагдаж байлаа. Зургаан жил гаруйхан хугацаанд Гэгээнтнүүд эв нэгдэл, итгэлийн хийгээд аз жаргалын гайхамшигт зэрэглэлийг харуулж, тэдний хот хөдөлмөрч зан чанар хийгээд үнэний гэрэлт цамхаг болов.

Навуугийн Номлогч нарын Золиослолууд

Гэгээнтнүүд орон гэр барьж, тариа тарих явцад тэднээс олон нь халуурч, дааран жихүүцдэг халдварт өвчин хумхаагаар өвчилжээ. Өвчтөнүүдийн дотор Арванхоёрын олонхи



Гэгээнтнүүд Миссиссиппи Мөрний эрэг дээр үзэсгэлэнт Навуугийн хотыг байгуулсан юм. Навуугийн Ариун Сүм хотын дээгүүр сүндэрлэн байдаг.

нь түүнчлэн Иосеф Смит өөрөө байжээ. 1839 оны Долдугаар сарын 22-нд Бошиглогч түүн дээр оршсон Бурханы хүчээр өвчин нь илааршиж, орноосоо босч ирэв. Тэрээр санваарын хүчийг ашиглан өөрийгөө болон өөрийнхөө гэрт байсан өвчтөнүүдийг эдгээж, өөрийнх нь хашаанд майхнуудад байрласан хүмүүсийг эсэн мэнд болгохоор зарлиг өгсөн ажээ. Олон хүмүүс эдгэрэв. Бошиглогч майхнаас майханд, гэрээс гэрт очиж, хүн бүрийг адисалж байв. Энэ бол Сүмийн түүхэн дэх итгэлийн хийгээд эдгэрлийн агуу өдрүүдийн нэг байлаа.

Энэ үед Бошиглогч Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгыг Англид номлолоор явуулахаар дуудав. Арванхоёрын Чуулгын гишүүн, Ахлагч Оорсон Хайдыг Иудейн хүмүүс болон Абрахамын бусад хүүхдүүдийн цугларалтын төлөө Палестиныг онцгойлон адислуулахаар Иерусалим уруу явуулав. Нэгдсэн Улс даяар болон дорнод Канадад номлуулахаар номлогч нарыг илгээж, мөн Аддисон Пратт болон бусад хүмүүс Номхон Далайн Арлууд руу явах дуудлага хүлээн авчээ.

Эдгээр ах нар гэр орон, гэр бүлээ орхин Их Эзэнд үйлчлэх дуудлагадаа хариулахын төлөө агуу золиослолууд хийсэн билээ. Арванхоёрын олон гишүүн Английг зорин явахаар бэлтгэж байхдаа хумхаагаар өвчилсөн ажээ. Хүнд өвчтэй байсан Вилфорд Вудрафф гэргий Фоебегээ бараг хоол хүнсгүй, амьдралын эн тэргүүний хэрэгцээтэй зүйлүүдгүйгээр орхин явжээ. Хамгийн залуу Төлөөлөгч Жорж А.Смит, түүнийг мухлаг тэргэнд өргөж оруулахаар тийм өвчтэй байсан бөгөөд түүнийг харсан нэг хүн, тэд оршуулгын газар тоносон хэрэг үү гэж жолоочоос нь асуусан ажээ. Эхнэр хүүхдүүдээ өөртэйгөө хамт авч явсан Парли П.Пратт, түүний ах Оорсон Пратт, түүнчлэн Жон Тейлор нар л зөвхөн Наувүүг орхиж явахдаа өвчлөөгүй байсан хэдий ч, Ахлагч Тейлор хожим нь тэд Нью-Йорк Хот руу явж байхдаа хүндээр өвчилж бараг үхэх шахжээ.

Бригам Янг бүр ойрхон зайд ч явган явж чадахгүй тийм их өвчтэй байсан бөгөөд түүний хамтрагч Хибер К.Кимбалл ч

мөн түүнээс дээр байсангүй. Тэдний гэргий нар, гэр бүлүүд ч бас зовлон бэрхшээлтэй байлаа. Төлөөлөгчид гэр орноосоо холгүй байх толгойн оройд хүрч ирэхэд, тэр хоёр хоёул мухлаг тэргэн дотроо хэвтэн, гэр бүлээ тийм хөөрхийлөлтэй нөхцөлд орхиод явж чадахгүй юм шиг тэдэнд санагдаж байжээ. Хиберийн санал болгосноор тэд хөл дээрээ өндийж, малгайгаараа толгой дээгүүрээ даллан, “Израилын төлөө Ура, Ура!” гэж гурвантаа хашхирчээ. Тэдний эхнэрүүд Мэри Анн, Вилате хоёр хөл дээрээ зогсох хангалттай хүч тамиртай болж, хаалганы хүрээ түшин, “Баяртай, Бурхан та нарыг адислаг” гэж чангаар хашгирав. Тэр хоёр эр өвчтэй орондоо хэвтэхийн оронд зогсож буй эхнэрүүдээ харан баяр хөөрийн болон сэтгэл ханамжийн сүнстэйгээр мухлаг тэргэн дэх ор уруугаа эргэн ирэв.

Ард үлдсэн гэр бүлүүд номлолын дуудлага хүлээн авсан хүмүүсээ дэмжихэд золиослол хийж, итгэлээ харуулж байлаа. Аддисон Праттыг Сандвич Арлуудад номлолд дуудагдахад, түүний гэргий Люиза Барнесс Пратт: “Дөрвөн хүүхэд маань сургуульд явж, хувцас хунартай болох хэрэгтэй байлаа, тэгээд мөнгө надад үлдэх учиртай байв. . . . Эхлээд би зориг шантрах шиг болсон, гэвч би Их Эзэнд итгэлтэй байж, амьдралын зовлон бэрхшээлийн өмнө зоригтой зогсохоор шийдэж, нөхөр маань сайн мэдээг номлохоор зохистойд тооцогдсонд баясаж байлаа” гэж тайлбарласан байдаг.

Люиза болон түүний хүүхдүүд нөхөр болон эцгээ үдэж гаргахаар зогсоол руу очсон ажээ. Тэд гэртээ эргэж ирсний дараа Люиза “зүрх сэтгэлийг минь уйтгар гуниг эзэмдсэн байлаа. Удалгүй аянга чангаар нүргэлэн цахилж эхлэв. Гудамжны нөгөө талд байдаг нэг айл нүх гарсан байшинтай, ядуу зүдүү, яахаа мэдэхгүй байдалтай байв. Удсан ч үгүй тэд бүгдээрээ аюулгүй газар эрж, шуурган дундуур манай уруу гарч ирэв. Бид тэднийг гэртээ орж ирсэнд баяртай байлаа; тэд биднийг тайвшруулан ярьж, дуулал дууллаа, тэгээд тэр ах бидэнтэй хамт залбирч, шуурга намдтал байцгаав”¹ гэжээ.

Аддисоныг явсны дараа удалгүй тэдний бага насны охин цэцэг өвчнөөр өвчлөв. Праттынханд хүрч ирж болох санваартан аль ч ахын хувьд уг өвчин бодитой аюул учруулахаар тийм их халдвартай байсан учраас Люиза итгэлээр залбирч, “халуун нь буурчээ.” Охиных нь биен дээр арван нэгэн жижиг толбо гарч ирсэн ч гэсэн, өвчин цааш газар авсангүй. Хэдэн өдрийн дараа халуун нь илааршчээ. “Би уг өвчнийг сайн мэдэх нэг хүнд охиноо үзүүлсэн юм; энэ бол дайралт эхэлж байна гэж тэр хэлэв; тэгээд би үүнийг итгэлээр байлдан дагуулсан юм”² гэж Люиза бичжээ.

Ийм золиослолд Навууг орхисон номлогч нар мянга мянган хүмүүсийг Сүмд авчирсан юм. Хөрвөгдсөн хүмүүсээс олон нь бас гайхамшигтай итгэл хийгээд эрэлхэг зоригийг харуулжээ. Мэри Анн Вестон хувцас оёход суралцаж байхдаа Виллям Женкинсийн гэр бүлтэй хамт Англид амьдарч байжээ. Женкинс Ах сайн мэдээнд хөрвөгдөж, тэгээд Вилфорд Вудрафф энэ гэр бүлтэй уулзах гэж гэрт нь ирэв. Тэр үед ганцхан Мэри Анн л гэртээ байжээ. Вилфорд галын дэргэд сууж, “Ядуу дорой нэгний төлөө айх уу би, Яавч Сүнсний минь нөлөөг үгүйсгэнэ” хэмээн дуулав. Мэри Анн түүний дуулж байгааг хараад, “тэр нэн амгалан, баяртай харагдаж байв, тэр сайн хүн байх ёстой, мөн түүний заадаг сайн мэдээ үнэн байх ёстой гэж би бодож билээ”³ хэмээн дурсчээ.

Мэри Анн Сүмийн гишүүдтэй тогтоосон өөрийн хэлхээ холбоогоор дамжуулан удалгүй хөрвөгдөж, баптисм хүртэн— өөрийнхөө гэр бүлээс сэргээгдсэн сайн мэдээний захиаст хариулсан цорын ганц гишүүн болов. Тэрээр Сүмийн нэг гишүүнтэй гэрлэсэн боловч дөрвөн сарын дараа Сүмийн цугларалтыг тасалдуулахыг санаархсан танхайрагчдад зодуулсны улмаас нөхөр нь нас барсан ажээ. Гэр орноо, найз нөхдөө түүнчлэн итгэлгүй эцэг эхээ орхин, Навууг зорьсон Хожмын үеийн бусад Гэгээнтнүүдээр дүүрсэн далайн хөлөг онгоцонд тэр цор ганцаараа суужээ. Тэр гэр бүлтэйгээ дахин хэзээ ч уулзаагүй юм.

Түүний эрэлхэг зориг, шийдвэр төгс байдал эцэстээ олон хүний амьдралыг адисалсан юм. Тэрээр умард Ютагийн Каче Валлид суурьшсан бэлэвсэн эр Петр Могантай гэрлэв. Тэгээд тэрбээр Сүмийг болон түүний нэрийг дээдэлсэн итгэлтэй, өнөр өтгөн гэр бүлийг өсгөн торниулсан билээ.

Жишиг Бүтээлүүд

Навуугийн үед, хожим нь Агуу Үнэт Сувд болсон зарим бичээсүүд хэвлэгдсэн юм. Уг ном нь Мосегийн ном, Абрахамын номноос авсан түүврүүд, Матайн гэрчлэлийн түүвэр, Иосеф Смитийн түүхийн цуглуулгууд, Итгэлийн Тунхагийг агуулдаг. Эдгээр баримт бичгүүдийг Их Эзэний удирдлага дор Иосеф Смит бичсэн буюу орчуулсан юм.

Гэгээнтнүүдэд эдүгээ Сүмийн жишиг бүтээлүүд болсон: Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд судрууд байдаг. Эдгээр номнууд бол Бурханы хүүхдүүдэд үнэлж байршгүй үнэ цэнэтэй юм, учир нь эдгээр судрууд сайн мэдээний суурь үнэнүүдийг зааж, шударга эрэн хайгчийг Бурхан Эцэг, болон түүний Хүү Есүс Христийн мэдлэгт авчирдаг. Их Эзэн өөрийн бошиглогчдоор дамжуулан чиглүүлснээр нэмэлт илчлэлтүүд өнөө үеийн судруудад ирсээр байдаг билээ.

Навуугийн Ариун Сүм

Навууг үндэслэснээс хойш ердөө арван таван сарын дараа Тэргүүн Зөвлөл илчлэлтийг дуулгавартай дагаж, “залбирлын өргөө, дэг журмын өргөө, Түүний бурханлиг хүсэл зоригт нийцүүлэн ёслолуудад оролцож болох, өөрсдийн Бурханыг шүтэн бишрэх өргөө босгох”⁴ цаг болсныг зарлажээ. Хэдийгээр ядуу байж, гэр бүлээ хангахын төлөө чадан ядан тэмцэж байсан хэдий ч, Хожмын Үеийн Гэгээнтнүүд удирдагчдынхаа дуудлагад хариулж, ариун сүм барихад цаг хугацаа, мөнгө хөрөнгө хандивлаж эхэлжээ. 1000 гаруй хүмүүс арав дахь өдөр бүр ажиллаж хувь нэмрээ оруулж байлаа. Люиза Деккер гэдэг бага насны охин, ээж нь нарийн

хийцтэй шаазан тавгууд бас маш сайхан хөнжлөө зарж ариун сүмийн хандив болгон өргөсөнд сэтгэл их хөдөлжээ.⁵ Бусад Хожмын Үеийн Гэгээнтнүүд ариун сүмийн барилгад туслахын тулд морь, мухлаг тэрэг, үнээ, гахайн мах, үр тариа зэргийг өгч байлаа. Ариун сүмийн санд зориулж өөрсдийн арван центийн зоос, нэг центийн зооснуудыг хандивлахыг Навуугийн эмэгтэйчүүдээс хүсчээ.

Каролин Бутлерт хандивлах арван центийн зоос ч, нэг центийн зоос ч байсангүй, гэвч тэр ямар нэг юм өгөхийг ихэд хүсч байв. Тэр нэг өдөр мухлаг тэргээр хот руу явж байгаад үхсэн хоёр зэрлэг үхэр харав. Ариун сүмд өгөх түүний бэлэг юу байж болохыг тэрээр тэр даруйд мэдлээ. Тэрээр хүүхдүүдтэйгээ хамт зэрлэг үхрүүдийн зогдорын урт хялгасуудыг сугалж аваад, гэртээ авчрав. Тэд хялгасыг угааж, самнаад бүдүүн ширхэгтэй утас болгон ээрч, найман хос зузаан бээлий болгон нэхэж, өвлийн хахир хүйтнээр ариун сүмийн барилга дээр ажиллаж байсан чулуу зүсэгчдэд өгчээ.⁶

Хайрум Смитийн эхнэр Мэри Фийлдинг Смит Англи дахь Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүдэд захидал бичсэнд тэд нэг жилийн дотор 434 фунт жинтэй 50 000 нэг центийн зоос цуглуулсныг Навуу уруу усан онгоцонд ачуулжээ. Фермийн эзэд тэргэнд хөллөх мал, мухлаг тэрэг өгч байв; бусад хүмүүс газрынхаа нэг хэсгийг зарж, мөнгийг нь барилгын хороонд хандивлаж байв. Олон цаг, буу хандивлажээ. Иллинойн Норвей дахь Гэгээнтнүүд ариун сүмийн хороо ашиглахын тулд 100 хонийг Навуу руу илгээжээ

“Ажилчдын хоол хүнсэнд зориулж талх, бусад хоол хүнс олоход хүнд хэцүү байсан үед бид Навуугийн ариун сүм дээр маш хүнд ажил хийсэн юм” гэж Бригам Янг дурсчээ. Ерөнхийлөгч Бригам Янг, Их Эзэн хангах болно гэдэгт итгэн, өөрсдөдөө байсан бүх гурилыг ариун сүмийн санг хариуцаж байсан хүмүүст өгөхийг мөн зөвлөжээ. Сицилээс сүмийн саяхны хөрвөгч болсон Жозеф Торонто богино хугацаанд Навууд ирж, 2500 алтан доллар авчран Ах нарын хөл дор

тавьсан аж.⁷ Торонто Ахын насан туршдаа хуримтлуулсан хадгаламжийг гурил нөхөн сэлбэх болон шаардлагатай бусад эд зүйлс худалдан авахад ашиглажээ.

Гэгээнтнүүд Навууд ирснээс хойш удалгүй Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, сайн мэдээг сонсолгүйгээр нас барсан өвөг дээдсийнхээ төлөө баптисмууд гүйцэтгэж болохыг илчилсэн юм (С ба Г 124:29–39-ийг үз). Дэлхий дээр сайн мэдээг хүлээн авдаг хүмүүст байдагтай нэгэн адил тийм адислалууд нас барагсдад байж болох тухай амлалтад олон Гэгээнтэн агуу тайтгарлыг олсон билээ.

Эдүгээ ариун сүмийн хишиг хэмээн нэрлэгддэг заасан зүйлүүд, гэрээнүүд болон адислалуудын тухай чухал илчлэлтийг Бошиглогч бас хүлээж авсан ажээ. Энэхүү ариун нандин ёслол нь “Мөнхийн үгст Элохимын . . . дэргэд хүрч ирэн оршиход нь” тэднийг бэлтгэх “тэдгээр адислалуудын бүрэн байдлыг хадгалах” боломжийг Гэгээнтнүүдэд олгосон юм.⁸ Ариун сүмийн хишиг хүлээж авсны дараа эхнэр, нөхрүүд санваарын хүчээр энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд лацдан холбуулж болно. Иосеф Смит дэлхий дээрх түүний цаг хугацаа богиныг мэдээд, ариун сүм баригдаж байх явц дундуур, улаан тоосгон дэлгүүрийн дээд давхрын өрөөнд сонгогдсон итгэлтэй дагалдагчдад тэрээр ариун сүмийн хишгийг хүртээж эхэлсэн ажээ.

Бүр Бошиглогч Иосеф Смитийг алагдсаны дараа, Гэгээнтнүүд Навууг түргэн орхиж явах ёстойгоо мэдсэн үед ч гэсэн, ариун сүмийг дуусгах тэдний шийдвэр төгс байдал нэмэгдсэн билээ. Дуусаагүй ариун сүмийн дээврийн давхрыг хишгийн ёслол гүйцэтгэх бүтцийн хэсэг болгон онцгойлон адислав. Гэгээнтнүүд ариун нандин ёслолыг хүлээн авахын төлөө нэн их санаа тавьж байсан бөгөөд Бригам Янг, Хибер, К.Кимбалл болон Арванхоёр Төлөөлөгчийн бусад гишүүд шөнө дөрвөн цагаас илүү унталгүй өдөржин, шөнөжин ариун сүм дээр байдаг байлаа. Мерси Фийлдинг Томпсон ариун сүмийн хувцаснуудыг угааж, индүүдэх болон гал тогооны ажлыг хянадаг байв. Тэр ч гэсэн ариун сүм дээр

амьдарч, зарим үед дараагийн өдөр бүх зүйл бэлэн байхын тулд шөнөжингөө ажилладаг байв. Бусад гишүүд ч гэсэн бие хайргүй ажиллаж байлаа.

Тэд удахгүй үүнийг орхиод явах байтал Гэгээнтнүүд яагаад барилгыг дуусгахын төлөө тийм шаргуу ажиллаж байв? Бараг 6000 Хожмын Үеийн Гэгээнтэн Навууг орхин явахаасаа өмнө өөрсдийн хувийн хишгийг хүртсэн юм. Тэд өрнөд тийш цагаачлах болсон үедээ итгэлд дэмжлэг тулгуур олж, тэдний гэр бүлүүд үүрд мөнхөд хамтдаа лацдан холбогдсон тухай мэдлэгт бэхэжсэн байлаа. Хүүхдээ эсвэл эхнэр буюу нөхрөө Америкийн уудам талд оршуулсны дараа, нулимсны оромтой тэдний нүүр, ариун сүмд өөрсдийн хүлээн авсан ёслолуудад агуулагдаж асан бат итгэлийн улмаас эрс шийдэмгий болж нүүдэллэхэд бэлэн болжээ.

Нийгмийн Халамжийн Бүлэг

Навуугийн Ариун Сүмийг баригдаж байхад, хотын хамгийн чинээлэг иргэдийн нэг Хайрам Кимбаллын гэргий Сара Гранжер Кимбалл, Маргарет А.Куук нэртэй нэг эмэгтэй оёдолчныг хөлсөөр ажиллуулсан ажээ. Сара Их Эзэний ажилд түлхэц өгөхийг хүсч, ариун сүмд ажиллаж байгаа хүмүүст цамц хийх даавуу хандивлаж, Маргарет оёхыг зөвшөөрчээ. Түүнээс хойш удалгүй, Сарагийн хөршүүдийн зарим нь цамц хийхэд оролцохыг бас хүсэв. Эгч нар Кимбаллын зочны өрөөнд цуглаж албан ёсоор зохион байгуулагдахаар шийджээ. Нийгэмлэгийн дүрэм, дотоод журмыг бичихийг Элиза Снөүгээс хүссэн ажээ.

Дууссан баримт бичгийг Элиза Бошиглогч Иосеф Смитэд танилцуулсанд тэрээр үүнийг өмнө нь үзэж байгаагүй, хамгийн сайн дүрэм болсон байна гэж хэлэв. Гэвч эмэгтэйчүүдийн үзэгдлийг тэд юу хийж болох тухайд өргөжүүлэх хэрэгтэй юм байна гэсэн сэтгэгдэл түүнд төржээ. Тэрээр дахиад нэг цуглаан хийхийг эмэгтэйчүүдээс хүсч, тэнд тэрээр тэднийг Навуугийн Эмэгтэйчүүдийн Нийгмийн Халамжийн Бүлэг болгон зохион

байгуулав. Бошиглогчийн гэргий Эмма Смит нийгэмлэгийн анхны ерөнхийлөгч болов.

“Удирдахаар томилогдсон хүмүүсээр дамжуулан Бурханы үндэслэсэн тэрхүү жаягийн дагуух зааврыг тэд хүлээн авах болно гэдгийг—мөн эдүгээ би түлхүүрийг та нарт Бурханы нэрээр өгч байна, мөн энэ Нийгэмлэг баяр баясалтай байх бөгөөд энэ цагаас эхлэн мэдлэг, оюун билиг доош цутган ирэх ирэх болно—энэ бол энэхүү Нийгэмлэгийн хувьд илүү сайн өдрүүдийн эхлэл юм” хэмээн Иосеф эгч нарт хэлжээ.⁹

Тус нийгэмлэг бий болсноос хойш удалгүй, хороо Навуугийн бүх ядуучуудаар айлчлан очиж, тэдний хэрэгцээг тодорхойлон, тэдэнд туслах хандивуудын талаар хөөцөлджээ. Мөнгөн хандив, хүнсний зүйл ор дэрний хэрэгсэл худалдан борлуулснаас орсон орлогоор гачигдсан хүүхдүүдийг сургуульд явах боломжоор хангав. Гачигдсан хүмүүст туслахын тулд маалинган даавуу, ноос, ээрсэн утас, савх мод, саван, лаа, сав суулга, үнэт эдлэл, сагс, хөвөнтэй хөнжил, нэхмэл хөнжил, сонгино, алим, гурил, талх, жигнэмэг болон мах хандивлаж байлаа.

Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар ядууст туслахын хажуугаар хамтдаа шүтэн биширдэг байв. Нэг цуглаанд “бараг бүх оролцогчид босч, үг хэлэн, Их Эзэний сүнс горхи цэвэршүүлэгч лугаа адил, бүх зүрх сэтгэлийг сэргээв” хэмээн Элиза Р.Снөү өгүүлжээ.¹⁰ Эдгээр эгч нар бие биенийхээ төлөө залбирч, бие биенийхээ итгэлийг бэхжүүлэн, Сионы зорилгод тус нэмэр үзүүлэхийн тулд өөрсдийн амьдралыг болон нөөц боломжуудыг өргөл болгон барьж байв.

Аллага

Навуу дахь он жилүүд Гэгээнтнүүдийн хувьд баяр баясгалант олон үеийг авчирсан хэдий ч, мөрдлөг хавчлага удалгүй дахин эхэлж, дээд цэгтээ хүрсэн нь Иосеф Смит, Хайрум Смит хоёрын аллага болов. Энэ бол хэзээ ч мартагдашгүй хар бараан, эмгэнэлт үе байлаа. Аллагын тухай сонссоныхоо дараа Люиза Барнес: “Тэргэл сар мандсан намуухан шөнө байлаа. Үхлийн шөнө лугаа адил, бүх юм үүнийг гүн хүндэтгэлтэй

болгосон байлаа! Хүмүүсийг хамтдаа цуглахыг дуудсан сүмийн удирдагчдын дуу хоолой алсаас сонсогдож, оршуулгын гашуудлын хонх лугаа адил хүмүүсийн зүрх сэтгэлд тусч байв. Эмэгтэйчүүд бүлгүүдэд цугларан, цурхиран уйлж, залбиран, зарим нь алуурчдыг аймшигтайгаар шийтгэхийг хүсч, бусад нь уг үйл явдал дахь Бурханы мутрыг хүлээн зөвшөөрч байлаа”¹¹ гэж өөрийн бодол санааг тэмдэглэн бичжээ.

Люиза Барнес Праттын нэгэн адил, олон Хожмын Үеийн Гэгээнтэн 1844 оны Зургадугаар сарын 27-ны үйл явдлуудыг нулимс асгаруулж, зүрх шимшрүүлсэн үйл явдал байсныг дурсан санадаг билээ. Уг аллага Сүмийн эхэн үеийн түүхэн дэх хамгийн эмгэнэлт үйл явдал байлаа. Гэвч энэ явдал гэнэтийнх биш байлаа.

1829 оны эхэн үеэс эхлэн хамгийн наад тал нь 19 өөр үйл явдлаар тохиолдуулан Иосеф Смит энэ амьдралыг тэрээр амар амгалан бусаар орхиж болзошгүйг Гэгээнтнүүдэд ярьж байжээ.¹² Дайснууд нь нэг л өдөр түүний амийг авна гэдгийг тэрээр мэдэрч байсан ч, чухам хэзээ гэдгийг мэдэхгүй байв. 1844 оны хавраас зунд шилжих үед Сүмийн доторх, гаднах дайснууд аль аль нь Иосефыг устгахаар ажиллаж эхэлсэн юм. Ойролцоох нэг сонины эрхлэгч бөгөөд Ханкок Гүнлэг дэх Мормоны эсрэг улс төрийн намын удирдагч Томас Шарп Бошиглогчийн аллагын төлөө олон нийтийн өмнө уриалан дуудаж байв. Иргэдийн бүлгүүд, урвагчид болон иргэний удирдагчид бошиглогчийг нь хөнөөх замаар Сүмийг устгахаар хуйвалдсан байлаа.

Иллинойн захирагч Томас Форд иргэний үймээн дэгдээхэд хүргэсний төлөө хариуцлага хүлээлгэхээр хотын зөвлөлийн гишүүдийг Мормон бус шүүгчдийн бүрэлдэхүүний өмнө шүүхэд татахыг шаардан Иосеф Смитэд бичжээ. Зөвхөн ийм шүүх хурал л хүмүүсийн сэтгэлд нийцэх болно гэж тэр хэлэв. Тэрээр хүмүүсийг бүрэн хамгаална гэсэн амлалт өгсөн хэдий ч, түүнийг амлалт үүргээ биелүүлж чадна гэдэгт Бошиглогч итгэхгүй байв. Өөр хувилбар байхгүй болох нь тодорхой болоход, тэд гэмт хэрэг үйлдээгүй гэм буруугүй гэдгээ бүрэн



Картхейжийн Шорон дахь аллагын дүр зураг. Шалны гол дунд хэвтэж байгаа Хайрум Смит агшин зуурт алагджээ; зүүн доод талд байгаа Жон Тейлор хүндээр шархадсан байв; Иосеф Смит буудуулж, цонх уруу харайгаад алагджээ; нийшингийн хажууд байгаа Виллярд Ричардс гэмтэлгүй үлджээ.

мэдэж байсан болохоор Бошиглогч, түүний ах Хайрум, Жон болон бусад хүмүүс баривчлуулжээ.

20 миль орчим зайтай орших Картхейжийг зорин, Бошиглогч Навуугаас явахдаа тэрээр гэр бүл, найз нөхдөө сүүлчийн удаа харж байгаагаа мэдэж байв. “Би нядлуулах хурга лугаа адил явж байна, гэвч би зуны өглөө лугаа адил тайван байна”¹³ хэмээн тэрээр бошигложээ.

Бошиглогчийг явахад Иосефийн ферм дээр гурван жил гаруй ажилласан Б.Рожерс, өөр хоёр хөвгүүн талбайг хөндлөн гарч, өөрсдийнх нь найз бөгөөд удирдагчийг хажуугаараа өнгөрөхийг хүлээн, хашааны хашлаган дээр сууж байлаа. Иосеф хөвгүүдийн хажууд морио зогсоогоод түүнтэй хамт явсан цагдаагийн ажилтнуудад: “Ноёд оо, энэ бол миний

ферм, эд бол миний хөвгүүд. Би тэдэнд таалагддаг, бас тэд надад таалагддаг” гэж хэлжээ. Хөвгүүн бүртэй гар барьсны дараа тэрээр мориндоо мордож, үхэлтэй нүүр тулан учрах газар уруугаа явав.¹⁴

Уэльсийн хөрвөгч Дан Жөүнс Картхейжийн Шоронд Бошиглогчтой нэгджээ. 1844 оны Зургадугаар сарын 26-нд, Иосеф амьдралынхаа сүүлчийн шөнө буун дуу сонсоод, орноосоо босч, Жөүнсийн ойролцоо шалан дээр хэвтжээ. “Чи үхэхээс айдаг уу?” гэж Бошиглогчийг шивнэхэд, “Ийм зорилгод оролцсон тохиолдолд үхэл олон айдас төрүүлнэ гэж би бодохгүй байна” гэж Жөүнс хариулжээ. “Чи бүр Уэльсийг үзэж, тэгээд үхэхээс чинь өмнө чанд томилсон номлолыг гүйцэлдүүлэх болно” гэж Иосеф бошиглов.¹⁵ Дан Жөүнс хожим нь Уэльст хүндтэй бөгөөд амжилттай номлолд үйлчилсэн учир мянга мянган итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүд өнөөдөр Сүмийн адислалуудыг эдэлж байгаа билээ.

1844 оны Зургадугаар сарын 27-ны үдээс хойш таван цагаас хойш удалгүй, нүүрээ будсан 200 орчим хүнтэй танхайрагч бүлэг Картхейж Шоронд дайран орж, Иосеф Смит, түүний ах Хайрум нарыг буудан алж, Жон Тейлорыг хүндээр шархдуулав. Ганцхан Виллард Ричардс бэртэлгүй үлджээ. “Мормончууд ирж явна” гэж хашгирах дуунаар танхайрагч бүлгийн, бас Картхейжийн оршин суугчдын ихэнх нь зугтжээ. Виллям Ричардс шархадсан Жон Тейлорыг халамжлан, тэр хоёр хоёул хөнөөгдсөн удирдагчдынхаа төлөө эмгэнэн гашуудаж байлаа. Хайрумын цогцос шоронгийн дотор байсан бол, цонхоор унасан Иосефийн цогцос гадаах худгийн дэргэд хэвтэж байв.

Болсон үйл явдлын газарт анх хүрч ирсэн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нэг нь алагдагчийн дүү Самуел байв. Тэр болон бусад хүмүүс цогцсуудыг Навуу руу эргүүлэн аваачих, урт удаан бөгөөд уй гашуутай аянд бэлтгэхэд Виллард Ричардст тусалсан ажээ.

Мөн тэр үед Иллинойн Варшавт сүмийн гишүүд байсан Жеймс Каулийн гэр бүл оройнхоо хоолыг бэлтгэж байв.

Арван дөрвөн настай Маттиас хотод ямар нэгэн ер бусын үймээн дэгдэхийг сонсоод, гарч цугласан олонтой нийлсэн аж. Гол үг хэлэгч нь залуу Каулиг харсан бөгөөд гэр рүүгээ ээждээ оч гэж түүнд тушаав. Сүмийн гишүүн биш хөвгүүд араас нь дагаж, хөршийнхөө хашаагаар дамжин зугттал нь хогоор шидсээр байв.

Байдал намдаж хэвийн болно гэдэгт Маттиас итгэн хувин ус авахаар гол уруу явав. Танхайрагч бүлгийн гишүүд түүнийг олж харан, нэг согтуу оёдолчноор түүнийг гол уруу шидүүлэх гэж мөнгө төлжээ. Маттиас ус утгах гэж зогсоход, нөгөөх оёдолчин түүний шилэн хүзүүн дээрээс барьж аваад, “Чи муу . . . жижигхэн Мормон, би чамайг усанд үйчихье” гэв. “Би түүнд ямар ч хор хүргээгүй байхад, яагаад тэр намайг усанд үйх гэж байгааг би түүнээс асуухад тэр, Үгүй ээ, би чамайг усанд үйхгүй. . . . Чи сайн хүүхэд, чи гэр рүүгээ явж болно” гэж билээ хэмээн Маттиас өгүүлжээ. Тэр шөнө танхайрагч бүлгийнхэн Каулийнхны гэрийг шатаах гэж гурван удаа амжилтгүй оролдсон хэдий ч итгэл, залбирлаар дамжуулан энэ гэр бүл хамгаалагдсан ажээ.¹⁶ Маттиас Каули өсч том болоод Сүмд итгэлтэй хэвээр үлдсэн ажээ; түүний хүү Маттиас болон ач хүү Матью хожим нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байжээ.

Иллинойн захирагч Томас Форд аллагын тухай бичихдээ: “Смитүүдийг алсан нь, олон хүний бодож байсанчлан, Мормончуудыг төгсгөл болгож . . . тэднийг тараахын оронд, харин ч бүр тэднийг хэзээ ч байгаагүйгээр ойртуулан нягтруулж, тэдний итгэл бишрэлд шинэ итгэлийг өглөө” гэж бичжээ.¹⁷ “Паул лугаа адил авьяас бэлэгт нэгэн, нэгэн сүр жавхлантай уран илтгэгч мянга мянган цугларагсдыг уран үгээрээ татан . . . шинэ амьдралаар [Мормоны сүмээр] амьсгалахад амжилт олж, алагдсан Иосефийн нэрийг . . . мандуулж, хүмүүсийн сэтгэл санааг чангалан хөдөлгөж болох юм” хэмээн Форд бас бичжээ. Форд ийм явдал болж мэднэ, түүний нэр Пилат болон Херодын нэр лугаа адил “үр удамд

нь гутамшиг болох вий” хэмээх айдастайгаар аж төрж байлаа.¹⁸ Фордын айдас биеллээ олсон юм.

Ерөнхийлөгч Жон Тейлор шархаа эдгээж, тэгээд хожим нь хөнөөгдсөн удирдагчдадаа хүндэтгэл үзүүлж бичсэн нь эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 135 юм. “Их Эзэний Бошиглогч хийгээд Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн билээ. . . . Тэрээр Бурханы болон өөрийн хүмүүсийн мэлмийд агуу ихээр амьдарч, мөн агуу байдлаар наснаас халив; мөн Их Эзэний эрт дээр үеийн тослогдогсдын адил өөрийн үүрэг зорилго хийгээд өөрийн ажлуудыг цусаараа лацадсан бөлгөө; мөн түүний ах Хайрум ч бас ингэсэн билээ. Амьдралд тэд салсан байсан нь үгүй, мөн үхэлд тэд тусдаа байсан нь үгүй! . . . Тэд алдар суугийн төлөө амьдарч байв; тэд алдар суугийн төлөө наснаас хальсан билээ; мөн алдар суу нь тэдний мөнхийн шагнал бөлгөө” (С ба Г 135:3, 6) хэмээн тэр хэлжээ.

Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх Залгамжлал

Бошиглогч Иосеф Смит, Хайрум Смит хоёр Картхейжийн Шпоронд алагдахад Арванхоёрын Чуулга болон Сүмийн бусад удирдагчдаас олон нь номлолд үйлчилж, Навууд байхгүй байлаа. Эдгээр хүмүүс аллагын тухай дуултал хэдэн өдөр өнгөрчээ. Бригам Янг энэхүү мэдээг сонсоод, санваарын удирдлагын түлхүүрүүд Сүмд хэвээр байгааг мэдэж байлаа, учир нь эдгээр түлхүүрүүд Арванхоёрын Чуулгад өгөгдсөн байлаа. Гэвч, Их Эзэний бошиглогч, үзмэрч хийгээд илчлэгч Иосеф Смитийг хэн орлохыг Сүмийн бүх гишүүд ойлгохгүй байжээ.

1844 оны Наймдугаар сарын 3-нд Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Сидней Ригдон Питтсбургээс ирэв. Энэ цагаас нэг жилийн өмнө тэрээр Бошиглогч Иосеф Смитийн зөвлөгөөнөөс зөрж эхлэн, улмаар Сүмээс хөндийрүүлэгдсэн байв. Тэрээр тэр үед Навууд байсан Арванхоёрын гурван

гишүүнтэй уулзахаас татгалзаж, Ням гарагийн шүтэн бишрэх үйлчлэлд цуглаад байсан Гэгээнтнүүдийн том бүлэгт хандаж үг хэлжээ. Хэн ч Иосеф Смитийг орлож чадахгүйг мэдсэн илчлэлт хүлээж авсан тухайгаа тэрээр тэдэнд ярьсан аж. Сүмд сахиулагч томилогдох ёстой бөгөөд тэр сахиулагч нь Сидней Ригдон байх ёстой хэмээн тэр хэлжээ. Цөөхөн Гэгээнтэн түүнийг дэмжив.


Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янг 1844 оны Наймдугаар сарын 6-ныг хүртэл Навууд эргэж ирсэнгүй. Сүмийг хэн удирдах ёстой тухайд зөвхөн “Бурхан юу хэлэхийг” л мэдэхийг хүсч байгаагаа тэр мэдэгджээ.¹⁹ Арванхоёр 1844 оны Наймдугаар сарын 8-нд хурал зарлан дуудав. Өглөөний хуралдаан дээр Сидней Ригдон цаг гаруй үг хэлэв. Түүний байр суурьт үнэнч цөөн хэдхэн хүний дэмжлэгийг тэр олжээ.

Дараа нь Бригам Янг Гэгээнтнүүдийн зүрх сэтгэлийг тайвшруулан товч үг хэлэв. Бригамыг үг хэлж байхад, “энэ бол Иосеф Смитийн өөрийнх нь дуу хоолой байлаа,” мөн “хүмүүсийн өмнө яг л Иосефийн өөрийнх нь бие зогсож байгаа юм шигээр хүмүүсийн нүдэнд тусч байлаа” гэж Бригам хэлснийг Жорж О.Каннон дурсчээ.²⁰ Бригам Янг Бошиглогч Иосеф Смитийн дуу хоолойтой адилхнаар ярьсныг Виллям К.Стайнс гэрчилсэн байдаг. “Би түүнийг л байна гэж бодсон, үүнийг сонсож байсан олон мянган хүн бас тэгж бодсон байлаа”²¹ гэж Стайнс хэлжээ. Тэрхүү гайхамшигтай агшны тухай Вилфорд Вудрафф бас дурсан санаж, бичихдээ, “Хэрэв би түүнийг өөрийн нүдээр хараагүй байсан бол, энэ бол Иосеф Смит байгаагүй гэдгийг хэн ч надад үнэмшүүлж чадахгүй байсан, мөн энэ хоёр хүнтэй танил байсан хүнд хэн ч нотолж чадахгүй байлаа”²² гэжээ. Олон хүн харсан энэхүү гайхамшигт илэрхийлэл Сүмийн удирдагч болгон Иосеф Смитийг залгамжлуулахаар Их Эзэн Бригам Янгийг сонгосныг Гэгээнтнүүдэд тодорхой мэдүүлжээ.

Үдээс хойших хуралдаан дээр Бригам Янг дахин үг хэлж, бүх дэлхийд Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгахын тулд Бошиглогч Иосеф Төлөөлөгчдийг томилсныг гэрчилжээ. Арванхоёрыг дагаагүй хүмүүс цэцэглэн хөгжихгүй, түүнчлэн гагцхүү Арванхоёр л Бурханы хаант улсыг байгуулахад ялалт байгуулж чадна гэдгийг тэрбээр бошигложээ.

Түүнийг үг хэлсний дараа Сидней Ригдоныг үг хэлнэ үү гэж Ерөнхийлөгч Янг хүссэн боловч, тэр үг хэлэхгүй байхаар сонгосон ажээ. Виллям В. Фелпс, Парли П.Пратт нарыг тайлбар хийсний дараа Бригам Янг дахин үг хэлэв. Тэрээр Навуугийн Ариун Сүмийг дуусгах тухай, аглаг зэлүүд газар луу явахын өмнө хишиг хүртээлтийг олж авах тухай, түүнчлэн судруудын ач холбогдлын тухай яриу. Тэрээр Иосеф Смитийг болон Бошиглогчийн гэр бүлийг хайрладаг өөрийн хайрын тухай яриу. Тэгээд Гэгээнтнүүд Арванхоёр Төлөөлөгчийг дэмжин Сүмийн удирдагчдаар санал нэгтэй сонгов.

Бусад цөөн хэдхэн хүн Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд эрхийг өгөхийг шаардсан бол Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн олонхийн хувьд залгамжлалын хямрал дууссан юм. Хамгийн ахмад настай Төлөөлөгч бөгөөд Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янг, түүний хүмүүсийг удирдахаар Бурханы сонгосон тэр хүн байв, тийнхүү түүнийг дэмжин батлахын тулд хүмүүс нэгдсэн байлаа.



*Гэгээнтнүүд танхайрагч бүлгийн хүчирхийллээр хайртай хот
Наувүүгаа орхин явахаар албадуулагдсан юм.*

Алхам Тутам Дахь Итгэл

Навууг Орхин Явахаар Бэлтгэсэн Нь

Наанадаж 1834 оноос эхлэн Гэгээнтнүүд амар амгаланд амьдарч болох Хадат Уулсын зүг өрнөд тийш шилжин нүүх тухай Сүмийн удирдагчид ярьдаг байжээ. Он жилүүд өнгөрөх тусам удирдагчид тодорхой газруудыг судлаачдын хамт хэлэлцэж, суурьших зөв газрыг олохын тулд газрын зургуудыг судалсаар байв. 1845 оны эцэс гэхэд Өрнөдийн талаарх хамгийн сүүлийн үеийн шинэчилсэн мэдээллийг Сүмийн удирдагчид олж авчээ.

Навуу дахь мөрдлөг хавчлага эрчимжихэд Гэгээнтнүүд эндээс явах ёстой нь тодорхой болжээ. 1845 оны Арваннэгдүгээр сар гэхэд бэлтгэлийн үйл ажиллагаа Навууд буцалж эхлэв. Гэгээнтнүүдийг тэдний дүрвэлтэд удирдах зуутууд, тавьтууд, аравтуудын ахмадууд дуудагдсан байв. 100 хүнтэй бүлэг бүрд нэг буюу түүнээс дээш мухлаг тэрэгний хэсэгтэй байв. Дугуй засварчид, мужаанууд, мухлаг хийгчид мод бэлтгэн, мухлаг тэрэгнүүд хийж шөнө дөл болтол ажиллаж байв. Төмөр худалдаж авахын тулд гишүүдийг дорнод уруу явуулж, төмрийн дархчууд аянд шаардлагатай материалууд болон шинэ Сионыг эзэмшихэд шаардлагатай фермийн тоног төхөөрөмж хийж байв. Гэр бүлүүд хүнс, гэрийн эд хогшил цуглуулж, агуулах чингэлгүүдийг хатаасан жимс, цагаан будаа, гурил, эмээр дүүргэж байлаа. Гэгээнтнүүд нийтийн сайн сайхны төлөө хамтран ажиллаж, боломжтойгоос илүү их зүйлийг богинохон хугацаанд амжуулжээ.

Өвлийн Аяны Хүнд Бэрхшээлүүд

Навуугаас нүүлгэн шилжүүлэхийг 1846 оны Дөрөвдүгээр сард хэрэгжүүлэхээр анх төлөвлөж байжээ. Муж улсын цагдаагийн газар Гэгээнтнүүдийг өрнөд рүү явахад нь саад учруулахаар заналхийлж байсны улмаас Арванхоёр Төлөөлөгч болон иргэний бусад удирдлага 1846 оны Хоёрдугаар сарын 2-нд зөвлөгөөнд яаралтай цуглав. Өрнөд рүү нэн даруй хөдлөх шаардлагатай гэдэгт тэд санал нийлснээр, дүрвэлт Хоёрдугаар сарын 4-нд эхлэв. Бригам Янгийн удирдлагаар Гэгээнтнүүдийн эхний бүлэг аянаа эхлэхийг тэсч ядан хүлээж байлаа. Гэвч, тэрхүү хүслэн агуу сорилттой тулгарав, учир нь өвлийн сүүлч үеийн цаг агаар, дараа нь ирэх бороорхог хавраас түр зуур амрах байнгын буудал хүртэл олон миль газар туулах шаардлагатай байлаа.

Мөрдөн хавчигчдаас аюулгүй байдлыг эрэлхийлэн, мянга мянган Гэгээнтнүүд Айовагийн нутгийг зорихын тулд өргөн Миссиссиппи Мөрнийг гатлах шаардлагатай байлаа. Нилээд олон Гэгээнтнүүдийг суулгаж явсан завийг нэг шар тийрч цоолсноос тэр завь живэн тэдний аяны аюул осол бүр эрт эхэлсэн ажээ. Өдөн дэвсгэр, саваа мод, “гишүү мод буюу барьж авч болох ямар нэг юмнаас зуурсан, хахир хүйтэнд, өршөөлгүй усны давалгаанд амь өрсөн шидэгдэн яваа золгүй зорчигчдыг нэг ажиглагч олж харжээ. . . . Зарим хүмүүс, тийм ч гүнд биш яваагүй мухлаг тэрэгнүүдийн орой дээр авиран гарч илүү тав тухтай явахад, тавцан дээрх үнээ, шарууд ирсэн эрэг рүүгээ сэлж байгаа нь харагдана.”¹ Эцэст нь бүх хүмүүс завь руу орж, нөгөө талд гарч ирэв.

Анхны гатлалтаас хойш хоёр долоо хоногийн дараа хэсэг хугацаанд мөрөн хөлдөв. Мөс хальтиргаатай байсан хэдий ч, мухлаг тэрэгнүүд, тэргэнд хөллөсөн малыг дааж, гатлалтыг хавигүй амар болгож байв. Гэвч хүйтэн цаг агаар их хүндрэл учруулж, Гэгээнтнүүд цасанд шигдэн удааширч байлаа. Мөрний нөгөө тал дахь Шугар Грийк дахь буудалд салхи байнга шуурч, цас бараг найман инч хүртэл гүн хунгарладаг байв. Тэгээд дараа нь урь орж, газрыг шавартай болгоно.

Эргэн тойронд, дээр, доор ороо бусгаа цаг агаар орчин тойрныг тав тухгүй болгож, 2000 Гэгээнтэн майхан, мухлаг тэрэгнүүдэд чихцэлдэн, цааш хөдлөх тушаал хүлээх зуураа толгой хоргодох оромжуудыг яаруу босгоно.

Аяны хамгийн хүнд хэсэг нь Айоваг туулах эхний үе шат байлаа. “Орны даавуунуудаар түр майхан босгосноор тэр шөнийн бэлтгэлийг хангав. Энэ үед эхнэр маань арайхийн суух боломжтой байсан мөн миний бяцхан хүү их халууран өвчилж, болж байгаа ямар ч юмыг ажиглах сөхөөгүй байлаа”² гэж Хосеа Стаут өгүүлжээ. Бусад олон Гэгээнтнүүд мөн л их зовлон зүдгүүр үзсэн юм.

Бүх Зүйл Сайн

Эдгээр Гэгээнтнүүдийн итгэл, эрэлхэг зориг хийгээд шийдвэр төгс байдал тэднийг өвлийн хүйтэн, өлсгөлөн, хайртай хүмүүсийнх нь үхэл дундуур туулан гаргасан юм. Виллям Клейтон Навууг орхин явах эхний бүлгүүдийн нэгэнд дуудагдан, тэгээд эхнэр Диантагаа, анхныхаа хүүхдийг гаргахад дөнгөж ганцхан сар дутуу байхад эцэг эхтэй нь хамт орхиод гарсан ажээ. Шавартай замаар зүтгэн, хүйтэн майханд хоноглож байсан нь түүний уцаарыг барж, Диантагийнхаа төлөө санаа нь зовдог байлаа. Хоёр сар болсны дараа түүнийг эсэн мэнд амаржсан эсэхийг тэрээр мөн л мэдэхгүй байсан хэдий ч, “сайхан мариалаг хөвгүүн” төрсөн тухай баярт үгийг тэр эцэст нь хүлээн авчээ. Бараг л тэр сонинг дуулангуутаа Виллям доош суугаад, зөвхөн түүний хувьд өвөрмөц утга учиртай байсан төдийгүй бурханлиг нөлөөллийн сүлд дуулал, Сүмийн гишүүдийн хувьд олон үеийнхний турш талархал болсон нэг дуу бичиж гарчээ. Энэ бол “Ирцгээ, Ирцгээ Гэгээнтнүүдээ” дуу байсан бөгөөд: “Бүгд нам гүм тайван байна! Бүгд нам гүм тайван байна!”³ гэсэн эдгээр алдарт мөрүүд түүний итгэл, мөн зовлон бэрхшээлийн дунд дуулж явсан мянга мянган Гэгээнтнүүдийн итгэлийг илэрхийлдэг байлаа. Тэд, өөрсдийг нь дагаж байсан гишүүдийн нэгэн адил золиослолын болон Бурханы хаант улс дахь дуулгавартай

байдлын шагналууд болох баяр хөөр хийгээд амар амгаланг олсон билээ.

Винтер Квортерс

Навуугаас өрнөд Айова дахь суурингууд хүртэл 310 миль аялж тэнд 1846-47 оны өвлийг өнгөрүүлж, Хадат Уулсын зүг хийх аяндаа бэлтгэхэд нь Гэгээнтнүүдэд 131 өдөр шаардагджээ. Энэ туршлага нь дараагийн жил 111 өдөрт 1000 миль Америкийн их талыг хурдан туулахад нь тэдэнд тусалж болох аяны талаар олон зүйлийг мэдүүлсэн ажээ.

Гэгээнтнүүдийн нилээд олон суурингууд Миссури Мөрний хоёр талаар сунан үргэлжилсэн байлаа. Хамгийн том суурин Винтер Квортерс өрнөдөд Небраскад байлаа. Уг суурин газар, дүнзэн байшингууд болон бургас, шороогоор ухаж хийсэн нүхэн гэрүүдэд амьдарч байсан ойролцоогоор Сүмийн 3000 гишүүний гэр орон тэр даруй болсон юм. Миссури Мөрний Айова талд байсан Калисвилл гэдэг газар болон үүний ойролцоо 2500 орчим Гэгээнтнүүд мөн амьдарсан. Эдгээр суурингууд дахь амьдрал бараг л замд яваа мэт тийм л тохь тухгүй байлаа. Зунд нь тэд халуурдаг хумхаа өвчинд нэрвэгдэж байв. Өвөл болоход шинэ хүнс олдохоо больж, хүмүүс булчин задрах тахал, чийг бам, шүдний өвчин, шөнийн харалган, хүнд суулга өвчинд нэрвэгджээ. Хэдэн зуун хүмүүс нас барсан ажээ.

Гэвч амьдрал үргэлжилж байв. Нөхөр Самуел нь Шотландад номлолд байсан Мэри Ричардсын өгүүлснээр, эмэгтэйчүүд цэвэрлэгээ хийж, юм индүүдэн, угааж, хөнжил хавж, захидал бичиж, хомс тарчигхан хоол ундаа бэлтгэн, гэрийнхэндээ анхаарал халамж тавьж өдрийг өнгөрүүлдэг байв. Тэрээр Винтер Квортерс дахь Гэгээнтнүүдийн ажил үйлс, ахуй амьдрал, түүний дотор шашны сэдэвт ярилцлагууд, бүжиг, Сүмийн цуглаанууд, үдэшлэгүүд болон хязгаар нутгийн сэргэн мандалтыг хөгжил хөөртэйгөөр тэмдэглэсэн байлаа.

Эрэгтэйчүүд хамт ажиллаж, аяны төлөвлөгөө болон Гэгээнтнүүдийн суурьших ирээдүйн газруудыг хэлэлцэхийн

тулд олонтаа цугладаг байв. Буудлын гадна хээр талд идээшилдэг байсан сүргээ эргэж тойроход тэд байнга хамтран ажилладаг байв. Тэд тариалангийн талбайд ажиллаж, суурингийн гадаад хилийг хамгаалан, гурилын тээрэм барьж, ажиллуулан мухлаг тэрэгнүүдийг аянд бэлэн болгож, ядарч туйлдах болон өвчинд нэрвэгдэх нь олонтаа тохиолддог байв. Тэдний ажлын нэг хэсэг нь тэд талбайг тариалалтад бэлтгэн тариалж өөрсдийнх нь дараа ирэх Гэгээнтнүүдээр ургац хураалгуулахын тулд амь бие хайргүй ажиллах хайрын хөдөлмөр байлаа.

[Лорензо] Янгийн хүү Жон Винтер Квортерсыг “Мормоны улсын Валли Форж” хэмээн нэрлэсэн ажээ. Тэрээр тэндхийн оршуулгын газрын ойролцоо амьдарч байсан бөгөөд “манай хаалганы хажуугаар олонтаа өнгөрдөг байсан эмгэнэлтэй харагддаг байсан оршуулгын бяцхан цувааны” гэрч болдог байжээ. Түүний гэр бүлийн өдөр тутмын хоол эрдэнэ шишийн талх, гахайн давсалсан өвчүү, өчүүхэн бага сүү нь “хичнээн ядуу тарчиг, нэг л хэвийн” байсныг тэрээр эргэн дурссан байдаг. Нухаш болон гахайн өвчүү идэх нь огиудас хүрмээр эм ууж байгаа юм шиг л хоолой давж өгдөггүй байсан гэж тэр ярьжээ.⁴ Гэгээнтнүүдийн зөвхөн итгэл хийгээд бүхнээ зориулсан чанар нь энэхүү хэцүү бэрх цагийн дундуур тэднийг туулан гаргасан юм

Мормоны Суман

Гэгээнтнүүдийг Айовад байх үеэр Нэгдсэн Улсын армид цэрэг татагчид 1846 оны Тавдугаар сард эхэлсэн Мексикийн Дайнд үйлчлэх тодорхой тооны эрчүүд гаргаж өгөхийг Сүмийн удирдагчдаас хүсчээ. Мормоны Суман гэж нэрлэгдэх учиртай байсан эрчүүд улс орны өмнөд хэсгийг туулан Калифорни уруу явган маршаар аялах ёстой байсан бөгөөд цалин, хувцас, тогтоосон хэмжээний хүнс авах ёстой байв. Навуугаас ядуучуудыг цуглуулж авах болон цэргүүдийн гэр бүлүүдэд туслах арга зам болгон цэрэг татлагад оролцохыг Бригам Янг эрчүүдэд урамшуулан дэмжив. Энэ хүч чармайлтад засгийн газартай хамтран ажиллах нь бас Сүмийн гишүүд улс орондоо үнэнч

байдгийг харуулж, улсын болон Индианчуудын газар нутагт түр буудаллахыг зөвтгөх учир үндэслэл болж өгөх байв.

Эцэстээ 541 хүн удирдагчдынхаа зөвлөгөөг хүлээн авч суманд элсчээ. Тэднийг 33 эмэгтэй, 42 хүүхэд дагалдан явжээ.

Дайнд явахын бэрх сорилтууд дээр сумангийн гишүүд хүнд цаг үед эхнэр, хүүхдүүдээ ганцааранг нь орхихын гуниг нэмэгдсэн байв. Виллям Хайд эргэцүүлэхдээ:

“Бэрх энэ цаг үед гэр бүлээ орхино гэдэг сэтгэлд дүрслэхийн аргагүй хэцүү байв. Тэд төрж өссөн газраасаа алс хол, зэлүүд хээр талд орон гэргүй мухлаг тэргэнд амьдарч, толгой дээрээс нь хурц нар шаран, эсвэл Арванхоёрдугаар сарын улам чангарч байгаа хүйтэн зэврүүн салхи тэднийг жиндүүлдэг тийм л хэцүүхэн газар үлдсэн юм.

“Миний гэр бүл эхнэр, бага насны хоёр хүүхэд байсан бөгөөд тэд настай аав, ээж хоёр нэг ахтай хамт үлдсэн. Сумангийнхны ихэнх нь гэр бүлээ орхин явсан юм. . . . Бид тэдэнтэйгээ дахин хэзээ уулзахыг зөвхөн Бурхан л мэдэж байсан байх. Гэсэн хэдий ч, дургүйцэн гомдоллох бодол бидэнд төрөөгүй.”⁵ гэжээ.

Суман хоол хүнс, усаар дутагдан, дутуу амарч, эмнэлгийн хүрэлцээгүй тусламжтай Калифорни уруу баруун өмнөд зүг 2030 миль газар хурдан маршаар аялсан юм. Тэд Сан Диего, Сан Люис Рей болон Лос Анжелест мэргэжлийн цэргүүд болж үйлчилсэн билээ. Тэдний дайчилгааны жилийн эцсээр тэд халагдаж, гэр орондоо эргэж харих боломжтой болов. Тэдний хүч чармайлтууд болон Нэгдсэн Улсын засгийн газарт үнэнч байсан нь тэднийг удирдсан хүмүүсийн хүндэтгэлийг хүлээжээ.

Тэднийг халагдсаны дараа сумангийн гишүүдээс олон нь Калифорнид улирлын ажил хийхээр үлдсэн ажээ. Тэднээс нилээд олон нь умард зүг Америк Гол уруу явж, 1848 онд тэнд алт илрэхэд, алдарт Калифорнийн Гоулд Рашт алт угааж, Жон Саттерын хөрөө рамд ажилд оржээ. Гэвч Хожмын Үеийн Гэгээнтэн ах нар энэ боломжийг далимдуулан ашиг завшаан олохын тулд Калифорнид үлдээгүй юм. Тэдний зүрх сэтгэл Хадат Уулсын зүг Америкийн их хээр талыг туулан өрнөд рүү

тэмцэн тэмүүлж байсан ах эгч нартайгаа хамт байсан юм. Тэдний нэг Жеймс С.Браун тайлбарлахдаа:

“Би тийм баялаг хөрстэй газрыг хэзээ ч үзээгүй; үүний төлөө надад харамсах юм алга, учир нь алтнаас илүү чухал зорилго миний өмнө ямагт байсаар ирсэн юм. . . . Биднийг өөрсдийнхөө ашиг сонирхлын төлөө харалган болжээ гэж зарим хүмүүс бодож болох юм; хэдийгээр бид уг нутагт аз завшаантай учирч, тэнд үлдэхийг өдөөсөн олон зүйл бидэнд байсан ч гэсэн, дөч гаруй жилийн дараа бид эргэн харахад харамсах зүйл байдаггүй. Энэ ордод алт байна, тэр толгод дээр алт байна, горхинуудад алт байна, газар сайгүй алт байна, . . . тэгээд та удалгүй биеэ даан азтан болж болно гэж хүмүүс хэлдэг байв. Бид энэ бүгдийг гүйцэлдүүлж болно л доо. Үүрэг маань дуудсан хэвээр, бидний хүндлэл гадсандаа байдаг байв, бид бие биентэйгээ гэрээнд орсон юм, оролцсон нэг зарчим байлаа; учир нь бидэнтэй хамт Бурхан болон Түүний хаант улс нэгдүгээрт байсан юм. Зэлүүд хээр газар, тийм ээ, эзгүй ээлүүд газар үлдсэн найз нар, төрөл төрөгсөд маань бидэнд байсан юм, хэн тэдний нөхцөл байдлыг мэдэх билээ? Бид мэдэхгүй байлаа. Тиймээс энэ бол баяр баясгалангийн түрүүн дэх, баялагийн түрүүн дэх үүрэг байсан бөгөөд энэхүү өдөөлт-тэйгөөр бид аян замд гарсан билээ.”⁶ Бурханы хаант улс энэ дэлхийн материаллаг зүйлүүдээс илүү агуу үнэ цэнэтэйг эдгээр ах нар мэддэг байсан бөгөөд өөрсдийнхөө замналыг энэ дагуу сонгосон байлаа.

Бруклины Гэгээнтнүүд

Гэгээнтнүүдийн олонх нь Навуугаас хуурай газраар аялан Хадат Уулс уруу нүүсэн бол Нэгдсэн Улсын дорнод хэсгээс Гэгээнтнүүдийн нэг бүлэг усан замаар аялсан юм. 1846 оны Хоёрдугаар сарын 4-нд 70 эрэгтэй, 68 эмэгтэй, 100 хүүхэд *Бруклин* усан онгоцонд сууж, Нью-Йорк боомтоос Калифорнийн эрэг хүртэл 17 000 миль аялан хөвжээ. Тэдний аяллын үед Атлантик, Пасифик гэж нэр өгсөн хоёр хүүхэд төрж, 12 хүн нас баржээ.

Зургаан сарын аян туйлын хүнд байв. Халуун бүсийн бүгчим халуунд зорчигчид чихцэлдэн, тэдэнд зөвхөн тааруухан хоол хүнс, ус л байдаг байв. Хорнын Хошууг тойрсны дараа тэд тав хоног амрахаар Хуан Фернандезын арал дээр зогсов. “Хуурай газрыг харж, түүн дээр дахин алхах нь далайн хөлөг дээрх амьдралаас амсхийх амралт байсныг бид талархалтайгаар мэдэж, үүнийг эдэлсэн билээ” гэж Каролин Августа Перкинс эргэн дурсчээ. Тэд усанд орж, цэнгэг усаар хувцсаа угааж, жимс, төмс түүж, загас, могой загас барьж, арлаар зугаалан, “Робинзон Крузогийн Агуйг”⁷ судалсан ажээ.

1846 оны Долдугаар сарын 31-нд аян хүчтэй шуургануудад өртөж, хүнс дуусах дөхөж, удаан хугацаагаар хөвсний эцэст тэд Сан Францискод хүрч ирэв. Зарим хүмүүс энд үлдэж, Нью Хоуп нэртэй эзэмшил үндэслэн байгуулсан бол, бусад нь Их Усны Сав газар дахь Гэгээнтнүүдтэй нэгдэхийн тулд дорно зүг уулс даван аялсан аж.

Цугларалт Үргэлжлэв

Америкийн бүх хэсгээс түүнчлэн олон улс үндэстнээс, олон янзын унаа хөсгөөр, мориор буюу явганаар, итгэлтэй хөрвөгчид гэр орон, унасан газар угаасан усаа орхин, Гэгээнтнүүдтэй нэгдэн нийлэхээр Хадат Уулсын зүг урт удаан аянд гарч эхэлжээ.

1847 оны Нэгдүгээр сард Ерөнхийлөгч Бригам Янг, өрнөд рүү чиглэсэн анхдагчуудын нүүдлийг удирдах бурханлигаар нөлөөлөгдсөн үндсэн хууль болсон “Израилын Буудлын талаарх Их Эзэний Үг ба Хүсэл” (С ба Г 136:1)-ийг гаргав. Хамтлагууд зохион байгуулагдаж, тэдний дундах бэлэвсэн эмэгтэйчүүд, эцэггүй хүмүүст анхаарал халамж тавих үүрэг хүлээсэн байлаа. Бусад хүмүүстэй харилцах харилцаанд хорон муу санаа, шунахайрал хийгээд хэрүүл маргаан байх ёсгүй байв. Хүмүүс баяртай байж, хөгжим, залбирал, бүжгээр талархлаа харуулах ёстой байв. Их Эзэн Ерөнхийлөгч Янгаар дамжуулан, “Замаараа явж мөн та нарт миний хэлсэнчлэн

хийгтүн, мөн дайснуудаасаа бүү эмээ” (С ба Г 136:17) гэж Гэгээнтнүүдэд хэлжээ.

Анхдагчуудын анхны хамтлаг Винтер Квотерсыг орхин явахаар бэлтгэж байх үед Парли П.Пратт Англи дахь номлолоосоо эргэж ирэн, Жон Тейлор Английн Гэгээнтнүүдийн бэлгэтэйгээр араас нь ирж байгаа тухай илтгэжээ. Маргааш нь Тейлор Ах эдгээр гишүүдээс өөрсдийн хайр хийгээд итгэлийн нотолгоо болгон аянчдад туслахын тулд тэдний илгээсэн аравны нэгийн мөнгөтэйгөөр хүрч ирэв. Тэр бас анхдагчуудын аяны зургийг гаргах болон орчныхоо газрыг мэдэхэд нь тэдэнд туслах шинжилгээ судалгааны үнэлж баршгүй чухал багаж авчирсан байв. 1847 оны Дөрөвдүгээр сарын 15-нд Бригам Янгаар удирдуулсан анхны хамтлаг аян замд гарав. Дараагийн хорин жилд ойролцоогоор 62 000 Гэгээнтэн Сионд цуглахын тулд мухлаг тэргүүд болон түрдэг тэргүүдээр хээр талыг туулан тэдний араас гарчээ.

Эдгээр аянчдыг гайхамшигтай сонин зүйлс, мөн түүнчлэн саад бэрхшээл тэдний аяны замд хүлээж байжээ. Солт Лейкийн Хөндийд хүрэхэд “хүнд бэрх үеийг” туулсан тухай Жозеф Моенор эргэн дурсчээ. Гэвч тэр өмнө нь огт үзээгүй зүйлүүдийг—үй олноороо сүрэглэсэн зэрлэг үхэр, толгод дээрх том том хуш моддыг харжээ.⁸ Цэцэглэж байсан асар их хэмжээний наранцэцгийг бусад нь харснаа санаж байлаа.

Гэгээнтнүүд бас өөрсдийнх нь бие бялдарт тавих шаардлагуудыг хөнгөрүүлсэн, итгэлийг хөхүүлэн дэмжигч туршлагуудтай болсон ажээ. Урт удаан өдрийн аяны дараа задгай гал дээр хоол хийж, тухайн өдрийн үйл ажиллагааг хэлэлцэхийн тулд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бүлгүүд болон цугладаг байв. Тэд сайн мэдээний зарчмуудын тухай ярилцаж, дуу дуулж, бүжиглэн бас хамтдаа залбирдаг байлаа.

Гэгээнтнүүд өрнөд рүү замаа алгуурхан хөөсөн тэр үед үхэл хагацал тэдэнд үе үе тохиодог байлаа. 1850 оны Зургадугаар сард Крандаллын гэр бүл арвантав болов. Долоо хоногийн төгсгөл гэхэд аймшигт булчин задрах тахлаар долоон хүн нас барав. Дараагийн хэдхэн хоногт гэр бүлийнх нь гишүүдээс

дахиад таван хүн нас барах нь тэр. Дараа нь Зургадугаар сарын 30-нд Крандалл Эгч төрөх үеэрээ сая төрсөн нярай хүүхдийнхээ хамт өөд болов.

Солт Лейкийн Хөндий рүү хийсэн аяндаа Гэгээнтнүүд их зовлон зүдгүүр амссан хэдий ч, эв нэгдэл, хамтын ажиллагаа болон өөдрөг үзлийн сүнс давамгайлсан юм. Итгэл хийгээд Их Эзэний төлөө шийдвэр төгс байх явдлаар холбогдсон тэд өөрсдийн зовлон зүдгүүрийн дунд баяр хөөрийг олдог байв.

Энэ Бол Зөв Газар

1847 оны Долдугаар сарын 21-нд анхдагчуудын эхний хамтлагаас Оорсон Пратт, Эраст Снөү нар цагаачдаас түрүүлж Солт Лейкийн хөндийд оржээ. Хүн харагдахааргүй тийм өндөр өвс, фермийн аж ахуйд нэн тохиромжтой газар, хөндий дундуур урсах хэдэн жижиг горхийг тэд олж харав. Гэдэсний хижгээр өвчилсөн байсан Ерөнхийлөгч Бригам Янг гурван өдрийн дараа хөндий рүү харсан хавцлын аманд хөнгөн морин тэргээрээ хүрч иржээ. Ерөнхийлөгч Янг орчин тойрноо хараад, бошиглолын байдлаар аянаа дуусган: “За боллоо. Энэ бол зөв газар байна” гэж хэлжээ.

Араас нь ирж явсан Гэгээнтнүүд уулын цаанаас гарч ирээд, тэд ч бас өөрсдөд нь амлагдсан нутгийг ширтэн харж байлаа! Энэ хөндий, баруун зүгт наранд гялтганан харагдах давст нуурын хамт үзэгдэл хийгээд бошиглолын тусгал, тэд болон мянга мянган хүмүүс үүний төлөө мөрөөдөж явсан газар байлаа. Энэ бол тэд Хадат Уулсын дунд хүчирхэг хүмүүс болж, тэдний толгой хоргодох тэрхүү газар байлаа.

Хэдэн жилийн дараа Английн хөрвөгч Жеан Рио Гриффитс Бейкер Солт Лейк хотыг анх удаа үзээд төрсөн сэтгэгдлийнхээ тухай, “Хот нь энд . . . талбайнуудад буюу тэдний нэрлэдгээр хорооллуудаар сунан оршино, хороолол бүр нь арван акр газрыг агуулж, найман хэсэгт хуваагдаж, хэсэг бүрд нэг байшин байна. Би зогсоод, харлаа, би сэтгэгдэлдээ чадан ядан шинжилгээ хийж болно л доо, гэвч хамгаалагч анхаарал халамжийн төлөөх баяр хөөр хийгээд талархал надад давамгайлж,

мөн бидний урт удаан хийгээд аюул осолтой аяны үед миний бодол санаа ч ийм байсан гэж би боддог” гэж хэлжээ.⁹

Гар Тэрэгтэй Анхдагчууд

1850-иад оны үед Сүмийн удирдагчид үй олон тооны цагаачдад туслах санхүүгийн тусламжийг өргөжүүлэхийн тулд зардлыг багасгах нэг арга зам болгож гар тэрэгний хамтлагуудыг бий болгохоор шийдвэрлэжээ. Энэ аргаар аялагч Гэгээнтнүүд зөвхөн 100 фунт гурил, бас нэн бага хүнсний зүйл, хувийн эд зүйлсээ тэргэн дээр ачиж, хээр талаар түрж явдаг байжээ. 1856, 1860 оны хооронд гар тэрэгний арван хамтлаг Юта руу аян хийжээ. Хамтлагуудаас найм нь Солт Лейкийн Хөндийд амжилттай хүрсэн боловч хоёр нь, Мартин, Вилли нарын гар тэрэгний хамтлаг өвлийн эхэн үеэр саатаж, тэдний дундах олон Гэгээнтэн эрсэджээ.

Хувь заяа нь өрөвдөлтэйгөөр эргэсэн хамтлагуудын нэгнийх нь анхдагч Нелли Пуселл хээр талд арван нас хүрсэн ажээ. Түүний эцэг, эх хоёул аяны үед нас барсан аж. Уулсад бүлэг ойртох үеэр цаг агаар хахир хүйтэн болж тогтоосон хэмжээтэй хүнс нь дуусч, өлссөнөөс ядарч туйлдсан Гэгээнтнүүд аянаа цааш үргэлжлүүлэх тэнхэлгүй болсон байв. Нелли, түүний эгч хоёр санаагаар их унасан байв. Тэд ямар ч найдлагагүй болоод байтал хамтлагийн удирдагч мухлаг тэргээр тэдэнд дээр хүрч ирэв. Тэрээр Неллийг мухлаг тэргэнд суулгаж, Маггийг тэрэгнээс чанга барин, хажуугаар нь дагаад яв гэжээ. Хөдөлгөөн Маггийг осгож үхэхээс аварсан учир тэр азтай байлаа.

Тэд Солт Лейк Хотод хүрч ирээд, Неллигийн хээр талыг туулахад элээсэн гутал, оймсыг нь тайлж авахад, осгосноос болж хөлийнх нь арьс хууран гарч ирсэн аж. Зоригт энэ охины хөлийг тайрсан болохоор тэрээр амьдралынхаа үлдсэн хугацаанд өвдөг дээрээ явсан юм. Хожим нь тэрээр гэрлэж, зургаан хүүхэд төрүүлэн, гэр орноо авч яван, сайн сайхан үр удмаа өсгөн бойжуулсан билээ.¹⁰ Өөрийнхөө байдлыг үл хайхарсан түүний зоримог шийдэмгий байдал, өөрийг нь халамжилж байсан хүмүүст нинжин сэтгэлээр

ханддаг байсан нь, эхэн үеийн Сүмийн гишүүдийн итгэл хийгээд золиослол хийх хүсэл эрмэлзлэлийн үлгэр жишээ болдог билээ. Тэдний үлгэр жишээ бол тэднийг дагах бүх Гэгээнтнүүдийн хувьд итгэлийн өв юм.

Мартины гар тэрэгний хамтлагт хээр талыг туулсан нэг хүн Ютад олон жил амьдарч байлаа. Нэг өдөр тэр гар тэрэгний хамтлагийн хангаж чадахаас илүү хангамж буюу хамгаалалтгүйгээр Гэгээнтнүүдийг хээр талыг туулахыг зөвшөөрсөн Сүмийн удирдагчдыг хурцаар шүүмжилсэн бүлэг хүмүүсийн дунд байв. Тэр настай хүн цаашид тэсч чадахгүй болох хүртлээ сонссоор байв; тэгээд тэр босч, ихэд сэтгэл хөдлөн хэлсэн нь:

“Би тэр хамтлагт чинь байсан юм, бас миний эхнэр ч тэнд байсан. . . . Та нарын төсөөлж чадах ямар ч зүйлээс илүү их зовлонг бид амсаж, олон хүн толгой халхлах юмгүй хүйтэнд байснаас, бас өлссөнөөс амь эрсэдсэн боловч, тэр хамтлагаас амьд мэнд үлдсэн хүн шүүмжилсэн үг хэлж байхыг нь та нар ер нь сонссон уу? . . . *Гай зовлонгийнхоо үед бид түүнтэй танилцахын төлөө Бурхан амьдардаг гэдэг үнэмлэхүй мэдлэгээр [бид] дамжин гарч ирсэн юм.*

“Би ихэд ядарч, өвчнөөс болж туйлдсан үедээ бас хоол хүнс дутагдсанаас нэг хөлөө нөгөө хөлнийхөө өмнө арай ядан зөөн гишгэж явахдаа гар тэргээ түрж л явсан. Би урагшаагаа харж, элсэн зурвас буюу толгойн бэл олж хараад, би зөвхөн тэр хүртэл явж чадна, тэгээд тэнд би бууж өгөхөөс аргагүйд хүрнэ, учир нь би ачааг түүгээр түрэн гаргаж чадахгүй . . . гэж хэлдэг байв. Би тэр элс рүү хүрч очин түүнд хүрэхэд тэрэг намайг урагш татаж эхэлдэгсэн. Хэн миний тэргийг түрээд байгааг харах гэж би олон удаа эргэн хардаг байлаа, гэвч хэнийг ч олж хардаггүй байлаа. Бурханы тэнгэр элчүүд тэнд байсныг би мэддэг байсан.

“Тар тэргээр явахаар сонгосондоо би харамсдаг байсан уу? Үгүй ээ. Тэр үед ч бас түүнээс хойш өнгөрсөн амьдралынхаа мөч болгонд шүү. *Бурхантай танилцахын тулд бидний төлсөн төлөөс нь төлөх онцгой боломж байсан юм, тэгээд би Мартины*



Өвлийн эхэн үеэр хээр талд хөсөр хаягдсан Мартины Гар Тэрээний Хамтлагийн гишүүдийг аврахын тулд Солт Лейк Хөндийн Гэгээнтнүүд амь насаараа дэнчин тавьсан юм.

Гар Тэрэгний Хамтлагт явах онцгой боломж надад олдсонд би талархалтай байдаг."¹¹

Манай дууллын номонд сайн мэдээг зоримгоор хүлээн авч, соёл иргэншлийн манлайд амьдрахын тулд алс холын аянд гарсан Сүмийн эхэн үеийн гишүүдийн тухай нэг дуу байдаг:

*Улс үндсээ байгуулагч тэд;
Улбаа замын дагуу тэд
Урьдаа байгаа үеийнхэнд тэдний
Урагш ахих гишгүүр өдөр бүрийнх нь үйлс.
Шинэ бат бөх суурийг барин
Зэлүүд хязгаар луу яаран
Урагшаа, ямагт урагшаа давшигч
Хүндэт Анхдагч, адислагдсан та!*

Тэдний үлгэр жишээ бид улс эх орондоо хэрхэн илүү их итгэл хийгээд эрэлхэг зоригтой амьдрахыг бидэнд заадаг:

*Үйлчлэл ямагт тэдний уриа
Хайр тэдний хөтөч од болсон
Хол ойрд гэрэл цацруулан
Эр зориг тэдний бөхөшгүй гэрэлт цамхаг.
Өдөр бүр ачаа үүрнэ
Өдөр бүр зүрхийг баярлуулна
Өдөр бүр найдварыг гэрэлтүүлнэ
Хүндэт Анхдагч, адислагдсан та!*¹²

Үндэстнүүдэд Тугийг Үндэслэсэн нь

Ерөнхийлөгч Бригам Янг Гэгээнтнүүдийн эхний хамтлагийг хээр талыг гаталган Ютад амжилттай авчирсны дараа эдүгээ зэлүүд нутагт Бурханы хаант улс үндэслэн байгуулахад анхаарлаа хандуулах болов. Түүний үзэгдэл, удирдлагаар дамжин нэгэн цагт эзгүй зэлүүд байсан газар соёл иргэншил дэгжин хөгжиж, Гэгээнтнүүдийн хувьд тайван амьдрах газар болов. Түүний шулуун шууд чиглүүлэл шинээр амьдрах газрынхаа боломжуудыг төсөөлөхөд нь Гэгээнтнүүдэд тусалж, Бурханы хаант улсыг байгуулах тэдний эрэл хайгуулд тэднийг урагш удирдсан юм.

Эхний хамтлаг ирснээс хойш хоёр хоногийн дараа Бригам Янг болон Арванхоёрын хэдэн гишүүн Навууг орхин явахаас өмнө Ерөнхийлөгч Янгийн үзэгдэлд харсан уулын хажуу дахь цохио хадны орчим өөдөө гарчээ. Тэд өргөн цэлгэр хөндийг тэндээс харж, дэлхийн бүх үндэстэн энэ газарт морилон ирэхийг мөн энд Гэгээнтнүүд хөгжил цэцэглэлт, амар амгаланг эдлэх болно гэдгийг бошигложээ. Тэд уг өндөрлөгийг, “Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөн газрын дөрвөн зүгээс Израилын цөлөгдсөн хүмүүсийг цуглуулах болно” (Исаиа 11:12)¹ хэмээн амласан Исаиа дахь судрын ишлэлээр Тугийн Оргил гэж нэрлэсэн ажээ.

1847 оны Долдугаар сарын 28-нд Ерөнхийлөгч Янгийн анхны олон нийтийн ажил нь ариун сүм барих гол газрыг сонгон, үүний төсөл, барилгын ажлыг гүйцэтгэх хүмүүсийг гаргах явдал байлаа. Тэрээр сонгосон газар дээр таягаа тавиад, “Энд бид Бурхандаа ариун сүм барих болно” гэж хэлжээ. Энэхүү мэдэгдэл нь Гэгээнтнүүд Навууг орхин явах

үед ариун сүмийн шүтээнийг үргэлжлүүлэхгүй байхад албадуулагдахаас өмнө богинохон хугацаанд байсан тэрхүү тайтгарлыг тэдэнд өгөх ёстой байв.

Наймдугаар сард, Сүмийн удирдагчид болон анхдагчуудын эхний хамтлагийн ихэнх нь дараагийн жил нь өөрсдийн гэр бүлүүдийг хөндий рүү ирэхэд нь бэлтгэхийн тулд Винтер Квортерст эргэж ирэв. Тэднийг ирсний дараа удалгүй Бригам Янг болон Арванхоёрын Чуулга, Тэргүүн Зөвлөлийг дахин зохион байгуулах цаг болсныг ойлгон мэдэрсэн ажээ. Бригам Янг Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчийн хувьд Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжин батлагджээ. Тэрээр Хибер К.Кимбалл, Виллар Ричардс нарыг өөрийн Зөвлөхүүдээр сонгож, Гэгээнтнүүд удирдагчдаа санал нэгтгэйгээр дэмжин батлав.

Хөндий Дэх Анхны Жил

1847 оны зун дуусахаас өмнө Гэгээнтнүүдийн өөр хоёр хамтлаг Солт Лейкийн Хөндийд ирж, ингээд бараг 2000 гишүүн Солт Лейк Гадас болж зохион байгуулагдав. Хожуу хураах үр тариа тариалсан боловч ургац шалихгүй гарч, улмаар хавар нь олон хүмүүс хүнсний хомсдолд нэрвэгдэв. Тэр үед хөвгүүн байсан Жон Р.Янг бичихдээ:

“Ногоо ургаж эхэлсэн цагаар өлсгөлөн хүчээ авав. Хэдэн сарын турш бид талхгүй байлаа. Үхрийн мах, сүү, гахайн өвс, сараана цэцгийн үндэс, өргөст халгай бидний өдөр тутмын хүнсийг бүрдүүлдэг байв. Би малчин хүү байлаа, тэгээд малаа хариулах зуураа, яг л үхрийн гэдэс дүүрэх лугаа адил, би өргөст халгайн иш идэж гэдсээ цатгадаг байлаа. Эцэстээ өлсөх нь бүр дэндэж, аав маань шувуу тоншсон хуучин үхрийн ширийг модны гишүүнээс буулган авчирлаа; тэгээд нөгөөх шир ихэд сайхан амттай шөл болон хувирч билээ”² гэжээ. Суурьшигчид үнэ хөлсгүйгээр хамтран ажиллаж, бие биентэйгээ хуваалцдаг байв, иймээс тэд энэ хүнд бэрх цаг үеийг даван туулах боломжтой байлаа.

1848 оны Зургадугаар сар гэхэд суурьшигчид таваас зургаан мянган акр газар тариалж, хөндий тэр чигээрээ ногоорон, ургац



*Гэгээнтнүүд өөрсдийн итгэл, хичээл зүтгэлээрээ
Солт Лейкийн хөндийд хот байгуулж эхлэв.
Энэ сийлбэр уг хөндий 1853 онд ямар байсныг харуулдаг.*

дүүрэн харагдаж байлаа. Гэвч хар хүрэлзгэнийн үй олон сүрэг ургац дээр бууж ирэхэд Гэгээнтнүүд айжээ. Суурьшигчид чадах бүхнээ хийв. Тэд шуудуу ухаж, горхины усыг хүрэлзгэнүүд рүү эргүүлэв. Тэд шавьжуудыг саваа, хогийн шүүрээр цохьж, шатаах гэж оролдсон боловч, тэдний хүч чармайлт үр ашиггүй байлаа. Хүрэлзгэнүүд тоо томшгүй олон тоогоороо ирэх нь үргэлжилсээр байв. Солт Лейк Гадасны ерөнхийлөгч Патриарх Жон Смит мацгийн болон залбирлын өдрийн төлөө уриалан дууджээ. Удалгүй цахлайн асар том сүрэг тэнгэрт гарч ирэн хүрэлзгэнүүд дээр буух нь тэр. Энэ туршлагын тухай Сюзан Нөүбл Грант өгүүлэхдээ: “Цахлайнууд үсэрч, дэвхрэх хүрэлзгэнүүдийг бараг л өлөн зэлмүүн мэт ховдоглон залгих нь гайхалтай байлаа”³ гэжээ. Гэгээнтнүүд баяр хөөр болон гайхан харж байлаа. Тэдний амьдрал аврагдлаа.

Гэгээнтнүүд хүнд нөхцөлийг эс хайхран эрч хүч, итгэлтэйгээр ажиллаж, улмаар тэд удалгүй их дэвшил гаргажээ. 1849

оны Есдүгээр сард Солт Лейк Хотоор дамжин Калифорни уруу явсан нэг аянчин тэдэнд энэ байдлаар магтаал өргөн: “Ийм дэг журамтай, чин хүсэл эрмэлзэлтэй, ажилч хичээнгүй, иргэншсэн хүмүүсийг би өмнө нь хэзээ ч үзээгүй, тэгээд ийм богинохон хугацаанд энд аглаг буйдад ийм ихийг хийсэн нь урьд хожид үзэгдэж дуулдаагүй билээ. Дөрвөөс таван мянган оршин суугчтай энэ хотод ганц нэгээрээ зорилгогүй тэнүүчлэгч залхуу зайдан нэгэн, эсвэл дэмий сэлгүүцэгч хэн нэгэнтэй тааралдсангүй. Ургац авах тэдний хэтийн төлөв дажгүй сайн бөгөөд таны харах юм бүхэнд байдаг оюун санаа хийгээд эрч хүч нь миний очиж үзсэн ямар ч хэмжээтэй, ямар ч хотод эндхийнхтэй эн тэнцүү байж чадахгүй”⁴ гэжээ.

Судалгаа Шинжилгээ

1848 оны зуны сүүлчээр Ерөнхийлөгч Бригам Янг Винтер Квотероос Солт Лейкийн Хөндий рүү дахин аялав. Тэр ирээд шинэ орчинд ямар нөөц баялаг, боломжууд байдгийг Гэгээнтнүүд мэдэх хэрэгтэй юм байна гэдгийг ухаарчээ. Энэ бүсэд амьдарч байсан Индианчуудаас их зүйлийг олж мэдсэн хэдий ч, эмийн ямар ургамлууд болон байгалийн ямар баялаг байдгийг нээн олж судлан шинжлэхийн тулд Ерөнхийлөгч Бригам Янг бас Сүмийн гишүүдийг илгээжээ.

Тэрээр хүмүүс суурьшуулах газруудыг олохын тулд судалгааны өөр хэсгүүдийг илгээв. Эдгээр гишүүд аяллаараа эрдсийн ордууд, их хэмжээний мод, усны нөөц, өвс ихтэй газрууд түүнчлэн суурин газрууд байгуулахад тохиромжтой газруудыг олж нээсэн ажээ. Газрыг дамлан худалдахаас сэрэмжлэн, өөрсдөд нь хуваарилан олгосон газрыг бусдад худалдахгүй байхыг бошиглогч Гэгээнтнүүдэд сэрэмжлүүлжээ. Газар бол тэдэнд хариуцуулсан үүрэгт ажил байсан бөгөөд санхүүгийн ашиг сонирхлын үүднээс бус, харин ухаалгаар, хичээнгүй зүтгэлээр эрхлэх ёстой байлаа.

1849 оны намар Ерөнхийлөгч Янгийн чиглүүлэл дор Цагаачлалын Байнгын Сан үндэслэгдэн бий болов. Үүний зорилго нь Сүмийн гол бие бүрэлдэхүүнтэй нэгдэн нийлэхийн

тулд нүүн шилжих хөрөнгө мөнгөгүй ядуучуудад туслах явдал байлаа. Олон Гэгээнтнүүд их золиослол хийж, уг санд хандивлаж байсны үр дүнд олон мянган гишүүн Солт Лейкийн Хөндий рүү нүүж ирэх боломжтой болсон ажээ. Тусламж хүлээн авсан хүмүүс боломжтой болмогц тусламж болгон өөрсдийн хүлээж авсан тоо хэмжээний мөнгийг эргүүлэн төлөх ёстой байлаа. Энэ санг мөн бусдад туслахад ашигладаг байв. Хоршин ажиллах энэхүү хүч чармайлтаар дамжуулан, Гэгээнтнүүд гачигдалтай хүмүүсийн амьдралыг адисалж байлаа.

Номлогч Нар Дуудлагад Хариулав

Ажил хөдөлмөрийн чимээ шуугиан болон дотоод амьдралын оргилсон уур амьсгалын зэрэгцээгээр Ерөнхийлөгч Бригам Янг Сүмд анхаарал халамж тавих болов. 1849 оны Аравдугаар сарын 6-нд болсон ерөнхий чуулган дээр тэрээр гадаадын номлолуудад үйлчлүүлэхээр Арванхоёрын хэдэн гишүүнийг шинээр дуудагдсан номлогч нарын хамт томилов. Тэд гэр бүлүүдээ, шинэ гэр орноо түүнчлэн дуусаагүй олон ажил үйлсээ ардаа орхих байсан ч гэсэн эдгээр дуудлагуудыг хүлээн авчээ. Эраст Снөү болон өөр хэдэн ахлагч Скандинавт номлогчийн ажлыг нээсэн бол Лорензо Снөү, Жозеф Торонто хоёр Итали уруу явав. Аддисон Пратт, Люиза Барнес Пратт Сосайти Арлууд дээрх Аддисоны хуучин хөдөлмөрийн талбарт эргэн ирэв. Жон Тейлор Франц, Германд дуудагдав. Номлогч нар дорнод зүгт явж, Хадат Уулст шинэ Сион уруу хөдөлсөн Гэгээнтнүүдийг дайран өнгөрчээ.

Номлогч нар хөдөлмөрийнхөө талбарт гайхамшгуудыг гэрчилж, Сүмд олон хүмүүст баптисм хүртээж байв. Хожим нь Сүмийн Ерөнхийлөгч болсон Лорензо Снөү Италид номлож байхдаа үхлийн ирмэг дээр байсан гурван настай жаал хүүтэй тааралджээ. Тэр хүүхдийг эдгээх болон уг бүс дэх хүмүүсийн зүрх сэтгэлийг нээх боломжийг тэрээр мэдэж байв. Тэр үдэш тэрээр Бурханы чиглүүлэл хүсч удаан бөгөөд чин сэтгэлээсээ залбирч, маргааш нь тэр хамтрагчтайгаа хамт нөгөөх хүүгийн

төлөө мацаг барьж, залбирав. Үдээс хойш нь тэд түүнийг адисалж, өөрсдийнхөө хөдөлмөрт тусламж эрэн чимээгүй залбирал хийжээ. Жаал хүү шөнөжингөө тайван унтаж, гайхамшигтайгаар эдгэрсэн ажээ. Энэхүү эдгэрэлтийн тухай үг Италийн Пиедмонтын хөндий даяар тархав. Номлогч нарт хаалгууд нээгдэж, тус бүсэд анхны баптисмууд боллоо.⁵

1852 оны Наймдугаар сард, Солт Лейк Хотод болсон тусгай чуулган дээр дэлхий даяар номлолд явахаар 106 ахлагч дуудагдав. Эдгээр номлогч нар мөн хожим нь дуудагдсан хүмүүс сайн мэдээг Өмнөд Америк, Хятад, Энэтхэг, Испани, Австрали, Хавай болон Өмнөд Номхон Далайд номлож байлаа. Эдгээр бүсүүдийн олонхид нь номлогч нар эхний үед багахан амжилттай байсан юм. Гэвч тэд хожмын номлогч нарын хүч чармайлтаар Сүмд ирсэн олон хүмүүст нөлөөлсөн үрийг суулгасан билээ.

Ахлагч Эдвард Стийвенсон Испанийн Гибралтарын Номлолд дуудагдав. Энэ дуудлага түүнийг төрсөн газартаа эргэн ирж, сэргээгдсэн сайн мэдээг эх орон нэгтнүүддээ зоригтойгоор тунхаглах боломжийг олгосон ажээ. Номлосныхоо төлөө тэрээр баривчлагдаж, тэрээр харуул хамгаалалтынханд зааж байснаас тэдний нэг нь бараг хөрвөгдөх шахсаныг эрх баригчид мэдэх хүртэл хэсэг хугацааг шоронд өнгөрөөжээ. Суллагдсаныхаа дараа тэрээр Сүмд хоёр хүнд баптисм хүртээж, улмаар 1854 оны Нэгдүгээр сар гэхэд арван гишүүнтэй нэг салбар зохион байгуулагджээ. Долдугаар сард зургаан гишүүн Ази дахь Британийн армид алба хаахаар явсан ч гэсэн, салбар арван есөн гишүүнтэй, түүний дотор нэг далтан, нэг ахлагч, нэг санваартан, нэг багштай болж, өсөлт хөгжилтөө үргэлжлүүлэхэд нь хэрэгтэй байсан удирдлагаар салбарыг хангаж байлаа.⁶

Францын Полинезийн орон нутаг дахь удирдлага 1852 онд номлогч нарыг хөөн гаргасан байна. Гэвч хөрвөгдсөн Гэгээнтнүүд 1892 он дахь номлолын дараагийн хүч чармайлт хүртэл Сүмийг авч явсан ажээ. Ахлагч Техоне, Маехеа хоёр бүр ч зоригтой байсан бөгөөд тэд итгэлээ үгүйсгэснээс

шоронд хоригдож, хүнд сорилтыг даван туулах нь дээр гэж үзсэн ажээ. Гэгээнтнүүдийг идэвхтэй, сайн мэдээнд итгэлтэй хэвээр байлгахыг тэр хоёр хоёул хичээж байлаа.⁷

Нэгдсэн Улсын гадна талд Сүмд нэгдсэн хүмүүсийн хувьд энэ бол Америк уруу усан онгоцоор ирж Сионд цуглах үе байлаа. Элизабет Вуд, Чарльз Вуд хоёр нүүж явахынхаа өмнө мөнгөтэй болохын тулд хэдэн жил хөдөлмөрлөсөн Өмнөд Африкаас 1860 онд гарчээ. Тэд шаардлагатай байсан мөнгийг цуглуулах хүртлээ Элизабет нэг баян хүний гэр орныг авч яван, нөхөр нь тоосго цохидог байжээ. Элизабетийг хүү төрүүлээд 24 цаг болсны дараа орон дээр хэвтүүлэн усан онгоцонд өргөж оруулан, түүнийг илүү тав тухтай байлгахын тулд ахмадын орыг түүнд гарган өгчээ. Аяны үед тэр нэн хүнд өвчтэй байж, хоёр удаа бараг үхэх шахсан боловч Ютагийн Филлморед суурьшин амьдарсан ажээ.

Номлогч нар өөрсдийн үйлчилж байсан орнууд дахь Гэгээнтнүүдэд нэн хүндтэй байлаа. Жозеф Ф.Смит 1857 онд Хавай дахь номлолынхоо төгсгөл хавьд өндөр халуунтай чичиргээ өвчнөөр өвчилж, энэ нь гурван сар ажлаас нь хөндийрүүлжээ. Тэрээр Хавайн итгэлтэй Гэгээнтэн Ма Махоохеегийн асрамжинд байхаар адислагдсан ажээ. Тэр Иосефыг яг өөрийнхөө хүүгийн адилаар асрамжилж, тэр хоёрын хооронд хайрын хүчтэй шижим холбоо бий болжээ. Хэдэн жилийн дараа Жозеф Ф.Смит Сүмийн Ерөнхийлөгч болоод Хонолулуд айлчлан очиж, энд дөнгөж ирэнгүүтээ, сор болсон хэдэн гадил жимс гартаа барьж өргөл болгон ирсэн, хараагүй настай эмэгтэйтэй уулзжээ. “Иосепа, Иосепа” гэж түүний дуудахыг тэр сонсов. Тэрээр тэр даруйд түүн рүү гүйж очин, чанга тэвэрч олон дахин үнсэж, толгойг нь илэн, “Ээж ээ, Ээж ээ, хайрт ээж минь” гэж хэлжээ.⁸

Эзэмших Дуудлагууд

Юта болон өмнөд Айдахо түүнчлэн хожим нь Аризона, Вайоминг, Невада, Калифонийн зарим хэсэгт хувь хүмүүс болон гэр бүлүүдээр үндэслэгдсэн олон хамт олноуд ерөн-

хий чуулган дээр дуудагджээ. Мянга мянган шинээр суурьшигчид амьдарч, фермийн аж ахуй эрхэлж байсан эдгээр хамт олнуудыг үндэслэн байгуулах ажлыг Ерөнхийлөгч Бригам Янг чиглүүлж байсан юм.

Түүний амьдралын туршид Солт Лейкийн бүх хөндий, түүнчлэн эргэн тойрны бүс нутгуудыг эзэмшсэн юм. Бригам Янгийн нас барсан 1877 он гэхэд 350 гаруй эзэмшил үндэслэгдсэн бөгөөд 1900 он гэхэд эзэмшил бараг 500-д хүрчээ. Мормоны эзэмшлийн амжилт нь Ерөнхийлөгч Янгаас хүлээн авсан дуудлагуудаа хэрэгжүүлэхэд “хүмүүс удирдагчиддаа үнэнч байснаас түүнчлэн [тэдний] хувийн амь бие хайргүй, бүхнээ зориулсан золиослолоос” үүдэлтэйг Сүмийн эхэн үеийн эрх мэдэлтэн Бригам Хенри Робертс тэмдэглэсэн байдаг.⁹ Эзэмшигчид Бурханы бошиглогчийг дагахын тулд материаллаг ая тух, найз нартайгаа хэлхээ холбоотой байх тэрчлэн зарим үед амь насаа золиосолж байв.

Алслагдсан бүсүүд рүү явахаар дуудагдсан ах нар болон тэдний гэр бүлүүдийн нэрсийг Ерөнхийлөгч Янг ерөнхий чуулганы хуралдаанууд дээр уншдаг байв. Эдгээр эзэмшигчид өөрсдийгөө номлолд дуудагдсан гэж үзэн, чөлөөлөгдөх хүртлээ тэд томилогдсон газартаа байх болно гэдгийг мэдэж байлаа. Тэд өөрсдийнхөө зардлаар, өөрсдийнхөө хангамжаар шинэ бүс нутгууд руу аянд гардаг байв. Гартаа байгаа нөөц боломжуудыг тэд хэрхэн сайн ашиглахаас тэдний амжилт шалтгаалдаг байлаа. Тэд тариалангийн талбайн сулалгаа хийж, цэвэрлэж, тариан тээрэм хийж, газар услахын тулд усалгааны шуудуу ухаж, малын бэлчээрт хашаа барин, зам тавьдаг байв. Тэд үр тариа, ногоо тарьж, сүм сургуулиуд барьж, Индианчуудтай нөхөрсөг харилцаатай байхыг хичээдэг байлаа. Тэд өвчин зовлон тохиолдох, түүнчлэн хүүхэд төрөх, үхэл хагацал тохиолдох, хурим хийхэд бие биендээ тусалдаг байлаа.

1862 онд Чарльз Лаувелл Вокер өмнөд Ютад суурьших дуудлага хүлээн авчээ. Тэрээр дуудагдсан хүмүүст зориулсан цуглаанд оролцоод: “Энд би хэсэг хугацаанд мартах аргагүй



Олон Гэгээнтнүүд Ерөнхийлөгч Бригам Янгийн дуудлагад хариулан,
шинэ газар нутгууд эзэмшихийн тулд төвхнөсөн гэр орноо орхин явж байлаа.

нэг зарчмыг мэдэж авлаа. Дуулгавартай байдал бол тэнгэрт ч газар дээр ч агуу зарчим гэдгийг энэ нь надад харуулсан юм. Тийм болохоор, би энд сүүлийн долоон жил халуунд халж, хүйтэнд хөрч, өлсөж цанган ажиллалаа, мөн хүнд бэрх нөхцөл байдал эцэстээ намайг гэр оронтой болгож, жимсний моддын олон нь дөнгөж цэцэглэн, гоё сайхан харагдаж байна. Тийм болохоор, Түүнийг хайрлан, мөн түүнээс эмээдэг хүмүүсийн сайн сайхны төлөө бүхнийг захирдаг Тэнгэр дэх Эцэгийнхээ хүслийг явж гүйцэлдүүлэхийн тулд би үүнийг орхих ёстой. Түүний өмнө хүлээн авагдаж болохуйц байдлаар надаас шаардагдах тэр зүйлийг хэрэгжүүлэх хүч чадлыг надад соёрхооч хэмээн би Бурханд залбирья” хэмээн тэмдэглэжээ.¹⁰

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Чарльз К.Рич бас эзэмших дуудлага хүлээн авчээ. Бригам Янг түүнийг болон өөр хэдэн ахыг гэр бүлээ аваачин Солт Лейк хотоос хойш 150 миль орчимд орших Беар Лейкийн Хөндийд суурьшихаар дууджээ. Тэр хөндий далайн түвшнээс дээш өндөрт байдаг бөгөөд өвөлдөө их хүйтэн, зузаан цастай байдаг байлаа. Рич ах Европ дахь номлолоосоо саяхан эргэж ирээд байсан бөгөөд гэр бүлээ нүүлгэж, хүнд нөхцөл байдалд дахин очъё гэж бодохгүй байжээ. Гэвч тэрээр дуудлагыг хүлээн авч 1864 оны Зургадугаар сард Беар Лейкийн Хөндийд иржээ. Дараагийн өвөл нь ер бусын хахир болж, хавар болоход бусад ах нарын зарим нь тэндээс явахаар шийдсэн аж. Энэхүү хүйтэн цаг агаарт амьдрал амаргүй байж болохыг Рич Ах мэдэж байсан боловч:

“Олон бэрхшээл зовлон байлаа. Би үүнийг хүлцэн тэвчиж . . . тэдгээрийг бид хамтдаа хуваалцдаг байлаа. Гэвч хэрэв та нар өөр хаа нэгэнтээ явах гэж байгаа бол, энэ нь та нарын эрх, гэвч би та нарыг энэ газрыг орхиж явах эрхийг хасахыг хүсэхгүй байна. . . . Харин би бүр ганцаараа үлдсэн ч ялгаагүй, эндээ үлдэх ёстой. Ерөнхийлөгч Янг намайг энд дуудсан юм, тиймээ тэрээр намайг чөлөөлж, эндээс явахыг надад зөвшөөрөх хүртэл энд үлдэх болно” гэж хэлжээ. Рич

Ах, түүний гэр бүл үлдсэн бөгөөд тэрээр дараагийн хэдэн арван жилд цэцэглэн хөгжиж байсан хамт олны удирдагч болсон билээ.¹¹ Бусад мянга мянган хүмүүсийн нэгэн адил тэрээр Бурханы хаант улсыг байгуулахад туслахын тулд удирдагчдаа дуулгавартайгаар дагах хүсэл эрмэлзэлтэй байсан юм.

Индианчуудтай Тогтоосон Харилцаа

Эзэмшигчид хил рүү цааш ахих тусам тэд Индианчуудтай олонтаа харилцаж байв. Өрнөдөд суурьшигчдын заримаас ялгаатай нь, Ерөнхийлөгч Бригам Янг, нутгийн уугуул ах эгч нараа тэтгэн, тэднийг Сүмд авчрахыг хичээхийг Гэгээнтнүүдэд заадаг байв. Индианчуудын дунд номлох үйл ажиллагааг Айдахогийн Нутаг Дэвсгэрийн Салмон Голын бүс дэх Форт Лимхай болон Ютагийн Нутаг Дэвсгэр дэх дээд Колорадогийн Элк Уулан дахь сууринд туршиж байв. Ерөнхийлөгч Янг бас гишүүд нь Индиан ах эгч нартаа зориулж хувцас оёх, мөн тэднийг тэжээхэд туслах мөнгө цуглуулах Нийгмийн Халамжийн Бүлгүүдийг бий болгосон ажээ.

Томас Л.Кейний эхнэр асан, Гэгээнтнүүдийн гишүүн бус агуу их найз Элизабет Кейн Юта даяар аялж, нэгэн ядмагхан Мормон эмэгтэйн гэрт буужээ. Тэр эмэгтэй Индианчуудтай хэрхэн харьцдагийг тэрээр харахаасаа өмнө Элизабет тэр эмэгтэйн талаар ихийг бодоогүй байлаа. Нөгөөх эмэгтэй зочдыг хоолонд дуудаад, тэрээр хүлээж байсан Индианчуудад бас хэдэн үг хэлжээ. Тэр эмэгтэй Индианчуудад юу гэж хэлснийг Элизабет асуухад тэр гэр бүлд байсан нэг хүү, “Гаднын энэ хүмүүс эхлээд ирсэн болохоор би зөвхөн тэдэнд хүрэлцэх хоол хийлээ; харин та нарын хоолыг одоо зуухан дээр хийж байна, хоол болмогц би та нарыг дуудна” гэлээ гэж түүнд хэлжээ. Элизабет итгэсэнгүй, тэгээд тэр эмэгтэй Индианчуудыг үнэхээр хооллох юм уу гэж асуужээ. “Ээж танд үйлчилсэн шигээ яг тэдэнд үйлчлэх болно, мөн тэднийг өөрийнхөө ширээнд суулгадаг юм” гэж хүү түүнд хэлэв. Тэднийг хооллож байх зуур тэр тэднийг хүлээн тэдэнд үйлчилсэн билээ.¹²

Санваартны болон Хавсралт Байгууллагуудын Чиг Үүргүүдийг Зохион Байгуулсан нь

Ерөнхийлөгч Янг сүүлчийнхээ жилүүдэд санваартны зарим чухал үүргүүдийг үндэслэн бий болгож тодруулсан юм. Тэрээр гадас болгонд чуулган хийлгэж байхад Арванхоёрыг чиглүүлдэг байв. Үүний үр дүнд Юта даяар долоон шинэ гадас, 140 шинэ салбар бий болов. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлүүд, дээд зөвлөлүүд, бишопын зөвлөлүүд болон чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлийн үүргүүдийг тодорхой тогтоож, хэдэн зуун эрэгтэйчүүд эдгээр албан тушаалуудыг хашихаар дуудагдав. Амьдралаа дэг журамд захируулж, аравны нэг, мацгийн өргөлүүд болон бусад хандивуудыг төлж байхыг тэрээр Сүмийн гишүүдэд зөвлөдөг байв.

1867 онд бошиглогч Жорж К.Канноныг Ням Гарагийн Сургуулийн ерөнхий хянагчаар томилов, ингээд хэдхэн жилийн дотор Ням Гарагийн Сургууль Сүмийн зохион байгуулалтын байнгын хэсэг болжээ. 1869 онд Ерөнхийлөгч Янг өөрийн охидод даруу амьдралын тухай зааврыг албан ёсоор өгчээ. Тэрээр энэ зөвлөгөөг бүх залуу эмэгтэйчүүдэд өгч 1870 онд Хэмнэлтийн Нийгэмлэгийг (*хэмнэлт* гэдэг нь хэтэрсэн зардлыг багасгах гэсэн утгатай) үүсгэн байгуулжээ. Энэ бол Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагын эхлэл байв. 1877 оны Долдугаар сард тэрээр гадасны анхны Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулахаар Ютагийн Огденд очив.

Ерөнхийлөгч Бригам Янгийн Нас Баралт Ба Өв

Ерөнхийлөгч Бригам Янг практикч бөгөөд эрч хүчтэй удирдагч байв. Тэрээр Гэгээнтнүүдийг зааварлаж, урамшуулан дэмжихийн тулд Сүмийн суурингуудаар явдаг байлаа. Тэрээр чиглүүлэл болон үлгэр жишээгээр Сүм дэх дуудлагуудаа биелүүлэхийг гишүүдэд заадаг байлаа.


Ерөнхийлөгч Янг Нью-Йоркийн нэг сонины эрхлэгчид хариулан өөрийнхөө амьдралд үнэлэлт дүгнэлт өгч, дараах зүйлийг бичжээ:

“Өнгөрсөн 26 жил дэх миний хөдөлмөрийн үр дүнг товчоор дүгнэвэл: Хожмын Үеийн Гэгээнтэн 100 000 орчим хүнийг энэ Нутаг Дэвсгэрт суурьшуулж, манай хүмүүсийн оршин суусан 200 гаруй хот, хотхон болон тосгон, . . . манай хамт олнуудыг сайжруулах болон тэдний ашиг тусын тулд зориулагдсан сургуулиуд, үйлдвэрүүд, тээрмүүд болон бусад байгууллагуудыг үндэслэн бий болголоо. . . .

“Миний бүх амьдрал Бүхнийг Чадагчид үйлчлэхэд зориулагдлаа” гэжээ.¹³

1876 оны Есдүгээр сард Ерөнхийлөгч Янг: “Есүс бол Христ, дэлхийн Аврагч хийгээд Гэтэлгэгч гэдгийг би гэрчилж байна; би түүний айлдваруудыг дуулгавартай дагасан, түүний амлалтыг хэрэгжүүлсэн, мөн надад байдаг түүний тухай мэдлэгийг энэ дэлхийн мэргэн ухаан өгч чадахгүй, бас үүнийг булаан авч чадахгүй”¹⁴ хэмээн Аврагчийн тухай хүчирхэг гэрчлэл хэлжээ.

1877 оны Наймдугаар сард Ерөнхийлөгч Янг хүндээр өвчилж, эмч нар хичнээн асарч сувилсан ч, долоо хоногийн дотор нас баржээ. Тэр 76 настай байсан бөгөөд сүмийг 33 жил удирдсан байлаа. Тэр бол өнөө үеийн Израилыг амлагдсан нутаг уруу удирдсан эрч хүчтэй бошиглогч байсныг өнөөдөр бид дурсан санадаг. Түүний номлолууд, шашин бол өдөр тутмын туршлагын хэсэг гэдгийг тодотгон, өдөр тутмын амьдралын бүх талыг хамардаг байлаа. Хилийн шугамын тухай түүний ойлголт болон нарийн мэдрэмж бүхий түүний удирдлага зэлүүд нутагт тэд хаант улсыг бий болгосон тэнгэрийн адислалуудаар боломжгүй мэт санагдаж байсан хүнд хүчир ажлуудыг хэрэгжүүлэхэд түүний хүмүүст бурханлигаар нөлөөлсөн юм.



Солт Лейкийн Ариун Сүмийн сүүлчийн чулуу тавих ёслолыг гэрчлэхээр олон мянган Гэгээнтэн 1892 оны Дөрөвдүгээр сарын 6-нд цуглаад байгаа нь.

Зовлон Зүдгүүр ба Сорилтын Үе

Ерөнхийлөгч Жон Тейлор

Ерөнхийлөгч Бригам Янг нас барсны дараа Жон Тейлорын удирдсан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг гурван жил тэргүүлсэн юм. 1880 оны Аравдугаар сарын 10-нд Жон Тейлор Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Ерөнхийлөгч Тейлор бол Цагаатгалаар нэг ном бичиж нийтлүүлсэн, Сүмийн хамгийн чухал зарим тогтмол хэвлэлүүд, түүний дотор *Times and Seasons*, *Mormon*-ыг хянан тохиолдуулдаг байсан, авьяаслаг зохиолч, сэтгүүлч байжээ. Тэрээр олон тохиолдолд, тухайлбал, Картхейжийн Шпоронд ах нартайгаа сайн дураар очиж нийлэн, тэнд дөрвөн удаа буудуулсан үйл явдал өөрийн эрэлхэг зориг, сэргээгдсэн сайн мэдээнд бүхнээ гүн гүнзгий зориулсан чанараа харуулсан юм. “Нэг бол Бурханы хаант улс, нэг бол юу ч үгүй” гэсэн түүний хувийн уриа Бурхан хийгээд Сүмд түүний үнэнч байсныг илтгэн харуулдаг.

Номлогчийн Ажил

Сайн мэдээ дэлхийн бүх өнцөг буланд тунхаглагдахыг тэрээр харахын тулд Ерөнхийлөгч Тейлор чадах бүхнээ хийхэд шийдвэр төгс байсан юм. 1879 оны Аравдугаар сарын ерөнхий чуулган дээр тэрээр Мозес Татчерийг Мексикийн Мексико Хотод номлол эхлүүлэхээр Сүмийн хамгийн сүүлчийн Төлөөлөгчөөр дуудав. Ахлагч Татчер болон өөр хоёр номлогч 1879 оны Арваннэгдүгээр сарын 13-нд Мексик дахь анхны салбарыг уг салбарын ерөнхийлөгч Доктор Плотино К.Родаканатийн хамт зохион байгуулжээ. Доктор Родаканати

Испани хэл дээр Мормоны Номын тухай өгүүллийг уншсаны дараа Сүмийн тухай нэмэлт мэдээлэл хүсч Ерөнхийлөгч Тейлорт бичсэний дараа хөрвүүлэгдсэн ажээ.

Арванхоёр гишүүн, гурван номлогч бүхий гол цөмтэйгөөр сэргээгдсэн сайн мэдээ Мексик хүмүүсийн дунд алгуураар тархаж эхлэв. 1881 оны Дөрөвдүгээр сарын 6-нд Ахлагч Татчер, Фераморз Янг, Пайс Ах нар Попакатепетл Уулан дээр 15 500 фут өндөрт явган гарч, онцгойлон адислах товчхон үйлчлэл хийжээ. Ахлагч Татчер Их Эзэний өмнө өвдөг сөгдөн тэд өөрсдийн жинхэнэ хоньчин, Их Эзэний дуу хоолойг сонсож болохын тулд Мексикийн газар нутаг болон хүмүүсийг нь онцгойлон адисалжээ.

Ахлагч Татчер Солт Лейк Хотод эргэж ирээд, Мексикт үйлчлэх нэмэлт номлогч нарыг дуудахыг зөвлөмж болгожээ. Удалгүй нилээд хэдэн залуу хүмүүс, түүний дотор Тэргүүн Зөвлөлийн ирээдүйн гишүүн Антони В.Айвинс Мексико хотод хөдөлмөрлөж байлаа. Мексикийн Номлол дахь Сүмийн хүч чармайлтын нэг хэсэг болж, 1886 онд Мормоны Ном испани хэл дээр хэвлэгдэн гарав. Мормоны Ном болон Сүмийн бусад ном зохиолыг испани хэлэнд орчуулахад тусалсан Милтон Трежоёгийн өгүүлэл Их Эзэн өөрийн ажлыг хэрхэн чиглүүлдгийг харуулсан байлаа.

Милтон Трежоё Испанид төрж, аливаа шашнаас гадуур өссөн ажээ. Тэрээр Хадат Уулс дахь Мормончуудын тухай тэмдэглэлийг сонсох үед Филиппенд цэргийн алба хааж байсан бөгөөд тэдэн дээр очих хүчтэй хүсэл түүнд төрсөн ажээ. Хожим нь тэрээр хүндээр өвчилж, тэр Ютад очих ёстой гэж зүүдэнд нь түүнд хэлжээ. Тэр эдгэрээд, Солт Лейк Хот руу явав. Тэрээр Бригам Янгтай уулзаж, сайн мэдээний сонирхогч болов. Тэрээр үнэнийг олсондоо итгэл үнэмшилтэй байсан бөгөөд улмаар Сүмийн гишүүн болов. Тэрээр Мексикт номлолд үйлчилсэн бөгөөд испани хэлээр яригч хүмүүс төрөлх хэлээрээ Мормоны Номыг уншиж чадахыг харахад гол үүрэг гүйцэтгэхэд сүнслэг байдлын хувьд мөн оюун санааны хувьд тэр үед бэлтгэгдсэн ажээ.

Ерөнхийлөгч Тейлор бас Америкийн Өрнөдөд амьдарч байсан Индианчуудад сайн мэдээг хүргэх номлогч нарыг дууджээ. Амос Врайтсын хөдөлмөр Вайомингийн Винд Голын Резервэшинд оршин сууж байсан Шошон овгийн дунд онцгой үр ашигтай байлаа. Ердөө цөөхөн сар үйлчилсний дараа Вrait 300 гаруй хүн, түүний дотор овгийн Ахлагч Вашакид баптисм хүртээжээ. Хожмын Үеийн Гэгээнтэн номлогч нар бас Аризона, Нью-Мексикт амьдарч байсан Навахос, Пуеблос болон Зунис овгийнхонд сайн мэдээг хүргэв. Вилфорд Вудрафф Индианчуудын дунд, түүний дотор Хопис, Апачес Зунисчуудын дунд номлон бүтэн жилийг өнгөрүүлжээ. Аммон М.Тенни Зунийн 100 гаруй Индианчуудад баптисм хүртэхэд нь тусалжээ.

Номлогч нар бас Англи, Европт сайн мэдээг заахаа үргэлжлүүлж байв. Ютагийн Лихайд амьдарч асан, Германд төрсөн Томас Байзингер Европын номлолд үйлчлэх дуудлагыг 1883 онд хүлээн авав. Пол Хаммер тэр хоёр тэр үед Австри-Унгарын эзэнт гүрний нэг хэсэг байсан Чехословакийн Праг руу илгээгдсэн байна. Шашин номлохыг номлогч нарт хориглосон учраас тэд уулзсан хүмүүстэйгээ энгийн яриа хөөрөө өрнүүлдэг байв. Эдгээр ярианууд шашны сэдэв рүү орох нь олонтаа байдаг байлаа. Ийм байдлаар ганцхан сар ажилласны дараа Ахлагч Байзингер баривчлагдаж, хоёр сар шоронд хоригдов. Тэрээр суллагдаад, Антонин Иостад баптисм хүртээн адислагдсан боловч түүний буруутгал түүнийг баривчлагдахад хүргэжээ. Иост Ах Чехословакт амьдарч байсан анхны Хожмын Үеийн Гэгээнтэн болсон юм.¹

Сайн мэдээ бас Полинезид номлогдож байв. Хавайн хоёр хүн Ахлагч Кимо Пелио, Самуела Маноа хоёр 1862 онд Самоа уруу илгээгдэв. Тэд 50 орчим хүнд баптисм хүртээж, Ахлагч Маноа өөрийн хөрвөгчдийн хамт дараагийн 25 жилийн турш Самоад амьдарсан ажээ. 1887 онд Ютагийн Солт Лейк Хотын Жозеф Х.Дийн Самоад үйлчлэх дуудлага хүлээн авав. Ахлагч Маноа болон түүний итгэлт гэргий нар Самоад хорин жил гаруй болоод уулзаж байгаа, гаднаас ирсэн анхны Хожмын

Үеийн Гэгээнтэн Ахлагч Дийн болон түүний гэргий Флоренс нарт гэрийнхээ хаалгыг нээн өгчээ. Ахлагч Дийн удалгүй 14 хүнд Сүмд баптисм хүртээж, сар орчмын дараа Самоа хэл дээр анхныхаа номлолыг хийжээ.² Тийнхүү уг арал дээр номлогчийн ажил шинээр эхэлжээ.

1866 оноос эхлэн уяман яр өвчин тархахаас сэрэмжлэн Хавайн эрх баригчид уг өвчнөөр зовж шаналсан хүмүүсийг Молокай арал дээрх Калаупапа Хойг уруу гаргажээ. Хожмын Үеийн Гэгээнтнүүд асан Жонатан Напела, Китти Напела нар 1873 онд тэнд хөл хоригдов. Зөвхөн Китти өвчин туссан, харин Солт Лейкийн Хишгийн Ордонд түүнтэй лацдан холбуулсан Жонатан түүнийг ганцааранг нь орхихыг хүсээгүй ажээ. Жонатан хожим нь өвчний халдвар авч, есөн жилийн дараа нэг сайн найз нь түүн дээр хүрч ирэхэд, танигдахааргүй болсон байжээ. 1900 он гэхэд 200 гаруйгаар тоологдож байсан тус хойг дээрх Гэгээнтнүүдийг тэрээр хэсэг хугацаанд тэргүүлж байлаа. Энэхүү тамирдуулагч өвчнөөр зовон шаналж байсан атлаа салбартаа байнга ирж, өөрсдийн сүнслэг хэрэгцээг анхаарч байсан итгэлтэй гишүүдийг Сүмийн удирдагчид мартдаггүй байв.³

Ойн Баярын Чуулган

1880 оны Дөрөвдүгээр сарын 6-нд Сүмийн гишүүд Сүм зохион байгуулагдсаны тавин жилийн ойг тэмдэглэв. Эртний Израилчууд тавь дахь жил бүрийг ингэж нэрлэдэг байсны адилаар тэд энэ жилийг Ойн Жил гэж нэрлэжээ. Ерөнхийлөгч Тейлор Сүмийн гачигдалтай гишүүдээс Сүмд тавьсан олон өрийг уучлав. Сүм бас 300 үхэр, 2000 хонийг өөрийн “зохи тусламж авууштай ядууст”⁴ хуваарилан хандивлав. Сүмийн Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар гачигдалтай хүмүүст бараг 35 000 бушель улаан буудай хандивлажээ. Ерөнхийлөгч Тейлор хувийн өрийг, ялангуяа зовж зүдрэгсдийн өрийг уучлахыг Сүмийн гишүүдээс хичээнгүйлэн хүсчээ. “Энэ бол Ойн баярын үе шүү дээ!” гэж тэрээр мэдэгджээ.⁵ Уучлалын

болон баяр хөөрийн сүнс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дунд хүчтэйгээр мэдрэгдэж байлаа.

1880 оны Дөрөвдүгээр сарын Ойн Жилийн ерөнхий чуулганы сүүлчийн өдөр нэн сэтгэл догдлом байлаа. Арванхоёр Төлөөлөгчийн арваннэг нь төгсгөлийн хуралдаан дээр гэрчлэлээ хуваалцав. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны гишүүдийн нэг Оорсон Пратт Сүм бүхлээрээ Нью-Йоркийн Фейетте дахь Ахмад Петр Витмерийн гэрт цугладаг байсан үеийн тухай ярьжээ. Хүнд сорилтууд, цугларалтууд, мөрдлөг хавчлага болон Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн зовлон зүдгүүрүүдийг тэрээр эргэн санаж, тэр эдүгээг хүртэл “энэ хүмүүстэй хамт тоологдож” байгаадаа баяртай байдаг гэв. Дараа нь тэр “өнгөрсөн тавин жилд Их Эзэн бидний Бурханы хийсэн агуу ажлын талаар”⁶ гэрчлэлээ хэлэв. Ахлагч Пратт амьд явах нь ердөө хэдхэн сар үлдсэн байжээ, мөн тэрээр итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэн болж эцсээ хүртэл тэвчсэндээ баяртай байлаа.

Ойн баярын жилийг тэмдэглэхээс хоёр жилийн өмнө Ерөнхийлөгч Жон Тейлор шашны зааврыг хүүхдүүдэд хүргэх байгууллага үндэслэн бий болгохыг зөвшөөрчээ. Анхны Хүүхдийн Хэсэг Солт Лейк Хотоос хойш 15 миль орчимд орших Ютагийн Фармингтон ажиллаж эхэлсэн бөгөөд 1880-аад оны дунд үе гэхэд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн бараг бүх суурин газруудад Хүүхдийн Хэсэг зохион байгуулагдсан байлаа. Хүүхдийн Хэсэг сайн мэдээний заавар, хөгжим болон долоо хоног бүр тэдний таалдаг уулзалтуудаар адислагдсан, дэлхий даяарх сая сая хүүхдүүдийг эгнээндээ багтаан өргөжин хөгжөөд байна.

Мөрдлөг Хавчлага Үргэлжлэв

Бошиглогч Иосеф Смит 1830-аад оны эхэн үеэр Библийн орчуулга дээр ажиллаж байх үедээ Абрахам, Иаков, Давид болон Хуучин Гэрээний бусад удирдагчид нэгээс илүү эхнэртэй байсан тэр баримтын учрыг олсонгүй. Бошиглогч ойлголтын төлөө залбирч, тэгээд тодорхой цаг үед, өвөрмөц

зорилгын учир, бурханлигаар өгөгдсөн хуулиудыг баримтлан, олон эхнэр авах ёс Бурханаар зөвшөөрөгдөн, чиглүүлэгдэж байсныг мэджээ. Бурханлиг зөвшөөрлөөр зарим Хожмын Үеийн Гэгээнтнүүд нэгээс илүү эхнэртэй гэрлэх нь санваарын эрх мэдлээр удахгүй сонгогдож болохыг Иосеф Смит бас мэджээ. Нилээд олон Хожмын Үеийн Гэгээнтэн Навууд олон эхнэр авах ёсыг хэрэглэсэн боловч, энэ сургаал болон дадал зуршлын тухай Солт Лейк Хотод болсон 1852 оны Наймдугаар сарын ерөнхий чуулганыг хүртэл нийтэд зарлан мэдэгдээгүй байжээ. Тэр чуулган дээр Ахлагч Оорсон Пратт Ерөнхийлөгч Бригам Янгийн чиглүүлээр, эрэгтэй хүн нэгээс илүү эхнэр авах дадал зуршил нь Их Эзэн бүх зүйлийг дахин бий болгосны нэг хэсэг мөн (Үйлс 3:19–21-ийг үз) хэмээн мэдэгджээ.

Ёс суртахуунгүй бөгөөд христийн бус хэмээн өөрсдийнх нь үздэг гэрлэлтийн тогтолцоог Ютад амьдарч байсан Хожмын Үеийн Гэгээнтнүүд хөхүүлэн дэмжиж байгааг Америкийн шашны болон улс төрийн удирдагчид мэдээд тэд ихэд уурлажээ. Сүмийн болон түүний гишүүдийн эсрэг улс төрийн ширүүн дайн дэгдлээ. Нэгдсэн Улсын Конгресс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн эрх чөлөөг хязгаарласан, Сүмийг эдийн засгийн хувьд хохироосон хууль тогтоомж гаргав. Энэхүү хууль тогтоомж эцэстээ сүмийн удирдагчдыг баривчилж, нэгээс илүү эхнэртэй эрчүүдийг шоронд хорьж, сонгуульд санал өгөх, гэр орондоо амар амгалан байх болон иргэний бусад эрх чөлөөг эдлэх эрхийг нь хасахад хүргэсэн ажээ. Хожмын Үеийн итгэлтэй Гэгээнтэн хэдэн зуун эрчүүд мөн хэдэн эмэгтэйчүүд Юта, Айдахо, Аризона, Небраска, Мичиган болон Өмнөд Дакота хэсэг хугацаагаар шоронд суув.

Сайн мэдээг номлох дуудлага хүлээн авсан олон хүмүүсийн хувьд, ялангуяа Нэгдсэн Улсын өмнөд хэсэгт мөрдлөг хавчлага бас ширүүсэв. Жишээ нь, Ахлагч Жозеф Стандинг Жоржийн Ромын ойролцоод хөдөлмөрлөж байгаад 1878 оны Долдугаар сард харгис хэрцгийгээр алагдав. Түүний хамтрагч ирээдүйн Төлөөлөгч Раджер Клоосон, үхлээс чадан ядан мултарчээ. Солт

Лейк Хот дахь Гэгээнтнүүд Ахлагч Стандинг алуулсан тухай мэдээнд ихэд цочирдон, Солт Лейкийн Табернеклд болсон түүний оршуулах ёслолд мянга мянган хүмүүс оролцжээ.

Ахлагч Жон Гиббс, Виллям Берри, Виллям Жөүнс, Хенри Томпсон нар сүмийн талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөхийг хичээн Теннесийн ихэнх нутгаар хөндлөн гулд аялжээ. Тэд Теннесий дахь Кейн Грийкийн ойролцоо Жеймс Кондорын гэрт 1884 оны Наймдугаар сард Хүндэтгэлийн нэг өдрийн өглөө амарч байлаа. Ахлагч Гиббс номлолдоо тохирох сэдвийг хайн судрууд үзэж байтал танхайрагч бүлэг ойгоос гарч ирэн буудаж эхэлжээ. Ахлагч Гиббс, Берри нар алагдав. Сургуулийн багш Ахлагч Гиббс, өөрийнх нь амь эрсдэлтэд эмгэнэн гашуудсан эхнэр, гурван хүүхдээ орхин одов. Гиббс Эгч 43 жил бэлэвсэн хэвээр үлдсэн бөгөөд хүүхдүүдээ өсгөн тэжээхээр эх баригч болсон ажээ. Тэрээр нөхөртэйгөө эргэн уулзахыг хүсэн хүлээж, сайн мэдээнд итгэлтэйгээр нас баржээ. Аллагын үед номлолын гүйцэтгэх ерөнхийлөгч байсан Бригам Хенри Робертс, Гиббс, Берри нарын цогцсыг ухан гаргаж авахаар зүсээ хувирган явснаар амь насаараа дэнчин тавьсан юм. Тэрээр цогцсуудыг Ютад авчрахад олон гадас тэр хоёр ахлагчид хүндэтгэл үзүүлсэн дурсгалын үйлчлэл явуулжээ.

Бусад бүсүүд дэх номлогч нар нуруунаасаа цус гартал жанчуулж, тэднээс олон нь ташуурын шарх сорвитойгоор булшиндаа орсон билээ. Сүмийн гишүүн байна гэдэг хэцүү цаг үе байсан юм.

Сүмийн олон удирдагчид нэгээс илүү эхнэртэй эрчүүдийг эрж хайж байсан холбооны ажилтнуудад баривчлагдахаас зайлсхийн нуугдаж байлаа. Эдгээр ажилтнууд шөнө гэр оронд нь халдан орж ирэхээс гэр бүлүүд айдаг байлаа. Ерөнхийлөгч Жорж К.Каннон, Лорензо Снөү, Раджер Клоосон, Бригам Хенри Робертс, Жорж Рейнолдс болон бусад олон хүмүүс шоронд орж, тэнд тэд ном бичин, сургуульд зааж, гэр орныхондоо захидал бичин цагийг өнгөрүүлдэг байв. Ерөнхийлөгч Жон Тейлор Солт Лейк хотоос хойш 20 миль орчимд Ютагийн

Кейсвиллд цөллөгт албадан явуулсан бөгөөд тэрээр тэнд 1887 оны Долдугаар сарын 25-нд нас баржээ. Тэр бол өөрийнхөө амьдралыг Есүс Христийн тухай гэрчлэх болон дэлхий дээр Бурханы хаант улсыг үндэслэн байгуулахад зориулсан итгэлтэй, эрэлхэг зоригтой хүн байсан юм.

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф

Вилфорд Вудрафф бол Сүмийн хамгийн амжилттай номлогч нарын нэг байсан бөгөөд бас бошиглолын зөн билгээрээ болон сүмд үнэнч байдлаараа нэрд гарсан нэгэн байлаа. Тэрээр сүмийн эхэн үеийн түүхийн талаар маш их мэдээлэл агуулсан нямбай тэмдэглэл хөтөлдөг байжээ. Жон Тейлорыг нас барахад тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгыг Ерөнхийлөгчөөр үйлчилж байсан бөгөөд бараг хоёр жилийн дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагджээ.

Түүний удирдлагын жилүүдэд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн эсрэг улс төрийн дайн улам эрчимжсэн боловч Сүм урагш ахсан юм. Ютагийн гурван хотхон— Сейнт Жорж, Логан, Мантайд ариун сүмүүд ажиллаж байснаас гадна Солт Лейкийн Ариун Сүм дуусах дөхөж байв. Их Эзэний эдгээр өргөөнүүд хувийнхаа хишгийг хүртэх болон нас барсан төрөл төрөгсдийнхөө өмнөөс ёслол үйлдэх боломжийг мянга мянган Гэгээнтнүүдэд олгосон билээ. Ерөнхийлөгч Вудрафф ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажилд насан туршдаа сонирхолтой байсан. Олон үйл явдлуудаар тохиолдуулан ариун сүмд өвөг дээдсийнхээ төлөө ёслол гүйцэтгэхийг тэрээр Гэгээнтнүүдэд зөвлөдөг байв.

Нас барагсдын төлөө Гэгээнтнүүдийн үйлдэж байсан ажлын ач холбогдлыг дараах хэрэг явдал онцлон харуулдаг. 1884 оны Тавдугаар сард Логаны Хоёрдугаар Хэсгийн Бишоп Хенри Баллард ариун сүмийн зөвшөөрлийн бичгүүдэд гэртээ гарын үсэг зурж байжээ. Гэрийнхээ ойролцоох явган хүний зам дээр найз нартайгаа ярилцаж байсан, Хенригийн

есөн настай охин ахимаг насны хоёр хүн ойртон ирж байхыг харсан ажээ. Тэд түүнийг дуудаж, нэг сонин өгөөд, үүнийг аавдаа аваачиж өг гэжээ.

Охин өөрөөс нь хүссэнийг ёсчлон биелүүлэв. Өөрийнх нь болон аавынх нь танилуудын 60 гаруй нэр, түүнчлэн угийн бичгийн мэдээлэл агуулсан, Англид хэвлэгдсэн *Newbury Weekly News* сонинь Бишоп Баллард харав. 1884 оны Тавдугаар сарын 15-наар хаяглагдсан энэ сониньг хэвлэгдсэнээс нь хойш ердөө гуравхан хоногийн дараа түүнд өгсөн байв. Агаарын тээвэр гарахаас хамаагүй өмнө, Англиас өрнөд Америк хүртэл шуудан эхдэн долоо хоног болж ирдэг үед энэ нь гайхамшиг байлаа.

Маргааш нь Бишоп Баллард сониньг ариун сүм рүү авч очин, үүний ирсэн түүхийг ариун сүмийн ерөнхийлөгч Марринер В.Меррилл ярьжээ. “Нөгөө талд байгаа хэн нэгэн өөрсдийнх ажил хийгдээсэй гэж ихэд санаа тавьсан байна, тэгээд та үүнийг хийх болно гэдгийг тэд мэдэж байснаас энэ сониньг таны гарт оруулсан хэрэг”⁷ гэж Ерөнхийлөгч Меррилл өгүүлжээ. Энэ сонин Ютагийн Солт Лейк Хот дахь Сүмийн Түүхийн Номын Санд хадгалагдаж байдаг.

Сүмийн удирдагчид мөрдлөг хавчлагыг эс хайхран, Америкийн өрнөд дэх хүн суурьшаагүй нутгуудыг эзэмшихийг урамшуулан дэмжсээр байлаа. 1885 оноос эхлэн Хожмын Үеийн Гэгээнтэн олон гэр бүл Жуарез Эзэмшил, Диаз Эзэмшил зэрэг хотхонуудыг үндэслэн, Мексикийн Сонора, Чихуахуад суурьшжээ. Умард Мексик дэх бусад нутгууд бас цагаачлагч Сүмийн гишүүдийг хүлээн авчээ.

Сүмийн гишүүд бас умард зүгт Канадад эзэмших газар эрж байлаа. Кач Валли Гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж асан Чарльз О.Кард 1886 онд өмнөд Албертад Хожмын Үеийн Гэгээнтэн хамт олныг үндэслэн бий болгов. 1888 оны өвөл гэхэд өрнөд Канадад 100 гаруй амьдарч байсан бол илүү олон хүмүүс 1890-ээд оны үед ирж, услах систем болон төмөр зам барихад ажиллах хүчээр хангажээ. Сүмийн олон удирдагч Албертад өсөн төлөвшсөн юм.

Тунхаг

1880-аад оны шувтрагаар Нэгдсэн Улсын засгийн газар олон эхнэр авсан хүмүүсийн сонгуульд санал өгөх эрх, шүүхэд ажиллах эрхийг нь хассан нэмэлт хуулиуд батлан гаргаж, Сүмийн эзэмшиж болох өмч хөрөнгийн тоо хэмжээг хатуу хязгаарлав. Бүр илүү олон эцгүүд нуугдсанаас Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлүүд хохирчээ. Ерөнхийлөгч Вудрафф Их Эзэнээс удирдамж хүсэв. 1890 оны Есдүгээр сарын 23-ны орой бошиглогч бурханлиг нөлөөллийн дор ажиллан, Сүмийн гишүүдийн хувьд олон эхнэр авах ёсыг төгсгөл болгосон баримт бичиг Тунхагийг бичжээ. Хэрэв олон эхнэр авах ёсыг төгсгөл болгохгүй бол Нэгдсэн Улсын Засгийн газар ариун сүмүүдийг хураан авч, ингэснээр амьд байгаа хүмүүс болон нас барагсдын төлөөх ажил төгсгөл болно гэдгийг Их Эзэн Ерөнхийлөгч Вудраффт үзэгдлээр харуулжээ.

1890 оны Есдүгээр сарын 24-нд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга Тунхагийг дэмжин батлав. Гэгээнтнүүд үүнийг 1890 оны Аравдугаар сарын ерөнхий чуулган дээр зөвшөөрөн батлав. Өнөөдөр энэ баримт бичиг Сургаал ба Гэрээнд Албан Тунхаг 1 болж орсон байдаг.

Сүмийн энэхүү үйлдлийн дараа холбооны удирдах ажилтнууд олон эхнэр авах ёсны эсрэг хуулиудыг зөрчсөн гэм буруутайд яллагдаж байсан Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс хүлцэл өчиж, их мөрдлөг хавчлага зогссон байна. Гэвч Ерөнхийлөгч Вудрафф: “Бүх ариун сүмүүд бидний гараас алдагдахад би хүргэх байлаа; би өөрийгөө шоронд суулгахаас аргагүйд хүрэх байсан, мөн өөр бусад олон хүнийг тийшээгээ очиход хүргэх байсан, миний хийснийг хий хэмээн тэнгэрийн Бурхан надад зарлиглаагүй юм; мөн цаг нь ирэхэд үүнийг хийхээр би зарлиг болгогдсон бөлгөө, энэ бүгд надад тодорхой байв. Би Их Эзэний өмнө очиж, мөн Их Эзэн бич хэмээн надад хэлснийг бибээр бичив” хэмээн тайлбарлажээ (“Албан Тунхаг—1-ийн дараа Тунхагийн талаар Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын хэлсэн Гурван

Үгнээс Авсан Хэсэг). Нэгдсэн Улсын засгийн газар биш, харин Бурхан олон эхнэр авах ёсыг албан ёсоор зогсоосон юм.

Удмын Бичгийн Нийгэмлэг

Хожмын Үеийн Гэгээнтнүүд удмын бичгийн нийгэмлэгийг үндэслэн байгуулахаас урт хугацааны өмнө Сүмийн гишүүд өөрсдийн нас барсан өвөг дээдсийн амьдралыг баримтжуулсан цэдгүүдийг цуглуулж байжээ. Тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийн тулд мянга мянган өвөг дээдсийнхээ нэрийг олж авсан хүмүүсийн дунд Вилфорд Вудрафф, Оорсон Пратт, Хибер Ж. Грант нар байдаг. 1894 онд Тэргүүн Зөвлөл Ахлагч Франклин Д. Ричардсыг үүний анхны удирдагч болгон угийн бичгийн нийгэмлэг зохион байгуулагдахыг чиглүүлсэн ажээ. Номын сан байгуулагдаж, тэдний төлөө ариун сүмийн ёслолууд гүйцэтгэгдэж болох хүмүүсийн нэрсийг хайж, нийгэмлэгийн төлөөлөгчид дэлхий даяар явжээ. Энэ нийгэмлэг Сүмийн Гэр Бүлийн Түүхийн Газрыг бий болгоход хүргэсэн билээ.

1894 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы үеэр Ерөнхийлөгч Вудрафф угийн бичгийн ажлын талаар илчлэлт хүлээн авснаа зарлав. “Өөрсдийн чадах хэмжээгээрээ угийн бичгийг аль болох холоос хөтөлж, эцэг эхчүүдтэйгээ лацдан холбуул. Хүүхдүүдийг эцэг эхчүүдтэй нь лацдан холбуулж, энэ гинжин хэлхээг чадах чинээгээрээ цааш үргэлжлүүлэхийг Бурхан Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс хүссэнийг тэрээр мэдэгджээ. . . . Энэ бол түүний хүмүүсийн талаарх Их Эзэний хүсэл мөн,” гэж тэр хэлээд, “тэгээд та нар үүнийг тусган ойлгох үед энэ нь зөв болохыг та нар мэдэх болно гэж би боддог”⁸ гэв. Хожмын Үеийн Гэгээнтнүүд өдөөг хүртэл нас барсан өвөг дээдсийнхээ цэдгүүдийг эрж хайн, тэдний нэрийн өмнөөс ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэсээр байна.

1885–1900 оныг хүртэл Сүмийн олон гишүүн удмын бичгийн номлолд үйлчилжээ. Тэд номлолынхоо төлөө Ерөнхий Эрх Мэдэлтнээс адислал авахаар Солт Лейк Хотод уригддаг байв. Тэдэнд бас номлогчийн үнэмлэх, томилолтын

захидал өгдөг байв. Тэд төрөл садангуудтайгаа уулзаж, булшны чулуунаас нэрс цуглуулж, сүм хийдийн цэдгүүд болон гэр бүлийн Библийг судалж, ариун сүмийн ажлыг гүйцэтгэх үнэ цэнэтэй мэдээлэлтэй гэртээ эргэж ирдэг байлаа. Их Эзэн тэдэнтэй хамт байж, шаардлагатай эх сурвалж буюу садан төрлөө олоход нь тэднийг олонтаа чиглүүлж байсныг баттай нотолсон сүнслэг туршлагуудын талаар олон номлогч илтгэдэг байжээ.⁹

Солт Лейкийн Ариун Сүмийг Онцгойлон Адисласан нь

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф амьдралынхаа үлэмж хэсгийг ариун сүмийн ажилд зориулсан юм. Тэрээр Сейнт Жоржийн Ариун Сүмийн анхны ерөнхийлөгч байсан бөгөөд Мантайн Ариун Сүмийг онцгойлон адисалжээ. Солт Лейкийн Ариун Сүмийн суурийн чулууг тавьснаас хойш 40 жилийн дараа Ерөнхийлөгч Вудрафф энэхүү хосгүй өвөрмөц ариун сүмийг онцгойлон адислахыг туйлын ихээр тэсч ядан хүлээж байлаа. Онцгойлон адислах үйлчлэлүүд 1893 оны Дөрөвдүгээр сарын 6-наас Тавдугаар сарын 18-ныг хүртэл явагдаж, ойролцоогоор 75 000 хүн оролцжээ.¹⁰

Дөрөвдүгээр сарын 6-нд болсон онцгойлон адислах эхний үйлчлэлийн дараа Ерөнхийлөгч Вудрафф өдрийн тэмдэглэлдээ: “Бурханы сүнс болон хүч бидэн дээр оршиж байлаа. Бошиглолын болон илчлэлтийн сүнс бидэнд дээр оршиж байсан бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэл уяран хайлж, олон зүйл бидэнд нээгдсэн билээ”¹¹ гэж бичжээ. Зарим Хожмын Үеийн Гэгээнтнүүд тэнгэр элчүүдийг харсан бол бусад нь өнгөрсөн үеийн Сүмийн Ерөнхийлөгчид болон нас барсан Сүмийн бусад удирдагчдыг харсан байлаа.¹²

Ерөнхийлөгч Вудраффыг ерэн насныхаа ойг тэмдэглэх үеэр Ням Гарагийн Сургуулийн мянга мянган хүүхдүүд түүнд хүндэтгэл үзүүлэхээр Ариун Сүмийн Талбай дахь Табернеклыг дүүргэсэн байлаа. Түүний сэтгэл ихэд догдолж, ихэд сэтгэл хөдлөн ярьж, тэрээр арван настай байхдаа Протестант Ням Гарагийн Сургуульд явж, төлөөлөгчид хийгээд бошиглогчдын

тухай уншдаг байснаа өсвөр насны сонсогчдод ярьжээ. Тэрээр гэртээ эргэж ирээд төлөөлөгчид болон бошиглогчдыг дэлхий дээр дахин харахаар хангалттай урт наслахын төлөө залбирав. Эдүгээ тэр төлөөлөгчид болон бошиглогчид аль аль нь байсан хүмүүсийн дунд зогсож байлаа; түүний залбирал олон удаа хариулагджээ.¹³

Жилийн дараа 1898 оны Есдүгээр сарын 2-нд Ерөнхийлөгч Вудрафф Сан Францискод айлчилж яваад нас баржээ.

Ерөнхийлөгч Лорензо Снөү ба Аравны Нэг

Ерөнхийлөгч Вудраффыг нас барсны дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Лорензо Снөү Сүмийн Ерөнхийлөгч болов. Тэр бол үүрэгт ажилдаа сайн бэлтгэгдсэн ухаалаг бөгөөд хайраар дүүрэн удирдагч байлаа. Тэрээр тэр үеийг хүртэл байсан хожмын үеийн бошиглогч бүрээр танигдсан, бас сургагдсан байлаа. 1900 оны Арваннэгдүгээр сард тэрээр Бошиглогч Иосеф Смит болон түүний гэр бүлтэй олонтаа уулздаг байснаа, түүний ширээнд хамт хооллодог байснаа, мөн түүнтэй хувьчлан ярилцдаг байсан тухайгаа Табернеклд цугласан Гэгээнтнүүдэд ярьжээ. Их Эзэн түүнд энэ үнэнийг “хамгийн тод бөгөөд бүрэн дүүрнээр”¹⁴ үзүүлсэн учраас Иосеф Смит бол Бурханы бошиглогч байсныг тэр мэддэг байв.

Ерөнхийлөгч Снөүгийн удирдлагын үед, олон эхнэр авах ёсны эсрэг холбооны засгийн газрын хууль тогтоомжоос үүдэлтэй санхүүгийн ноцтой хүндрэл бэрхшээлтэй Сүм тулгарав. Ерөнхийлөгч Снөү тунгаан бодож, Сүмийг доройтуулагч өрнөөс хэрхэн чөлөөлөгдөх тухайд удирдамж хүсч залбирчээ. 1899 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы дараа тэрээр Ютагийн Сейнт Жоржид очихоор бурханлигаар нөлөөлөгдсөнөө мэдрэв. Тэнд үг хэлж байхдаа тэрээр хэсэг хугацаанд ярихаа зогсож, тэгээд цааш үргэлжлүүлэхдээ, илчлэлт хүлээж авснаа мэдэгджээ. Сүмийн хүмүүс аравны нэгийн хуулийг үл тоомсорлож, ингээд хэрэв Сүмийн гишүүд аравны нэгээ бүрнээр нь илүү их итгэлтэйгээр төлөх

юм бол адислалууд тэдэнд дээр юүлэгдэх болно гэдгийг Их Эзэн түүнд хэлжээ.

Бошиглогч аравны нэгийн ач холбогдлыг Юта даяар цугларагсдад номлов. Гэгээнтнүүд түүний зөвлөгөөг дуулгавартай дагаж, тэгээд тэр жил тэд өмнөх жилийнхээс хоёр дахин илүү аравны нэг төлсөн ажээ. 1907 он гэхэд Сүм бүх зээлээ төлж, өргүй болоход хангалттай мөнгөн хөрөнгийг эзэмшиж байлаа.

1898 онд Залуу Эмэгтэйчүүдийн Мючелийн Сайжралтын Нийгэмлэгийн ерөнхий зөвлөлд зориулсан хүлээн авалт дээр Ерөнхийлөгч Жорж К.Каннон, “манай ухаалаг, хэрсүү зарим эмэгтэйчүүдийг номлолын талбарт”¹⁵ дуудах шийдвэрийг Тэргүүн Зөвлөл гаргасныг мэдэгдэв. Энэ үеэс өмнө хэдхэн эгч л номлолд нөхрүүдээ дагалдан явсан байв, харин энэ бол эгч нарыг Их Эзэн Есүс Христийн номлогч элчин сайд нар болгон Сүм анх удаа албан ёсоор дуудаж, онцгойлон адисалсан үе байлаа. Эгч нар номлолд үйлчлэх үүрэггүй байсан бол, өнгөрсөн хэдэн арван жилд мянга мянган эгч нар энэхүү онцгой боломжийг ашиглан, бүрэн цагийн номлогч нараар Их Эзэнд зоримгоор үйлчилсэн билээ.

Ерөнхийлөгч Лорензо Снөү Сүмийг хорьдугаар зуун уруу удирдан золгуулсан юм. Шинэ зууны үүр гэгээрэх үеэр Сүм 43 гадас, 20 номлол, 967 хэсэг, салбартай болсон байлаа. 283 765 гишүүнээс олонхи нь Нэгдсэн Улсын Хадат Уулсын бүсэд амьдарч байлаа. Дөрвөн ариун сүм үйл ажиллагаа явуулж, *Juvenile Instructor, Improvement Era, Young Women's Journal* сэтгүүлүүд Сүм болон түүний гишүүдийн тухай өгүүллүүд нийтэлж байв. Хамгийн багаар нэг номлол шинээр нээгдэнэ гэж цуурхаж дараагийн зуун жилд юу болохыг Хожмын Үеийн Гэгээнтнүүд төсөөлөхөд амаргүй байсан биз ээ. Гэвч Сүмийн хувь заяаны талаарх бошиглолууд гүйцэлдэх болно гэдэгт тэд итгэлтэй байлаа.

Сүмийг Өргөжүүлсэн нь

1901–1970 онд дөрвөн бошиглогч—Жозеф Ф.Смит, Хибер Ж.Грант, Жорж Алберт Смит, Давид О.МакКей нар өргөжин тэлсэн Сүмийг тэргүүлж байлаа. Эдгээр Ерөнхийлөгчид морь болон тэргэн тээврээс сансар уруу пуужингаар хийх аялалд шилжсэн шилжилтийг гэрчилсэн юм. Дэлхийн хоёр удаагийн дайн, дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн уналт Гэгээнтнүүдэд хатуу сорилт болов. Энэ үед есөн ариун сүм баригджээ. 1901 онд 50 гадсанд ойролцоогоор 300 000 гишүүн байсан бол 1970 он гэхэд дэлхий даяар 500 гадсанд 2 800 000 гишүүн цуглаж байв.

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит

Жозеф Ф.Смит 1838 онд Миссури дахь мөрдлөг хавчлага дээд цэгтээ хүрч байсан үед Фар Вест дахь ариун сүмийн газрын ойролцоо нэг жижигхэн бүхээгт төржээ. Жозефыг төрөх үед түүний эцэг Хайрум Смит Миссурийн Ричмондод шоронд хоригдож байв, харин түүний эх Мэри Фийлдинг Смит хүүхдүүдээ асрахаар гэртээ ганцаараа үлдсэн байжээ.

Бяцхан Иосеф гэр бүлийнхээ хамт Миссуригээс Иллинойн Навууд шилжиж, тэнд амьдралынх нь үлдсэн хугацаанд санаанаас нь огт гардаггүй нэг үйл явдал—Картхейжийн Шпоронд аав, авга ах хоёр алагдсан үйл явдал тохиосон ажээ. Аав нь Картхейж уруу мориор явах замдаа хүүгээ өргөн авч, үнсээд түүнийг доош нь буулгасан тэр сүүлчийн удаа аавыгаа харснаа хэзээ ч мартдаггүй байлаа. Бас хөрш нь шөнөөр цонх тогшиж, Хайрум алагдсан тухай ээжид нь хэлэхийг сонссон тэрхүү аймшигт мөчийг тэр бас хэзээ ч мартдаггүй байлаа.

Аав, авга ах хоёрыгоо Навуу дахь Маншен Хауст авсан дотроо хэвтэж байхыг харсан нь түүний ой ухаанаас хэзээ ч арилж алга болоогүй ажээ.

Жозеф хөвгүүн бараг л нэгэн шөнийн дотор эр хүн болов. Мэри Фийлдинг Смит болон түүний гэр бүл Навуугаас дүрвэгчидтэй нийлэхэд 7 настай Жозеф мухлаг тэрэгнүүдийн нэгнийх нь жолооч болжээ. Түүнийг өнчрүүлэн ээж нь нас барахад Жозеф 13-тай байсан бөгөөд тэр 16 хүрэхээсээ өмнө Сандвич Арлууд уруу номлолд явжээ (хожим нь Хавайн Арлууд гэж нэрлэсэн). Хонолууд ирснээс хойш гурван сарын дотор тэрээр нутгийн хэлээр чөлөөтэй ярьдаг болж, түүнийг онцгойлон адисалсан Арванхоёрын Ахлагчид Парли П.Пратт, Оорсон Хайд нар түүнд сүнсний бэлэг өгсөн ажээ. Тэр 21-тэй байхдаа өөр нэг номлолд явсан бөгөөд энэ удаад Британийн Арлуудад гурван жилээр явжээ.

Ерөнхийлөгч Бригам Янг түүнийг Төлөөлөгчөөр томилох санаа төрсөн үед Жозеф дөнгөж 28-тай байлаа. Дараагийн жилүүдэд тэрээр Сүмийн дөрвөн Ерөнхийлөгчид Зөвлөхөөр үйлчлэв. 1901 оны Аравдугаар сард Лорензо Снөүг нас барахад Жозеф Ф.Смит Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч болов. Сайн мэдээний үнэнүүдийг ухуулж, хамгаалах чадвараараа тэр гарамгай нэгэн байв. Түүний номлолууд болон бичсэн зүйлүүдийг *Сайн Мэдээний Номлол* нэртэй боть болгон эмхэтгэсэн нь Сүмийн сургаалын чухал ач холбогдолтой бичвэрүүдийн нэг болсон юм.

Хорьдугаар зууны эхний арван жилүүдэд Сүм хэд хэдэн чухал арга замаар урагш ахив. Аравны нэг болон Гэгээнтнүүдийн итгэлтэй хариултад анхаарал төвлөрүүлэхээ үргэлжлүүлснээр, Сүм бүх өрөө төлөх боломжтой болжээ. Үүний дараа цэцэглэн хөгжилтийн үе залгаж, ариун сүмүүд, шүтээний байрууд, айлчлагчдын төвүүд барих, Сүмийн түүхэнд холбогдолтой газруудыг худалдан авах боломж Сүмд бий болов. Эдүгээг хүртэл Сүмийн төв байр болж байгаа Захиргааны Байрыг Солт Лейк Хотод Сүм бас барилаа.

Дэлхий даяарх ариун сүмүүдийн хэрэгцээг Ерөнхийлөгч Смит ойлгож мэдсэн байлаа. Швейцарийн Бернд болсон 1906 оны чуулган дээр тэрээр гараа дэлгэн, “Энэ газар ариун сүмүүдээр тэмдэглэгдэж, та нар тийшээ явж, өөрсдийн нас барагсдыг гэтэлгэх тэр цаг ирэх болно”¹ хэмээн мэдэгджээ. Европ дахь хожмын үеийн анхны ариун сүм, Швейцарийн Ариун Сүм, бараг хагас зууны дараа Ерөнхийлөгч Смит бошиглолоо хийсэн хотын захад онцгойлон адислагджээ. Ерөнхийлөгч Смит 1913 онд Канадын Албертын Кардстонд, 1915 онд Хавайд ариун сүм барих газрыг онцгойлон адислав.

1900-гаад оны эхэн үеэс Гэгээнтнүүдийг Ютад цуглахаас илүүгээр өөрсдийнхөө нутагт үлдэхийг нь Сүмийн удирдагчид урамшуулан дэмжих болов. 1911 онд Жозеф Ф.Смит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний Зөвлөхүүд: “Манай хүмүүс төрөлх нутагтаа үлдэж, номлолын ажилд туслах байнгын шинжтэй цугларагсдыг бий болгох нь хүсүүштэй байна”² гэсэн мэдэгдэл гаргав.

Ерөнхийлөгч Смит нас барахаасаа зургаан долоо хоногийн өмнө нас барагсдын гэтэлгэлийн талаар нэг чухал илчлэлт хүлээн авчээ. Тэрээр сүнсний дэлхий дэх Аврагчийн тохинууллыг үзэгдэлд харж, сүнсний дэлхийд сайн мэдээг үргэлжлүүлэн заах боломж итгэлтэй Гэгээнтнүүдэд байдгийг мэдсэн ажээ. Энэ илчлэлт 1976 онд Агуу Үнэт Сувдад нэмэгдэн орсон бөгөөд 1979 онд Сургаал ба Гэрээнд хэсэг 138 болон шилжиж орсон юм.

Ерөнхийлөгч Хибер Ж.Грант

1918 оны Арваннэгдүгээр сард, нас барахаасаа өмнөхөн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит тэр үед Арванхоёрын Ерөнхийлөгч асан Хибер Ж.Грантыг гараас нь барьж: “Их Эзэн чамайг адислаг, Хүү минь, Их Эзэн чамайг адислаг, чамд агуу хариуцлага буй. Энэ бол хүнийх биш, харин Их Эзэний ажил гэдгийг ямагт санаж яв. Их Эзэн ямар ч хүнээс илүү агуу юм. Сүмийг хэнээр удирдуулахыг Тэрээр хүсдэгээ Тэр мэддэг бөгөөд хэзээ ч ямар ч алдаа гаргадаггүй юм”³



Гачигдалтай хүмүүсийг хүнсээр хангахад туслахын тулд Сүм халамжийн фермүүдийг үндэслэн байгуулсан билээ. 1933 онд чихрийн манжингийн ферм дээр ажиллаж байсан эдгээр Гэгээнтнүүдийн нэгэн адил Сүмийн гишүүд хөдөлмөрөө хандивладаг байв.

хэмээн хэлжээ. Хибер Ж.Грант 62 насандаа Сүмийн долоо дахь Ерөнхийлөгч болж, 1882 оноос хойш Төлөөлөгчөөр үйлчилсэн ажээ.

Хибер залуу байхдаа мөн насан туршдаа, зорилгодоо хүрэхийн төлөө ер бусын шийдэмгий байдаг байлаа. Бэлэвсэрсэн эхийнхээ өсгөн хүмүүжүүлсэн айлын ганц хүү байсан тэрээр өөрийнхөө насны бусад хөвгүүдийн үйл ажиллагаанаас ямар нэг байдлаар зожиг хөндий байжээ. Тэр бейсболлын багт орох гэж оролдох үед, түүнийг эв дүйгүй гэж шоолон, ур чадвараар тааруу байснаас багийн гишүүнээр хүлээн авсангүй. Санаагаар унахын оронд тэрээр шидсэн бөмбөг эсэргүүцэх дасгалыг олон цагаар шаргуу хийж, эцэстээ орон нутгийн хэд хэдэн ялалт байгуулсан өөр нэг багийн гишүүн болсон ажээ.

Тэрээр хүүхэд байхдаа данс хөтлөгч болохыг хүсдэг байсан бөгөөд энэ нь гутал тослох түүний ажлаас илүү их цалинтайг олж мэдсэн ажээ. Тэр үед данс хөтлөх нь бичгийн яггүй сайн ур чадвар шаарддаг байлаа, гэвч түүний бичиг цасан дээрх шувууны мөр шиг муухай харагддаг гэж хэлдэг байв. Тэр мөн л санаагаар унасангүй харин бичгийнхээ хэвийг сайжруулах дадлагыг олон цагаар хийжээ. Сайхан бичих чадвараараа тэр нэрд гарч, эцэстээ хичээнгүй бичгийг их сургуульд заадаг болж, чухал баримт бичгүүдийг бичүүлэхээр түүнийг олонтаа дууддаг байв. Их Эзэнд болон өөрийн нөхдөд үйлчлэхийн төлөө чадах бүхнээ хийхэд түүний шийдэмгий чанарыг олж харсан олон хүний хувьд тэрээр агуу үлгэр жишээ байсан юм.

Ерөнхийлөгч Грант бол ухаалаг, амжилттай бизнесмен байсан бөгөөд түүний ур чадвар дэлхий дахиныг хамарсан санхүүгийн уналтын үед Сүмийг авч гарахад тусалсан бөгөөд хувь хүний асуудлууд нь үүнд нөлөөлсөн юм. Тэрээр бие даан амьдрах чадвартай байх мөн Их Эзэнээс хамааралтай байхад түүнчлэн, засгийн газраас бус, харин өөрийнхөө шаргуу хөдөлмөрөөс хамааралтай байхад итгэдэг байлаа. Тэрээр өөрийн олсон мөнгөөр гачигдалтай олон хүнийг адисалсан билээ.

1930-аад онд Гэгээнтнүүд дэлхий даяарх бусад хүмүүсийн нэгэн адил Их Уналтын үед ажилгүйдэл, ядууралтай тэмцэж байлаа. 1936 онд Их Эзэнээс ирсэн илчлэлтийн үр дүнд Ерөнхийлөгч Грант гачигдалтай хүмүүст туслах, бие дааж амьдрах чадвартай болоход нь бүх гишүүдэд дэмжлэг үзүүлэхийн тулд Сүмийн халамжийн хөтөлбөрийг үндэслэн бий болгосон юм. Тэргүүн Зөвлөл энэ хөтөлбөрийн тухай: “Бидний үндсэн зорилго бол, боломжийнхоо хэрээр, залхуурлын зүхлийг үгүй болгож, ажилгүйн тэтгэмжийн хилэнцийг халсан тогтолцоог бий болгох, манай хүмүүсийн дунд ажилч хичээнгүй, арвич хямгач, өөрийгөө хүндэтгэдэг чанарыг эгнэгт төлөвшүүлэх явдал мөн. Сүмийн зорилго бол өөрсдөдөө туслахад хүмүүст туслах явдал мөн. Ажил

хөдөлмөр манай Сүмийн гишүүдийн амьдралд тэргүүлэх зарчим болж эрхэмлэн дээдлэгдэх ёстой” гэж хэлжээ.⁴

Тэргүүн Зөвлөлд Зөвлөхөөр 28 жил үйлчилсэн Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк, “Халамжийн Төлөвлөгөөний урт хугацааны бодит зорилго бол өөрсдийнхөө дотор талд гүнд байгаа тэр хамгийн сайхан бүхнийг өгөгч бас авагч байх зан чанарыг Сүмийн гишүүдэд төлөвшүүлж, сүнсний далд баялгийг цэцэглэлт хийгээд үр өгөөжид авчрах явдал мөн”⁵ хэмээн онцлон тэмдэглэжээ.

Сүмийн халамжийн хүч чармайлтуудад хяналт тавихын тулд Халамжийн Ерөнхий Хороо 1936 онд үндэслэн байгуулагджээ. Анхдагчдын Гадасны ерөнхийлөгч, Харольд Б.Ли уг хорооны гүйцэтгэх захирал болов. Хожим нь Дезерет Индастрийн дэлгүүрүүд ажилгүйчүүд болон тахир дутуу хүмүүст туслахаар ажиллаж, мөн фермүүд болон үйлдвэрлэлийн төслүүд ийм гачигдалтай хүмүүст туслахын тулд үндэслэн байгуулагдав. Халамжийн хөтөлбөр нь Сүмийн гачигдалтай гишүүд болон дэлхий даяар ядуу зүдүү нөхцөлд аж төрдөг бусад мянга мянган хүмүүсийг өнөөдөр үргэлжлүүлэн адисалсаар байна.⁶

Номлогчийн ажил өргөн хүрээгээр үргэлжилсэн үед Ерөнхийлөгч Грант нэгэн ер бусын хөрвүүлэгт зэмсэг болсон ажээ. Шашны тохинуулагч Винжензо ди Франческа гэгч нэгэн итали хүн сүм рүүгээ Нью-Йорк Хотын нэгэн гудамжаар уруудан явж байгаад, нэг хавтасгүй ном торх дүүрэн үнсэн дотор байхыг харжээ. Тэрээр номыг авч, хуудсуудыг нь эргүүлж үзвэл Нифай, Мозая, Алма, Моронай гэхчлэн нэрнүүдийг анх удаа харжээ. Номны нэр гарал үүслийг тэрээр мэдэхгүй ч гэсэн номыг уншиж үзмээр, бас үүний үнэн эсэх талаар залбирч үзмээр санагдав. Тэгээд ингэж үзтэл, “ямар нэг үнэтэй, ер бусын юм олсон мэт баярын мэдрэмж төрж, бодгальд минь тайвшрал ирж, хүмүүний хэл дүрслэх үгс олдомгүй баяр хөөр надад үлдэж билээ” гэж тэрээр хэлжээ. Тэрээр уг номон дахь зарчмуудыг өөрийнхөө сүмийн гишүүдэд зааж эхлэв. Үүнийх нь төлөө

сүмийнх нь удирдагчид түүнд хатуухан сануулж, номыг шатаахад түүнийг чиглүүлсэн боловч, тэр хийхээс татгалзжээ.

Хожим нь тэрээр Италид эргэн ирж, уг номыг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэвлэснийг мэдсэн аж. Тэрээр Юта дахь Сүмд захидал бичсэнийг Ерөнхийлөгч Грантад гардуулжээ. Ерөнхийлөгч Грант итали хэл дээр хэвлэгдсэн Мормоны Номыг түүнд илгээж, Европын номлолын ерөнхийлөгчид нэрийг нь өгчээ. Дайны үеийн хүнд бэрх цаг баптисм хүртэхийг нь Винжензод олон жилээр саатуулсан хэдий ч, тэрээр эцэстээ 1951 оны Нэгдүгээр сарын 18-нд, Сицили арлаас анхны баптисм хүртсэн хүн болж, Сүмийн гишүүн болох боломжтой болов. Таван жилийн дараа тэр Швейцарийн Ариун Сүмд хишиг хүртжээ.⁷

1922 оны Тавдугаар сарын 6-нд Ерөнхийлөгч Грант Сүмийн анхны радио станцыг онцгойлон адислав. Хоёр жилийн дараа радио станц ерөнхий чуулганы хуралдааныг нэвтрүүлж эхлэн, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн захиасуудыг сонсох боломжийг Сүмийн илүү олон гишүүдэд олгожээ. Түүнээс хойш удалгүй, 1929 оны Долдугаар сард Табернеклын Найрал дуу, бурханлигаар нөлөөлөгдсөн хөгжим болон хэлсэн үгийн долоо хоног тутмын нэвтрүүлэг *Music and the Spoken Word*-ийн анхны хөтөлбөрийг агаар мандалд цацжээ. Энэ хөтөлбөр өнөө үеийг хүртэл долоо хоног тутмын нэвтрүүлэг болж үргэлжилсээр байгаа билээ.

Ерөнхийлөгч Грант 1945 оны Тавдугаар сарын 14-нд нас барав. Сүмийн Ерөнхийлөгчөөр үйлчилсэн түүний 27 жилийг зөвхөн Бригам Янгийн үйлчлэлийн жилүүд л уртаараа даван гарчээ.

Ерөнхийлөгч Жорж Алберт Смит

Жорж Алберт Смит Хибер Ж.Грантыг залгамжилж Сүмийн Ерөнхийлөгч болов. Амьдрал нь сайн мэдээгээр амьдарч аз жаргал олохын үлгэр жишээ болсон Ерөнхийлөгч Смит: “Бурханы зарлигуудыг, мөн түүний зөвлөгөө, зөвлөмжийг

сахихын үр дүн болж байгаа тэр нэрний зохистой байдал нь аз жаргал бүхэн бас баяр хөөр бүхэн байдаг”⁸ хэмээн гэрчилжээ.

Бурханы зарлигуудыг болон Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дуулгавартай дагах нь Ерөнхийлөгч Смитийн гэр бүлийн олон үеийнхний хувьд зөв шударга байдлын загвар болсоор ирсэн юм. Бошиглогч Иосеф Смитийн үеэл бөгөөд Бригам Янгийн Зөвлөх асан, аавынхаа талын өвөг эцэг Жорж А.Смитийн нэрээр түүнийг нэрлэсэн ажээ. Жорж Албертын эцэг Жон Хенри Смит Жозеф Ф.Смитийн удирдлага дор Тэргүүн Зөвлөлд үйлчилж байжээ. Жорж Алберт Смит 33 настайдаа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад дуудагдсан нь энэ эрин үед эцэг хүү хоёр 1903–1910 уг Чуулгад хамт үйлчилсэн цорын ганц тохиолдол ажээ.

Арванхоёрын Чуулгад үйлчилсэн Жорж Албертын 42 жил нь эрүүл мэнд нь муу байсан хэсэг үеийг үл хайхран, нэр хүндтэй үйлчлэлээр дүүрэн байлаа. Өмнөд Ютад төмөр замд судалгаа хийж байсан үед түүний нүд наранд гэмтэн, түүний бараг хараагүй болсон нүдэнд хийсэн мэс засал амжилтгүй болжээ. Даралт нь ихэсч, цаг үеийн шаардлага түүний ядруу биеийг улам доройтуулж, улмаар 1909 онд ядаргаанаас бүр ч дорджээ. Бүрмөсөн амрах тухай эмчийн тушаал өөртөө итгэх түүний итгэлийг алдагдуулж, хэнд ч хэрэггүй болсон мэт мэдрэмж төрүүлэн, бухимдалтыг нь улам гааруулав.

Энэ хүнд үед Жорж том нуурын ойролцоо нэгэн сайхан ой харсан зүүд зүүдэлсэн аж. Тэрээр ой дундуур хэсэг алхтал, өөрийнх нь хайрт өвөг эцэг Жорж А.Смит өөдөөс нь ирж явахыг таньжээ. Жорж урагш яаран алхтал, өвөг эцэг нь ойртож ирээд, зогсож, “Миний нэрээр чиний юу хийснийг би мэдмээр байна” гэж хэлсэн гэнэ. Түүний амьдралын дүр зураг Жоржийн оюун ухаанд зурсхийн бууж, тэрээр, “таныг ичихэд хүргэх юуг ч би таны нэрээр хэзээ ч хийгээгүй” гэж даруухнаар хариулж гэнэ. Энэ зүүд Жоржийн сүнснийг бас түүний бие бялдрын тэвчээр хатуужлыг шинэчилж, тэрээр удалгүй ажилдаа эргэж орох боломжтой болжээ. Хожим нь



Ерөнхийлөгч Корнели Заптей болон Нидерландын Номлол дахь номлогч нар Германы Гэгээнтнүүдэд зориулсан халамжийн төмсийг гардуулж байгаа нь, 1947 он

тэрээр энэ туршлагыг түүний амьдрал дахь үндсэн гол эргэлтийн үе гэж олонтаа дүрсэлдэг байжээ.⁹

1945–1951 оныг хүртэл үргэлжилсэн Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн удирдлагын үед Сүмийн гишүүдийн тоо нэг саяд хүрч, Айдахогийн Айдахо Фоолсын ариун сүм онцгойлон адислагдаж, номлогчийн ажил Дэлхийн II Дайны дараа сэргэсэн юм.

Түүнчлэн, дайны уршгаар ядуурч хоосорсон Европын Гэгээнтнүүдэд тусламж үзүүлэх хүч чармайлтууд зохион байгуулагдав. Нэгдсэн Улс дахь Сүмийн гишүүдийг хувцас, бусад эд зүйл хандивлахыг нь урамшуулан дэмжиж байлаа. Цуглуулсан хүнс, хувцас, ор дэрний хэрэглэлүүдийг Европ уруу илгээх зөвшөөрөл авахаар Ерөнхийлөгч Смит, Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Харри С.Трумэнтэй уулзжээ. Ерөнхийлөгч Смит энэ уулзалтыг ийм байдлаар дүрсэлсэн байдаг:

“Үүнийгээ та юунаас өгөх гэж тийш нь ачуулах гэж байгаа юм бэ? Тэдний мөнгө огт хэрэггүй болсон шүү дээ” гэж Ерөнхийлөгч хэлэв.

“Бид тэднээс мөнгө авахыг хүсэхгүй байна” гэж би хэллээ. Тэрээр над уруу харж: “Та үүнийг тэдэнд зүгээр өгөх гэж байна гэж хэлэх гээгүй биз?” гэж асуулаа.

“Мэдээжийн хэрэг, бид үүнийг тэдэнд зүгээр өгнө. Тэд бол бидний ах, эгч дүүс бас тэдэнд зовлон зүдгүүр тохиолдоод байгаа шүү дээ. Бурхан биднийг элбэг дэлбэгээр адисалсан юм, хэрэв бид засгийн газартай хамтран ажиллаж, үүнийг илгээх юм бол бид баяртай байх болно” гэж би хэлэв.

“Та зөв зам дээр байна гэж тэр хэлээд, бид танд чадахаараа ямар нэг байдлаар туслахдаа баяртай байх болно” гэж нэмж хэлэв.¹⁰

Хандивуудыг далайн чанад уруу ачуулахаар Ютад ангилан, баглаж байхад Ерөнхийлөгч Смит бэлтгэлийг шалгахаар иржээ. Өгөөмөр сэтгэлээр хандивласан өдий их хэмжээний эд зүйлийг хараад түүний нүүрэн дээгүүр нулимс урсаж байлаа. Хэдэн хормын дараа тэрээр цоо шинэхэн гадуур хүрмээ тайлж, “Үүнийг ачуул” гэв. Хүйтэн салхитай өдөр хүрэм нь түүнд хэрэгтэй гэж ойрхон зогсож байсан хэдэн хүн түүнд хэлсэн боловч, тэрээр үүнийг явуулах ёстой гэж зүтгэжээ.¹¹

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Эзра Тафт Бенсон Европт номлолуудыг дахин нээх, тусламжийн зүйлсийг тараах ажлыг харах, түүнчлэн Гэгээнтнүүдийн сүнслэг хэрэгцээг адислахаар томилогдсон байв. Ахлагч Бенсоны анхны айлчлалтуудын нэг нь Рене Мөрөн дээрх Германы хот Карлсрухе дахь Гэгээнтнүүдийн чуулган байлаа. Ахлагч Бенсон энэхүү туршлагын тухай өгүүлэхдээ:

“Бид эцэстээ цуглааны газар, хорооллын дотор орших, нэг хэсгийг нь бөмбөгдсөн нэг барилга руу очих замыг олов. Биднийг тэнд чуулганд очих байх гэсэн үг тэдэнд хүрсэн учраас Гэгээнтнүүд биднийг ирнэ гэж найдан, цуглаад биднийг хоёр цаг гаруй хүлээсэн ажээ. Тэгээд биднийг тавцан руу алхан хүрч очиход бараг бүх цугларагсад нүдэндээ ну-

лимстай байсныг би амьдралдаа анх удаа харж билээ, зургаа буюу долоон урт жилийн дараа, тэд суурийг нь тавьсан Сионы төлөөлөгчид сая нэг юм тэдэнд дээр эргэж ирсэн байлаа. . . . Тэдний уруу царайлсан, цонхигор, туранхай нүүрийг, эдгээр Гэгээнтнүүдийн олон нь уранхай ноорхой хувцастай, зарим нь хөл нүцгэн байсныг би хараад, энэхүү хожмын өдрийн агуу ажлын бурханлиг чанарыг тэд гэрчилж, Их Эзэний адислалуудын төлөө талархал илэрхийлж байх үед тэдний нүдэн дэх итгэлийн гэрлийг би олж харж билээ”¹² гэжээ.

Түүний олон ажил үүргийн дунд Ахлагч Бенсон 127 вагон хүнс, хувцас, ор дэрний хэрэглэл болон эмийг Европ даяар тарааж өгөх ажилд хяналт тавьж байлаа. Хэдэн жилийн дараа Ерөнхийлөгч Томас С.Монсон Германы Звискауд шүтээний шинэ байр онцгойлон адисалж байх үед нас ахимаг нэг ах нүдэндээ нулимс цийлэлзүүлэн урагш гарч ирээд Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонд өөрийг нь сануулна уу гэж хүсэв. “Америк дахь Сүмийн гишүүдээс илгээсэн хүнс, хувцсыг тэр бидэнд авчирснаараа амьдралыг минь, бас төрөлх эх оронд минь миний ах, эгч дүүсээс олныг нь аварсныг түүнд хэлж өгөөч” гэж тэр хэлжээ.¹³

Нидерландын Гэгээнтнүүд Герман дахь өлсгөлөнд нэрвэгдсэн Гэгээнтнүүдэд жинхэнэ Христийн үйлчлэл үзүүлэх боломжтой байв. Нидерландын гишүүд дайны үед их зовлон үзсэн бөгөөд дараа нь Нэгдсэн Улс дахь Сүмийн гишүүдээс халамжийн тусламж хүлээн авчээ. 1947 оны хавар, өөрсдийн халамжийн төслүүдийг эхлэхийг тэднээс хүсэхэд тэд үүнийг амжилттай хэрэгжүүлжээ. Тэд ихэвчлэн төмс тариалж, их ургац авна гэж хүсэн хүлээж байв.

Энэ үед Зүүн Германы Номлолын Ерөнхийлөгч Уолтер Стөүвер Голландад ирж, нүдэндээ нулимс цийлэлзүүлэн, Герман дахь Сүмийн гишүүдийн өлсгөлөн, үгүйрлийн тухай ярьжээ. Нидерландын Номлолын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Корнели Заппей, дайны үед тэдний дайсан байсан Германчуудад ургаж байгаа төмсөө өгөх үү гэдгийг

гишүүдээсээ асуужээ. Гишүүд дуртай зөвшөөрч, тэгээд төмснийхөө ургацыг ихэд сонирхон ажиглаж эхлэв. Ургац тэдний хэнийх нь ч хүлээж байснаас хавигүй их гарч, тэгээд Нидерландын Гэгээнтнүүд Герман дахь ах эгч нартаа 75 тонн төмс явуулах боломжтой болжээ. Жилийн дараа Нидерландын Гэгээнтнүүд Герман дахь Гэгээнтнүүдэд 90 тонн төмс, 9 тонн май загас илгээв.¹⁴

Эдгээр Гэгээнтнүүдийн харуулсан Христийнхтэй адил хайрын бялхалт нь Христийн хайрыг ер бус их хэмжээгээр цацруулдаг байсан Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн хувьд хэв шинж болсон зүйл байлаа. “Ах эгч нар минь, энэ дэлхий дэх хамгийн аз жаргалтай хүмүүс бол хөршүүдээ өөрсдийн нэгэн адил хайрладаг, амьдралд биеэ авч яваа байдлаараа Бурханы адислалуудын төлөө талархлаа харуулдаг хүмүүс юм гэдгийг би та нарт хэлж чадна”¹⁵ хэмээн тэр хэлжээ.

Ерөнхийлөгч Давид О.МакКей

Давид О.МакКей Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн Тэргүүн Зөвлөлд түүний Зөвлөх байв. 1951 оны хавар Ерөнхийлөгч Смитийн эрүүл мэнд бага зэрэг сайжрахад Ерөнхийлөгч МакКей, түүний гэргий Эмма Рае нар хойшлуулаад байсан амралтаараа Солт Лейк Хотоос Калифорни уруу явахаар шийдэв. Тэд Ютагийн Сейнт Жоржид хонохоор түр саатжээ. Маргааш өглөө нь эрт сэрээд, тэрээр Сүмийн төв байр луу эргэж очих ёстой гэсэн тов тодорхой сэтгэгдэл Ерөнхийлөгч МакКейд төржээ. Ерөнхийлөгч Смит түүнийг Солт Лейк Хотод ирснээс хойш хэдхэн хоногийн дотор хурц саа өвчин тусч, энэ нь улмаар түүнийг 1951 оны Дөрөвдүгээр сарын 4-нд нас барахад хүргэжээ. Тийнхүү Давид О.МакКей Сүмийн ес дэх Ерөнхийлөгч болов.

Ерөнхийлөгч МакКей Сүмийг удирдахын тулд сайн бэлтгэгдсэн юм. Тэр найман настай хүүхэд байхдаа аавыгаа Британийн Арлуудад номлолд дуудагдахад өрхийн тэргүүн эр хүний үүргүүдийг өөр дээрээ авсан ажээ. Түүний хоёр эгч



*Ерөнхийлөгч Давид О.МакКей бага байхдаа гэр бүлийнхээ хамт.
Давид аавынхаа өвөр дээр байна.*

саяхан нас барсан байлаа, мөн түүний ээж хүүхэд төрүүлэх гэж байв, тиймээс фермийн ажил үүргүүд Давидын ээжид үлдэхэд хэтэрхий ахадна гэж аав нь бодож байжээ. Ийм нөхцөлд МакКей Ах: “Мэдээжийн хэрэг миний хувьд явах боломжгүй байна шүү дээ” гэж эхнэртээ хэлэв. МакКей Эгч түүн рүү харж, “Мэдээж хэрэг та хүлээж авах ёстой; та надад санаа зовох хэрэггүй. Давид О. бид хоёр бүх зүйлийг сайхан амжуулна!”¹⁶ гэж хэлжээ. Түүний эцэг эхийн итгэл, бүхнээ зориулсан чанар, насан туршдаа Их Эзэнд үйлчлэх хүслийг залуу Давидад шингээжээ. Тэрээр 1906 онд 32 настайдаа Арванхоёрын Зөвлөлд дуудагдаж, Сүмийн Ерөнхийлөгч болохоосоо өмнө уг Зөвлөл болон Тэргүүн Зөвлөлд (Ерөнхийлөгч Хибер Ж.Грант, Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн Зөвлөхөөр) 45 жил үйлчилжээ.

Ерөнхийлөгч МакКей дэлхий даяарх Сүмийн гишүүдтэй өөрийг нь уулзуулсан аяллын өргөн цар хүрээтэй хуваарийг эхэлсэн юм. Тэрбээр Их Британи болон Европ, Өмнөд Африк, Латин Америк, Өмнөд Номхон Далайн болон бусад газруудын Гэгээнтнүүдтэй уулзсан ажээ. Тэрээр Европт байхдаа Лондон,

Швейцарьт ариун сүмүүд барих зохицуулалтыг урьдчилан хийсэн байлаа. Түүний Ерөнхийлөгчийн Зөвлөл дуусгавар болохын өмнө тэрээр Сүмийн гишүүдийг адислан, тэдэнд бурханлигаар нөлөөлж, бараг дэлхийд бүхэлд нь айлчилжээ.

Ерөнхийлөгч МакКей гишүүн бүр жил бүр наад зах нь нэг шинэ гишүүнийг Сүмд авчирч байх зорилготой ажиллахыг шаргуу хүсэх замаар номлолын ажилд шинэ түлхэц өгсөн юм. “Гишүүн бүр номлогч” хэмээх дахин давтагдсан санамжаараа тэр нэрд гарсан юм.

1952 онд бүрэн цагийн номлогч нарын үр ашгийг дээшлүүлэх хүч чармайлтад анхны албан ёсны номлолын төлөвлөгөөг дэлхий даяарх номлогч нарт илгээв. Энэ нь *Сайн Мэдээг Заах Байнгын Хөтөлбөр* гэсэн нэртэй байлаа. Уг хөтөлбөр Сүнсээр заах түүнчлэн Бурхан тэргүүтний мөн чанар, авралын төлөвлөгөө, Урвалт ба Сэргээлт түүнчлэн Мормоны Номын ач холбогдлыг заахад анхаарал төвлөрүүлсэн номлогчийн долоон ярилцлагыг агуулж байв. Дэлхий даяар Сүмд хөрвүүлэгдсэн хүмүүсийн тоо эрс өсөв. 1961 онд Сүмийн удирдагчид номлолын бүх ерөнхийлөгчдийн семинарыг зохион байгуулж, гэр бүлүүдийг найз нөхөдтэйгөө нөхөрлөл тогтоож, тэдэнд номлогч нараар гэр оронд заалгуулахыг урамшуулан дэмжихийг заажээ. 1961 онд шинээр дуудагдсан номлогч нарт зориулсан хэл сургалтын хөтөлбөр бий болж, мөн хожим нь номлогчийн сургалтын төв баригджээ.

Ерөнхийлөгч МакКейн удирдлагын үед зэвсэгт хүчинд алба хааж байсан Сүмийн гишүүд Ази дахь Сүмийн өсөлт хөгжилтийг үрийг суулгасан юм. Ютагийн Америк Форкоос Өмнөд Солонгост алба хааж байсан нэг залуу цэрэг, Нэгдсэн Улсын цэргүүд Солонгосын энгийн иргэдтэй тааралдахад Солонгосчууд хажуугаараа цэргүүдэд зам тавьж өгөн хажуу тийшээ ухасхийн зайлдгийг ажиглажээ. Сүмийн тэр залуу гишүүн, үүний эсрэгээр, хажуу тийшээ болж, Солонгосчуудад замаар явах боломж олгодог байв. Тэр бас тэдний нэрийг тогтооход хүч чармайлт гарган, тэрээр тэдний хажуугаар өнгөрөхдөө тэдэнтэй баяртайгаар мэндэлдэг байв. Нэг өдөр тэр өөрийн

таван найзтай хамт нэг эмх цэгц муутай танхимд орлоо. Хоол авах дараалал нэн урт байсан болохоор тэр хэсэг хугацаанд ширээний ард хүлээлээ. Удалгүй нэг Солонгос ажилчин та-виуртай хоол барин хүрч ирэв. Тэр цэрэг өөрийнхөө гар дээрх нэг зурвасыг зааж, “Та надад үйлчлэх хэрэггүй. Би бол ердөө л нэг цэрэг” гэж түүнийг хэлэхэд нөгөөх Солонгос хүн, “Би танд үйлчилнэ. Та бол Нэг Номерын Христэд итгэгч”¹⁷ гэж хэлэв.

1967 он гэхэд номлогч нар болон цэргийн албан хаагчид Солонгост сайн мэдээг заахад маш их үр ашигтай байж, Мормоны Ном Солонгос хэлэнд орчуулагдаж, гадас болон хэсгүүд уг нутагт удалгүй бий болов.

Номлогч нар бас Японд их амжилт оллоо. Дэлхийн II Дайны дараа Япон дахь Сүмийн гишүүд хэдэн жилийн турш Сүмийн төлөөлөгчидтэй хааяа нэг холбоо барьдаг байв. Гэвч Японд байрласан Хожмын Үеийн Гэгээнтэн цэргийн албан хаагчид дайны дараа хүчирхэг болон өсөхөд нь Сүмд тусалсан юм. 1945 онд Тацуй Сато, цай уухаас татгалзсан Хожмын Үеийн Гэгээнтэн цэргийн албан хаагчдын тухайд өндөр сэтгэгдэлтэй байж, улмаар дараа жил нь түүнийг болон гэр бүлийнх нь гишүүдээс нилээд хэдэн хүнийг баптисм хүртэхэд хүргэсэн асуултуудыг тэрээр тэднээс асуусан ажээ. Эллойт Ричардс Тацуйд, хожим нь Арванхоёрын Чуулгын гишүүн болсон цэргийн албан хаагч Бойд К.Пакер Сато Эгчид баптисм хүртээжээ. Сатогийнхны гэр олон япон хүмүүс сэргээгдсэн сайн мэдээний захиасыг анх сонссон газар болсон юм. Дэлхийн II Дайны үед Япончуудын эсрэг тулалдаж явсан Хожмын Үеийн Гэгээнтэн номлогч нар удалгүй Японы хотуудыг номлогчийн ажилд нээлттэй болгосон билээ.

Сүм Филиппинд оршин тогтносон нь бас л Дэлхийн II Дайны дараа Америкийн цэргийн албан хаагчдын хүч чар-майлттай шижмийн холбоотой бөгөөд тэнд Сүмийн эрчим-тэй өсөлт 1961 онд эхэлсэн юм. Сүмийн гишүүн биш асан нэгэн залуу Филиппин эмэгтэй Мормоны Номын тухай сон-сож, тэгээд хэдэн Хожмын Үеийн Гэгээнтэнтэй уулзжээ. Үүний үр дүнд тэрээр Хожмын Үеийн Гэгээнтэн Номлогч

нарыг Филиппинд ирэх зөвшөөрөл хүсэхийн тулд өөрийнхөө танил засгийн газрын ажилтнуудад хандах санаа түүнд төрсөн аж. Зөвшөөрөл олгогдож, тэгээд хэдхэн сарын дараа Арванхоёрын Чуулгын Ахлагч Гордон Б.Хинкли тус орныг номлогчийн ажлын төлөө дахин онцгойлон адисалжээ.

1950-иад оны үед Сүм эрчимтэй өссөний үр дүнд Ерөнхийлөгч МакКей санваартны зохицуулах хөтөлбөрийг зарлав. Арванхоёрын Чуулгын Ахлагч Харольд Б.Лигийн даргалсан хороо Сүмийн хамгийн чухал зорилгуудад Сүмийн бүх хөтөлбөрүүд хэрхэн сайн нийцэж байгааг харахын тулд тэдгээрийг бүх талаас нь, залбиралтайгаар судлахаар томилогджээ. 1961 онд Тэргүүн Зөвлөлийн зөвшөөрснөөр Ахлагч Ли Сүмийн сургалтын хөтөлбөрийн бүх материалуудыг төлөвлөх, бичиж боловсруулах хийгээд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах бодлогыг хөгжүүлэх болно гэж зарлав. Сүмийн хавсралт байгууллагууд эдгээр материалуудаас олныг өмнө нь хөгжүүлж байсан билээ. Энэхүү шинэ чиглүүлэл нь сайн мэдээг дэлхий даярх Сүмд олон өөр хэлээр ярьдаг, бүх насны гишүүдэд үр ашигтайгаар заахын тулд хөтөлбөрүүдийн болон хичээлийн материалуудын шаардлагагүй давхцлыг арилгасан ажээ.

Сүм бас бүх хөтөлбөрүүд, үйл ажиллагаанууд, түүний дотор халамж, номлогч болон гэр бүлийн түүхийн ажлыг Сүмийн үүрэг зорилгын дагуу илүү үр ашигтайгаар хэрэгжүүлэн зохицуулахын тулд бусад өөрчлөлтүүдийг бас хийжээ. Иосеф Смитийн үеэс Сүмийн нэг хэсэг байгаа гэрийн багшлалтыг Сүмийн бүх гишүүдийн сүнслэг болон түр зуурын хэрэгцээнд анхаарал халамж тавих арга зам гэж үзэн, 1960-аад онд дахин онцгой анхаарал хандуулах болсон юм. Заах явцыг өргөжүүлэхийн тулд цуглааны байрын номын сангуудыг бий болгож, мөн багшийг хөгжүүлэх хөтөлбөрийг эхлүүлсэн юм. 1971 онд Сүм Ерөнхий Эрх Мэдэлтний хяналтан дор англи хэлээр гурван сэтгүүл: хүүхдүүдэд зориулсан *Найз*, залуу хүмүүст зориулсан *New Era* (Шинэ Эрин), насанд хүрэгчдэд зориулсан *Ensign* (Туг) сэтгүүлүүдийг нийтэлж эх-

лэв. Мөн энэ үе орчимд Сүм өмнө нь өөр өөр номлолууд бие даан нийтэлдэг байсан гадаад хэлээр гардаг өөрийн сэтгүүлүүдийг нэгтгэсэн юм. Одоо нэг сэтгүүл орчуулагдаж, дэлхий даяарх Сүмийн гишүүдэд илгээгдэж байна.

Ерөнхийлөгч Давид О.МакКей гэр орны болон гэр бүлийн амьдралыг өнөө үеийн амьдралд тохиолддог хүнд сорилтууд хийгээд уруу таталтуудын эсрэг бат найдвартай хамгаалалт хийгээд аз жаргалын эх сурвалж гэж үзэн дээр үеэс эхлэн чухал ач холбогдол өгдөг байв. Тэрээр гэр бүлээ хайрлах хайрыг мэдэрдэг байсан хийгээд гэргий Эмма Раегаасаа хүлээн авдаг байсан үнэнч хайрын тухай олонтаа ярьдаг байжээ. Ерөнхийлөгч МакКейн удирдлагын үед, эцэг эхчүүд хүүхдүүддээ ойр дотно байж, сайн мэдээний зарчмуудыг тэдэнд заах нэг арга зам болгон, долоо хоног тутам гэр бүлийн үдэш явуулдаг зуршилд дахин хүчтэй анхаарал хандуулах болсон юм.

Нийгмийн Халамжийн Бүлэг гэр орон, гэр бүлүүдийг бэхжүүлэхийн чухалд онцгойлон анхаарахад нь бошиглогчдыг дэмждэг байлаа. Нийгмийн Халамжийн Бүлэг Навуу дахь эхлэлийнхээ үеэс, заах явц болон Нийгмийн Халамжийн Бүлгээр дамжсан хэлхээ холбоогоор өөрийгөө болон гэр бүлүүдээ адисалсан, дэлхий даяарх хэдэн зуун мянган эмэгтэйчүүдийг өөртөө багтаан өсч хөгжсөн билээ. 1945–1974 он хүртэл Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч нь, 1968–1970 онд Нэгдсэн Улсын Эмэгтэйчүүдийн Үндэсний Зөвлөлийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа улс орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг удирдагч, Ерөнхийлөгч Белле С.Спаффорд байлаа.

Ерөнхийлөгч МакКей 1970 оны Нэгдүгээр сард 96 настайдаа өөд болжээ. Сүмийн гишүүнчлэл бараг гурав дахин өсч, сайн мэдээний захиасыг бүх дэлхийд хүргэхэд агуу дэвшил гаргасан үед тэрбээр Сүмийг бараг 20 жил тэргүүлсэн байв.



*Дэлхий дахины Хожмын Үеийн Гэгээнтнүүд сайн мэдээний
адислалуудад баясдаг.*

Дэлхий Даяарх Сүм

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит

Давид О.МакКейг нас барахад, тэр үед бараг 93 настай байсан Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит Сүмийн Ерөнхийлөгч болов. Тэр бол Сүмийн Ерөнхийлөгч асан Жозеф Ф.Смитийн хүү байв.

Хөвгүүн байхдаа Жозеф Фийлдинг Смит Их Эзэний хүслийг мэдэхийг хүсдэг байсан нь тэрээр арван нас хүрэхээсээ өмнө Мормоны Номыг хоёр дахин уншиж, явж байхдаа судруудыг биендээ авч явдаг байжээ. Бөмбөгний баг түүнийг байхгүй бол, өвс хадгалдаг дээврийн хөндийд судар уншиж байхад нь ихэвчлэн олдог байжээ. “Би мэдээ орсон цагаасаа, би анх уншиж чаддаг болсон цагаасаа, судруудыг судалснаас мөн Их Эзэн Есүс Христийн тухай түүнчлэн Бошиглогч Иосеф Смитийн тухай, хүмүүний авралын тулд хийгдсэн ажлын тухай уншсанаас, бүх дэлхий дэх өөр юунаас ч илүүгээр агуу их сэтгэл ханамж хүлээн авдаг байлаа”¹ гэж тэрээр хожим нь хэлжээ.

Ийнхүү эртнээс судалсан нь судруудын тухай болон Сүмийн түүхийн тухай өргөн цар хүрээтэй мэдлэгийн суурийг тавьж, энэ нь номлолууд болон бараг хорь гаруй ном, сургаалын сэдвүүдээр олон чухал өгүүллүүд бичихэд түүнийг хөтөлжээ.

Түүний удирдлагын үед Ази (Японы Токио), Африкт (Өмнөд Африкийн Иоханнесбург) анхны гадсууд зохион байгуулагдав. Сүмийн гишүүнчлэл өссөнтэй холбогдуулан Ерөнхийлөгч Смит болон түүний Зөвлөхүүд орон нутгийн удирдагчдыг сургаж, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдтэй уулзах боломжийг гишүүдэд олгохын тулд дэлхий даяар бүсийн



*Сүмийн анхны бүсийн чуулган 1971 оны Наймдугаар сард
Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн удирдлагаар Англид болов.
Ахлагч Ховард В.Хантер индэр дээр.*

чуулгануудыг хийж байх ажил хэргийг эхлүүлэв. Ийм анхны чуулган Английн Манчестерт болжээ. Дэлхий даяар хүмүүст илүү сайн үйлчлэхийн тулд эрүүл мэндийн үндсэн зарчмууд болон эрүүл ахуйг заахын тулд эрүүл мэндийн номлогч нарыг дуудав. Удалгүй олон оронд 200 гаруй эрүүл мэндийн номлогч нар үйлчилж байлаа.

1912 оноос хойш Нэгдсэн Улсын өрнөд хэсэгт ахлах сургуулиудтай залгаа оршдог байрнуудад семинарын ангиудыг Сүм ивээн тэтгэсээр байна. 1920-иод онд Хожмын Үеийн үй олон Гэгээнтний сурдаг коллеж, их сургуулиуд дээр шашны институтууд эхлэв. 1950-иад оны эхэн үеэр өглөө эрт хичээллэдэг семинарын ангиуд Калифорнийн бүсийн Лос Анжелест эхэлж, удалгүй 1800 оюутан явдаг болов. 15–18 настай Хожмын Үеийн Гэгээнтэн залуус долоо хоногт таван өдөр шашин судлах хичээлд явахаар өглөөний 5:30-д босдог гэхэд гишүүн бус хүмүүс

гайхдаг байлаа. 1970-аад оны эхээр, дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтэн оюутнууд шашны заавар хүлээн авахын тулд семинарийн хичээлийг гэрээр судлах хөтөлбөрийг нэвтрүүлжээ. Ерөнхийлөгч Смитийн удирдлагын үед семинар институтын элсэлт эрс өсөн нэмэгдсэн байна.

1972 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Смитийн сүүлчийн удаа нийтэд хандаж хэлсэн үгэнд тэрээр хэлэхдээ: “Их Эзэн Есүс Христийн сайн мэдээнээс өөр дэлхийн өвчнүүдийг эдгээх зүйл байхгүй. Амар амгалангийн төлөөх, түр зуурын хийгээд сүнслэг байдлын цэцэглэл хөгжилт, түүнчлэн Бурханы хаант улс дахь зайлшгүй өвийн төлөөх бидний найдвар гагцхүү сэргээгдсэн сайн мэдээгээр дамжин хэрэгждэг билээ. Сайн мэдээг номлох хийгээд Сүм болон дэлхий дээрх Бурханы хаант улсыг байгуулахаас илүү чухал оролцох ажил бидний хэнийх нь ч хувьд байхгүй”² гэжээ.

Жозеф Фийлдинг Смит Сүмийн Ерөнхийлөгчөөр хоёр жил хагас үйлчилсний дараа охиныхоо гэрт анир чимээгүйхэн таалал төгсчээ. Тэрбээр 95 нас хүрсэн бөгөөд насан туршдаа Их Эзэнд зоримог шийдэмгий үйлчилсэн билээ.

Харольд Б.Ли

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийг таалал төгссөний дараагийн өдөр Арванхоёрын Чуулгын хамгийн ахмад гишүүн, Ерөнхийлөгч Харольд Б.Лигийн гэр бүл гэр бүлийн үдэш хийхээр цуглажээ. Ерөнхийлөгч Лид хамгийн ихээр туслахын тулд тэд юу хийж болохыг гэр бүлийнх нь нэг гишүүн асуув. “Итгэлдээ үнэнч бай; та нарт миний заадгаар яг тэгж сайн мэдээгээр амьдар” гэж тэрээр хариулжээ. Энэ захиас Сүмийн бүх гишүүдэд хамаатай юм. Сүмийн Ерөнхийлөгч болоод өөрийн хийлгэсэн анхны хэвлэлийн бага хурал дээр Харольд Б.Ли: “Бурханы зарлигуудыг сахигтун. Эдгээр ороо бусгаа цагт чухам үүнд л хувь хүмүүсийн болон улс үндэстнүүдийн аврал оршино”³ хэмээн мэдэгджээ.

1972 оны Долдугаар сарын 7-нд Харольд Б.Ли Сүмийн Ерөнхийлөгч болоход тэрээр 73 настай буюу Хибер Ж.Грантаас хойш Ерөнхийлөгч болсон хамгийн залуу Төлөөлөгч байв. Тэрээр 1935 онд Сүмийн халамжийн хөтөлбөрийг удирдахаар дуудагдсанаасаа хойш (хуудас 109-ийг үз) Сүмийн удирдлагад гол чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэрээр бас Сүмийн хөтөлбөрүүд болон сургалтын төлөвлөгөөний материалуудыг хянан засварлахад гол үүрэг гүйцэтгэсэн нь Сүмийн хөтөлбөрүүдийг хялбаршуулан, зохицуулалт хийхэд хүргэсэн юм. Тэрээр тэнгэрээс хүлээн авсан санаа бодлуудад түргэн хариулдаг, гүн гүнзгий сүнслэг байдалтай хүн байв.

Ерөнхийлөгч Ли болон түүний Зөвлөхүүд Мексик Хотод болсон бүсийн хоёр дахь чуулганыг тэргүүлсэн ажээ. Энэ чуулганд цугласан Сүмийн гишүүд бол шинэ Тэргүүн Зөвлөлийг дэмжин баталсан анхны Хожмын Үеийн Гэгээнтнүүд байлаа. “Сүмийн агуу өсөлтийг авчрахад . . . зэмсэг болсон олон хүний гайхамшигт хөдөлмөрийг хүлээн зөвшөөрч, магтан сайншаахын тулд цуглаануудыг Мексикт хийсэн юм” хэмээн Ерөнхийлөгч Ли тайлбарлажээ.

Мексик болон Төв Америк дахь Гэгээнтнүүд бүсийн чуулган Мексик Хотод болох нь гэдгийг мэдээд, олон хүн үүнд оролцохоор төлөвлөж эхлэв. Нэг эгч айлаас айлд очиж угаалгах юм байна гэж асууж байв. Тэрээр таван сарын турш хөршүүдийнхээ хувцсыг сойздож угааснаас олсон песог хадгалсаар байгаад чуулганд очиж, бүх хуралдаануудад оролцох боломжтой болжээ. Олон Гэгээнтнүүд цуглаануудад оролцохын тулд ажил хийж, мөнгө хадгалсны дараа хоол хүнс авах мөнгөгүйгээс чуулганы өдрүүдэд сайн дураараа мацаг барьж байжээ. Золиослол хийсэн хүмүүс сүнслэг агуу хүч чадлаар шагнагджээ. Чуулган “миний амьдралын хамгийн сайхан туршлага” байлаа гэж нэг гишүүн мэдэгдсэн ажээ. Өөр нэг гишүүн, “Эдгээр өдрүүдэд бидний энд мэдэрсэн хайрыг мартахын тулд бидэнд олон жил шаардагдах болно”⁴ гэж сурвалжлагчид ярьжээ.

Түүний удирдлагын үед Ерөнхийлөгч Ли Ариун Нутагт очин, энэ эрин үед ийнхүү тийшээ очсон Сүмийн анхны Ерөнхийлөгч болов. Тэрээр бас жижиг ариун сүмүүд баригдаж, эцэстээ дэлхийд олшрох болно гэдгийг зарласан юм.

1973 оны Зул Сарын Баярын нэг өдрийн дараа, Сүмийн Ерөнхийлөгчөөр ердөө арваннаймхан сар үйлчилсний эцэст Ерөнхийлөгч Ли нас баржээ. Аварга сүнслэг хүн тэрбээр мөнхийн гэртээ эргэн очив.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл

Өвчин эмгэг, гай зовлонгийн талаар ихийг мэддэг хүн байсан Арванхоёрын хамгийн ахмад гишүүн Спенсер В.Кимбалл Ерөнхийлөгч Лиг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Хавдрын улмаас түүний хоолойн ихэнх хэсгийг тайрсан учраас тэрээр маш намуухан, сөөнгө дуугаар ярьдаг байсан нь Хожмын Үеийн Гэгээнтнүүд түүнийг хайрлахад хүрдэг байжээ. Даруу байдал, шийдэмгий зан чанар, ажиллах чадвар болон “Үүнийг хий” гэдэг хувийн уриагаараа нэрд гарсан Ерөнхийлөгч Кимбалл хадуураараа бүх хүч чадлаараа хаддаг байв.

Ерөнхийлөгч болоод Спенсер В.Кимбаллын анхны хэлсэн үг нь Сүмийн бүс нутгийн төлөөлөгчдөд хандсан байсан бөгөөд энэ нь сонссон хүн бүрийн хувьд мартагдашгүй дурсгалтай байжээ. Уг цуглаанд оролцогчдын нэгний эргэн дурссанаар, яриа дөнгөж эхэлсний дараа, “гайхан бишрүүлсэн сүнслэг оршихуйд бид сэргэлэн шалмаг болж, тэгээд бид ямар нэг ер бусын, хүчирхэг, өөр . . . зүйл сонсож байгаагаа мэдэв. Энэ нь Бүхнийг Чадагчийн зорилгыг халхалсан хөшгүүдийг тэрбээр арагш татан, сайн мэдээний хувь тавиланг хийгээд үүний тохиууллын тухай үзэгдлийг өөртэйгөө хамт нэгтгэн дүгнэхэд биднийг урих лугаа адил байв.”

“Их Эзэн өөрийн хүмүүсээс хүсэн хүлээдэг тэрхүү итгэлтэй байдалд Сүм хэрхэн бүрэн дүүрэн амьдарч байгаагүйг, мөн энэ нь тодорхой хэмжээгээр, бид юмсын байгаа байдлаар маадгар,

сэтгэл ханамжтай байдаг тийм сүнсэнд бид нүд дассаныг Ерөнхийлөгч Кимбалл удирдагчдад харуулжээ. Энэ бол 'Бид том алхах ёстой' гэж түүний алдартай уриагаа хэлсэн тэр агшин байлаа. Дэлхийн үндэстнүүдэд сайн мэдээг тунхаглах шийдвэр төгс байдлаа нэмэгдүүлэхийг тэрээр цугларагсдад сануулах. Тэр бас өөрсдийнхөө оронд үйлчилж чадах номлогч нарын тоог их хэмжээгээр нэмэгдүүлэхийг уриалав. Номлолын төгсгөлд Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, 'Үнэхээр Израилд бошиглогч байгаа юм байна' "⁵ хэмээн хэлжээ.

Ерөнхийлөгч Кимбаллын эрчимтэй удирдлага дор улам олон гишүүд бүрэн цагийн номлолд үйлчилж, Сүм дэлхий дахинд урагш ахисан юм. 1977 оны Наймдугаар сард Ерөнхийлөгч Кимбалл Варшавт очиж, тэнд тэрээр Их Эзэний ажил урагш ахьж болохын төлөө Польшийн нутгийг онцгойлон адисалж, мөн хүмүүсийг нь адисалсан юм. Номлогчийн сургалтын төвүүд Бразил, Чили, Мексик, Шинэ Зеланд, Японд бий болов. 1978 оны Зургадугаар сард Бурханаас илчлэлт хүлээн авснаа тэрээр зарласан нь дэлхий даяарх номлолын ажилд асар их нөлөө үзүүлэв. Олон жилийн туршид санваарыг Африкаас гаралтай хүмүүст олгохоос татгалзсаар ирсэн хэдий ч, эдүгээ санваар болон ариун сүмийн адислалууд зохистой бүх эрэгтэй гишүүдэд хүртээх болов.

Дэлхий даяарх итгэлтэй хүмүүс энэхүү илчлэлтийг удаан хугацаанд найдлага тавин хүлээж байсан ажээ. Африкт сайн мэдээг хүлээн авсан анхны хар арьст хүмүүсийн нэг нь бүр 1913 онд Сүмийн тухай мэдсэн Виллям Пол Даниелс байв. Тэрээр Ютад очиж, тэнд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитээс тусгай адислал хүлээж авсан ажээ. Хэрэв тэрээр итгэлтэй хэвээр байх юм бол, тэр энэ амьдралд буюу дараагийн амьдралд санваар хүлээн авах болно гэдгийг Ерөнхийлөгч Смит түүнд амласан байжээ. Даниелс Ах Сүмийн итгэлтэй гишүүн хэвээр байсаар 1936 онд нас барсан бөгөөд охин нь санваарын талаарх 1978 оны илчлэлтийн дараа удалгүй аавынхаа төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэсэн ажээ.⁶

Африкт өөр олон хүмүүс Сүмийн ном зохиолоор буюу хувийн гайхамшигтай туршлагаудаар дамжуулан сайн мэдээний үнэний тухай гэрчлэлүүдээ хөгжүүлж байсан хэдий ч, тэд сайн мэдээний бүх адислалуудыг эдлэх боломжгүй байв.

1978 оны Зургадугаар сарын илчлэлтээс өмнө Ерөнхийлөгч Кимбалл өөрийн Зөвлөхүүд болон Арванхоёр Төлөөлөгчтэй Африк гарлын хүмүүст санваар олгохыг татгалзаж байсан талаар олон сарын турш хэлэлцжээ. Сайн мэдээний бүрэн адислалуудыг Сүмийн зохистой гишүүдэд олгож болохгүй байсан дэлхийн бүсүүдэд номлолуудыг нээхэд Сүмийн удирдагчид дургүй байв. Өмнөд Африкт болсон нэгэн бүсийн чуулган дээр Ерөнхийлөгч Кимбалл, “Би их эрч хүчтэйгээр залбирсан. Бурханы хүүхдүүдийн олонд нь туйлын чухал нэг зүйл бидний өмнө байгааг би мэдэж байв. Бид зөвхөн зохистой байснаар, мөн илчлэлтүүдэд бэлэн байснаар, бас илчлэлтүүдийг хүлээн авахад бэлэн байснаар түүнчлэн тэдгээрийг байранд нь тавьснаар бид Их Эзэний илчлэлтүүдийг хүлээн авч чадна гэдгийг би мэдэж байв. Өдөр дараалан би ганцаараа, бас агуу хүндэтгэл хийгээд буурь суурьтайгаар ариун сүмийн дээд өрөөнүүд рүү очиж, тэнд би өөрийн бодгалийг мөн уг хөтөлбөрийг урагш ахиулах өөрийн хүч чармайлтуудыг өргөн барьдаг байлаа. Түүний хийхийг хүсдэг зүйлийг би хийхийг хүсч байв. Энэ тухай би түүнд ярьж, ‘Их Эзэн, би гагцхүү зөв зүйлийг л хүснэ’ гэж хэлэв” хэмээн мэдэгджээ.

Ариун сүм дэх тусгай цуглаан дээр харь арьстай эрэгтэйчүүдэд санваар олгох талаарх өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэйгөөр илэрхийлэхийг Ерөнхийлөгч Кимбалл өөрийн Зөвлөхүүд болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас бүгдээрэнгээс нь хүсчээ. Тэгээд тэд тахилын ширээний дэргэд Ерөнхийлөгч Кимбаллтай хамт чангаар залбирав. Тэнд байсан Ахлагч Брюс Р.МакКонки хожим нь өгүүлэхдээ, “Энэ үйл явдлаар, шаардлага хийгээд итгэлийн улмаас цаг нь болсны улмаас Их Эзэн Ариун Сүнснийг Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын дээр өөрийн бурханлиг зөн билгээр, гайхамшигтай хийгээд гайхмаар



*Ойрын жилүүдэд
ариун сүмүүд
дэлхий даяар өндөр
хурдацтайгаар
баригдав. Германы
Франкфуртын
Ариун Сүм бол
эдүгээ Сүмийн
гишүүдийг
адисалдаг олон
ариун сүмийн нэг
мөн.*

байдлаар, тэнд байгсдаас аль нь өмнө нь үзээгүй тийм тэдэнд гаргуунаар юүлсэн юм”⁸ гэжээ. Бүх зохистой эрэгтэйчүүд санваарын бүрэн адислалуудыг хүлээн авах цаг болсон гэдэг нь Сүмийн удирдагчдад тодорхой байлаа.

“Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүд яс үндэс буюу арьсны өнгөнөөс үл хамааран санваарт томилогдож болохыг” Их Эзэн илчилснийг Тэргүүн Зөвлөл тайлбарлан, 1978 оны Зургадугаар сарын 8-наар хаяглагдсан захидлыг санваарын удирдагчдад илгээжээ. 1978 оны Есдүгээр сарын 30-нд Гэгээнтнүүд ерөнхий чуулганаар удирдагчдынхаа үйлдлийг санал нэгтэй дэмжин батлав. Эдүгээ энэ захидал Сургаал ба Гэрээнд Албан Тунхаг—2 болж орсон байна.

Энэхүү зарлалаас хойш Африк гаралтай мянга мянган хүмүүс Сүмд ирсэн аж. Африк дахь нэг хөрвөгчийн туршла-

га эдгээр хүмүүсийг Их Эзэн хэрхэн адисалсныг харуулдаг. Коллежийн төгсөх ангийн оюутан бөгөөд багш тэрээр цагаан хувцастай хүмүүс дотогшоо орж байгаа шовх оройтой буюу цамхагтай том барилга зүүдэлжээ. Хожим нь тэрээр явж байгаад Хожмын Үеийн Гэгээнтний шүтээний харж, энэ сүм яагаад ч юм түүний зүүдтэй холбоотой юм шиг санагджээ, тиймээс тэр тэнд нэг Ням гарагийн үйлчлэлд оролцов. Цуглааны дараа номлолын ерөнхийлөгчийн гэргий түүнд нэг томхимол үзүүлсэн аж. Нөгөөх хүн үүнийг нээтэл, зүүдэндээ түүний харсан нөгөөх барилга, Солт Лейкийн Ариун Сүмийн зургийг харав. Хожим нь тэрээр хэлэхдээ, “Би сэрэхээсээ өмнө уйлж байлаа. . . . Тэр мэдрэмжийг би тайлбарлаж чадахгүй байв. Би бүх дарамтаасаа чөлөөлөгдөв. . . . Би олонтаа ирсэн газартаа ирсэн юм шиг надад санагдаж байв. Ингээд одоо би гэртээ байлаа”⁹ гэжээ.

Ерөнхийлөгч Кимбаллын удирдлагын үед Далын Нэгдүгээр Чуулга зохион байгуулагдаж, Ням гарагийн гурван цагийн цуглааны хуваарь нэвтрүүлж, ариун сүмүүд түргэн хурдацтай баригдаж байлаа. 1982 онд төлөвлөлтийн шатандаа байгаа буюу баригдаж байсан ариун сүм дэлхий даяар 22 байсан нь Сүмийн түүхэнд тэр үедээ хамгийн олон ариун сүм байв. Ерөнхийлөгч Кимбалл бас шахуу аяллын хуваарь гаргасан нь бүсийн чуулганууд хуралдуулахын тулд түүнийг олон оронд очиход хүргэсэн ажээ. Эдгээр хурлууд дээр тэрээр өөрийн хувийн хэрэгцээг эс хайхран, орон нутгийн Гэгээнтнүүдтэй уулзаж, тэднийг хүчирхэгжүүлэн, адислах боломж бүрийг төлөвлөдөг байв.

Олон оронд Сүмийн гишүүд ариун сүмүүдэд санал болгогддог авралын ариун ёслолуудыг хүлээн авах тэмүүлэл хүсэл болдог байв. Ийм хүмүүсийн дунд олон номлолд үйлчилсэн, номлолын ерөнхийлөгчийн зөвлөлд ажиллаж байсан Шведийн нэг Хожмын Үеийн Гэгээнтэн байлаа. Тэрээр нас барахдаа, тэр оронд ариун сүм баригдахаар зарлагдахаас удаан хугацааны өмнө өмч хөрөнгийнхөө үлэмж хэсгийг Шведийн ариун сүмийн санд үлдээжээ. Ерөнхийлөгч Кимбалл ариун сүмийг зарлахад энэ хүний хандив хүүгээрээ өсч асар их хэмжээтэй болсон байв.



*Ерөнхийлөгч
Спенсер
В.Кимбалл
Нэгдсэн Улсын
баруун өмнөд
нутаг дахь
Индианчуудтай
хамт.*

Ариун сүмийг онцгойлон адисалсны дараа удалгүй, амьддаа хишиг хүртсэн энэ итгэлтэй ах, түүний мөнгө үүнийг барихад тусалсан тэр ариун сүмд тэрээр эцэг эхтэйгээ лацдан холбогдсон ажээ.

Сингапурт нэг аав, ээж хоёр лацдан холбуулж, өөрсдийнхөө ариун сүмийн адислалуудыг хүлээж авахын тулд гэр бүлээ ариун сүмд аваачъя гэж шийджээ. Тэд шаардлагатай мөнгийг олохын тулд олон зүйлээ золиосолсны дүнд эцэстээ аялал хийж, ариун сүмд орох боломжтой болжээ. Тэд хэдэн жилийн өмнө өөрсдөд нь зааж байсан номлогчийн гэрт буужээ. Хүнсний дэлгүүрт очих үед энэ эгч нөхөр, номлогч

хоёроос төөрчихөж. Тэд түүнийг олоход тэр гартаа лонхтой шампунь бариад уйлж байв. Ариун сүмд орохын тулд түүний хийсэн золиослолуудын нэг нь, тэрээр долоон жилийн турш шампуньгүйгээр, үүнийг хэрэглэхгүй явснаа тайлбарлажээ. Түүний золиослолууд хийхэд хэцүү байсан ч гэсэн, одоо бол ялигүй юм шиг санагдаж болно, учир нь түүний гэр бол Их Эзэний өргөөний ёслолуудаар үүрд мөнх хамтдаа холбогдсоныг тэр мэдэж байлаа.

Ерөнхийлөгч Кимбаллын удирдлагын үед тохиосон өөр нэг томоохон дэвшил бол 1979 онд Сүм Хаан Жеймсийн Библийн англи хэлээрх шинэ хэвлэлийг нийтлүүлсэн явдал мөн. Бичвэр өөрчлөгдөөгүй боловч, Библийг Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдтай ишлэлүүдийг харьцуулсан зүүвэр тайлбар нэмэгдсэн ажээ. Том хэмжээний Сэдэвчилсэн Удирдамж болон Библийн Толь Бичиг өнөө үеийн судруудын талаарх хосгүй өвөрмөц ойлголтуудаар хангасан юм. Энэ хэвлэл бүх бүлгүүдийн хувьд шинэ толгой гарчгуудтай бөгөөд түүнчлэн Иосеф Смитийн, Хаан Жеймсийн Библийн бурханлигаар нөлөөлөгдсөн засваруудаас түүвэрлэн оруулсан болно.

1981 онд бас Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдын шинэ хэвлэлүүд нийтлэгдэв. Эдгээр хэвлэлүүд зүүвэр тайлбарын шинэ тогтолцоо, шинэ бүлэг, хэсгийн толгой гарчгууд, газрын зургууд түүнчлэн товъёогийг өөртөө багтаасан юм. Мөн энэ үе орчимд Сүм бас хожмын үеийн судруудыг олон хэлэнд орчуулахад онцгой анхааралд тавьж эхэлжээ.

Ерөнхийлөгч Кимбалл өөрийн үлгэр жишээ болон өөрийн заадаг зүйлүүдэд Сүмийн гишүүдийг өөрсдийнхөө бүх хүч чармайлтуудад гарамгай байхад бурханлигаар нөлөөлдөг байв. Бригам Янгийн Их Сургуулийг үндэслэн байгуулсны 100 жилийн ойн хүндэтгэн тэмдэглэх үед тэрээр, “Энэ Их Сургуулиас болон Сүмийн Боловсролын Системээс хоёулангаас нь жүжиг, утга зохиол, хөгжим, уран баримал, уран зураг, шинжлэх ухааны гялалзах одод, мөн тэрчлэн эрдэм мэдлэгийн бүхий л эрхэм чанар нь ундран гарах болно гэдэгт би итгэж мөн хүсэн хүлээж

байдаг билээ”¹⁰ гэжээ. Бусад үйл явдлуудаар тэр Хожмын Үеийн Гэгээнтэн зураачид сэргээгдсэн сайн мэдээний түүхийг хүчирхэг хийгээд итгүүлэн үнэмшүүлэгч байдлаар өгүүлэх болно гэдэгт найддагаа илэрхийлсэн байлаа.

Ерөнхийлөгч Кимбалл өөрийн маш шахуу ажлын хуваарийг үл харгалзан, бусдад ямагт хайр хийгээд үйлчлэлээр хүрдэг байлаа. Хойд болон Өмнөд Америк дахь Америкийн уугуул хүмүүс, түүнчлэн Полинезийн арлуудын хүмүүсийн хувьд түүнд өвөрмөц мэдрэмж байсан бөгөөд тэдэнд туслах янз бүрийн хүч чармайлтуудад тэрээр олон цаг зарцуулдаг байв. Тэднийг харж хандаж байх талаар өөрт нь заавар өгдөг байсан Ерөнхийлөгч Жорж Албертаас тэр адислал хүлээж авсан юм, тэрчлэн тэрээр Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд сайн мэдээг номлохын төлөө Төв болон Өмнөд Америкийн нутгуудыг онцгойлон адислах буюу дахин онцгойлон адислахыг Арванхоёрын Чуулгын гишүүдэд даалгадаг байв. Тэр үеэс хойш Төв болон Өмнөд Америк даяар хэдэн арван мянган хүмүүс сайн мэдээний адислалуудад баяр баясал эдэлсэн билээ.

Бүх хүмүүст санаа тавих нь түүний хэвийн шинж чанар байсныг түмэн хүн бужигнасан онгоцны буудал дээр хоёр настай охинтой нэг залуу ээж, муу цаг агаарт хавчигдан, хүрэх газрынхаа нислэгийн тийз олж авахаар дараалалд зогсож байхад болсон үйл явдал харуулжээ. Тэр эмэгтэй жирэмслээд хоёр сар болж байсан бөгөөд ядарч туйлдан, өлсгөлөн бяцхан хүүхдийг авч явж болохгүй гэж эмч нар шаардсан байжээ. Уйлж байгаа түүний хүүхдийн талаар хэд хэдэн хүн дургүйцэн шүүмжилсэн атал хэн ч түүнд туслая гэсэнгүй. Тэгээд тэр эмэгтэй хожим нь өгүүлэхдээ:

“Бидний урдаас нэг хүн хүрч ирээд ялдамхан инээмсэглэж, ‘Танд туслахын тулд миний хийж чадах ямар нэг зүйл байна уу?’ гэж хэлэв. Би талархалтайгаар санаа алдаж түүний санал болгосныг хүлээн авав. Тэр эхэр татан уйлж байгаа миний бяцхан охиныг хүйтэн шалан дээрээс өргөж аваад, нурууг нь аяархан илж, хайраар түүнийг өөр рүүгээ тэвэрлээ. Бохь захилах уу гэж тэр охиноос минь асуув. Охиныг тайвшрахад

тэр түүнийг аваад миний өмнө дараалалд зогсож байсан хүмүүст ямар нэг юм хэлсэн нь тэдний туслалцаа надад хэрэгтэй байна гэсэн бололтой. Тэд зөвшөөрөв бололтой, тэр тийзний лангуу руу дарааллын өмнө тал дахь хүрч очин удахгүй явах нислэгт намайг оруулж өгөх талаар тийзийн ажилтантай зохицуулж өгөв. Тэрээр бидэнтэй хамт вандан сандал руу хүрч очин, одоо намайг дажгүй гэж тэрээр итгэтэл бид тэнд хэсэгхэн зуур ярилцав. Тэр хүн өөрийнхөө замаар яваад өгсөн. Долоо хоногийн дараа би Төлөөлөгч Спенсер В.Кимбаллын зургийг харж, тэр бол нөгөөх нисэх онгоцны буудал дээр тааралдсан хүн болохыг таньж билээ”¹¹ гэжээ.

Ерөнхийлөгч Кимбалл таалал төгсөхөөсөө хэдэн сарын өмнө эрүүл мэндийн ноцтой асуудалд нэрвэгдсэн боловч хүнд сорилттой тулгарсан үед тэсвэр, тэвчээр хатуужил, хичээнгүй зүтгэлийн үлгэр жишээ ямагт болдог байлаа. Сүмийн Ерөнхийлөгчөөр 12 жил үйлчилсний дараа тэрбээр 1985 оны Арваннэгдүгээр сарын 5-нд таалал төгсчээ.



Дэлхий даяарх хүмүүс Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авснаар тэд ариун нандин ёслолуудын адислалуудыг хүлээн авах боломжтой болдог.

Өнөө Үеийн Сүм

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон

Спенсер В.Кимбаллыг таалал төгссөний дараа Эзра Тафт Бенсон Сүмийн Ерөнхийлөгч болов. Түүний удирдлагын эхэн үед тэрээр Мормоны Номыг уншиж, судлахын чухал ач холбогдлыг онцгойлон анхаарч байв. “Мормоны Ном хүмүүсийг Христэд авчирдгийг,” мөн энэ ном “манай шашны тулгуурын чулуу, мөн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой”¹ гэсэн Иосеф Смитийн нотолгоог давхар баталдгийг тэрээр гэрчилжээ.

1986 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Бенсон: “Сүмийг санхүүгийн боолчлолоос гэтэлгэхийн тулд аравны нэгийн зарчимд дахин онцгой анхаарал хандуулахад Их Эзэн Өөрийн үйлчлэгч Лорензо Снөүд бурханлигаар нөлөөлсөн юм. . . . Эдүгээ, манай өнөө үед Мормоны Номонд дахин онцгой анхаарал хандуулах хэрэгцээг Их Эзэн илчлээд байна. . . . Хэрэв бид үүний хуудсуудаас өдөр бүр балгаж, үүний зааврыг мөрдөх юм бол Бурхан Сионы болон Сүмийн хүүхэд бүр дээр өдийг хүртэл мэдэгдээгүй адислалыг юүлэх болно гэдгийг би энэ хормоос эхлэн та нарт амлаж байна”² хэмээн мэдэгджээ. Дэлхий дахины сая сая хүмүүс сорилтыг, мөн амлагдсан адислалуудыг хүлээн авсан юм.

Өөр нэг гол сэдэв бол бардамналаас зайлсхийхийн ач холбогдол юм. 1989 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр тэрээр “бардамналыг байлдан дагуулах замаар дотор талынхаа савыг цэвэршүүлэхийг” Сүмийн гишүүдэд уриалсан нь Нифай үндэстэн устгагдсан учир шалтгааныг тэрээр сэрэмжлүүлсэн

хэрэг байлаа. “Бардамналаас хамгаалах ерөндөг нь (хэрэгсэл) даруу байдал—номхон дөлгөөн байдал, захирагддаг чанар мөн”³ гэж тэрээр зөвлөжээ.

Эзра Тафт Бенсон Арванхоёрын Чуулгын гишүүнээр үйлчилж байхдаа сайн мэдээгээр амьдрахын үлгэр жишээ байх ер бусын боломжтой байжээ. 1952 онд тэрээр Ерөнхийлөгч Давид О.МакКейн дэмжлэгээр Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Двайт Д.Эйзенхауерын удирдлага дор Хөдөө Аж Ахуйн Нарийн бичгийн даргын томилолт хүлээн авчээ. Энэ бол Сүмийн түүхэнд Арванхоёрын Чуулгын гишүүн Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн кабинетад алба хашсан цорын ганц тохиолдол байв. Энэхүү албыг хашсан найман жилийн хугацаанд тэр өөрийн ёс суртахууны эрхэм чанар, Нэгдсэн Улсын засгийн газрын хөдөө аж ахуйн бодлогыг удирдан, хэрэгжүүлэхэд харуулсан мэргэжлийн мэдлэгээрээ эх орондоо болон гадаадад өндөр хүндэтгэл хүлээсэн юм. Тэрээр улс орнуудын удирдагчидтай хэлхээ холбоо тогтоож, дэлхий дахинд Сүмийн төлөөлөгчдөд үүд хаалгыг нээж өгсөн билээ.

Сүм Ерөнхийлөгч Бенсоны удирдлагаар дэлхий дахинд чухал амжилт гаргасан юм. 1987 оны Наймдугаар сарын 28-нд тэрээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Германы Франкфуртын Ариун Сүмийг онцгойлон адисалсан нь түүний хувьд утга учир бүхий онцгой боломж байв, учир нь тэрээр 1964–өөс 1965 онуудад Европын номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байх үед түүний төв байр Франкфуртэд байрлаж байжээ.

Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс дахь Германы Фрейбергийн Ариун Сүм 1985 оны Зургадугаар сарын 29-нд онцгойлон адислагдав. Энэхүү онцгойлон адислалтын дараа ариун сүмийг баригдах боломжтой болгосон нилээд хэдэн гайхамшиг тохиосон ажээ. Арванхоёрын Чуулгын Ахлагч Томас С.Монсон 1968 онд Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад анх удаа айлчлахдаа: “Хэрэв та нар Бурханы зарлигуудад үнэнч итгэлтэй хэвээр үлдэх юм бол, аливаа бусад оронд Сүмийн аль ч гишүүний эдэлдэг адислал бүр та нарынх байх болно” хэмээн



Ахлагч Рассел М.Нелсон 1991 оны Зургадугаар сарын 24-нд болсон төрийн хүлээн авалтын зоог дээр Оросын Холбооны Улсын дэд ерөнхийлөгчтэй хамт байгаа нь. Сар гаруйн өмнө Сүм бүгд найрамдах улс даяар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн гэж дэд ерөнхийлөгч мэдээлжээ.

Гэгээнтнүүдэд амлажээ. 1975 онд Ахлагч Монсон мөн энэ оронд томилолтоор ирсэн үедээ, “Аав аа, энэ нутаг дахь Таны сүмийн гишүүдийн хувьд энэ нь шинэ үеийн эхлэл байх болтугай” гэж хэлэн, энэ нутгийг Их Эзэнд Сүнсээр онцгойлон адислах сэтгэгдэл төржээ. “Ариун сүмүүдийн адислалуудыг хүртэх” Гэгээнтнүүдийн чин зүрхний хүсэл гүйцэлдсэн байхыг тэрээр гуйжээ. Бурханлигаар нөлөөлөгдсөн түүний амлалт, онцгойлон адислалтын бошиглолын залбирал хэрэгжсэн билээ.⁴

1989 оны Гуравдугаар сарын сүүлчийн өдөр Хожмын Үеийн Гэгээнтэн номлогч нарыг Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад орохыг зөвшөөрсөн юм. 1989 оны Арваннэгдүгээр сарын 9-нд зүүн, баруун Европын хоорондох саад тотгор арилж эхлэхэд олон Гэгээнтнүүдийн итгэл, залбирлууд

хариулагдсан нь хөрвөгчдийн баптисмууд нэмэгдэж, Сүмийн барилгууд баригдахад хүргэсэн билээ. Нэгэн хөрвөгч 1990 оны Тавдугаар сарын 1-нд Германы Дрезденд шинээр баригдаж дууссан шүтээний байрын нээлтийн ёслолд очоод Сүмийн тухай анх удаа мэдсэн ажээ. Долоо хоног хүрэхгүй хугацааны дараа, тэрээр номлогчийн хичээлүүдийг хүлээн авсны дараа баптисм хүртэж, Мормоны номыг хоёр удаа эхнээс нь эцсийг хүртэл уншиж, тэгээд сайн мэдээний үнэний тухай хүчирхэг гэрчлэлтэй болжээ.⁵

1991 оны Зургадугаар сарын 24-нд Москвад Мормоны Табернеклын Найрал Дууны концертын дараа болсон хүлээн авалт дээр Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Оросын Холбооны Улсын дэд ерөнхийлөгч улс оронд нь Сүм албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг мэдэгдэв. Энэ нь энэ том бүгд найрамдах улс даяар цулаануудыг бий болгох боломжийг Сүмд олгосон юм. 1990-ээд оны үед хуучин Зөвлөлтийн нилээд хэдэн бүгд найрамдах улс, төв болон зүүн Европын орнууд, түүний дотор Албани, Армен, Беларус, Болгар, Эстони, Унгар, Латви, Литви, Румын, Орос, Украин сайн мэдээний номлолын төлөө онцгойлон адислагдсан байлаа. Эдгээр орон тус бүрт Сүмийн барилга байгууламжууд түрээслэгдэх буюу баригдан, олон хүмүүс сайн мэдээний үнэний тухай гэрчлэлүүдтэй болж байлаа. Дэлхийн II Дайны өмнөх үеэс хойш Польшид Хожмын Үеийн Гэгээнтний анхны цуглааны байрыг онцгойлон адислахад Арванхоёрын Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон тус цуглааны байр нь “зовлон зүдгүүр тохиолдсон бодгалиудад амар амгалангийн хоргодох газар, зөв шударга ёсны төлөө өлсөж, цангадаг хүмүүсийн хувьд амрах газар нь болж үйлчлэхийн тулд”⁶ залбирсан ажээ. Сайн мэдээний амар амгалан хийгээд баяр хөөрийг олсон олон орон дахь Гэгээнтнүүдийн амьдралд энэ адислал хэрэгжиж байна.

Сүмийн гишүүнчлэлийн агуу өсөлтийн, түүнчлэн Ерөнхийлөгч Бенсон номлолын ажилд онцгой анхаарсны үр дүнд, түүний удирдлагын төгсгөлд бараг 48 000 номлогч Сүмийн 295 номлолд үйлчилж байв.

Бас түүний удирдлагын үед Сүмийн халамжийн хөтөлбөр дэлхий даяарх ондоо сүсэг бишрэлийн гишүүдэд хүмүүнлэгийн тусламж болгон, өсөн нэмэгдсэн өргөлийг эхлэв. Энэхүү тусламжийг зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх болон удаан хугацааны бие даан амьдрах чадварыг хөхүүлэн дэмжихэд олгодог. Үлэмж их хэмжээний хүнс, хувцас, эмнэлгийн хэрэгсэл, хөнжил, бэлэн мөнгө болон бусад зүйлүүдийг гачигдалтай хүмүүст хуваарилан тарааж, урт хугацааны төслүүдээр эрүүл мэндийн үйлчилгээ, бичиг үсэгт сургах болон бусад үйлчлэлүүдийг үзүүлж байна. Нинжин сэтгэлийн энэхүү үйлчлэл өнөөдөр дэлхийн олон хэсэгт, мянга мянган хүнд хүрч байна.

Насны доройтол болон хайрт гэргий Флорагаа алдсанаар зовлон шаналалд унасан Ерөнхийлөгч Бенсон 1994 оны Тавдугаар сарын 30-нд 94 настайдаа, Их Эзэний бошиглогчийн үүрэг зорилгоо эрэлхэг зоригтойгоор дуусгаад, таалал төгсчээ. Тэр үед Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч асан Ховард В.Хантер түүнийг залгамжлав.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер

1994 оны Зургадугаар сарын 6-нд өөрийн анхны хэвлэлийн бага хурал дээр Ерөнхийлөгч Ховард В.Хантер өөрийн удирдлагын чухал сэдвүүдээс заримыг нь үндэслэн бий болгожээ. “Их Эзэн Есүс Христийн амьдрал, үлгэр жишээнд, ялангуяа Түүний харуулсан тэрхүү хайр, найдвар хийгээд нинжин сэтгэлд хэзээ хэзээнийхээс илүү анхаарал тавьж амьдрахад би Сүмийн бүх гишүүдийг урьж байна” гэж тэрээр хэлжээ.

“Бид бие биендээ илүү өрөвч сэтгэлээр, илүү эелдэг уриалгахан, илүү даруу хийгээд тэвчээртэй, бас уучлалаар хандаж байхын төлөө би залбиръя.”

Тэрээр бас “Их Эзэний ариун сүмийг өөрсдийн гишүүнчлэлийн хийгээд өөрсдийн хамгийн ариун гэрээнүүдийн тэнгэрлэг чанарын агуу бэлэгдэл болгон үндэслэн байгуулахыг Сүмийн гишүүдээс хүсчээ. Сүмийн гишүүн бүр ариун сүмд орохуйц зохистой байх нь миний сэтгэл зүрхний хамгийн гүн гүнзгий хүсэл байх болно.”⁷ Сүмийн олон мянган гишүүн эд-

гээр захиасуудыг амьдралдаа хэрэгжүүлж, агуу гүнзгий сүнс-лэг байдлаар адислагдсан билээ.

Ерөнхийлөгч Хантер хурц хөгжсөн ухаантай байсан нь Сүмд агуу үнэ цэнэтэй байлаа. 1970-аад оны сүүлчээр түүний бүх ур чадваруудыг шаардсан томилолтыг тэрээр хүлээн авсан юм. Ариун Нутаг дахь Сүмийн гол барилга—Бригам Янгийн Их Сургуулийн Ойрхи Дорнод Судлалын Иерусалим дахь Төвийн барилгын газар олж авах хэлэлцээр хийх болон барилгад хяналт тавихад тэрээр чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. Энэ төв Чидуны Уулын нэг салбар Скопу Уулан дээр байрладаг. Сонгогдсон энэ нутаг, түүнчлэн үүний хүмүүс (Иудейчүүд болон Арабчууд гэхчлэн), мөн Есүс Христ болон түүний эртний бошиглогчид алхалж явсан газруудын талаар гүнзгий судалгаа хийдэг оюутнуудын хувьд энэ төв оршин суух болон судалгааны үйл ажиллагааных нь газар юм. Энэ төв дотор нь сурдаг хүмүүсийн хувьд адислал болсоор ирсэн бөгөөд үүний үзэсгэлэн төгөлдөр нь энд ирсэн олон хүмүүст бурханлигаар нөлөөлдөг билээ.

Ерөнхийлөгч Хантер бас Хавайн Хавай Лейе дэх Бригам Янгийн Их Сургуулийн хажууд байдаг Полинезийн Соёлын Төвийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. Тэрээр Сүмийн эзэмшиж, ажиллуулдаг 42 акр талбайтай айлчлагчдын энэ төвийн зөвлөлийн үндэслэгч дарга байсан юм. Төвийн зорилго нь Полинезийн соёлыг хамгаалж, оюутнуудыг ажлаар хангах явдал мөн. 1963 онд баригдсан энэ төвд эдүгээ жил бүр бараг сая хүн ирж, Полинезийн арлуудын хөгжим, бүжиг, урлаг, гар урлалыг үзэж сонирхдог.

Ахлагч Хантер Сүмийн Ерөнхийлөгч болохоосоо өмнө өнөөдрийн Гэр Бүлийн Түүхийн Газрын өмнө нь байсан Ютагийн Угийн Бичгийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгчөөр найман жил үйлчилжээ. Энэ үед тус нийгэмлэг 1969 онд болсон Дэлхийн Бүртгэлийн Чуулганыг ивээн тэтгэсэн бөгөөд тэр хэлэхдээ, “энэ нь Сүмийн хувьд нэн их сайн санааг бий болгож, бүх дэлхийд бидний ажилд үүд хаалгыг нээсэн юм”⁸ гэжээ. Амьд байгаа болон нас барсан бүх



Иерусалим дахь Оорсон Хайдын Дурсгалын Цогцолборыг Онцгойлон Адисалсан нь.

хүмүүсийг хайрлах агуу хайрыг тэрээр хөгжүүлж, бид бол нэг агуу их гэр бүлийн хэсэг хэмээн олонтаа заадаг байлаа. Тэрбээр Христийнхтэй адил хайрыг эзэмшсэн хүн байснаараа нэрд гарсан ажээ.

Ерөнхийлөгч Хантер бүх амьдралынхаа туршид олон бэрхшээлтэй тулгарч байв. Тэрээр эрүүл мэндийн ноцтой, хүнд бэрх асуудлуудтай итгэл хийгээд тэсвэр хатуужил нүүр тулан учирч, анхных нь эхнэр доройтон удаан хугацаагаар өвчилж, өөд болсон хийгээд бусад бэрхшээл хүндрэлүүд дундуур туулан гарсан юм. Эдгээр саад тотгоруудыг эс хайхран, тэрээр Их Эзэнд идэвхтэй үйлчилж, их аялж, Сүмийн ажил хэргүүдийг удирдахад шаргуу ажиллаж байлаа. “Хэрэв хүүхдүүд чинь замаа алдаж байгаа асуудал танд гэр оронд чинь байгаа бол, хэрэв та санхүүгийн уруудал болон гэр орон болон аз жаргалд чинь заналхийлэгч сэтгэл санааны дарамтад орсон бол, хэрэв амьдрал, эрүүл мэндээ алдах аюул танд учирсан бол, бодгальд чинь амар амгалан байг. Бидний тэсч чадах чадвараас гадуур бид сорилтод орох нь үгүй. Бидний тойруу зам болон сэтгэлийн гунихрал бол Түүнд хүрэх шулуун бөгөөд нарийн зам мөн”⁹ түүний захиастай түүний үлгэр жишээ дүйдэг байв.

Сүмийн түүхэн дэх хөгжлийн нэг чухал үе болсон Сүмийн 2000 дахь гадсыг 1994 оны Арванхоёрдугаар сарын 11-нд Мексикийн Мексико Хотод байгуулагдахад Ерөнхийлөгч Хантер тэргүүлэн удирдсан юм. Цугларагсдад хандаж тэрээр хэлэхдээ: “Их Эзэн Өөрийн үйлчлэгчдээр дамжуулан энэхүү гайхамшгийг тохиолгон авчирлаа. Энэ ажил хүч чадал хийгээд амьдрах чадварт урагшлахаа үргэлжлүүлэх болно. Эцэг Лихай болон түүний хүүхдүүдэд тэдний үр удмын тухай өгөгдсөн амлалтууд Мексикт гүйцэлдэн, мөн үргэлжлэн гүйцэлдэж байна”¹⁰ гэжээ. Ерөнхийлөгч Хантер Ерөнхий Эрх Мэдэлтнээр үйлчилж байх үед Латин Америк дахь Сүм эрс түргэн өссөн юм. Түүнийг Сүмийн Ерөнхийлөгч болох үед Мексик, Бразил, Чилид 1.5 сая гаруй Хожмын Үеийн

Гэгээнтэн байсан нь тэр үед Ютад амьдарч байсан Сүмийн гишүүдээс олон байлаа.

Ерөнхийлөгч Хантер хэдийгээр Сүмийн Ерөнхийлөгчөөр ердөө есхөн сар үйлчилсэн хэдий ч, нинжин сэтгэл, гэсвэр хатуужил хийгээд Христийнхтэй адил амьдралынх нь гарамгай үлгэр жишээнийх нь төлөө түүнийг дурсан санадаг Гэгээнтнүүдэд хүчтэй нөлөө үзүүлсэн билээ.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли

Ерөнхийлөгч Хантерыг таалал төгссөний дараа Гордон Б.Хинклиг Сүмийн Ерөнхийлөгч болоход түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гол анхаарах зүйл юу байхыг түүнээс асуужээ. “Үргэлжлүүлэх. Тийм ээ, үнэнхүү биширмээр (үнэнхүү итгэлтэйгээр, мөн үнэнхүү сайнаар үйлчилж асан бидний өмнөх залгамжлагчдын урагш ахиулсан агуу ажлыг үргэлжлүүлэх нь бидний зорилго мөн. Тийм ээ, гэр бүлийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх. Тийм ээ, боловсролд түлхэц өгөх. Тийм ээ, газар бүрийн хүмүүсийн дунд хүлээцтэй байдал, хүлцэнгүй чанарын сүнсийг төлөвшүүлэх. Мөн Есүс Христийн сайн мэдээг тунхаглах”¹¹ гэж тэрээр хариулсан ажээ.

Сүмийн удирдлагын талаарх Ерөнхийлөгч Хинклийн өргөн цар хүрээтэй туршлага түүнийг Ерөнхийлөгчийн Зөвлөлийн ажилд сайн бэлтгэсэн юм. Тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад 1961 онд дэмжигдэн батлагджээ. 1981 оноос эхлэн тэрээр Сүмийн гурван Ерөнхийлөгч—Спенсер В.Кимбалл, Эзра Тафт Бенсон, Ховард В.Хантер нарын Ерөнхийлөгчийн Зөвлөлд Зөвлөхөөр үйлчилсэн ажээ. Энэ жилүүдэд эдгээр Ерөнхийлөгчид насны доройтлоор зовон шаналж байсан үед тэрээр ер бусын хүнд үүрэг хариуцлагуудыг үүрч байсан юм.

Залуу Гордон Б.Хинкли Англид номлолд байхдаа, хүнд бэрх үүрэг хариуцлагын жилүүдийн туршид түүнд сайнаар үйлчилсэн зарим зөвлөгөө хүлээн авчээ. Тэрээр ямар нэг хэмжээгээр урам нь хугарсан үед, “Би өөрийнхөө цагийг бас таны мөнгийг үрж байна. Би энд байгаагийнхаа утга учрыг

олж харахгүй байна” гэж тэр хэлэн аавдаа захидал бичжээ. Хэсэг хугацааны дараа, “Эрхэм Гордон. Би чиний захидлыг авлаа Би ердөө ганцхан зөвлөгөө өгье. Өөрийгөө мартаж, тэгээд ажиллахаар яв. Хайраа дэвшүүлсэн Аав чинь” хэмээн өгүүлсэн товчхон захидлыг тэр ааваасаа хүлээн авчээ.

Ерөнхийлөгч Хинкли тэр үеийн тухай: “Би үүнийг тунгаан бодов, тэгээд маргааш өглөө нь бид судрын хичээл дээрээ: “Учир нь хэн өөрийн амийг аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана, харин хэн миний төлөө, сайн мэдээний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ аварна” (Марк 8:35) гэсэн Их Эзэний агуу нотолгоог уншиж билээ. Энэ нь надад нөлөөлөв. Тэрхүү нотолгоо, тэрхүү амлалт, аавын минь захидалтай нийлээд, намайг шатаар дээш өгсөн, . . . өвдөг дээрээ сөгдөж, би өөрийгөө мартахыг хичээж, ажиллахаар явах болно хэмээн Их Эзэнтэй гэрээ хийхэд намайг өдөөв. Үүнийг би өөрийнхөө амьдралд шийдвэр гаргасан өдөр гэж тооцдог билээ. Тэр үеэс хойш надад тохиолдсон сайн сайхан юм бүрийг би, тэр үед гаргасан шийдвэртэй холбож үздэг.”¹²

Ерөнхийлөгч Хинкли бол гандан бууршгүй өөдрөг үзэлтэй, Бурханд болон ирээдүйд итгэх итгэлээр ямагт дүүрэн байдгаараа нэрд гарсан хүн юм. “Юмс шийдвэрлэгдэнэ. Үргэлж хичээж бай. Итгэлтэй бай, Баяртай бай. Санаагаар бүү уна. Юмс шийдвэрлэгдэнэ”¹³ гэсэн үгс Ерөнхийлөгч Хинклийн гэр бүлдээ, найз нөхөддөө түүнчлэн таньдаг хүмүүстээ дахин давтан өгүүлдэг хамгийн итгэл үнэмшилтэй нотолгоо юм.

Сүмд тулгарч байгаа хамгийн том бэрхшээлийг мэдэхийн тулд сурвалжлагч түүнээс асуухад тэрээр, “Бидэнд тулгарч байгаа хамгийн ноцтой бэрхшээл, түүнчлэн хамгийн гайхамшигтай бэрхшээл бол өсөлтөөс үүдэлтэй бэрхшээл юм” гэж хариулжээ. Өсөлт нэмэгдэж байгаа нь улам олон барилга байшин, түүний дотор ариун сүмүүдийн хэрэгцээг бий болгож байгааг тэрээр тайлбарлан: “Энэ бол ариун сүм барихын хувьд Сүмийн түүхэн дэх хамгийн агуу үе мөн. Эдүгээ урагш ахиж байгаа ариун сүмүүдийн барилгын ажил хэзээ ч ийм

аварга цар хүрээгээр урагш ахиж байсангүй. Үйл ажиллагаа явуулж байгаа 47 ариун сүм бидэнд байна. Барилгын явцад зургийн төслийг нь хэрэгжүүлж байгаа өөр 13 ариун сүм бидэнд байна. Бид ариун сүмүүд барихаа үргэлжлүүлэх болно”¹⁴ гэж гэж хариулжээ. Сүмийн өсөлт нэмэгдсэн нь бас Мормоны Номыг олон хэлэнд орчуулах явдлыг зайлшгүй чухал болгосон юм.

Сүмийн эрчимтэй өсөлтийн тухайд Ерөнхийлөгч Хинклид хувийн туршлага бий. 1967 онд Японы Осакад чуулганд оролцож байхдаа тэрээр, олон залуу хүмүүс оролцсон сонсогчдыг гүйлгэн харснаа: “Япон дахь Сүмийн ирээдүйг би та нарын дотор харж байна. Бас би агуу ирээдүйг харж байна. Бид дөнгөж гадаргууд нь хүрч байна. Гэвч энэ агуу нутагт Сионы гадсууд бий болох тэр өдөр холгүй байгааг би их эртнээс мэдэрдэг байснаа хэлье гэж надад бодогдлоо”¹⁵ гэж хэлжээ. Нэг үеийнхний хугацаанд Японд 100 000 Хожмын Үеийн Гэгээнтэн, олон гадас, номлол, дүүрэг, мөн нэг ариун сүм бий болсон ажээ.

1973 онд Манилд анхны гадас зохион байгуулагдсан Филиппин дахь Сүмийн өсөлтийг Ерөнхийлөгч Хинкли бас их сонирхдог байлаа. Хорин жилийн дараа, түүнийг Сүмийн Ерөнхийлөгч болсон үед сайн мэдээний адислалуудыг, түүний дотор улс орон дахь нэг ариун сүмийг Филиппиний 300 000 гаруй гишүүд хүлээн авсан байлаа. Азийн бусад хэсгүүд, түүний дотор Солонгос, Хятад, Зүүн Өмнөд Ази дахь Сүмийн өсөлтөд Ерөнхийлөгч Хинкли асар их санаа тавьсан юм.

Филиппиний нэг гадсанд гадасны шинэ ерөнхийлөгч дуудахаар томилогдсон нэг Ерөнхий Эрх Мэдэлтний туршлага Ази дахь олон гишүүний сүнслэг байдлын нотолгоо болсон билээ. Нилээд хэдэн санваартан ах нартай ярилцлага хийсний дараа хорь гаруй насны нэг хүнийг гадасны ерөнхийлөгчөөр дуудах санаа түүнд төржээ. Тэрээр нөгөөх залуу ахыг зэргэлдээ өрөөнд орж, зөвлөхүүдээ сонгож авахад хэсэгхэн цаг гаргана уу гэж хүсэв. 30 секундын дараа нөгөөх ах эргэж ирэв. Ерөнхий Эрх Мэдэлтэн түүнийг буруу ойлгосон юм болов уу гэж бод-

тол, гадасны шинэ ерөнхийлөгч, “Үгүй ээ. Их Эзэний Сүнсээр дамжуулан би гадасны ерөнхийлөгч болохоо сарын өмнө мэдсэн юм. Би зөвлөхүүдээ аль хэдийн сонгочихсон” гэж хэлжээ.

Дэлхий даяар Сүмийг байгуулахад туслахын тулд өдий ихийг хийсэн Ерөнхийлөгч Хинкли өөрийн удирдлагын үед: “Хэрэв одоогийн хандлага хэвээр үргэлжлэх юм бол 1996 оны Хоёрдугаар сарын орчим, одоогоос ердөө хэдхэн сарын дараа Нэгдсэн Улсын гадна Нэгдсэн Улсад байгаагаас илүү олон Сүмийн гишүүд байх болно. Энэ шугамыг давах нь гайхамшигт ач холбогдолтой зүйл. Энэ бол агуу их ажлын үр жимс юм”¹⁶ гэж зарлан мэдэгдэх боломжтой болсон билээ.

Ерөнхийлөгч Хинклийн удирдлагын гол анхаарал тавьдаг зүйл бол, ялангуяа гэр бүлийн үнэт зүйлсийг дэмждэггүй нь олонтаа тохиолддог дэлхий дэх сайн гэр бүлийн амьдралын ач холбогдол юм. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Зөвлөл түүний удирдлагаар, гэр бүлийн сэдвээр дэлхийд тусгай тунхаг гаргасан бөгөөд үүний нэг хэсэгт:

“Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахьдаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн заадаг зүйлүүдэд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. . . .

“Ариун явдлын гэрээнүүдээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүмүүс хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэхээр зогсох болно гэдгийг бид анхааруулж байна. Түүнчлэн, гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүмүүс, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид анхааруулж байна”¹⁷ хэмээн мэдэгджээ.

Ерөнхийлөгч Хинкли 1995 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы үеэр, 1995 оны Наймдугаар сарын 15-наас эхлэн маш сайн үйлчилсэн Сүмийн бүс нутгийн төлөөлөгчид чөлөөлөгдөж, Бүсийн Эрх Мэдэлтэн гэдэг шинэ албан тушаал бий

болно гэдгийг зарлан мэдэгджээ. Бүсийн Эрх Мэдэлтнүүд гадасны чуулганууд дээр тэргүүлдэг; гадсуудыг дахин зохион байгуулах буюу шинээр бий болгодог; гадас, номлол болон дүүргийн ерөнхийлөгчдөд зориулан сургалт явуулдаг; мөн Тэргүүн Зөвлөл болон өөрсдийнх нь Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс өгсөн бусад ажил үүргүүдийг биелүүлдэг. Энэ шинэ албан тушаал нь өөрсдийн үйлчилдэг хүмүүстэй илүү ойр дөт амьдарч, ажиллах болон дэлхий даяар барилга байгууламжуудыг өгсөн нэмэгдүүлэх боломжийг Сүмийн удирдагчдад олгож байна.

Гэгээнтэн бүр Ерөнхийлөгч Хинклийг хичнээн сайнаар дэмждэгийг нэг Ерөнхий Эрх Мэдэлтэн тайлбарлан: “Өөрийнхөө дуудагдсан—бошиглогч, үзмэрч, илчлэгч, Тэргүүлэгч Дээд Санваартан болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгчийн ариун албан тушаалыг тэрээр авсан үед . . . бидний хийж болох хамгийн сайн зүйл бол түүнийг албан тушаалд нь ‘үргэлжлүүлэх, үргэлжлүүлэх, үргэлжлүүлэх’ явдал мөн”¹⁸ гэжээ.



“Бурханы үнэн тив болгонд нэвтэрч, . . . чих болгонд сонсогдох хүртэл зоримгоор, эрхэмсгээр түүнчлэн тусгаар байдалтайгаар урагш давших болно” гэсэн Иосеф Смитийн бошиглоглыг гүйцэлдүүлэхэд эдгээр номлогчид тусалж байна.

Төгсгөл

Бидний хүн нэг бүр Сүмийн түүхэнд байр сууртай байдаг. Зарим гишүүд хэдэн үеэрээ сайн мэдээг баяртай хүлээж авсан, хүүхдүүдээ Их Эзэний замуудаар өсгөн хүмүүжүүлсэн гэр бүлүүдэд төрсөн байдаг. Бусад нь сайн мэдээг анх удаа сонсож, баптисмын усанд орж, түүгээр Бурханы хаант улсын байгуулахад өөрсдийн хувь нэмрээ оруулахаар ариун гэрээнүүд хийсэн байдаг. Олон гишүүд Сүмийн түүхэн дэх өөрсдийнхөө эрин үеийг дөнгөж эхлэн, үр хүүхдүүдийнхээ хувьд итгэлийн өвийг бий болгож байгаа бүс нутгуудад амьдардаг. Бидний нөхцөл байдал ямар ч байлаа гэсэн бид бол Сионыг байгуулах зорилгын нэг амин чухал хэсэг бөгөөд Аврагчийн хоёр дахь ирэлтэд бэлтгэж байгаа билээ. Бид бол “цаашид харь хүмүүс болон гаднын хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм” (Ефес 2:19).

Бид шинэ гишүүд ч байна уу, хуучин ч байна уу ялгаагүй, өөрсдийнхөө өмнө байсан хүмүүсээс итгэл, золиослолын өвийг өвлөн авдаг. Бид бас өөрсдийнхөө хүүхдүүд болон Есүс Христийн сайн мэдээг хараахан сонсоогүй, бас хүлээж аваагүй байгаа Тэнгэрлэг Эцэгийн сая сая хүүхдүүдийн хувьд өнөө үеийн анхдагчууд билээ. Бид Их Эзэний ажлыг итгэлтэйгээр биелүүлснээр дэлхий даяар өөрсдийн хувь нэмрийг өөр өөр арга замуудаар оруулдаг.

Эцэг эхчүүд хүүхдүүдээ зөв шударга ёсны зарчмуудад залбиралтайгаар сургадаг. Гэрийн болон айлчлагч багш нар гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавьдаг. Сайн мэдээний захиасуудыг бусдад хүргэхийн тулд амьдралынхаа жилүүдийг зориулахаар сонгосон номлогч нарт гэр бүлүүд баяртай

гэж хэлдэг. Амь биеэ үл хайрлагч санваартны болон хавсралт байгууллагуудын удирдагчид үйлчлэх дуудлагуудад хариулдаг. Өвөг дээдсийнхээ нэрсийг эрж хайхад зориулагдсан тоолшгүй олон цагийн чимээгүй үйлчлэлийн тоо болон ариун сүмд ариун нандин ёслолуудыг гүйцэтгэхээр дамжин, амьд байгаа хүмүүс болон нас барагсдад адислалууд өгөгддөг.

Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хувь тавиланг гүйцэлдүүлэхийн тулд бид бүгд тусалдаг. 1842 онд тэрээр:

“Үнэний Жишиг тогтлоо; цэвэршигдээгүй гар уг ажлыг өсөлтөөс зогсоож чадахгүй; мөрдлөг хавчлага гаарч болно, танхайрагч бүлэг нэгдэж болно, армиуд цуглаж болно, гүтгэлэг нэр төрийг гутааж болно, гэвч Бурханы үнэн тив болгонд нэвтэрч, орон бүрт очиж, улс бүрт хүрэн, чих болгонд сонсогдох хүртэл, Бурханы зорилгууд хэрэгжих хүртэл, мөн уг ажил хийгдлээ гэж Агуу Их Иеховаг хэлэх хүртэл урагш зоримгоор, эрхэмсгээр түүнчлэн тусгаар байдалтайгаар урагш давших болно”¹ хэмээн бошигложээ.

Бошиглогч Иосеф Смитийг амьдарч байх үед Сүм хэдийгээр жижигхэн байсан ч гэсэн, энэ нь Есүс Христийн сайн мэдээний үнэнүүдээр бүх дэлхийг дүүргэх хувь тавилан бүхий газар дээрх Бурханы хаант улсын байсныг тэрээр мэдэж байсан юм. Ойрын жилүүдэд Сүм эрс хурдан өссөнийг бид харж байна. Үүрд мөнхөд орших хаант улс, Бурханы хаант улсыг байгуулахад туслахын тулд бид өөрсдийн итгэл хийгээд золиослолуудыг өргөн барьж болох үед амьдрах онцгой боломж бидэнд заяасан билээ.

Төгсгөл дэх Тэмдэглэл

ОРШИЛ

1. *History of the Church*, 3:30.
2. "Easter Greetings from the First Presidency," *Church News*, 1995 оны Дөрөвдүгээр сарын 15, 1.

БҮЛЭГ ХОЁР

1. Люси Мак Смит, *History of Joseph Smith* (1958), 128.
2. Reuben Miller Journals, 1848–49, 21 1848 оны 10-р сар; Түүхийн Газар, Архивын Хэлтэс, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм; үүнээс хойш ХҮГ Сүмийн Архив хэмээн иш татагдана; зөв бичгийн дүрэм болон цэг таслалыг шинэчлэв.
3. Дин Жессий, хянагч, "Joseph Knight's Recollection of Early Mormon History," *BYU Studies*, Autumn 1976, 36; зөв бичгийн дүрмийг шинэчлэв.
4. *History of the Church*, 5:124–25.
5. *The Saints' Herald*, 1882 оны Гуравдугаар сарын 1, 68.
6. *History of the Church*, 1:55.
7. "History of Brigham Young," *Millennial Star*, 1863 оны Зургадугаар сарын 6, 361.
8. Бригам Янг, in *Journal of Discourses*, 3:91.
9. "History of Brigham Young," *Millennial Star*, 1863 оны 7-р сарын 11, 438.
10. "Letter from Oliver Cowdery to W. W. Phelps," *Latter-day Saints' Messenger and Advocate*, 1835 оны 10-р сар, 199.
11. *History of the Church*, 1:78.
12. *History of the Church*, 1:78.
13. Люси Мак Смит, *History of Joseph Smith*, 168.
14. Дин Жессий, хянагч, "Joseph Knight's Recollection of Early Mormon History," 37; зөв бичгийн дүрмийг шинэчлэв.
15. *History of the Church*, 5:126.
16. *History of the Church*, 2:443.
17. "Conference Minutes," *Times and Seasons*, 1844 оны 5-р сарын 1, 522–23.
18. Joseph Knight Autobiographical Sketch, 1862; ХҮГ Сүмийн Архивт.
19. Ньюел Найт, Ларри Портер, "A Study of the Origins of The Church of Jesus Christ of Latter-day Saints in the States of New York and Pennsylvania, 1816–1831" (Ph.D. diss., Brigham Young University, 1971-ээс иш татав), 296.

20. *Broome Republican*, 1831 оны 5-р сарын 5; Ларри Портер, "A Study of the Origins of The Church of Jesus Christ of Latter-day Saints,"-ээс иш татав, 298–99; онцлон тэмдэглэлтийг нэмэв.
21. Люси Мак Смит, *History of Joseph Smith*, 204.

БҮЛЭГ ГУРАВ

1. Оорсон Ф.Витней, "Newel K. Whitney," *Contributor*, 1885 оны 1-р сар, 125.
2. Элизабет Анн Витней, Эдвард В. Тюллиж, *Women of Mormondom*-оос иш татав [1877], 42.
3. Оорсон Ф.Витней, Чуулганы Илтгэлд, 1912 оны 4-р сар, 50.
4. Бригам Янг, in *Journal of Discourses*, 11:295.
5. Оорсон Ф.Витней, "Newel K. Whitney," 126.
6. Жозеф Холбрук, Жеймс Л. Бадли, *Zion's Camp 1834: Prelude to the Civil War* (1990)-ээс иш татав, 33.
7. Жорж Алберт Смит, "History of George Albert Smith, 1834–1871," 17; ХҮГ Сүмийн Архивт.
8. *History of the Church*, 2:73.
9. *History of the Church*, 2:68.
10. Жозеф Янг Ахмад, *History of the Organization of the Seventies* (1878), 14.
11. Вилфорд Вудрафф, *Deseret News*, 1869 оны 12-р сарын 22, 543.
12. "Zera Pulsipher Record Book, 1858–1878," 5; ХҮГ Сүмийн Архивт.
13. "History of John E. Page," *Deseret News*, 1858 оны 6-р сарын 16, 69.
14. Оорсон Ф.Витней, *Life of Heber C. Kimball*, 3 дахь хэвлэл. (1945), 104.
15. Оорсон Ф.Витней, *Life of Heber C. Kimball*, 105.
16. Элиза Р.Снөү: *An Immortal* (1957), 54.
17. "Sketch of an Elder's Life," *Scraps of Biography* (1883), 12.
18. *History of the Church*, 2:430.
19. Даниел Тайлер, "Incidents of Experience," *Scraps of Biography*, 32.
20. Элиза Р.Снөү, Тюллиж, *Women of Mormondom*-оос иш татав, 95.

БҮЛЭГ ДӨРӨВ

1. Эмили М.Аустин, *Mormonism; or, Life Among the Mormons* (1882), 63.
2. Эмили М.Аустин, *Mormonism*, 64.
3. Иосеф Смит, *Latter Day Saints' Messenger and Advocate*, 1835 оны 9-р сар, 179.
4. Ларри К.Портер, "The Colesville Branch in Kaw Township, Jackson County, Missouri, 1831 to 1833," *Regional Studies in Latter-day Saint Church History: Missouri*, хянагч. Арнольд К.Гарр, Кларк В.Жонсон, (1994), 286–87.
5. *History of the Church*, 1:199.
6. Эмили М.Аустин, *Mormonism*, 67.
7. *Autobiography of Parley P. Pratt*, хянагч. Парли П.Пратт Бага, (1938), 72.
8. *History of the Church*, 1:269.
9. *Far West Record*, хянагч. Дональд К.Каннон, Линдон В.Кук (1983), 65.
10. "Newel Knight's Journal," *Scraps of Biography* (1883), 75.
11. Мэри Элизабет Роллинс Лайтнер, *Utah Genealogical and Historical Magazine*, 1926 оны 7-р сар, 196.
12. *History of the Church*, 1:391.

13. "Philo Dibble's Narrative," *Early Scenes in Church History* (1882), 84–85.
14. *Autobiography of Parley P. Pratt*, 102.
15. "Newel Knight's Journal," *Scraps of Biography*, 85.
16. Андрей Женсон, *The Historical Record* (1888), 7:586.
17. С ба Г 116:1; мөн С ба Г 107:53–57-г үз; *History of the Church*, 3:34–35.
18. Оорсон Ф.Витней, *Life of Heber C. Kimball*, 3 дахь хэвлэл. (1945), 213–14.
19. Леланд Хомер Жентри, "A History of the Latter-day Saints in Northern Missouri from 1836 to 1839," (Философийн Докторын диссертаци, Бригам Янгийн Их Сургууль, 1965), 419.
20. Аманда Барнес Смит, Эдвард В.Тюлиж, *Women of Mormondom*-оос иш татав [1877], 124, 128.
21. Аманда Барнес Смит, Тюлиж, *Women of Mormondom*-оос иш татав, 126.
22. Е.Дейл ЛеБарон, "Benjamin Franklin Johnson: Colonizer, Public Servant and Church Leader" (магистер хамгаалсан сэдэв, Brigham Young University, 1966), 42–43.
23. Леланд Хомер Жентри, "A History of the Latter-day Saints in Northern Missouri," 518.
24. *Autobiography of Parley P. Pratt*, 211.
25. "Copy of a Letter from J. Smith Jr. to Mr. Galland," *Times and Seasons*, 1840 оны 2-р сар, 52.
26. Лайман Омер Литтлфиелд, *Reminiscences of Latter-day Saints* (1888), 72–73.
27. *History of the Church*, 3:423.
28. Маттиас Ф.Каули, *Wilford Woodruff* (1909), 102.

БҮЛЭГ ТАВ

1. "Journal of Louisa Barnes Pratt," *Heart Throbs of the West*, ЭМХЭТГЭСЭН. Кейт Б.Картер, 12 боть. (1939–51), 8:229.
2. "Journal of Louisa Barnes Pratt," 8:233.
3. "Journal of Mary Ann Weston Maughan," *Our Pioneer Heritage*, ЭМХЭТГЭСЭН. Кейт Б.Картер, 9 боть. (1958–66), 2:353–54.
4. *History of the Church*, 4:186.
5. Люиза Деккер, "Reminiscences of Nauvoo," *Woman's Exponent*, 1909 оны 3-р сар, 41.
6. "The Mormons and Indians," *Heart Throbs of the West*, 7:385.
7. Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 2:472.
8. *History of the Church*, 5:2.
9. Minutes of the Female Relief Society of Nauvoo, 1842 оны 4-р сарын 28, 40.
10. Minutes of the Female Relief Society of Nauvoo, 1842 оны 4-р сарын 28, 33.
11. "Journal of Louisa Barnes Pratt," 8:231.
12. *History of the Church*, 4:587, 604; 6:558.
13. *History of the Church*, 6:555.
14. Кеннет В.Годфри, "A Time, a Season, When Murder Was in the Air," *Mormon Heritage*, 1994 оны 7, 8-р сар, 35–36.
15. *History of the Church*, 6:601.
16. Маттиас Каули, "Reminiscences" (1856), 3; ХҮГ Сүмийн Архивт.

17. Томас Форд, *A History of Illinois*, хянагч. Milo Milton Quaife, 2 боть. (1946), 2:217.
18. Томас Форд, *A History of Illinois*, 2:221–23.
19. *History of the Church*, 7:230.
20. *History of the Church*-өөс иш татав 7:236.
21. *History of the Church*-өөс иш татав 7:236.
22. *History of the Church*-өөс иш татав 7:236.

БҮЛЭГ ЗУРГАА

1. Жоанита Брукс, хянагч, *On the Mormon Frontier: The Diary of Hosea Stout*, 2 vols. (1964) 1:114; зөв бичгийн дүрэм ба цэг таслалыг шинэчлэв.
2. Жоанита Брукс, *On the Mormon Frontier*, 1:117; зөв бичгийн дүрэм ба цэг таслалыг шинэчлэв.
3. Жеймс Б.Аллен, *Trials of Discipleship: The Story of William Clayton, a Mormon* (1987), 202.
4. Рассел Р.Рич, *Ensign to the Nations* (1972), 92.
5. *Readings in LDS Church History: From Original Manuscripts*, хянагч. Виллям Е.Берретт болон Алма П.Бортон, 3 боть. (1965), 2:221.
6. Жеймс С.Браун, *Giant of the Lord: Life of a Pioneer* (1960), 120.
7. Каролин Августа Перкинс, "The Ship Brooklyn Saints," *Our Pioneer Heritage*-ээс иш татжээ, (1960), 506.
8. Utah Semi-Centennial Commission, *The Book of the Pioneers* (1897), 2 боть., 2:54; ХҮГ Сүмийн Архивт.
9. "Jean Rio Griffiths Baker Diary," 1851 оны 9-р сарын 29; ХҮГ Сүмийн Архивт.
10. "Story of Nellie Pucell Unthank," *Heart Throbs of the West*, эмхэтгэсэн. Кейт Б.Картер, 12 боть. (1939–51), 9:418–20.
11. Виллям Палмер, Девид О.МакКей, "Pioneer Women, Women-ээс иш татжээ" *Relief Society Magazine*-ээс иш татжээ, 1948 оны 1-р сар, 8.
12. "They, the Builders of the Nation," *Hymns*, no. 36.

БҮЛЭГ ДОЛОО

1. *Journal of Discourses*, 13:85–86-г үз.
2. Жон Р.Янг, *Memoirs of John R. Young* (1920), 64.
3. Картер Е.Грант, *The Kingdom of God Restored* (1955), 446.
4. Б.Х.Робертс, *Life of John Taylor*-оос иш татав (1963), 202.
5. Францис М.Гиббонс, *Lorenzo Snow: Spiritual Giant, Prophet of God* (1982), 64.
6. "The Church in Spain and Gibraltar," *Friend*, 1975 оны 5-р сар, 33.
7. Р.Ланиер Бритш, *Unto the Islands of the Sea: A History of the Latter-day Saints in the Pacific* (1986), 21–22.
8. Чарльз В.Нибли, "Reminiscences of President Joseph F. Smith," *Improvement Era*, 1919 оны 1-р сар, 193–94.
9. Рассел Р.Рич, *Ensign to the Nations*-аас иш татав (1972), 349.
10. *Diary of Charles Lowell Walker*, хянагч. А.Карл Ларсон, Катарин Майлес Ларсон, 2 боть. (1980), 1:239; зөв бичгийн дүрэм болон цэг таслалыг шинэчлэв.

11. Леонард Ж.Аррингтон, *Charles C. Rich* (1974), 264.
12. Елизабет Вуд Кейн, *Twelve Mormon Homes Visited in Succession on a Journey through Utah to Arizona* (1974), 65–66.
13. Гордон Б.Хинкли, *Truth Restored*-ээс иш татав (1979), 127–28.
14. Бригам Янг, in *Journal of Discourses*, 18:233.

БҮЛЭГ НАЙМ

1. Калил Мехр, "Enduring Believers: Czechoslovakia and the LDS Church, 1884–1990," *Journal of Mormon History* (Fall 1992), 112–13.
2. Р.Ланиер Бритш, *Unto the Islands of the Sea: A History of the Latter-day Saints in the Pacific* (1986), 352–54.
3. Лий Г.Кантвелл, "The Separating Sickness," *This People* (Summer 1995), 58.
4. Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 5:592.
5. Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 5:593.
6. Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 5:590–91.
7. Мелвин Ж.Баллард: *Crusader for Righteousness* (1966), 16–17.
8. Жеймс Р.Кларк, эмхэтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. (1965–75), 3:256–57.
9. Жеймс Б.Аллен, Жессси Л.Эмбри, Калил Б.Мехр, *Hearts Turned to the Fathers: A History of the Genealogical Society of Utah, 1894–1994* (1995), 39–41.
10. Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 6:236.
11. "Wilford Woodruff Journals" (1833–98), 1893 оны 4-р сарын 6; ХҮГ Сүмийн Архивт; зөв бичгийн дүрэм болон цэг таслалыг шинэчлэв.
12. Ричард Нейтзел Холзапфел, *Every Stone a Sermon* (1992), 71, 75, 80.
13. Маттиас Ф.Каули, *Wilford Woodruff-ыг үз* (1909), 602.
14. "The Redemption of Zion," *Millennial Star*, 1900 оны 11-р сарын 29, 754.
15. "Biographical Sketches: Jennie Brimhall and Inez Knight," *Young Women's Journal*, 1898 оны 6-р сар, 245.

БҮЛЭГ ЕС

1. Серж Ф.Баллиф, Чуулганы илтгэлээс иш татав, 1920 оны 10-р сар, 90.
2. Жеймс Р.Кларк, эмхэтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. (1965–75), 4:222.
3. "Тэргүүн Өгүүлэл," *Improvement Era*, 1936 оны 10-р сар, 692.
4. Тэргүүн Зөвлөл, Чуулганы Илтгэлд, 1936 оны 10-р сар, 3.
5. Ж.Рюбен Кларк Бага, гадасны ерөнхийлөгчдийн тусгай цуглаан, 1936 оны 10-р сарын 2.
6. Дэлгэрэнгүй мэдээллийг Глен Л.Рудд, *Pure Religion: The Story of Church Welfare Since 1930* (1995)-аас үз.
7. Винжензо ди Франческа, "I Will Not Burn the Book!" *Ensign*, 1988 оны 1-р сар, 18.
8. Жорж Алберт Смит, Чуулганы Илтгэлд, 1948 оны 4-р сар, 162.
9. Жорж Алберт Смит, *Sharing the Gospel with Others*, түүвэр зохиол. Preston Nibley, (1948), 110–12.
10. Жорж Алберт Смит, Чуулганы илтгэлд, 1947 оны 10-р сар, 5–6.
11. Глен Л.Рудд, *Pure Religion*, 248-ыг үз.

12. Эзра Тафт Бенсон, Чуулганы Илтгэлд, 1947 оны 4-р сар, 154.
13. Герри Авант, "War Divides, but the Gospel Unites," *Church News Unites*-ээс иш татжээ, 1995 оны 8-р сарын 19, 5.
14. Дэлгэрэнгүй мэдээллийг Глен Л.Рудд, *Pure Religion*-аас үз, 254–61.
15. Жорж Алберт Смит, Чуулганы Илтгэлд, 1949 оны 4-р сар, 10.
16. Ллювелен Р.МакКей, *Home Memories of President David O. McKay*-аас иш татжээ (1956), 5–6.
17. Жорж Дюррант, "No. 1 Christian," *Improvement Era*, 1968 оны 11-р сар, 82–84.

БҮЛЭГ АРАВ

1. Жозеф Фийлдинг Смит, Чуулганы Илтгэлд, 1930 оны 4-р сар, 91.
2. Жозеф Фийлдинг Смит, Чуулганы Илтгэлд, 1972 оны 4-р сар, 13; *Ensign*, 1972 оны 7-р сар, 27.
3. Франсис М.Гиббонс, *Harold B. Lee* (1993), 459.
4. Жей М.Тодд, "The Remarkable Mexico City Area Conference," *Ensign*, 1972 оны 11-р сар, 89, 93, 95.
5. В.Грант Бангертер, Чуулганы Илтгэлд, 1977 оны 10-р сар, 38–39; *Ensign*, 1977 оны 11-р сар, 26–27.
6. Е.Дейл ЛеБарон, "Black Africa," *Mormon Heritage*, 1994 оны 3/4-р сар, 20.
7. *The Teachings of Spencer W. Kimball*, хянагч. Эдвард Л.Кимбалл (1982), 451.
8. Брус Р.МакКонки, "All Are Alike unto God," *Charge to Religious Educators*, 2 дахь хэвлэл. (1981), 153.
9. Е.Дейл ЛеБарон, "Black Africa," 24.
10. Спенсер В.Кимбалл, "The Second Century of Brigham Young University," *Speeches of the Year*, 1975 (1976), 247.
11. *Спенсер В.Кимбалл*, хянагч. Эдвард Л.Кимбалл, Andrew E. Kimball Jr. (1977), 334.

БҮЛЭГ АРВАННЭГ

1. Эзра Тафт Бенсон, *A Witness and a Warning* (1988), 3, 21; мөн *History of the Church*, 4:461-ийг үз.
2. Эзра Тафт Бенсон, Чуулганы Илтгэлд, 1986 оны 4-р сар, 100; *Ensign*, 1986 оны 5-р сар, 78.
3. Эзра Тафт Бенсон, Чуулганы Илтгэлд, 1989 оны 4-р сар, 6–7; *Ensign*, 1989 оны 5-р сар, 6–7.
4. Томас С.Монсон, Чуулганы Илтгэлд, 1989 оны 4-р сар, 66; *Ensign*, 1989 оны 5-р сар, 51; мөн 1985 оны 10-р сарын Чуулганы Илтгэлийг үз, 44; *Ensign*, 1985 оны 11-р сар, 34.
5. Гарольд Дэвис, Норма Дэвис, "The Wall Comes Down," *Ensign*, 1991 оны 6-р сар, 33.
6. *Church News*, 1991 оны 6-р сарын 29, 12.
7. Ховард Хантер, *Church News*, 1994 оны 6-р сарын 11, 14.
8. Элеанор Ноулес, *Howard W. Hunter* (1994), 193.
9. Ховард В.Хантер, Чуулганы Илтгэлд, 1987 оны 10-р сар, 71; *Ensign*, 1987 оны 11-р сар, 60.

10. *Church News*, 1994 оны 12-р сарын 17, 3.
11. *Church News*, 1995 оны 3-р сарын 18, 10.
12. Гордон Б.Хинкли: *Man of Integrity, 15th President of the Church*, видео хуурцаг (1994).
13. Жеффри Р.Холланд, "President Gordon B. Hinckley," *Ensign*, 1995 оны 6-р сар, 5.
14. *Church News*, 1995 оны 3-р сарын 18, 10.
15. Гордон Б.Хинкли, "Addresses," AV 1801; ХҮГ Сүмийн Архивт.
16. Гордон Б.Хинкли, Чуулганы Илтгэлд, 1995 оны 10-р сар, 92–93; *Ensign*, 1995 оны 11-р сар, 70.
17. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл, "Тэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг," *Ensign*, 1995 оны 11-р сар, 102.
18. Жеффри Р.Холланд, "President Gordon B. Hinckley," 13.

ТӨГСГӨЛ

1. *History of the Church*, 4:540.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02354 48363 6

35448 363